

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-45
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	46-188
	1.Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох тухай асуудал	46-51
	2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 11 дүгээр дүгнэлт	51-53
	3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 12 дугаар дүгнэлт	54-71
	4.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	71-188

Дөрөв.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.04.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Л.Атарцэцэг, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Улсын дээд шүүхийн Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Амардэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Хонгорзул, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Тэмүүлэн, Н.Учрал, Н.Энхболд нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Б.Пүрэвдорж нар гишүүдийн асуулт асуух хугацааг 3 минут болгож нэмэх нь зүйтэй гэсэн горимын саналыг гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Б.Пүрэвдорж нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 34

Бүгд: 67

49.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, М.Оюунчимэг, Г.Дамдинням, Д.Тогтохсүрэн, Ж.Ганбаатар, Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, Д.Ганбат, Х.Болорчулуун, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, С.Ганбаатар, Т.Доржханд, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Ж.Мөнхбат нарын “Их хуралдай” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, С.Чинзориг, Т.Энхтүвшин, Н.Ганибал, О.Цогтгэрэл, С.Амарсайхан, Б.Дэлгэрсайхан, Л.Мөнхбаатар, Т.Аубакир нарын цахимаар тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт, Хууль зүй,

дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, судлаач О.Мөнхсайхан нар “Их Хуралдай” танхимаас, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил цахимаар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан 12 цаг 32 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Нэг.Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Ш.Адьяа, Н.Алтанхуяг, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэснийг хасаж, 3.1.5, 3.1.6 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.5 дахь заалт, мөн зүйлийн 43.4, 43.5 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 44 дүгээр зүйл болгож, 74 дүгээр зүйлийн 74.1.3 дахь заалтын “сэлгэн ажиллуулах,” гэснийг хасах:

“44 дүгээр зүйл.Шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

44.1.Шүүхийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, тухайн шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн орон тоо дутуу байгаа адил шатны шүүхэд, адил шатны шүүхэд орон тоо байхгүй бол доод шатны шүүхэд шилжүүлэн томилж болно.

44.2.Шүүгчийг энэ хуулийн 44.1-д заасан үндэслэлээр шилжүүлэн томилуулах тухай саналаа Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн шүүгчийг шилжүүлэн томилно.

44.3.Шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүгчийг адил шатны шүүхэд хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.

44.4.Энэ хуулийн 44.3-т заасан үндэслэлээр шүүгчийг сэлгэн ажиллуулах журмыг Ерөнхий зөвлөл батална.

44.5.Шүүгч энэ хуулийн 44.3-т заасан сэлгэн ажиллах хугацаа дууссанаар урьд ажиллаж байсан шүүхэд эргэн ажиллах баталгаагаар бүрэн хангагдана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 19

Бүгд: 69
72.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.4.шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 16
Бүгд: 69
76.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйл, 14 дүгээр зүйлүүдийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулж, 14 дүгээр зүйл болгох:

“14 дүгээр зүйл.Шүүхийн тогтолцоо

14.1.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулсан шүүх хэрэгжүүлнэ.

14.2.Монгол Улсын шүүхийн тогтолцоо зохион байгуулалтын хувьд бие даасан байх бөгөөд Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

14.3.Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

14.4.Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 15.4-т заасныг харгалзахаас гадна иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Д.Ганбат, М.Оюунчимэг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 26
Бүгд: 68
61.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.1 дэх хэсэг болгож, 6.4 дэх хэсгийн “тухайлсан” гэснийг, 6.5 дахь хэсгийн “гадаад, дотоодын хүн, хуулийн этгээдээс аливаа” гэснийг хасаж, 6.7 дахь хэсэгт “Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмж, 6.11 дэх хэсгийн “шүүн таслах ажиллагаанаас” гэснийг “шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхээс” гэж өөрчлөх:

“6.1.Шүүх нь шүүх эрх мэдлийг аливаа этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 19

Бүгд: 68

72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “мэдээлж болно” гэснийг “мэдээлнэ. Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг Ерөнхий зөвлөл батална.” гэж, 13.6 дахь хэсгийн “дамжуулах” гэснийг “нэвтрүүлж болох” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 17

Бүгд: 68

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.3 дахь хэсэг болгож, 15.4 дэх хэсгийн “тоог” гэсний өмнө “төрөл,” гэж нэмэх:

“15.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 16

Бүгд: 68

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “шүүн” гэсний өмнө “шүүгчийн” гэж нэмж, 16.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.4, 16.5 дахь хэсэг болгож, 16.5 дахь хэсгийн “Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.” гэснийг “Томилолтоор ажиллахтай холбоотой харилцааг хэрэг, маргаан хянан шийдвэрлэх холбогдох хуулиар зохицуулна.” гэж өөрчлөх:

“16.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн Ерөнхий шүүгч томилогдох хүртэл хугацаанд түүнийг хамгийн олон жил шүүгчээр ажиллаж байгаа танхимын тэргүүн орлоно.

16.5.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн Ерөнхий шүүгч сонгогдох хүртэл хугацаанд түүнийг шүүгчээр хамгийн олон жил ажиллаж байгаа танхимын тэргүүн, эсхүл шүүгч орлоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 22

Бүгд: 68

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “түүний” гэснийг хасаж, 17.1.6 дахь заалтын “тусгай” гэсний өмнө “хууль хэрэглээний талаар” гэж, 17.1.9 дэх заалтын “Ерөнхий шүүгч,” гэсний дараа “танхимын тэргүүн,” гэж тус тус нэмж, 17.1.7, 17.1.11 дэх заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.1.10 дахь заалтын “Шүүгчдийн зөвлөлийн төлөөлөгч,” гэснийг, “мэргэшлийн болон” гэснийг тус тус хасаж, 17.2 дахь хэсгийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцогчдын хүсэлтээр зохих” гэснийг “хэрэг, маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар” гэж өөрчлөх:

“17.1.7.энэ хуулийн 20.1-д заасан Нийт шүүгчийн чуулганд оролцох;”

“17.1.11.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 21

Бүгд: 68

69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.3 дахь заалтын “шүүх хуралдааныг даргалах,” гэснийг хасаж, 18.1.4, 18.1.5 дахь заалтуудыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.4 дэх заалт болгож, 18.1.7, 18.1.8 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.7-18.1.9 дэх заалт болгож, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмж, 30 дугаар зүйлийг хасах:

“18.1.1.тухайн шүүхийг бүрэн эрхийнхээ хүрээнд төлөөлөх;

18.1.4.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд Тамгын газраас хариу өгч байгаа ажиллагаанд хяналт тавих;

18.1.7.танхимын тэргүүний ажлыг уялдуулах;

18.1.8.шүүхийн практик, тоон мэдээлэлд үндэслэн шүүн таслах ажиллагааны чанар, үр дүн, хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Зөвлөгөөнд мэдээлэл хийх;

18.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.”

“18.2.Ерөнхий шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, М.Оюунчимэг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 22

Бүгд: 68

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 19 дүгээр зүйл нэмж, 31, 33 дугаар зүйлүүдийг хасах:

“19 дүгээр зүйл.Танхимын тэргүүний бүрэн эрх

19.1.Танхимын тэргүүн энэ хуулийн 17.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.танхимыг тэргүүлж, шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангахад танхимын шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг уялдуулан зохион байгуулах;

19.1.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхэд Тамгын газарт туслалцаа үзүүлэх;

19.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

19.2.Танхимын тэргүүн шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй.

19.3.Танхимын тэргүүн бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 20

Бүгд: 68

70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Шүүгчдийн зөвлөгөөн

19.1.Шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн Зөвлөгөөн ажиллана.

19.2.Зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

19.2.1.тодорхой хэрэг, маргаан хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн дотоод ажлын зохион байгуулалт, журмыг хуульд өөрөөр заагаагүй бол тогтоох;

19.2.2.шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох;

19.2.3.шүүгчийг мэргэшүүлэх сургалтын саналаа энэ хуулийн 24.1-д заасан Хүрээлэнд хүргүүлэх;

19.2.4.тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийг шүүгчид дотроосоо сонгох;

19.2.5.энэ хуулийн 19.3-т заасан нөхцөл, шаардлага болон энэ хуулийн 20.2.4-т заасан нийтлэг журамд үндэслэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг батлах;

19.2.6.энэ хуулийн 18.1.8-д заасан мэдээлэлтэй танилцах;

19.2.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

19.3.Энэ хуулийн 19.2.5-д заасан журам нь хуваарилагдах шүүгчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд дараах шаардлага хангасан программ хангамжийг ашиглана:

19.3.1.шүүх хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдэд шууд өгөх боломжтой байх;

19.3.2.цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.

19.4.Энэ хуулийн 19.2.5-д заасан журам олон нийтэд нээлттэй байна.

19.5.Зөвлөгөөн ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус зөвлөгөөнийг тухайн шүүхийн шүүгчдийн гуравны нэгийн, эсхүл танхимын, эсхүл Ерөнхий шүүгчийн саналаар хуралдуулна.

19.6.Шүүгч Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцах, санал гаргах, хуралдаанд оролцох тэгш боломжоор хангагдах бөгөөд шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, шуурхай, үндэслэл бүхий байна.

19.7.Зөвлөгөөн хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

19.8.Тухайн шүүхийн шүүгчдийн дийлэнх олонх оролцсоноор Зөвлөгөөнийг хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуулийн 19.2-т заасан асуудлыг Зөвлөгөөнд оролцсон шүүгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 19

Бүгд: 68

72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Нийт шүүгчийн чуулган

20.1.Бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн хуралдааныг /цаашид “Нийт шүүгчийн чуулган” гэх/ дөрвөн жил тутам зохион байгуулна.

20.2.Нийт шүүгчийн чуулганаар дараах асуудлыг шийдвэрлэнэ:

20.2.1.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, огцруулах;

20.2.2.шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг Улсын дээд шүүхэд уламжлах;

20.2.3.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсох;

20.2.4.энэ хуулийн 19.2.5-д заасан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журмыг батлах;

20.2.5.шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг авч хэлэлцэх, зөвлөмж гаргах.

20.3.Нийт шүүгчийн чуулган хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

20.4.Нийт шүүгчийн ээлжит бус чуулганыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн, эсхүл бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн гуравны нэгийн, эсхүл нийт шүүгчийн тавны нэгээс доошгүйн саналаар хуралдуулна.

20.5.Нийт шүүгчийн олонх оролцсоноор чуулганыг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг чуулганд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.

20.6.Нийт шүүгчийн чуулганд шүүгч биечлэн оролцох боломжгүй тохиолдолд түүнийг цахимаар санал өгөх боломжоор хангана.

20.7.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчийг нууц санал хураалтаар сонгоно.

20.8.Нийт шүүгчийн чуулганы шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

20.9.Нийт шүүгчийн чуулганыг Улсын дээд шүүхийн Зөвлөгөөнөөс сонгосон хоёр, нийслэлийн эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Зөвлөгөөн тус бүрээс сонгосон нэг, дүүргийн анхан шатны шүүхээс шүүгчээр хамгийн олон жил ажилласан хоёр шүүгч, Ерөнхий зөвлөл дотроосоо сонгосон шүүгч хоёр гишүүнээс бүрдсэн ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ зохион байгуулна.

20.10.Ажлын хэсэг Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулж дуусах хүртэл ажиллах бөгөөд ахлагчаа дотроосоо нууц санал хураалтаар сонгоно. Ерөнхий зөвлөлийн ажлын алба хуралдааны зохион байгуулалтын асуудлаар Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх бөгөөд хуралдааны материал архивлах асуудлыг хариуцна.

20.11.Нийт шүүгчийн чуулган даргалагчаа дотроосоо сонгоно.

20.12.Нийт шүүгчийн чуулганаар хэлэлцэх асуудлын саналыг тоолох тооллогын комисс ажиллана. Комиссын бүрэлдэхүүнд хяналтын болон давж заалдах шатны шүүхээс тус бүр хоёр, анхан шатны шүүхээс гурван шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгох бөгөөд даргыг дотроосоо сонгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 20
Бүгд: 68
70.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “бэлгэ тэмдэг,” гэснийг, мөн зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 18
Бүгд: 68
73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.3, 22.8, 22.9, 22.10 дахь хэсэг, 22.5 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн шүүгч нь тусгай саналаа уг шүүхийн цахим хуудаст байршуулж, нийтлэх эрхтэй.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмэх:

“22.3.Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал нь шүүхийн шийдвэрийн бүтэц, төрөл, агуулга, хэл найруулга, хууль зүйн техник, шүүхийн шийдвэр эшлэхэд тавих шаардлага, талуудын шаардлага, татгалзал, тайлбарт маргаж байгаа үйл баримт болон хууль зүйн үндэслэл бүрд бүрэн дүгнэлт өгөх арга зүйг агуулсан байна.

22.8.Улсын дээд шүүхийн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.

22.9.Олон нийтийг мэдээллээр хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тайлбарлах зорилгоор шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлнэ.

22.10.Хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэрийг тухай бүр, ойлгомжтой байдлаар бичгээр болон биечлэн тайлбарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 19
Бүгд: 68
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

24.1.Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг сургалт, судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал бэлтгэх, шүүхийн шийдвэрийн

хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн /цаашид “Хүрээлэн” гэх/ Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.

24.2.Хүрээлэн нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг бүхий бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөл, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус хороотой байна.

24.3.Хүрээлэнгийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батална.

24.4.Зөвлөгөөн болон шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг зургаан сар хүртэлх хугацаагаар судлаачаар ажиллуулж болох бөгөөд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 14

Бүгд: 68

79.4 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “зэрэг” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 25.3 дахь хэсэг нэмж, 25.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “Ерөнхий шүүгч, шүүгч” гэж өөрчилж, 25.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 25.6, 25.7 дахь хэсэг болгох:

“25.3.Улсын дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана.”

“25.6.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.6.1.хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

25.6.2.энэ хуулийн 25.6.1-д заасан болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх;

25.6.3.хуульд заасан үндэслэлээр Улсын дээд шүүхийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох;

25.6.4.хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;

25.6.5.Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх:

25.6.5.1.анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;

25.6.5.2.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;

25.6.5.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.

25.7.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.7.1.хуульд тусгайлан заасан тохиолдолд Улсын дээд шүүхэд хэрэг, маргааны төрлөөр дагнасан танхим байгуулах, бүрэлдэхүүнийг батлах;

25.7.2.давж заалдах шатны шүүхэд шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхим байгуулах асуудлыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн хэлэлцэж, шийдвэрлэх;

25.7.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төсөлд саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;

25.7.4.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх;

25.7.5.хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

25.7.6.энэ хуулийн 75.2-т заасан Ерөнхий зөвлөлийн саналын дагуу, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;

25.7.7.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах;

25.7.8.хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Ш.Адъяаа, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 31

Бүгд: 68

54.4 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “хорин дөрвөөс доошгүй” гэснийг “хорин дөрвөн” гэж өөрчлөх

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 17

Бүгд: 68

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатарын гаргасан, Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.7.8 дахь заалт нэмэх:

“25.7.8.улс төрийн намын бүртгэл хөтлөх;” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар өгөв.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “25.6.3, 25.6.4, 25.6.5, 25.6.6, 25.6.7, 25.6.8, 25.6.9, 25.6.10-т ” гэснийг “25.6.3, 25.6.4, 25.7-д” гэж, 26.2 дахь хэсгийн “түүний түр эзгүйд,” гэснийг “эсхүл энэ хуульд заасны дагуу түүний” гэж өөрчилж, 26.4 дэх хэсгийн “асуудлыг” гэсний дараа “нийт шүүгчийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 15

Бүгд: 68

77.9 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч энэ хуулийн 18.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөн зарлах, бэлтгэлийг хангах, даргалах;

27.1.2.Улсын дээд шүүхийг гадаад харилцаанд төлөөлөх;

27.1.3.Улсын дээд шүүхийн шүүгчид гадаад, дотоод ажлын томилолт олгох;

27.1.4.танхим хоорондын ажлыг уялдуулан зохион байгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцүүлэхээр танхимд хуваарилах;

27.1.5.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн зөвлөгөөнд танилцуулснаар Тамгын газрын дарга, Хүрээлэнгийн захирлыг томилох, чөлөөлөх;

27.1.6.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газартай Улсын дээд шүүхийг төлөөлөн харилцах;

27.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 17
Бүгд: 68
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.1.5 дахь заалт нэмэх:

“27.1.5.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан иргэний өргөдөл, гомдолд албан бичгээр хариу өгөх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 19
Бүгд: 68
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн танхимын бүрэн эрх

28.1.Улсын дээд шүүхийн танхим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журамд нийцүүлэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллыг тогтоох;

28.1.2.хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол залруулга хийх;

28.1.3.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оруулах;

28.1.4.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөн зарлан хуралдуулах талаар Ерөнхий шүүгчид санал гаргах;

28.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 16
Бүгд: 68
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 29.5.1 дэх заалтын “хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийг үндэслэн” гэснийг “хуульд заасны дагуу” гэж, 29.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “Ерөнхий шүүгч, шүүгч” гэж тус тус өөрчилж, 29.5.3 дахь заалтын “мэдээлэл, зөвлөмж гаргуулах,” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай 29.5.3 дахь заалт нэмэх:

“29.3.Давж заалдах шатны шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхимтай байж болно. Танхимыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн батална.”

“29.5.3.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллын талаар доод шатны шүүх хооронд гарсан маргааныг шийдвэрлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 14

Бүгд: 68

79.4 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “дүүргийн” гэсний дараа “шүүх” гэж нэмж, 32.3 дахь хэсгийн “тодорхой хэрэг, маргааны төрлөөр” гэснийг “шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан” гэж өөрчилж, 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32.5 дахь хэсгийн “нүүдэллэн ажиллаж” гэснийг “шүүх хуралдааныг шүүхийн байрнаас бусад газарт хийж” гэж өөрчлөх:

“32.4.Энэ хуулийн 32.3-т заасан танхимыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 18

Бүгд: 68

73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтын “гэмт хэрэгт холбогдоогүй буюу” гэснийг хасаж, 34.2 дахь хэсгийн “жагсаалтыг” гэснийг “жагсаалт болон энэ хуулийн 41.2.2-т заасан эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журмыг” гэж, 34.4 дэх хэсгийн “шаардлагыг” гэснийг “шаардлагын аль нэгийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 34.4.3 дахь заалт нэмж, 34.5, 34.6 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.4.3.магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан.”

“34.5.Сүүлийн зургаан жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан хүнийг шүүгчээр томилохыг хориглоно.

34.6.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн гуравны хоёроос доошгүй нь энэ хуулийн 34.4.1-д заасан шүүгч байна. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 19

Бүгд: 68
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35 дугаар зүйл.Шүүгчийг сонгон шалгаруулах журам

35.1.Хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах, шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг Ерөнхий зөвлөл нээлттэй, ил тод, хараат бус байх, хууль дээдлэх зарчмыг баримтлан зохион байгуулна.

35.2.Ерөнхий зөвлөл дараах хугацаанд шүүгчийн сонгон шалгаруулалтын зарыг өөрийн цахим хуудас болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ:

35.2.1.шүүгч энэ хуулийн 49.6-д заасны дагуу өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол тэтгэвэр тогтоолгох өдрөөсөө 120-оос доошгүй хоногийн өмнө Ерөнхий зөвлөлд мэдэгдэх бөгөөд орон тоо гарахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө;

35.2.2.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээр байгаа бол орон тоо гарахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө;

35.2.3.энэ хуулийн 35.2.1, 35.2.2-т зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн сул орон тоо гарсан бол тухайн өдрөөс хойш 14 хоногийн дотор.

35.3.Энэ хуулийн 35.2-т заасан зард шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх болзол, шаардлага, өргөдөл, хавсралт баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон байна.

35.4.Энэ хуулийн 35.2-т заасан зарыг тухайн шүүгчийн ажиллах аймаг, нийслэлийн өдөр тутмын хэвлэлд нийтэлж болно.

35.5.Ерөнхий шүүгч тухайн шатны шүүхийн шүүгч, эсхүл өөрөө шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээс 120-оос доошгүй хоногийн өмнө, бусад тохиолдлоор шүүгчийн сул орон тоо гарсан бол Ерөнхий зөвлөлд ажлын таван өдрийн дотор мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 23
Бүгд: 68
66.2 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийг өргөн мэдүүлэх

36.1.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 89.8-д заасан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн эрэмбийн дагуу зарлагдсан орон тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах тухай саналыг

Ерөнхийлөгчид, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай албан бичгийг Улсын Их Хуралд холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 18

Бүгд: 68

73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.2 дахь хэсэг нэмж, 37.2 дахь хэсгийн “хуульд” гэснийг “энэ хуулийн 34 дүгээр зүйлд” гэж өөрчилж, 37.4-37.6 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 37.4-37.8 дахь хэсэг болгох:

“37.2.Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй дараах журмаар танилцана:

37.2.1.шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурал чуулганы үеэр хүлээн авсан бол 14 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ нэр дэвшигчийн талаарх танилцах сонсголын товыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж, нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй;

37.2.2.энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу танилцах сонсголын товыг нийтэд зарласнаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд шүүгчид нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Байнгын хороонд ирүүлж болох бөгөөд нэргүй асуулт, саналыг хүлээн авахгүй;

37.2.3.Байнгын хороо энэ хуулийн 37.2.2-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор танилцах сонсголыг зохион байгуулах;

37.2.4.энэ хуулийн 37.2.3-т заасны дагуу танилцах сонсгол зохион байгуулснаас хойш 14 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигч болон сонсголын тайланг Байнгын хороогоор хэлэлцэж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах;

37.2.5.энэ хуулийн 37.2.4-т заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын дарга нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсан талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх;

37.2.6.энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор Улсын Их Хурал танилцах сонсгол зохион байгуулж танилцаагүй бол тухайн нэр дэвшигчийг танилцуулсанд тооцох бөгөөд уг хугацаа дууссан өдрөөс хойш 7 хоногийн дотор Ерөнхий зөвлөлийн дарга шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсанд тооцсон талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх.”

“37.4.Энэ хуулийн 37.2.3-т заасан танилцах сонсголыг зохион байгуулах журмыг Байнгын хороо батална.

37.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүх санал болгосноос хойш Ерөнхийлөгч 14 хоногийн дотор зургаан жилийн хугацаагаар, зөвхөн нэг удаа томилно.

37.6.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар олонхын саналаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.

37.7.Энэ хуулийн 37.6-д заасны дагуу Ерөнхий шүүгчид нэр дэвшээгүй бол шүүгчээр хамгийн олон жил ажилласан шүүгчийг гурван жилийн хугацаагаар тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс томилно.

37.8.Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн дотроосоо нууц санал хураалтаар, гурван жилийн хугацаагаар сонгох бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 22

Бүгд: 68

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “мэргэшүүлэх” гэсний өмнө “гурван сар хүртэлх хугацаагаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 21

Бүгд: 68

69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “орон тооны” гэснийг хасаж, 40.5 дахь хэсгийн “сэргээнэ.” гэснийг “даруй сэргээж, энэ тухай Ерөнхий зөвлөлд мэдэгдэнэ.” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.5 дахь хэсэг нэмэх:

“40.5.Энэ хуулийн 40.4-т заасан үндэслэлээр бүрэн эрх нь түдгэлзсэн шүүгчид уг хугацаанд цалин хөлсийг 90 хувиар тооцож олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 18

Бүгд: 68

73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 41.2.9 дэх заалт, 41.5 дахь хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.2.2 дахь заалтын “болон хүндэтгэн үзэх бусад” гэснийг хасаж, 41.2.3 дахь заалтын “өөр” гэснийг “өөрийн хүсэлтээр энэ хуулийн 40.1-д зааснаас бусад” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 41.6 дахь хэсэг нэмэх:

“41.1.Шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн, эсхүл шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдөж болно.”

“41.2.9.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн.”

“41.5.Шүүгч огцорсон бол түүнийг шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.”

“41.6.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх бол хүсэлтээ Улсын дээд шүүхийн Зөвлөгөөнд гаргах бөгөөд Зөвлөгөөн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл Ерөнхийлөгчид уламжилна. Ерөнхий шүүгч албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийн үндэслэлээ олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Дэлгэрсайхан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 46

Татгалзсан: 22

Бүгд: 68

67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгчийн” гэснийг “Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн, шүүгчийн” гэж өөрчилж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 42.1, 42.2 дахь хэсэг болгох:

“42.1.Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох хугацааг шүүгч өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн бол уг насанд хүрэх сарын сүүлийн өдрөөр, бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэр гарсан бол уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр тоолно.

42.2.Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний бүрэн эрх дуусгавар болох хугацааг сонгогдсон хугацаа дуусгавар болох өдрөөр тоолно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 17

Бүгд: 66

74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд” гэснийг, 43.3.4 дэх заалтын “эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 43.3.6 дахь заалт нэмэх:

“43.3.6.шүүгч өөрийн хүсэлтээр ахисан түвшинд мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор хоёр жил хүртэл хугацаагаар гадаад улсад суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50
Татгалзсан: 16
Бүгд: 66
75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн гарчгийг “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага” гэж өөрчилж, Арван зургадугаар бүлэгт шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 18
Бүгд: 66
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “Мэргэшлийн болон” гэснийг, “ашгийн төлөө бус хуулийн этгээд, бусад” гэснийг, 45.5 дахь хэсгийг тус тус хасаж, 45.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“45.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 11.1.6, 11.1.7, 11.1.8, 12.1.4-т заасан этгээд нь шүүгчтэй албан ажлаар уулзах тохиолдолд тэмдэглэл хөтөлж, баталгаажуулан тухайн байгууллагын нууцын асуудал хариуцсан албан тушаалтанд ажлын гурван өдрийн дотор өгөх үүрэгтэй. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэх болон албан ёсны тэмдэглэл хийгдэх бусад үйл ажиллагааны явцад шүүгчтэй уулзсан тохиолдолд тэмдэглэл хөтөлж, баталгаажуулах үүргээс чөлөөлөгдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48
Татгалзсан: 18
Бүгд: 66
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.8-46.10 дахь хэсэг нэмэх:

“46.8.Шүүгч энэ хуулийн 46.1-д заасан нөлөөллийн мэдүүлгээс гадна энэ хуулийн 45.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан тухайн шүүгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх бүхий л мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэн Ерөнхий зөвлөлд битүүмжлэн ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

46.9.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 46.8-д заасны дагуу битүүмжлэн ирүүлсэн тэмдэглэлийг хадгалах бөгөөд эрх бүхий байгууллага, эсхүл шүүгчийн хүсэлтээр холбогдох этгээдэд гарган өгнө.

46.10.Энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 14

Бүгд: 66
78.8 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгч” гэсний өмнө “Шүүх,” гэж нэмж, 47.2, 47.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 47.8 дахь хэсгийн “журам, шалгуур үзүүлэлтийг” гэснийг “шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох” гэж өөрчлөх:

“47.2.Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ. Шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь

жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэнэ.”

“47.5.Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэл, энэ хуулийн 16.5-д заасны дагуу томилолтоор ажиллах болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Б.Энхбаяр, С.Чинзориг, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 33
Бүгд: 66
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.9.1, 47.9.2 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 47.9.1-47.9.3 дахь заалт болгох:

“47.9.1.Улсын дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх;

47.9.2.Улсын дээд шүүх, Ерөнхий зөвлөл Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх;

47.9.3.Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 16
Бүгд: 65
75.4 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 48 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дахин боловсруулах чиглэл Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар өгөв.

40.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, Төслийн 49 дүгээр

зүйлийн 49.1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 14

Бүгд: 65

78.5 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.2.1 дэх заалтын “өв залгамжлагчид” гэснийг “гэр бүлд” гэж өөрчилж, 49.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 49.7, 49.8 дахь хэсэг болгох:

“49.7.Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгох бөгөөд өндөр насны тэтгэврийн хэмжээг түүний авч байсан сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно. Шүүгчийн өндөр насны тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

49.8.Шүүгчийн ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралтын хугацааг энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд шүүгчээр ажилласан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Д.Тогтохсүрэн, М.Оюунчимэг, С.Чинзориг нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 33

Бүгд: 65

49.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

42.Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.6.Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 28

Бүгд: 65

56.9 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийн гаргасан, Төслийн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсэгт “Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 23
Бүгд: 65
64.6 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.2.3 дахь заалт нэмж, мөн зүйлийн 51.9 дэх хэсгийг хасах:

“51.2.3.ажил хэргийн нэр хүнд;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46
Татгалзсан: 19
Бүгд: 65
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Шүүгчид дараах зүйлийг хориглоно:

52.1.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох;

52.1.2.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулах;

52.1.3.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн албаны, байгууллагын, хувь хүний нууцыг задруулах;

52.1.4.шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааны талаар шүүхийн шийдвэр гарахаас өмнө өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлэх, илэрхийлэх;

52.1.5.албан ажлын хэрэгцээнд зориулсан материал, техник хэрэгслийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар ашиглах;

52.1.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн аливаа мэдээллийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зорилгоор ашиглах;

52.1.7.шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хуульд зааснаас бусад хэлбэрээр оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх;

52.1.8.шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон бусад иргэн, хуулийн этгээдээс шууд ба шууд бусаар тусламж авах, үйлчлүүлэх, давуу байдал, хөнгөлөлт, мөнгөн болон бусад урамшуулал, хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авах;

52.1.9.өөрийн, гэр бүлийн гишүүний, төрлийн хүний, эсхүл албан байгууллагын эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байх, хууль зүйн зөвлөгөө өгөх;

52.1.10.тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчтэй гэр бүл, эсхүл төрөл, садангийн

холбоотой талаар Ерөнхий зөвлөлд мэдэгдэхгүйгээр ажиллах;

52.1.11.өөрөө, эсхүл итгэмжлэгдсэн этгээдээр дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, тэдгээрийн холбоо, нэгдлийн удирдах бүрэлдэхүүнд орох, зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах;

52.1.12.Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр багшлах, эрдэм шинжилгээний болон бусад ажил эрхлэх, гадаад улсад зорчих;

52.1.13.гадаад улсын төр, олон нийтийн болон бусад байгууллагын шинжлэх ухааныхаас бусад хүндэт, тусгай цол, шагнал, одон, тэмдэг авах;

52.1.14.төрийн дээд одон, медаль, шинжлэх ухааныхаас бусад хүндэт, цол, шагнал, одон, тэмдэг авах;

52.1.15.Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаад улсын холбогдох шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин байгаа гадаад улсын болон олон улсын байгууллага, түүний салбар нэгжийн удирдах бүрэлдэхүүнд орох;

52.1.16.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

52.1.17.улс төрийн байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага, улс төрийн сонгуульд нэр дэвшигчийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийн сурталчилгаанд оролцох, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт, хандив өгөх;

52.1.18.хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах;

52.1.19.хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн дотно харилцаа тогтоох;

52.1.20.хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, эсхүл хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох талаар шаардлага тавих үүргээ биелүүлэхгүй байх;

52.1.21.хуульд заасны дагуу олгосон бие хамгаалах тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах;

52.1.22.энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасан дараалал, журмыг санаатай зөрчих;

52.1.23.хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах;

52.1.24.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан ажлаа удаа дараа таслах;

- 52.1.25.шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлгийн товыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчих;
- 52.1.26.шүүхийн шийдвэр гаргахтай холбоотой хуульд тодорхой заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа 30 хоногоос дээш хугацаагаар, эсхүл нэг удаа 60 хоногоос дээш хугацаагаар зөрчих;
- 52.1.27.шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон;
- 52.1.28.хуульд заасны дагуу татгалзан гарах үүрэгтэйгээ мэдсээр байж татгалзан гараагүй;
- 52.1.29.ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэхдээ согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх, эсхүл ийм байдалтай ажилдаа ирэх;
- 52.1.30.шүүгчийн сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах;
- 52.1.31.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэх;
- 52.1.32.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дууны, дуу-дүрсний бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл тараах, байршуулах;
- 52.1.33.шийдвэр гаргахаар зөвлөлдөх явцад бусадтай аливаа хэлбэрээр харилцах, зөвлөлдөх тасалгааны нууцыг задруулах;
- 52.1.34.шүүх хуралдааны явцад гар утас хэрэглэх зэрэг хэрэгт хамааралгүй өөр бусад үйл ажиллагаа явуулах;
- 52.1.35.шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг даалгавар өгөх;
- 52.1.36.шүүгч өөрөө гэрчээр дуудагдсан, эсхүл өөрийн удирдлага дахь ажилтны талаар тодорхойлохоос бусад тохиолдолд хүний зан байдал, ёс зүй, нэр төр, ур чадварын талаар тодорхойлох;
- 52.1.37.албан үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглан өөртөө давуу байдал бий болгох, хувийн хэрэгцээнд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглах, барьцаа болгон үлдээх;
- 52.1.38.хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн талаар эргэлзээ төрүүлэхүйц ойлголтыг бусдад өгөх, нийтэд мэдээлэх;
- 52.1.39.энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй;

52.1.40.энэ хуулийн 68.7-д заасныг биелүүлээгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяа, Д.Ганбат, Ц.Мөнхцэцэг, С.Амарсайхан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 23

Бүгд: 66

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 45 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 14

Бүгд: 67

79.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдааныг 19.00 цаг хүртэл сунгаж хуралдуулах нь зүйтэй гэсэн горимын саналыг гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 19

Бүгд: 67

71.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 56.1, 56.2 дахь хэсэг болгож, 56.2 дахь хэсгийн “алдаа” гэсний өмнө “мэргэжлийн үйл ажиллагааны” гэж нэмж, 56.3 дахь хэсгийг хасах.

“56.1.Шүүгч зөвхөн хуульд захирагдах бөгөөд зөрчсөн бол хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

56.2.Шүүгчид зөвхөн энэ хуульд заасан үндэслэл, журмаар сахилгын шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 12

Бүгд: 67

82.1 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 47 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан

төслийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“57.1.Шүүхийн сахилгын хороо энэ хуулийн 52, 53.1, 54, 55 дугаар зүйлд заасан хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон зохицуулалтыг зөрчсөн /цаашид “сахилгын зөрчил” гэх/ шүүгчид сахилгын шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 15
Бүгд: 67
77.6 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 48 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 58 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 14
Бүгд: 66
78.8 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 59 дүгээр зүйлийн 59.1.3, 59.1.4, 59.6.1 дэх заалтуудыг доор дурдсанаар, мөн зүйлийн 59.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 59.2-59.5 дахь хэсэг болгож, 59.4 дэх хэсгийг хасах:

“59.1.3.цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

59.1.4.шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;”

“59.6.1.энэ хуулийн 59.1.1, 59.1.2-т заасан шийтгэл оногдуулах зөрчлийг 10-аас дээш удаа, эсхүл энэ хуулийн 59.1.3, 59.1.4-т заасан шийтгэл оногдуулах зөрчлийг таваас дээш удаа гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн;”

“59.2.Энэ хуулийн 59.1.5-д зааснаас бусад шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш нэг жил, зөрчил гаргаснаас хойш хоёр жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.3.Энэ хуулийн 59.1.5-д заасан шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш хоёр жил, зөрчил гаргаснаас хойш таван жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.4.Шүүгчид сахилгын хэрэг үүсгэснээр энэ хуулийн 59.2, 59.3-т заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно.

59.5.Энэ хуулийн 59.1.4-т заасан шийтгэл оногдуулсан шүүгчид сургалтад суух хугацаанд албан тушаалын цалинг 50 хувиар тооцож олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49
Татгалзсан: 17
Бүгд: 66

74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

“60 дугаар зүйл.Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах

60.1.Энэ хуульд заасан сахилгын зөрчил гаргасан шүүгчид дараах сахилгын шийтгэлийг энэ хуулийн 59.5-д заасныг баримтлан оногдуулна:

60.1.1.энэ хуулийн 52.1.5, 52.1.21, 52.1.34, 52.1.35, 52.1.36, 52.1.37, 52.1.38, 52.1.40-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах;

60.1.2.энэ хуулийн 52.1.13, 52.1.14, 52.1.20, 52.1.25, 52.1.29, 52.1.32, 52.1.33, 53.1-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

60.1.3.энэ хуулийн 52.1.3, 52.1.4, 52.1.9, 52.1.28-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

60.1.4.энэ хуулийн 52.1.18, 52.1.19-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.5.энэ хуулийн 52.1.22, 52.1.26, 52.1.31-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.6.энэ хуулийн 52.1.15, 52.1.17, 52.1.23, 52.1.30, 55.1-д заасан зөрчилд цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.7.энэ хуулийн 52.1.6, 52.1.10, 52.1.12, 52.1.39, 54.1-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.8.энэ хуулийн 52.1.8, 52.1.16, 52.1.24-д заасан зөрчилд цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.9.энэ хуулийн 52.1.7, 52.1.11, 52.1.27-д заасан зөрчилд шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.10.энэ хуулийн 52.1.1, 52.1.2-д заасан зөрчилд огцруулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, С.Чинзориг нар

үг хэлэв.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 22

Бүгд: 67

67.2 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 65 дугаар зүйлийн 65.5 дахь хэсгийн “үзэх шалтгаантай” гэснийг “шүүх хуралдаанд оролцох боломжгүй” гэж өөрчилж, 68 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 68.3-68.8 дахь хэсэг нэмэх:

“68.3.Иргэдийн төлөөлөгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүхийн хуралдаанд оролцохдоо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

68.3.1.шүүх хуралдааны үед тодруулах асуулт тавих замаар нотлох баримт шинжлэхэд оролцох;

68.3.2.шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, зохигч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, гэрч, шинжээчид асуулт тавих;

68.3.3.хэргийн үйл баримтад үнэлэлт өгч, шүүгдэгч, зохигчийн гэм буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргах;

68.3.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

68.4.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 68.3.3-т заасан дүгнэлтийг бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, дүгнэлтийг амаар гаргаж болно.

68.5.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 68.3.3-т заасан дүгнэлтээ шүүх хуралдаанд уншиж сонсоно.

68.6.Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзнэ.

68.7.Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана.

68.8.Давж заалдах шатны шүүх хуульд заасан тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзэж, энэ хуулийн 68.7-д заасны дагуу шийдвэртээ тусгана.

68.9.Шүүх бүрэлдэхүүн энэ хуулийн 68.7-д заасныг биелүүлээгүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 18

Бүгд: 67

73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн “шүүгч” гэсний өмнө “шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах,” гэж, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн “зорилго” гэсний өмнө “, хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах” гэж тус тус нэмж, 72.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 72.2.3 дахь заалтын “эрх” гэснийг “хараат бус байдлыг хангах” гэж өөрчлөх:

“72.2.1.шүүхийн бие даасан байдлыг хангах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56

Татгалзсан: 11

Бүгд: 67

83.6 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 73 дугаар зүйлийн гарчгийг “Шүүхийн бие даасан байдлыг хангах” гэж, 73.1 дэх хэсгийн “захиргааны удирдлагын” гэснийг “шүүхийн бие даасан байдлыг хангах” гэж, 73.1.1 дэх заалтын “шүүх эрх мэдлийн” гэснийг “шүүхийн бие даасан, шүүхийн хараат бус байдлыг хангах” гэж, 73.1.2 дахь заалтын “Засгийн газар болон Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Улсын Их Хуралд” гэснийг “Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Засгийн газарт” гэж өөрчилж, 73.1.23 дахь заалтыг 73.2 дахь хэсэг болгон шилжүүлж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 73.1.26, 73.1.27 дахь заалт нэмэх:

“73.1.26.хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, ажиллагаанд байгаа хэргийн насжилт, тодорхой хэргийн хөдөлгөөний талаар хяналт-шинжилгээ хийх болон хуульд заасан бусад аргыг ашиглан хэрэгжүүлэх;

73.1.27.хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тогтоосон журмын дагуу хуваарилсан, томилсон эсэхэд хяналт тавих, улирал бүр нийтэд мэдээлэх, хүсэлт гаргасан этгээдэд уг мэдээллийг гаргаж өгөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 13

Бүгд: 66

80.3 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 74 дүгээр зүйлийн 74.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 74.1.5 дахь заалтын “болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах журам, шалгуурыг Мэргэшлийн хороотой хамтран” гэснийг “журам” гэж өөрчлөх:

“74.1.4.шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэр гаргах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 12

Бүгд: 67

82.1 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 75 дугаар зүйлийн гарчгийн, 75.1 дэх хэсгийн “эрх” гэснийг “хараат бус байдлыг хангах” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 75.2-75.4 дэх хэсэг нэмэх:

“75.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ.

75.3.Энэ хуулийн 75.2-т зааснаас бусад этгээд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, дээрх шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу хүсэлт, гомдол, нэхэмжлэл, мэдэгдэл гаргах зэрэг хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.

75.4.Шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс Ерөнхий зөвлөлд хандан гомдол, хүсэлт гаргасан бол уг асуудлаар шүүгчийг төлөөлөн гомдол, нэхэмжлэл гаргах зэргээр холбогдох этгээдэд хандаж хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 20

Бүгд: 67

70.1 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 78 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“78 дугаар зүйл.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа

78.1.Ерөнхий зөвлөл орон тооны 10 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.

78.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.

78.3.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүд нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

78.4.Ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно. Ерөнхий зөвлөлийн даргын сул орон тоо гарснаас хойш 14 хоногийн дотор даргыг сонгоно.

78.5.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

78.6.Ерөнхий зөвлөлийн нөхөн сонгогдсон, томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

78.7.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол өөр хүнийг энэ хуульд заасан журмын дагуу нөхөн сонгох, эсхүл нөхөн томилно.

78.8.Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

78.9.Ерөнхий зөвлөлийн гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд тохирсон цалин хөлс, зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж, хуульд заасан баталгаагаар хангагдана.

78.10.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тус зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 19

Бүгд: 67

71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 79 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“79 дүгээр зүйл.Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох, сонгох журам

79.1.Улсын Их Хурал Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг дараах журмаар нээлттэйгээр нэр дэвшүүлж, томилно:

79.1.1.Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч биш гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 120-оос доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын гурван өдрийн дотор Байнгын хороонд болон олон нийтэд энэ тухай мэдэгдэх;

79.1.2.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор, хэрэв чуулганы чөлөө цагт эдгээр нөхцөл бий болсон бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Байнгын хорооноос Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай

зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

79.1.3.иргэн сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт Байнгын хороонд хүргүүлэх:

79.1.3.а.Ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар;

79.1.3.б.төрийн албан хаагчийн анкет;

79.1.3.в.мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга;

79.1.3.г.нийгмийн даатгалын дэвтэр, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

79.1.3.д.энэ хуулийн 78.3-т заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг.

79.1.4.Байнгын хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг байршуулах;

79.1.5.Байнгын хороо энэ хуулийн 79.1.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээдээс нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй;

79.1.6.Байнгын хороо энэ хуулийн 79.1.2-т заасан зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор сонгон шалгаруулалтыг хараат бусаар зохион байгуулах чиг үүрэгтэй ажлын хэсэг байгуулах.

79.2.Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална.

79.3.Ажлын хэсэг энэ хуулийн 79.1.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 60 хоногийн дотор сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгоно.

79.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг дараах журмаар зохион байгуулна:

79.4.1.энэ хуульд заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийг бүртгэн нийтэд мэдээлэх;

79.4.2.нэр дэвшигчийг тохиолдлын журмаар ажлын хэсгийн гишүүдэд тэнцвэртэй хуваарилж, илтгэгч гишүүнийг томилох;

79.4.3.илтгэгч гишүүн нь нэр дэвшигчийн баримт бичиг, олон нийтээс ирүүлсэн саналыг судлах, нэр дэвшигчтэй болон бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр

мэдээллийг бүрдүүлж, тухайн нэр дэвшигч Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дэлгэрэнгүй тайлан бичих;

79.4.4.ажлын хэсгийн гишүүд илтгэгч гишүүний тайлан болон холбогдох бусад баримт, мэдээлэлд үндэслэн нууцаар санал хураах;

79.4.5.энэ хуулийн 79.4.4-т заасан санал хураалтын дүнгээр ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэлх хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.

79.5.Байнгын хороо энэ хуулийн 79.4.5-д заасны дагуу ирүүлсэн тайланг хүлээн авснаас хойш дараах ажиллагааг хийнэ:

79.5.1.хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг агуулсан тайланг ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах;

79.5.2.энэ хуулийн 79.5.1-д заасны дагуу тайланг байршуулснаас хойш ажлын таван өдрийн дотор томилгооны сонсголын товыг зарлах;

79.5.3.тайланг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй;

79.5.4.энэ хуулийн 79.5.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор хуульд заасны дагуу томилгооны сонсголыг зохион байгуулах.

79.6.Энэ хуулийн 79.5.4-т заасны дагуу томилгооны сонсголыг хийснээс хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох эсэх талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

79.7.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилно.

79.8.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилохоос татгалзсан бол ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчдээс дараагийн хамгийн олон санал авсан хүнийг энэ хуулийн 79.4.5-д заасны дагуу Улсын Их Хуралд нэр дэвшүүлнэ.

79.9.Энэ хуулийн 79.8-д заасан нөхцөлд ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигч байхгүй бол ажлын таван өдрийн дотор Байнгын хороо сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, 90 хоногийн дотор энэ зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулалтыг дахин явуулна.

79.10.Улсын Их Хурлаас татгалзсан нэр дэвшигчийг дахин нэр дэвшүүлэхгүй.

79.11.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулахтай холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн Байнгын хороо баталж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна.

79.12.Нийт шүүгчийн чуулган Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг дараах журмаар нэр дэвшүүлж, сонгоно:

79.12.1.Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын таван өдрийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

79.12.2.Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор Нийт шүүгчийн чуулганы товыг энэ хуулийн 20.4-т заасны дагуу зарлаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх бөгөөд нийтэд мэдээлснээс хойш 45 хоногийн дараа Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах;

79.12.3.Нийт шүүгчийн чуулганы товыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор шүүгч Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт энэ хуулийн 20.9-д заасан ажлын хэсэгт хүргүүлэх:

79.12.3.а.Ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар;

79.12.3.б.мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга.

79.12.4.ажлын хэсэг хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах;

79.12.5.мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг ажлын хэсэг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй.

79.13.Нийт шүүгчийн чуулганд нэр дэвшигч нь хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ танилцуулж, оролцогчийн асуултад хариулна.

79.14.Нэр дэвшигчийн танилцуулга хийх дарааллыг тохиолдлын журмаар тогтоож, танилцуулга хийх, энэ хуулийн 79.12.5-д заасны дагуу ирүүлсэн асуултад хариулах ижил хугацааг нэр дэвшигч бүрд олгоно.

79.15.Нийт шүүгчийн чуулганд оролцогчид нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах бөгөөд санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно.

79.16.Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын санал авсан нэр дэвшигчдийг саналын дарааллаар эрэмбэлж, сул орон тоо гарсан тоогоор Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно. Санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч оролцогчдын олонхын санал аваагүй бол дахин санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.

79.17.Ажлын хэсэг энэ хуулийн 79.16-д заасан санал хураалт дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор Нийт шүүгчийн чуулганы тогтоол, тэмдэглэлийг үйлдэж,

Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

79.18.Энэ хуулийн 79.12.3-т заасан хугацаанд хүсэлт гаргаагүй шүүгчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгохыг хориглоно.

79.19.Ерөнхий зөвлөлийн гишүүнд шүүгчийг нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд шүүгчийн хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах, үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай бусад асуудлыг энэ хуулийн 20.3-т заасан дэгээр зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 18

Бүгд: 67

73.1 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн “архив, бүх шатны шүүхийн тамгын газарт түүний салбар” гэснийг хасаж, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсгийн “хэлэлцэн” гэсний дараа “ил санал хураалт явуулж” гэж нэмж, 81.4 дэх хэсгийн “тав” гэснийг “гурав” гэж өөрчилж, 81.6 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 81.8 дахь хэсэг нэмэх:

“81.8.Ерөнхий зөвлөл хуульчдаас шүүгчийг шилж олох, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбогдуулан гаргасан шийдвэрээ тухай бүр, ажлын тайланг жил бүр өөрийн цахим хуудаст байршуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 19

Бүгд: 67

71.6 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 82 дугаар зүйлийн 82.1.1 дэх заалтын “удирдах” гэснийг “уялдуулан зохицуулах” гэж, 82.1.11 дэх заалтын “Шүүгчдийн зөвлөлд” гэснийг “Нийт шүүгчийн чуулганд” гэж тус тус өөрчилж, 82.4 дэх хэсгийн “түр” гэснийг, “орон тооны” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45

Татгалзсан: 22

Бүгд: 67

67.2 хувийн саналаар дэмжигдлээ.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 83 дугаар зүйлийн 83.1.1 дэх заалтын “орон тооны гишүүний хувьд” гэснийг хасаж, 83.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 83.1.6, 83.1.7 дахь заалт нэмэх:

“83.1.6.Ерөнхий зөвлөлийн хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө холбогдох баримт бичгийг урьдчилан хүлээн авч танилцах;

83.1.7.хүндэтгэн үзэх шалтгаантай бол Ерөнхий зөвлөлийн хуралдаанд цахим хэлбэрээр оролцох, эсхүл саналаа бичгээр өгөх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 16

Бүгд: 66

75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 84 дүгээр зүйлийн 84.2.1 дэх заалтын “энэ хуулийн 20.2.3-т заасны дагуу сонгогдсоноос бусад гишүүн” гэснийг, 84.2.6 дахь заалтын “хороо болон Шүүхийн мэргэшлийн” гэснийг тус тус хасаж, 84.2.1 дэх заалтын “гурван” гэснийг “нэг” гэж, 84.2.2 дахь заалтын “үүсэхээс урьдчилан сэргийлэх” гэснийг “үүсгэх” гэж тус тус өөрчилж, 84.2.7 дахь заалтын “авах” гэсний дараа “, өөртөө аливаа давуу байдал бий болгохыг шаардах” гэж нэмж, 84.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 84.2.5-84.2.7 дахь заалт болгох:

“84.2.5.шүүн таслах ажиллагаа, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцох;

84.2.6.нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын болон үнэлгээ, шалгалтын баримт бичгийг урьдчилан ил болгох, тодорхой нэр дэвшигчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх;

84.2.7.нэр дэвшигчийн үнэлгээг үндэслэлгүйгээр өөрчлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 14

Бүгд: 66

78.8 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 85 дугаар зүйлийн гарчгийн “, эгүүлэн татах” гэснийг, 85.7 дахь хэсгийн “эгүүлэн татах,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд дараах агуулгатай 85.2.3 дахь заалт нэмж, 85.3, 85.4, 85.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 85.3-85.8 дахь хэсэг болгох:

“85.2.3.энэ хуулийн 89.3-т заасны дагуу хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй байх, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг зөрчсөн, эсхүл шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг задруулсан;”

“_____85.3.Энэ хуулийн 85.2-т заасан зөрчил гарсан тухай өргөдөл, мэдээллийг Сахилгын хороонд гаргана.

85.4.Сахилгын хороо Ерөнхий зөвлөлийн гишүүний талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Сахилгын хэрэг үүсгэсэн бол тухайн өргөдөл, мэдээллийн үндэслэлийг шалгах хараат бус шинжээч /цаашид “шинжээч” гэх/-ийг Сахилгын хороо томилно.

85.5.Шинжээч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэлд дурдсан зөрчлийн талаарх баримт, мэдээллийг цуглуулж, хууль зүйн дүгнэлт гаргах

бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

85.6.Шинжээч энэ хуулийн 85.2-т заасан сахилгын зөрчил гарсан байх үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Сахилгын хороо уг дүгнэлтийг эрх бүхий этгээдэд даруй хүргүүлж, Ерөнхий зөвлөлийн гишүүнийг огцруулах эсэх асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

85.6.1.Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг огцруулах асуудлыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдааныг зохион байгуулж, Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын саналаар, нууцаар санал хурааж, шийдвэрлэх;

85.6.2.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг огцруулах асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх;

85.6.3.гэмт хэргийн шинжтэй бусад үйлдэл, эс үйлдэхүйг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

85.7.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний энэ хуулийн 84.1, 84.2-т заасныг зөрчсөн үйлдэлд огцруулах шийтгэл оногдуулахааргүй бол зөрчлийн шинж, хэр хэмжээнд тохируулан хаалттай, эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Ерөнхий зөвлөл оногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн гишүүнийг оролцуулахгүй.

85.8.Сахилгын хороо энэ хуулийн 84.1, 84.2-т заасныг зөрчсөн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх зарчимд нийцүүлэн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 17

Бүгд: 66

74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 8 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 87 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 17

Бүгд: 66

74.2 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 88 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36 дугаар зүйл болгон Наймдугаар бүлэгт шилжүүлэх:

“36 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх

36.1.Энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан гэж үзсэн иргэн энэ хуулийн 35.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасны дагуу өргөдөл гаргагч нь энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан тухай баримтыг өргөдөл, анкет, мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн болон эд хөрөнгийн эрхийн лавлагаа, Монгол Улсын иргэний үнэмлэх, мэргэжлийн боловсролын диплом, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хөдөлмөр эрхлэлтийн талаарх болон бусад баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт Ерөнхий зөвлөлд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

36.3.Ерөнхий зөвлөл өргөдөл гаргагчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан тухай тогтоол гаргана.

36.4.Энэ хуулийн 36.3-т заасан тогтоол гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор нэр дэвшигчийн баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

36.5.Энэ хуулийн 36.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Ерөнхий зөвлөлд ирүүлэх бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг хүлээн авахгүй.

36.6.Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн мэдээллийг тухайн шүүхийн болон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

36.7.Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тавих болзол, шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх баримт бичиг болон бүртгэлтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 74.1.5-д заасан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 16

Бүгд: 66

75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 89 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 37 дугаар зүйл болгон Наймдугаар бүлэгт шилжүүлэх:

“37 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт

37.1.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг энэ хуулийн 36.3-т заасны дагуу бүртгэснээс хойш 60 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигчийн шалгалт авна. Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт нь хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтаас бүрдэнэ.

37.2.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх, сорилын асуултад хариулах, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зэрэг аргаас сонгон хэрэглэж, 70 хүртэлх оноогоор үнэлнэ. Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн шалгалт ялгаатай байна.

37.3.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт нь нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг хангасан байх бөгөөд шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг Ерөнхий зөвлөл хариуцна.

37.4.Энэ хуулийн 37.2-т заасан шалгалтад 50, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэнд тооцож, тогтоол гарган мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад оруулна.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан тогтоол гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор хувь хүний нууцад хамаарахаас бусад нэр дэвшигчийн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга болон холбогдох баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулна. Ийнхүү байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчийн талаарх саналаа Ерөнхий зөвлөлд хүргүүлж болох бөгөөд нэр, хаяггүй саналыг хүлээн авахгүй.

37.6.Энэ хуулийн 37.4-т заасан нэр дэвшигчийг тохиолдлын журмаар Ерөнхий зөвлөлийн гишүүн /цаашид “илтгэгч гишүүн” гэх/-д тэнцвэртэй хуваарилна. Илтгэгч гишүүн өөрт хуваарилагдсан нэр дэвшигчийн баримт бичиг, шүүн таслах болон бусад ажлын туршлага, шүүгчээр ажиллаж байсан нэр дэвшигчийн хувьд хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийн чанар, олон нийтээс хүлээн авсан санал, нэр дэвшигчийн талаар бусад этгээдтэй болон нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын дүн зэргийг судалсны үндсэн дээр тухайн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлсэн үндэслэл бүхий тайлан бичиж, Ерөнхий зөвлөлийн бусад гишүүдэд хүргүүлж, хуралдаанд танилцуулна.

37.7.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчтэй ярилцлага хийсний дараа дараах зүйлийг үндэслэн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг 30 хүртэл оноогоор үнэлэх бөгөөд 20, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг уг шалгалтад тэнцсэнд тооцно:

37.7.1.нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага;

37.7.2.нэр дэвшигчийн баримт бичиг;

37.7.3.нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх хөндлөнгийн дүгнэлт;

37.7.4.олон нийтээс хүлээн авсан санал;

37.7.5.илтгэгч гишүүний тайлан;

37.7.6.бусад.

37.8.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадвар болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт тус бүрд өгсөн оноо, тэдгээрийн нийлбэр онооны дарааллаар эрэмбэлэн өөрийн цахим хуудаст байршуулж, нийтэд мэдээлнэ.

37.9.Энэ хуулийн 37.8-д заасан үнэлгээ хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

37.10.Шүүгчийн сонгон шалгаруулалт олон нийтэд ил тод байх бөгөөд шалгалттай холбогдуулан гаргасан Ерөнхий зөвлөлийн шийдвэр үндэслэл бүхий, оролцогч болон сонирхогч этгээдэд ойлгомжтой, нээлттэй байна.

37.11.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчээс шалгалт авахдаа зохих журмын дагуу хөндлөнгийн хараат бус шинжээчийг оролцуулж болно.

37.12.Шалгалт авах арга, хэлбэр, үнэлэх аргачлал, нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх хөндлөнгийн дүгнэлт гаргах, олон нийтээс санал хүлээн авах болон холбогдох бусад харилцааг энэ хуулийн 74.1.5-д заасан журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 18

Бүгд: 66

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

67.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 91 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 91.1.9 дэх заалт нэмэх:

“91.1.9.иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 16

Бүгд: 66

75.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19 цаг 05 минут болсон тул санал хураалтыг дараагийн хуралдаанаар үргэлжлүүлэн явуулахаар тогтож, хуралдаан завсарлав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн референт Б.Туул, шинжээч М.Номиндулам, Э.Сувд-Эрдэнэ нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, мөн хэлтсийн ахлах референт Ч.Тунгалаг, шинжээч У.Энхжин нар хариуцан ажиллав.

Хуралдаан 09 цаг үргэлжилж, 74 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 95.9 хувийн ирцтэйгээр 19 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
2021 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН**

Дөрөв.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр танилцуулна. Энхбаяр гишүүнийг индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын эрхэм дарга, гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2020 оны 32 дугаар захирамжаар төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Н.Алтанхуяг, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар нар ажилласан.

Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоолоор ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажлын дэд хэсгийг байгуулан ажилласан. Байнгын хороо 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно. Ийнхүү хэлэлцэхдээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу хуралдаан даргалагчийн чиглэлийн дагуу 30 минутын хугацаатайгаар шүүгчид хориглох зүйлсийн асуудлаар гишүүдэд саналаа чөлөөтэй илэрхийлэх боломж олгож, мэтгэлцээн явуулсан болно. Ажлын хэсгээс хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дараах санал, дүгнэлтийг гаргасныг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

Нэг.Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэх талаар:

-Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах зорилгын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүх гишүүд орон тооны байх;

-Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр олон нийтэд болон салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн хүнийг сонгох үүднээс нээлттэй хэлэлцэж, сонгон шалгаруулалтаар тодруулах;

-Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүний сонгон шалгаруулалтыг хараат бусаар явуулах чиг үүрэгтэй Ажлын хэсгийг тал талын, тэнцвэртэй төлөөллөөс бүрдүүлэх, Байнгын хороо танилцах сонсголыг зохион байгуулах;

-Шүүхийн ерөнхий зөвлөл хуульчдаас шүүгчийг сонгон шалгаруулах гол чиг үүргээ өөртөө хадгалж, сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр шүүгчээр томилуулахаар Ерөнхийлөгчид санал болгох.

Хоёр.Шүүгчийн сахилга хариуцлагын асуудлыг нарийвчлан зохицуулах талаар:

-Шүүгчийн сахилга хариуцлагыг чангатгах, шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг хамгаалахын тулд шүүгчийн сахилгын зөрчлийг тодорхой тусгах;

-Шүүхийн сахилгын хороо нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүргийг хэрэгжүүлэх;

-Шүүхийн сахилгын хороо нь хуульд заасан үндэслэл журмын дагуу, Шүүхийн сахилгын хороо иргэний гаргасан өргөдөл, гомдлыг шалгах, шийдвэрлэх, гаргасан шийдвэрт гомдол гаргах харилцааг нарийвчлан зохицуулах;

-Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр олон нийтэд болон салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн хүнийг сонгох үүднээс нээлттэй хэлэлцэж, сонгон шалгаруулалтаар тодруулах;

-Шүүхийн сахилгын хорооны гишүүн зөрчил гаргасан бол түүнийг огцруулах харилцааг нарийвчлан зохицуулах;

-Шүүхийн сахилгын хорооны зарим шийдвэрийг Улсын дээд шүүх хянадаг байх.

Гурав.Шүүхийн бие даасан байдал, шүүгчийн хараат бус байдлын талаар:

-Шүүгч, шүүхийн эдийн засгийн хараат бус байдлыг хангах зорилгоор шүүхийн төсвийг төсвийн хэмнэлтээс бусад тохиолдолд бууруулахгүй байх;

-Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн “шүүх хуралдааныг даргалах,” “шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцох,” “доод шатны шүүх хооронд гарсан хэргийн харьяаллын маргааныг шийдвэрлэх” зэргээр шүүн таслах ажилд эдэлдэг байсан давуу эрхийг хасах;

-Хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг урьдчилан мэдэх боломжгүй байдлаар томилох, хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг санамсаргүй тохиолдлоор хуваарилах цахим программ хангамж ашиглах;

-Улсын дээд шүүхийн дэргэд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ажиллах бөгөөд шүүгчийн сургалтын хөтөлбөрийг боловсруулахад бүх шатны шүүгч, Шүүхийн судалгааны төв, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн төлөөллийг оролцуулах зэрэг багтана.

Ажлын хэсгээс Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 82 санал, найруулгын шинжтэй 4 санал болон хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 28 саналыг тус тус гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар хуулийн төслийн 20 дугаар зүйлийн гарчгийг “Нийт шүүгчдийн чуулган” гэж, Улсын дээд шүүгчдийн тоог “хорин дөрөв” гэж өөрчлөх, Улсын дээд шүүх улс төрийн намын бүртгэл хөтлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан иргэний өргөдөл, гомдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч албан бичгээр хариу өгөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан шүүгч эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас хэтэрсэн зардал, цалин хөлсийг бүрэн олгох хэт ерөнхий зохицуулалтыг хуулийн төслөөс хасах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Н.Алтанхуяг нар шүүгчийн ажлын ачаалал, онцлогоос шалтгаалан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг 60 болгох талаар зарчмын зөрүүтэй санал тус тус гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Тус Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Монгол Улсын шүүхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Шүүхийн захиргааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Индэрт ганцаараа байгаа учраас маскаа авъя. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Барсүрэнгийн Баасандорж, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Пүрэвжавын Ганзориг, Сайнзориг,

Пүрэвжавын Сайнзориг, Одонхүүгийн Мөнхсайхан Хууль зүйн их сургуулийн профессор, доктор Үндсэн хууль судлаач, Лхүндэвийн Атарцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн, Цэндийн Цогт шүүгч цахимаар оролцож байна уу? Орж ирэх үү? Шагдарсүрэнгийн Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, манай Хууль зүйн байнгын хороо Улсын Их Хурлын түүхэнд хамгийн урт удаан хугацаагаар 18 цаг хуралдаж энэ шүүхийн багц хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулсан. Олон санал хураалттай. 120 гаруй санал хураалттай. Тэгэхээр өнөөдөр бас өнөө маргаашдаа ажил хэрэгч хуралдаж энэ хуулиудаа батлахыг эрмэлзэж байна. Манай Хууль зүйн байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт гишүүнээр ахлуулсан манай Хууль зүйн байнгын хорооныхон бол бас их сайн ажилласан. Шүүсийг нь нэлээн шахсан гэж ойлгож байгаа.

Нэлээн урт хугацаанд хуралдах учраас эхлээд бас нэг гишүүдээ төрсөн өдөр энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа гишүүдээ мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал 1 сарын 02-нд төрсөн. Улсын Их хурлын эрхэм гишүүн Нямаагийн Энхболд 1 сарын 06-нд төрсөн. Улсын Их Хурлын эрхэм гишүүн Гонгорын Дамдинням 1 сарын 09-нд төрсөн. Улсын Их Хурлын эрхэм гишүүн Ганзоригийн Тэмүүлэн 1 сарын 10-нд төрсөн. Энэ долоо хоногт төрсөн эрхэм гишүүн Ням-Осорын Учрал, Нямаагийн Энхболд, Гонгорын Дамдинням, Ганзоригийн Тэмүүлэн нартаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс төрсөн өдрийн баярын мэнд хүргэж эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Өнөөдрийн хуралдаа идэвхтэй оролцоорой. Ингээд горимын санал Бөхчулуун Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Ардчилсан улс орнуудад төрийн эрх мэдлийг ер нь гурван гурав хуваадаг. Өөрөөр хэлбэл нэгнийгээ хянах ийм одоо үүргийн дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл гээд. Тэгэхээр бид нар одоо өнөөдрийн Үндсэн хуулийнхаа заасны дагуу шүүх эрх мэдлийг одоо хэрхэн зохицуулах тухай хуулийг өнөөдөр ярьж байна. Тэгэхлээр энэ бол төрийн болон иргэний улс орны, одоо үйл ажиллагаанд маш чухал ийм олон асуудлыг хөнддөг, иргэдийн эрх ашгийг хөнддөг ийм одоо чухал хууль байгаа. Бүхэл бүтэн одоо нэг төрийн эрх мэдлийг хэрхэн одоо үйл ажиллагаа нь явуулах уу гэдэг ийм хуулийг хэлэлцэж байгаа энэ үед энэ цахим дэгээр буюу хоёр минутаар үг хэлж энэ хуулийг батлах нь бол одоо маш их ийм өрөөсгөл зүйл гэж үзэж байна. Тийм учраас энэ цахим хуралдааны энэ хоёр минутыг гурван минут багадаа болгох, тэгээд нэг минутаар нэмж цаг авах ийм одоо дэгээр явуулж өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Пүрэвдорж гишүүн сая тэр үг хэлэх хугацаа сунгах асуудлыг хөндлөө. Хоёр минут үнэхээр хүмүүс асуултаа асууж, үгээ хэлж багтахгүй байна. Тэгэхээр цахимаар явж байгаа ч гэсэн гурван минут болгож өгөөч гэсэн энэ асуудлыг бол дэмжиж байна.

Г.Занданшатар: Монгол Улсын Их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн долоогийн ес, долоогийн аравт онцгой нөхцөлд захирмаар хуралдаж байгаа үед асуулт асуух хугацаа хоёр минутаас илүүгүй, хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл нэг минутаас нэг удаа нэг минутаас илүүгүй хугацаагаар асуулт асууж, тайлбар авах бөгөөд үг хэлэх хугацааг гурван минутаас илүүгүй байхаар тогтооно гэж заасан. Нам, эвслийн бүлгийн бүлэг, гишүүд шаардлагатай гэж үзвэл саналаа нэгтгэн асуулт асууж саналаа илэрхийлж болно гэж заасан. Цэндийн Цогт шүүгч тийшээ суугаарай. Зарчмын зөрүүтэй саналын томьёолол тус бүр дээр

дэмжсэн, дэмжээгүй гурав хүртэл гишүүн үг хэлж болно. Тэгэхдээ таван минутаас таван минут үг хэлнэ. Саналын томъёолол дээр.

Тэгэхдээ энэ хууль бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу хийж байгаа. Нэн ялангуяа шүүхийн хариуцлага, хараат бус байдлыг хангахад томоохон хоёр шинэчлэлт өөрчлөлт хийж байгаа юм органик Үндсэн хуульчилсан суурь хууль. Ийм учраас энэ хуулийг хэлэлцэхэд бас гишүүдийн саналыг харгалзан үзэж гурван минутаар асуулт асуух хугацааг тогтоож болно гэж бодож байна. Тэгээд энийг боломжийг хангахын тулд горимын саналаар санал хураалт явуулна. Дэгд санал хураалтаа өөрчлөлт оруулж болно. За ингээд Хаянгаагийн Болорчулуун, Бөхчулууны Пүрэвдорж нарын гишүүдийн гаргасан саналаар асуулт асуух хугацааг гурван минутаар тогтооё гэсэн ийм горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалтад жаран долоон гишүүн оролцож гучин гурван гишүүн дэмжиж энэ санал дэмжигдсэнгүй. За ингэе. Наранбаатар Цахим бодлогын байнгын хорооны асуулт асуух хугацааг гурван минут дээр тавиулчих. Гурван минутаар тавьж явуулаад шууд хоёр минутаа нэмэлт нэг минутаар хамт гурван минутаар явууллаа шүү. Тэндээ л багтаж асууна. Товч тодорхой асуугаарай.

Ганбат дарга дэг сахина шүү. Чуулганы хуралдаанаас гарч сануулна шүү. Нэмэлт нэг минут, нэмэлт нэг минутын санал хураалтыг хамт явуулъя гэж байна. Та татгалзаж байгаа бол тэгвэл энэ Ганбат дарга гишүүн татгалзаж байна. Тэгвэл хоёр минутаар явуулъя. Ингээд Ганбат гишүүн дэгээрээ явъя гэсэн санал гаргасан учраас дэгээрээ явъя. Ардчилсан намын бүлгийн дарга гишүүдийнхээ эрхийг хүндэтгэж үзэхгүй байгаа учраас цөөнхийнхөө саналыг хүндэтгэнэ. Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү. Сандагийн Бямбацогт гишүүнээр танхим тасаллаа. Цахимаар асуулт асуух гишүүд myparliament.zuum.chat хэсэгт нэрээ бүртгүүлээд Наранбаатар надад танилцуулна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна. Хоёр минутаар.

Л.Энх-Амгалан: Гурван минутаар тавьчхаарай даргаа. Үндсэн хуульд шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана гэж бид нар ийм Үндсэн хуультай. Гэтэл харамсалтай нь өнөөдөр бүх шүүгч нар хараат болсон гэдэг ийм судалгаа бид нарт байна. Шүүгч нар хуульд захирагддаггүй эзэнд захирагддаг ийм шүүхтэй болчихсон гэсэн энэ судалгаа бид нарт байна. Эзэнд захирагдаг. Хонгилын эзэнд захирагддаг болчихсон байна гэж байна шүү дээ. Тэгээд одоо бие даасан нэг ийм төрийн бус байгууллагын судалгаагаар шүүгчдийн дунд хийсэн судалгаа шүү. Судалгаагаар нийт шүүгчдийн шийдвэр гаргахдаа гучин хувь нь өөрийнхөө томилсон болон улс төрийн нөлөөлөлд автаж шийдвэр гаргадаг гэж гучин хувь нь. Гурван шүүгчийн нэг нь гэсэн үг.

Хоёрт нь дээд шатны шүүгчдийнхээ нөлөөлөлд барьцаанд шантаанжинд шантаажинд байдаг гэж гучин хувь. За ингээд өнөөдөр Монгол улсын шүүхээр гарч байгаа бүх шатны шүүхээр гарч байгаа шийдвэрийн чинь далан хувь нь жараас, далан хувь нь гаднын төлөөлөлд хараат байдлын дотор шийдвэр гаргаж байна гэдэг энэ судалгаа байгаа. Энэ судалгаагаар бол ер нь Монгол улс бол хараат бус биш, хараат шүүхтэй болчихсон, хараат шүүхэд шүүхтэй болчихсон юм байна уу. Хараат шүүгчтэй болчихсон юм байна. Хоёрдугаар асуудал бол ер нь бусад улс орнуудтай харьцуулахад Монголд одоо хараат бус шүүх байна уу гэдэг энэ судалгаагаар бид нар өнөөдөр зуун хорьд жагсаж байна. Зуун хорьд, африкийн улсуудын дараа. Хүний эрх хамгийн их зөрчигддөг африкийн улсуудын дараа бид нар өнөөдөр жагсаж байна, жагсаж байна. Энэ бол Монгол улсад хараат бус шүүх байхгүй байна

л гэдгийг илэрхийлж байгаа ийм илэрхийлэл байгаа юм.

Бид нар шүүхийн шинэчлэлийг хийх гэж Үндсэн хуулийн өөрчлөлтдөө томоохон өөрчлөлт хийсэн. Өнөөдөр бэх нь хатаагүй байгаа манай Үндсэн хуулийн өөрчлөлт. Гэтэл харамсалтай нь өнөөдөр шүүх эхнээсээ ингээд хараат бус.../минут дуусав/

Г.Занданшатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн нэг минут.

Л.Энх-Амгалан: Тийм учраас энэ өнөөдрийн бид нарын батлах гэж байгаа хууль бол нэг Монгол улсад байгаа таван зуун жаран шүүгчийн асуудал биш юм. Энэ бол Монгол улсад шударга ёс тогтоох, Монголд бид нар шударга нийгэм байгуулах ийм л том шинэчлэлт өөрчлөлтүүдийг хийх ийм шаардлага өнөөдөр үүсчихсэн байж байгаа. Нийгмийн захиалга ч өнөөдөр. Өнөөдөр энэ шударга ёсны хүсэмжлэл бол нийгэмд хамгийн том хүсэмжлэл бол энэ шударга ёсны хүсэмжлэл байна гэж байгаа шүү дээ. Ходоодны өлсгөлөнгөөс илүү шударга ёсны өлсгөлөнд Монголчууд бид нар нэрвэгдчихээд байна. Тэгэхээр яг ингээд өнөөдрийн энэ хийж байгаа энэ өөрчлөлтүүд маань энэ Монгол улсад шударга ёсыг бий болгох, шударга нийгмийг бий болгох, хүн бүр хуулийн өмнө тэгш эрхтэй байх энэ эрх зүйн баталгааг нь бид нар хангаж өгч чадах уу гэдгийг л би асуумаар байгаа юм.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт Хууль зүйн байнгын хороон дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Энх-Амгалан гишүүний асууж байгаа асуулт яах аргагүй одоо Монголын нийт ард түмний хүсэн хүлээж байгаа асуух ёстой, шийдэх ёстой асуудлыг бас хөндөж тавьж байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид нар хоёр мянга арван есөн онд хийсэн. Ингэхдээ Үндсэн хуулийн 49, 50, 48 гээд шүүхтэй холбоотой заалтууд дээр тодорхой өөрчлөлтүүд хийсэн. Үндсэндээ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуульд нийцүүлж шүүхийн тухай хуулийг бас шинэчилж найруулж батлах энэ Үндсэн хуульчилсан хууль буюу органик хуулийг баталж байгаа. Яах аргагүй өнөөдөр шударга ёс гэдэг асуудал бол нийгмээрээ Монголын ард түмэн бүгдээрээ хүсэн хүлээдэг, ийм зарчим байх ёстой гэдгээ бол ярьдаг болсон асуудлаа шийдэх ёстой. Энэ үүднээс Монгол Улсын Засгийн газар хоёр мянга хорин оны дөрвөн сард шүүхийн тухай хуулийн шинэчилсэн нар Их Хуралд өргөн барьсан. Энэ хүрээнд ажлын хэсэг одоо үндсэндээ гурван сар гаруй ажиллаж, өнөөдөр анхны хэлэлцүүлэг хийгдэж байна.

Ажлын хэсэг ажиллахдаа Засгийн газар өргөн барьсан төсөлд орж ирэхдээ, бас яг таны ярьж байгаа энэ асуудлуудыг шийдэх гэж орж ирсэн. Шүүх шударга байх, шүүгч хараат бус байх энэ асуудлыг Үндсэн хуульд бол хуульчилсан. Энэ зарчимд л нийцүүлж шүүхийн хуулийн шинэчилсэн найруул хийгдэж байгаа. Энэ хүрээнд сая Их Хурлын дарга бас хэлсэн. Ажлын хэсэг маань бүтэн одоо арван найман цаг хуралдаж, тасралтгүй энэ асуудлыг тал талаас нь одоо мэтгэлцээний зарчимд үндэслэж тулгуурлаж хэлэлцсэн. Энэ хүрээндээ ажлын хэсэг маань за Засгийн газрын процессыг улам одоо сайжруулж, хэн нэгнээс хараат бусаар шүүх ажиллах, энэ бололцоо боломж бүрдүүлсэн. Шүүхийн тухай хуулийн дөчин зургаадугаар зүйл, дээрээс нь далан тавдугаар зүйл дээр бол шүүгч хараат бусаар ажиллах, мөн одоо шүүгчид хэн нэгэн нөлөөлөх энэ нөлөөллийг бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Тодруулга байхгүй, сая нэг минутаа авчихсан. За одоо эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг.

М.Оюунчимэг: Гурван минутаар өгчихөөрөө даргаа. Энэ Монголын нийгэм бараг энэ шүүхийн шинэчлэлийг харж байна л даа. Улсын Их Хурлын чуулганы танхимаас яаж өөрчлөгдөх бол, яаж энэ бид саяын хэлээд байгаа нөгөө шударга шүүх, бие даасан хараат бус шүүгч байж чадах уу, үгүй юу гэдэг асуудал байна. Бид нар маш олон жил ярьж байгаа. Одоо ганц яриад байгаа юм биш л дээ. Энэ шударга бусын хонгил гээд л. Монголын ард түмэн энэ шударга ёсыг хүсэмжилж байгаа хүсэмжлэл бүр дал, ная, ерэн хувьд хүрч, одоо гучин хэмийн хүйтэнд яаж гуч дөчин мянга болоод зогсож байсан гол шалтгаан бол энэ шударга ёсны хүсэмж л байсан л даа. Тэгэхээр бид нар энэ шүүхийн хуулийг шинэчлэн найруулах гол зорилго бол энэ шүүхийг хэн нэгэн хүнээс юм уу, хэн нэгэн институтээс хамааралтай байх биш, яг л одоо бодитоор юмыг шударгаар шүүдэг байх, өөрсдөө бие даасан тэр үнэний туйл болж асуудлаа шийддэг байх энэ асуудал өөрөө туйлын чухал байгаа. Одоо энэ яг энэ шүүхийн анхны хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцэх гэж байхад бараг хүмүүс шөнөжин харсан байх.

Яагаад гэвэл энэ өөрөө хүн бүхний амьдралтай холбоотой асуудал. Сая хэлж байна. Нэг таван зуун жаран шүүгчийн асуудал биш. Монгол улсад шүүхийн тогтолцоог яг зөв голдирол руу нь оруулж, одоо яг шударга шүүгддэг тийм тогтолцоо руу оруулахын тулд шинэчлэл явагдаж байгаа гэж бид нар харж байгаа. Зүгээр маргалдаанаас ингээд харж байхад нэг талаасаа мэдээж энэ хэдийнээ бүр гажуудсан тогтолцоо гэдгийг өнөөдөр хүн бүхэн хүлээн зөвшөөрчихсөн байна. Энэ тогтолцоог бид сууриар нь тэр гажуудлыг, нөгөө тэр хорт хавдрыг бүхлээр нь авах бололцоо яг энэ хуулиараа гарч чадаж байгаа юу, үгүй юу. Эсвэл дахиад л нэгнээс нэг юунаас гараад л өөр нэг юмны хараат руу болчих, эсвэл нөгөө талаасаа шүүгчид өөрсдөө одоо яг шударгаар асуудлыг шүүж чадахгүй, алдаа гаргахаас айгаад ажилдаа өөрөөр ханддаг болчих вий гэсэн болгоомжлол. Тэр эртээд шүүгчдийнх нь өөрсдийн ярианаас бол харагдаж байсан л даа. Би мэргэжлийн алдаа хүртэл гаргаж болохгүй юм уу гээд. Мэргэжлийн алдаа гэж юуг үзэх юм. Энэ хүн хариуцлага алдсан, шударгаар шүүж чадаагүй.../минут дуусав/

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Ажлын хэсэг бас нэмж хариулах нь зөв байх. Энхбаяр гишүүн, за манай ажлын хэсгээс холбогдох хүмүүс. Тэгэхээр шүүгчийн хариуцлагатай холбоотой заалт Үндсэн хуульд бас орсон. Үндсэн хуулийн дөчин есийн тав дээр дөчин есийн зургаа дээр шүүхийн сахилгын хороо ажиллана. Хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бус шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий шүүхийн сахилгын хороо ажиллана гэж заасан. Яг энэний дагуу энэ шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад сахилгын хороо хэрхэн яаж ажиллах вэ, шүүгчид хэрхэн яаж сахилга хариуцлага оногдуулах вэ гэдэг асуудлыг нийтдээ дөч гаруй заалтаар зохицуулж өгсөн байгаа. Өөрөөр хэлэх юм бол үндсэндээ шүүгч хараат бусаар ажиллана нэг талаасаа. Нөгөө талаасаа бол хариуцлагатай ажиллах энэ бололцоо боломжийг нь бүрдүүлж, тэр шүүхийн тухай хуулийн тодорхой зүйлд заасан тэр дөч гаруй заалтаар ийм асуудал үүсэх юм бол шүүгчид сахилга хариуцлага оногдуулна. Бусдаар бол шүүх бол хэнээс ч хараат бус ажиллах бололцоо, боломжийг бүрдүүлэх заалт орж өгсөн. Энэ дээр манай Энхбаяр гишүүн ажлын хэсгийн ахлагч нэмээд хариулчих.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Баярлалаа. Тэгэхээр шүүх эрх мэдлийн асуудал бол сая Их Хурлын

дарга бас хэлж байна. Энэ бол Үндсэн хуулийн одоо эрх мэдэл хуваарилах маш том хяналтынхан хариуцлага шийтгэдэг ийм одоо салаа мөчрийн асуудал. Тийм учраас бол Үндсэн хуульчилсан хуулийн төслөө гэдэг агуулгыг бас тодотгож хэллээ. За ерэн хоёр оны Үндсэн хуульд бол энэ гол зарчмуудыг бол суулгасан. Өөрөөр хэлбэл шүүх эрх мэдэл бол бие даасан байна шүү. Шүүгч бол ер нь хэнээс ч хараат бус байна шүү. Тэгээд энэ чиглэлд бол одоо олон хууль тогтоомжийн шинэчлэл, бас олон удаагийн Их Хурал сүүлийн хорин найман жилийн хугацаанд хийж ирсэн. Нөгөө талдаа бас гол юун дээр алдчихав гэхээр Үндсэн хуулиасаа гадуур хууль, ердийн хуулиуд батлахдаа нөгөө шүүгчтэй бас нөгөө хараат болгох улс төрчдөөс тийм ердийн хуулиудыг бас нэлээн баталснаас улбаатайгаар тодорхой субъектэд хэт шүүх эрх мэдлийн бүх албан тушаалтнуудыг мэдэх, томилох, удирдах, бүр одоо хариуцлага тооцох, томилохгүй байх, чөлөөлөх ийм одоо дур зоргын шинжтэй эрх мэдлүүдийг хэд өгсөнтэй холбоотойгоор одоо таны асууж байгаа яг ийм асуудал үүссэн.

Тэгээд энийг одоо ердийн хуулиар бол залруулъя гэж байгаа. Дахиж, ер нь энэ Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалыг алдагдуулсан чиглэл дээр нэлээн хариуцлагатай байх ёстой юм байна. Улсын Их Хурал маань. Өнгөрсөн онд одоо Улсын Их Хурал маш чухал өөрчлөлтийг одоо Үндсэн хуулийн өөрчлөлтөд хийсэн. Хоёр гурван одоо ийм зарчмын шинжтэй шүүх эрх мэдлийн, одоо бие даасан байдлыг хангахтай холбоотой өөрчлөлт хийсэн. Энэ өөрчлөлт бол өнөөдөр одоо үр өгөөжөө өгөх үү, үгүй юу гэдгийг бол бид ердийн хуулиар улам амилуулах уу, үгүй юу гэдэг ийм одоо шийдвэрээ гаргах гэж байгаа. Тэр ч утгаараа одоо Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг яг тэр шүүх эрх мэдлийн хэсгийг хэлэлцэж байснаас дутахгүй ийм одоо үүрэг хариуцлага бол бидэнд байгаа. Их Хурлын дарга маань ч гэсэн яг энэ асуудал дээр бол бас манлайлж хариуцлагатай хандаж яг энэ хуулийн одоо ажлын хэсгийг байгуулахаас эхлээд дэд ажлын хэсэг одоо байгуулах энэ одоо бүх зүйлүүд хүртэл одоо Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалын хүрээнд байна уу гэдэг дээр их анхаарал тавьж байсан. Манай Лүндээжанцан дарга хүртэл одоо ажлын хэсгийн хуралд одоо тасралтгүй сууж, яг энэ Үндсэн хуулийг баталж байх үед энэ өөрчлөлтийг баталж байх үед юу бодож баталж байсан бэ гэдэг тэр үзэл баримтлалыг хүртэл одоо бидний хажууд одоо зааж зөвлөж, ингэж хэлж байсанд бас одоо баяртай байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо цахимаар эрхэм гишүүн Гонгорын Дамдинням асуулт асууна. Танхимд орж ирсэн байна, Гонгорын Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. За энэ шүүхийн тухай хууль бол нэлээн улд нь чангаалтын дараа л чуулганд орж ирж байна. Мэдээж энэ улд нь чангааж байгаа нь бол ойлгомжтой. Хэн ч чангааж байгаа, яагаад чангаагаад байгааг бүгдээрээ л харж байгаа байх. За энэ дээр бол өнөөдөр манай бас энэ цэцийн дүгнэлттэй холбоотой манай энэ Ардчилсан намаас Их Хурлын дэд дарга Одонтуяа гишүүн бол бас энэ шүүхийн шийдвэрүүд улс төрийн нөлөөлөлтэй гардаг. Мөн бас сая сөрөг хүчний одоо дарга Эрдэнэ дарга маань бол саяхан тэр Улсын дээд шүүх дээр бүртгэл хийхэд Улсын дээд шүүхийн бүртгэлд хуульд байхгүй намын даргын үүрэг гүйцэтгэчихсэн хүн бүртгэл оруулсан байна гээд. Ийм одоо юу гэдэг юм хууль бус үйл ажиллагаанууд хэний нөлөөгөөр хийгдээд байдаг юм бэ? Энэ Улсын Их Хурлын гишүүн болоод ороод ирсний дараа энэ саарал ордон дотор хамгийн том яригдаж байгаа юм энэ л яригдаж байна шүү дээ. Энэ шүүхийн хуулийн процессын үед.

Томилогдохоос нь өмнө халагдах өргөдлийг нь, чөлөөлөгдөх өргөдлийг нь бичүүлж

аваад, тэгээд хугацаагүйгээр бичүүлж аваад тэгээд томилдог. Тэгээд хурал хийгээд сууж байхад нь чөлөөлөх шийдвэр нь гарчихсан байдаг гээд л ингээд ярианууд яваад байх юм. Энийг ер нь Улсын Их Хурал нэг шалгаж цэгцлэх цаг болсон. Тэгэхээр энэ улс төрийн нөлөөлөл нөгөө энэ шударга бусын хонгилыг бүтээгээд байгаа энэ системийг нураах тал дээр энэ шүүгч нарын нөлөөлөлд ордог, энэ дарамтад ордог, шүүх, прокурорын өндөр албан тушаалтнуудын эрх чөлөөтэй, шударга ажиллах боломжийг нь одоо бүрдүүлсэн өөрчлөлт ер нь ямар юм орсон бэ? Энийг одоо энэ хууль санаачлагчдаас асууя. Тэгээд бид нар энэ дээр бол Их Хурал онцгой анхаарч, энэ шалгалт шүүлэг хийдэг өөрийнхөө эрх хэмжээг хэрэгжүүлэх ёстой шүү. Энэ дээр бол санаачилга гаргаад ажиллана. Баярлалаа.

Г.Занданшатар: Бямбацогт гишүүн аль зэрэг орсон бэ гээд.

С.Бямбацогт: За тэгэхээр Үндсэн хуулийн бас нэмэлт, өөрчлөлтийн нэг суурь зарчим бол энэ эрх мэдэл хуваах, засаглалын тэнцвэртэй байдлыг бий болгох энэ чиглэлд бас тодорхой өөрчлөлт орсон. Энэ хүрээндээ Их Хурал Их Хурал шиг байя. Их хурал бол төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага, ард түмний төлөөлөл. Ард түмнээс сонгогдсон ард түмнийг төлөөлөх бага ард түмэн. Энэ хүрээндээ үйл ажиллагаа явуулах нь тодорхой хэмжээнд хязгаарлаж тодорхой хэмжээнд бас тодорхой эрхийг нь олгож өгсөн. Энэ хүрээнд бол Улсын Их Хурал хуулийн хэрэгжилтэд хяналт тавих энэ чиг үүргээ хэрэгжүүлнэ. Хууль тогтоох онцгой бүрэн эрхтэй. Дээрээс нь хуулийн хэрэгжилт нь хяналт тавих энэ чиглэлдээ бол өнгөрсөн хугацаанд Монгол Улсын парламент бол харьцангуй сул ажиллаж ирсэн. Үндсэн хуульд бол энэ зохицуулалт орсон. Нөгөө талдаа энэ шүүх, шүүгчид нөлөөлөх, одоо юу гэдэг юм өөрийн бас тодорхой түрүүн Энх-Амгалан гишүүн хэлсэн. Энэ асуудлыг зохицуулах заалт Үндсэн хуульд орсон.

Энэ хүрээндээ энэ шүүхийн тухай хуулийн шинэчлэл бол энэ шүүгчийг шударга ажиллах, шүүхийг хараат бус байх заалтууд түрүүн би хэлсэн. Шүүхийн тухай хуулийн дөчин зургаа болон одоо далан тав дугаар зүйлүүдээр зохицуулагдаж өгсөн. Өнөөдөр хэн ч шүүгчид, шүүхэд нөлөөлөх эрх нь хязгаарлагдаж байгаа. Хэн нэгэн албан тушаалтан сая Дамдинням гишүүний хэлж байгаа тийм үү? Урьдчилж өргөдлийг нь авах гэдэг юм уу, эсвэл утсаар уулзаад нөлөөлөх, ингэсэн тохиолдолд яаж зохицуулах вэ гэдэг заалтууд маш тодорхой орсон байгаа. Өөрөөр хэлэх юм бол шүүгчид хэн нэгэн нөлөөлөх гэж оролдох юм бол утсаар болон биеэр уулзаад, мөн одоо бичгээр болон бусад байдлаар нөлөөлөх гэж оролдох юм бол үүнийг протоколд нь, үүнийг шүүхийн ерөнхий зөвлөл.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултад нэмж хариулна.

Б.Энхбаяр: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Тийм өргөдлийг нь томилохдоо бичүүлээд авчихдаг шүүгчдийг, тэгээд тэрүүгээр нь нийнтэглээд үгэнд нь орохгүй бол нөгөө огноогүй өргөдлийг нь гаргаж ирж огноог нь бичиж байгаад явуулчихдаг. Өөрөө мэдээгүй байж байсан чинь ажлаасаа чөлөөлөгдчихсөн байсан энэ тэр гэсэн ийм ярианууд бол байдаг. Би бол яг хажууд нь байгаагүй учраас хараад зогсож байгаагүй учраас хэлж мэдэхгүй. Баталгаа нотолгоотой бас дүгнэлт хийж чадахгүй л байна л даа. Тэгэхдээ ийм яриа нэгэнт байдаг, бас байгаа учраас тэр томилж байгаа этгээдээс шүүгчийг хараат бус байлгахын тулд тодорхой заалтууд оруулж байгаа юм. Тухайлбал улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх өргөдлөө одоо Ерөнхийлөгчид биш улсын дээд шүүхийн нийт шүүгчдэд гаргана. Улсын дээд шүүхийн нийт шүүгч тэр өргөдлийг хэлэлцэнэ. Үндэслэлтэй байна гэж үзвэл Ерөнхийлөгчид уламжилна.

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь олон нийтэд өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтийнхээ агуулгыг, үндэслэлээ олон нийтэд урьдчилж мэдээлнэ. Заавал гэдэг ийм одоо заалтуудыг ажлын хэсгээс оруулж, одоо та бүхэн маань дэмжвэл санал хураалтад дэмжвэл ингээд батлагдана. Энэ нь яах гэж оруулж байна вэ гэхээр саяын таны асууж байгаа урьдчилж өргөдөл авдаг, барьдаг байж магадгүй болзошгүй тэр эрсдэлийг хаах гэж оруулж байгаа ийм хамгаалалтын заалтууд байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Тогтохсүрэн Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. За энэ хуулийн төсөл бол үнэхээр чухал хууль. Хоёр парламент дамжаад Засгийн газраас өргөн барьсан энэ хуулийн төслийг. Хоёр парламент дамжаад хоёр гурван ч чуулган дамжаад явж байгаа ийм хуулийн төсөл. Сүүлийн хоёр гурван сар үнэхээр ажлын хэсэг сайн ажиллаж байгаа. Энэ дээд шүүх, шүүхийн ерөнхий зөвлөл, хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн яам гээд энд оролцогч нар бол маш сайн ажиллаж байгаа гэдгийг би зориуд тэмдэглэж хэлье. Энэ хуульд хамгийн чухал юм нийгэмд шударга ёс тогтоочихье гэдэг нэг ийм л том зарчим явж байгаа гэдгийг манай гишүүд ч бүгдээрээ ойлгож байгаа. Тэр утгаар нь Монгол ардын намын бүлэг ч гэсэн энэ хуулийн төслийг гурван удаа авч хэлэлцсэн байгаа. Тийм учраас бол би энэ хуулийн төслийг нэлээн чамбай болгож өнөөдөр орж ирж байгаа гэж ингэж ойлгож байгаа юм. Би тийм учраас хуулийн төсөл дээр ажиллаж байгаа ажлын хэсгээс дөрвөн зүйлийг асууя. Маш тодорхой.

Хуулийн төслийн арван дөрөвдүгээр зүйл дээр энэ шүүхийн тогтолцоог зааж өгсөн. Ажлын хэсэгт ч тодорхой саналуудыг оруулж ирсэн байна. Арван дөрвийн гуравт шүүхийг эрүү хэргийн захиргааны захиргаа гэж төрөлжсөн байна гэж заасан. Энэ заалтыг ажлын хэсэг авчихсан байгаа юм. Тэгээд энэ төрөл төрлийг нь цаашдаа дээд шүүх өөрөө тогтоогоод явах юм уу гэдэг асуудал байгаа юм. Хуульд заагаагүй. Хоёрдугаарт нь энэ арван дөрвийн дөрөв дээр нөгөө анхан болон тойргийн журмаар шүүхийг байгуулж болно гэж байгаа юм. Өнөөдөр Монгол улсад шүүх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжээр дарагдаж байгуулагдаж байгаа. Шүүх хүний эрхийг хангадаг, хүний эрхийг хамгаалдаг учраас иргэддээ аль болохоор ойр байх ёстой юм.

Тийм учраас миний асуух гээд байгаа юм энэ хууль гарсны дараа анхан болон давж заалдах шатны шүүхүүд одоо байгаа бүтэц нь өөрчлөгдөх үү, үгүй юу. Ер нь практик дээр бол орон нутагт болбол нэг аймгуудад хоёр шүүх л байгаа анхан шатны. Давахын нэг шүүгч л байгаа. Эдгээр нь нэг болох уу, танхимтай байх уу, үгүй юу гээд энэ асуудлын нэг тодорхой яг ийм юм байна.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариултын дараа тодруулъя. Эрхэм гишүүн Баттөмөрийн Энхбаяр ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт шүүн таслах үйл ажиллагааны чиглэлийг хууль дээрээ нэг бүрчлэн бичих үү, дээд шүүх цаашдаа энэ саналаа гаргадаг байх уу гэдэг дээр. Энэ одоо бол эрүү, иргэн, захиргаа гээд биччихээд байгаа юм. Гэтэл энэ нь дотроо байх ёстой. Цаашдаа ер нь задрахыг бас үгүйсгэхгүй байгаад байгаа юм. Жишээлбэл эрүүгийн шүүх гээд байх уу? Магадгүй авлигын шүүх гээд дагнаж бас гарч болзошгүй. Яг одоо авлигын гэмт хэргийг шийддэг, эсвэл одоо яг хүүхдийн эсрэг, бага насны ялангуяа хүүхдийн эсрэг

шийдсэн ийм гэмт хэргүүдийг дагнаж шийддэг шүүх бас гарахыг бас үгүйсгэхгүй. Иргэний хэрэг гээд ингээд байж байдаг. Тэгтэл яг гэр бүлийн маргааныг дагнаж шийддэг шүүх бас гарахыг үгүйсгэхгүй. Өв залгамжлалын маргааныг одоо мэргэших. Өөрөөр хэлбэл бусад улс оронд байдаг шиг энэ онцлог, онцлог хэргүүд дээр мэргэшиж дагнах байгуулах асуудал бол цаашдаа дээд шүүх магадгүй санал гаргаад эцсийн шийдвэрийг бол Улсын Их Хурал гаргана. Яагаад гэхээр Үндсэн хуульд зааснаар шүүх байгуулах шийдвэрийг Улсын Их Хурал гаргаж байгаа юм.

Тэгэхээр эцсийн шийдвэр бол цаашдаа Улсын Их Хурал дээрээ л гарч явна. Яг энэ агуулгаараа таны асуусан хоёр дахь асуулт буюу цаашдаа энэ сум, сум дунд, аймгийн шүүхүүд дээр одоо бүтцийн өөрчлөлт энэ хууль батлагдсанаар хийгдэх үү гэвэл хийгдэхгүй. Ямарваа нэгэн өөрчлөлт орохгүй. Яагаад гэхээр энэ нь хууль батлагдсаны дараа магадгүй тусдаа дахиад шүүхээ задлах тойргийг шүүх байгуулах, эсвэл нэг, хоёр дүүргийн хооронд юм уу хоёр аймгийн дунд нэг ийм онцлогтой шүүх байгууллага гэдэг юм уу ийм шийдвэрүүд дандаа Улсын Их Хурал дээр эцэглэж гарах юм. Шүүх байгуулах тухай тус тусдаа хууль гарна. Энэ хуулийн хуулиудаар шийдэгдэх юм гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тэр шүүх дагнасан байхгүй бол хольчих юм бол нөгөө мэргэшсэн шүүхийн мэргэшсэн байдал алдагдах юм биш үү л гэсэн агуулгатай асуулт асуугаад байна шүү дээ. Захиргааны, иргэний, эрүүгийн танхимуудыг чинь. Тэр дагнасан шүүхийг аваад хаячихаар чинь тэр утга алдагдчих юм биш үү гэсэн агуулгаар асуугаад байгаа шүү дээ. Тогтохсүрэн гишүүн тодруулъя.

Д.Тогтохсүрэн: Энэ цаг маш бага байгаа юм. Тийм учраас юм ярьж болохгүй байгаа юм. Тийм учраас саяын Их Хурлын даргын тодруулга миний тодруулгыг гишүүд тэрийг нэмээд хэлчхээрэй. Хоёрдугаарт нь арван наймдугаар зүйл дээр арван наймын нэгийн дөрөв, нэгийн тав дээр энэ иргэний оролцоог бий болгоод байсан юм хуучин. Шүүхэд иргэн хүн гомдол мэдүүлдэг, саналаа хэлдэг, шүүмжилдэг тэрийг байхгүй бол хаячихсан байгаа юм. Арван наймын нэгэн дөрвийг. Иргэдийг хүлээж авна. Энэ манай шүүхэд чинь иргэдээсээ холдоод явчихсан байхгүй юу. Бүх шатандаа холдоод явчихсан юм. Хараат бус гээд холдоод явчихсан байхгүй юу. Гэтэл амьдралыг нь мэдэрч байж энэ шиг шүүх шийдвэр гаргах ёстой юм. Тийм учраас энэ арван наймын нэгийн дөрөв, нэгийн тав гэсэн их чухал заалтуудыг ажлын хэсэг хасаад хаячихсан байгаа юм. Дараагийн заалт нь дөч дүгээр заалт дээр байгаа дөчдүгээр санал дээр. Нийгмийн даатгалын хууль, Хөдөлмөрийн хуулиар зохицуулдаг харилцааг энэ хуулиар зохицуулахаар хийчихсэн байгаа юм. Жишээлбэл тэтгэвэрт гараад тэтгэвэр тогтоолгохтой холбоотой асуудал байгаа. За гучин зургаан сарыг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ тэтгэвэрт гарахад нь цалингийнх нь авч байгаа цалингийнх нь наян хувиар тэтгэвэр тогтоолгоно гээд Нийгмийн даатгалын хуульд ордог зүйлийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Наян найм Цэндийн.Цогт шүүгч наян зургаа.

Ц.Цогт: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүхтэй байх нь бол Монгол Улсын Үндсэн хуулиар батлагдсан ийм зарчим байгаа. За энэ дагуу бол одоо шүүх байгуулах тухай хуулиар бол шүүхүүд байгуулагдсан ажиллаж байгаа. Тэгэхээр яг энэ шүүхийн тухай хууль шинэчлэн найруулагдсантай холбогдуулж бол шүүхийн тогтолцоонд бол шууд өөрчлөлт орохгүй байхаар байгаа. Харин Их Хурал, шүүх байгуулах тухай хууль одоо хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд бол энэ шүүхийн тогтолцооны асуудал өөрчлөгдөх асуудал хөндөгдөх байх.

Тэгээд зарчмын хувьд бол энэ дагнасан шүүх, мэргэшсэн шүүгч гэдэг зүйлээ хадгалж явах нь бол иргэдийн одоо хэрэг маргаанаа мэргэшсэн хүнээр шийдүүлэх энэ эрхийн баталгаа болж явдаг юм. Дараагийн тэр арван наймдугаар зүйлтэй холбоотой. Шүүхийн иргэдийг хүлээж авахтай холбоотой асуудал дээр нэг онцлог шүүн таслах ажиллагааны нэг онцлог бол нөгөө хэргийн маргаж байгаа талууд байдаг учраас тэд нарын аль нэгэнтэй нь дангаараа бол уулзаж болдоггүй. Ингэх юм бол нөгөө хэргийн оролцогчдынх нь аль нэгийг нь нөлөөнд нь ордог гэж үздэг учраас дангаараа уулзахыг нь бол хорьсон байгаа. Шүүхийн тухай хуульд. Бусад тохиолдолд бол хэргийн оролцогчдоо талуудтай нь бол хамт олон уулзаж болно. Дангаараа бол уулзаж болохгүй. Шүүхэд ирсэн хэргийн оролцогч бус этгээд одоо шүүхэд аливаа асуудлаар хандах, шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдэгдэл, санал шүүмжлэл хэлэхийг бол шүүхийн Тамгын газар зохион байгуулаад хүлээж аваад уулзах боломж бол бий. Энэ бол энүүгээр хязгаарлагдахгүй.

Г.Занданшатар: Тэр эрүү, иргэн дагнасан давах нь болон дагнасан байх нь нөгөө шүүгчийн мэргэшсэн байдал, хүний эрхийг хангах талдаа ч гэсэн тэрнийгээ тэгж хуульчилбал яасан юм бэ. Үндсэн хуультайгаа нийцүүлж л гээд байна шүү дээ.

Ц.Цогт: Тийм. Тэр бол энэ уг нь энэ шүүхийнхээ тухай хуульд тэр эрүүгийн иргэн захиргаа гэдэг үг нь байхад бол илүү байж болох юм. Тэгэхдээ ер нь бол Үндсэн хуульд байгаа шүү дээ. Тэгэхдээ яг энэ хуулиар бол шүүхийн тогтолцоонд шууд өөрчлөлт хийхгүй байхгүй юу. Шүүх байгуулах тухай хууль хөндөгдсөн тохиолдолд л саяын асуудлууд хөндөгдөх юм.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт Хууль зүйн байнгын хорооны дарга нэмж хариулна.

С.Бямбацогт: Тогтохсүрэн гишүүн бас сая асуулаа. Шүүгч нарын одоо тэтгэвэр наян хувиар тогтооно үндсэн цалингийнх нь одоо наян хувь тогтооно гэж хэт өндөр юм биш үү гэж. Ингэж хуульд зааж өгөх нь бас цааш цаашдаа ингээд хуулиуд нийгмийн халамж, нийгмийн даатгал, даатгалын хуулиар зохицуулах зохицуулалтуудыг энэ хуульд суулгаж өгөх нь зөв үү гэж. Энэ дээр тэгэхээр хуучин бас жишиг байгаа. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль болон одоо бусад хуулиуд тодорхой төрлийн одоо албан хаагчдын тэтгэврийн асуудлыг хуульд нь суулгаж өгдөг. Яг энэ жишгийн дагуу бас ажлын хэсэг оруулж ирсэн. Наян хувь гэдэг бол бас байх ёстой байх. Энэ бол онцгой. Өнөөдөр хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, шударга ёсыг тогтоох онцгой ажил эрхэлж байгаа учраас шүүгч нарын тэтгэврийг авч байгаа цалингийнх нь наян хувиар тогтоох нь зөв юм гэдэг байдлаар ажлын хэсэг маань бас томъёолол оруулж ирсэн. Байнгын хороон дээр энэ саналыг дэмжсэн байгаа.

Харьцангуй одоо бас өндөр биш юм байна лээ. Нийгэмд бас тэгээд ойлгочихсон болохоос шүүгчдийн цалин бас харьцангуй бас өндөр биш юм байна лээ.

Г.Занданшатар: Тэгэхдээ шүүхийн тогтолцоо гэсэн арван дөрөвдүгээр зүйлийн арван дөрвийн гурав тэр шүүхийг дагнасан хэлбэрээр байгуулж болох бөгөөд гээд заачихаар үүрэгжүүлэхгүй. Ер нь анхан болон давах шатны шүүгч нарыг дагнасан хэлбэрээр нь эрүү иргэн гэж мэргэшүүлж томилж ажиллуулж байвал энэнтэйгээ уялдахгүй бол энэ чинь зөвхөн шүүхийн байгууллын хууль дээр ингээд явчихна гээд хоорондоо уялдааг нь хангах зорилгоор тэр нэгэнтээ Үндсэн хуульд дагнасан шүүх байгуулна гээд заачихсан юмыг тодруулбал яасан юм бэ л гэж асуугаад байна л даа.

Тогтохсүрэн гишүүн. Тэрийг тэгээд бас Баттөмөрийн.Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Сая Их Хурлын дарга бас хэллээ. Энэ шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулж болно гээд яах вэ ажлын хэсэг бол эндээ нэгэнт Үндсэн хуульд байгаа учраас багтаж байгаа гэж ойлгоод санал гаргачихсан. Тэгээд бас нэг тийм болгоомжлол бас гишүүд байгаа учраас, энийг хоёр дахь хэлэлцүүлгийн явцад сая Их Хурлын даргын хэлж байгаа чиглэлийн дагуу эрүү, иргэн, захиргааны гэдгийн төрлөөр та байвал байх юм гэдгийг нь шууд бичээд ингээд явчихъя гэсэн ийм зүйл байна.

Г.Занданшатар: Баярлалаа. Үндсэн хуультай нийцүүлэх үүднээс. Одоо эрхэм гишүүн Жамбалын Ганбаатар асуулт асууна.

Ж.Ганбаатар: Баярлалаа. За мэдээж одоо гишүүд маш тодорхой асууж байгаа. Тэгээд хамгийн гол зүйл бол шүүгч яаж хараат бус байх вэ гэдэг асуудал л байгаа юм л даа. Тэгэхээр шүүгчид янз янзын байдлаар хөндлөнгийн нөлөөнүүд одоо орохоос шүүхийн ерөнхий зөвлөл хамгаална л гэж ойлгож байгаа. Би Энхбаяр одоо ажлын хэсгийн ахлагчаас асууя. Гэхдээ яаж хамгаалах вэ гэдэг заалтыг нь би олж уншихгүй юм л даа. Ялангуяа тэр улс төрийн одоо байгууллагуудаас ч гэдэг юм уу, эсхүл одоо ямар нэгэн бүлэглэлээс тэр шүүгчийг шүүхийн ерөнхий зөвлөл яаж хамгаалах вэ гэсэн тодорхой заалтууд нь хэлж өгөөч гэдгийг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт төслийн тавин наймдугаар зүйл дээр шүүгч хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны журам зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн бол мэргэжлийн ур чадварын талаар дүгнэлт гаргуулахаар дээд шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж мэргэжлийн хороонд хүргүүлнэ гэсэн. Энэ чинь нөгөө одоо сая Энх-Амгалан гишүүн хэлээд байна шүү дээ. Шүүгч шүүгчдээ нөлөөлдөг судалгаанууд их байна гэж. Тэгэхлээр энэ чинь өөрөө энэ чинь алдагдаж байгаа юм биш үү? Одоо тэгээд анхан шатны шүүгчид давахын одоо нэг гурван шүүгч сууж байгаад ч юм уу тэр хүнийхээ талаар мэргэжлийн хороонд дүгнэлт хүргүүлэх юм байна гэсэн ийм ойлголт харагдах юм. Тавин наймдугаар зүйл гэдгийг хараарай. За шүүхийн шүүгчийг сонгон шалгаруулах асуудлаар ер нь өмнөхөөсөө ахиц дэвшил хэрэг гарсан бэ? Тэр шүүгчийг сонгон шалгаруулна гэдэг чинь өөрөө хэнийг сонгон шалгаруулаад, хэнд одоо одоо үүрэг хариуцлага хүлээлгэх вэ гэдэг асуудал их чухал шүү дээ.

Тэгэхээр өмнөх хуульд одоо эндээс өөрөөр яаж заасан бэ гэдгийг бас хэлж өгөөч. Шүүгчийн ажлын ур чадвар, мэргэжлийн түвшинг үнэлэх, дүгнэх талаар одоо гомдол гаргах гэж байгаа тохиолдолд хүлээж авах бололцоо байна уу? Сахилгын хороо яг ийм журмаар одоо байгуулагдсан гэж би үзэж байгаа. Би Цогт шүүгчээс асууж байна. Яг одоо ийм.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Байнгын хорооны дарга Бямбацогт дарга хариулъя.

С.Бямбацогт: Шүүгчийн хараат бустай холбоотой асуудал бол олон жил яригдсан сүүлийн гучин жил үндсэндээ бас хэрэгжиж чадаагүй. Үүнтэй холбоотойгоор шүүхийг шударга биш байна, шүүгч нарыг хараат байна гэдэг шүүмжлэл нийгэм даяараа хавтгайрсан. Олон улсын үнэлэлт дүгнэлтээр ч гэсэн Монгол улс одоо тийм хараат бус байдлаараа зуун хорьд орж байна. Шүүх, шударга биш байдлаараа гэдэг бас үнэлгээ авдаг болсон. Үүнтэй холбоотой маш том зохицуулалтуудыг энэ шүүхийн тухай хуульд оруулж ирсэн. Засгийн газар ч оруулж ирсэн. Дээрээс нь ажлын хэсэг улам сайжруулсан. Үндсэн хуулийн дөчин есийн нэгд, шүүгч хараат бус

байж гагцхүү хуульд захирагдана гэсэн үндсэн заалттай зарчимтай. Энэ заалт маань амьдрал дээр хэрэгжиж байгаагүй. Энэ хуулиар бол одоо хэрэгждэг болно. Шүүхийн тухай хуулийн дөчин зургаа. Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх гээд. Энэ дээр тухайн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдэд нөлөөлөх гэж оролдсон бүх тохиолдлыг тэмдэглэн баталгаажуулна.

Шүүхийн тухай хуулийн далан тавдугаар зүйл шүүгчийн хараат бус байдлыг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах гээд. Ийм хоёр зүйлээр маш тодорхой шүүгчийг хараат бус ажиллах бололцоог бүрдүүлж өгсөн. Өнөөдөр шүүгчдэд зөвхөн одоо Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар нөлөөлдөг гэдгээс гадна олон нийт нийгмээс хүртэл нөлөөлдөг. Тодорхой хэмжээгээр тийм үү, одоо юу гэдэг юм. Мөнхбат гишүүн байнгын хороонд ярьж байсан юм. Байнгын хорооны хурал дээр. Зориуд захиалгаар урьдчилаад зориуд хүнийг гүтгээд гутаагаад доромжлоод гэмт хэрэгт холбогдуулчихдаг. Тэгчхээд түүнийг нь шүүх яах аргагүй одоо яллахгүй бол шийтгэхгүй бол шударга биш болчих гээд байдаг. Энэ хүртэл нөлөөллийг зохицуулах заалт орсон. Үүнтэй холбоотой бас холбогдох хуулиудад тодорхой зохицуулалтыг оруулах талаар Байнгын хороон дээр яригдсан. Хэрэв дэмжигдэх юм бол.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Ажлын хэсэг наян зургаадугаар микрофон асуултад хариулъя.

Ц.Цогт: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Саяын тэр нөлөөлөлтэй холбоотой асуудал дээр бол хоёр мянга арван гурван оны шүүгчийн ирсэн хуулийн тухай хуульд нөлөөллийн мэдүүлэг гэж ийм зохицуулалт орсон юм. Хөндлөнгийн этгээдүүд шүүгч рүү нөлөөлөх юм бол энийг одоо disclose хийдэг, ил гаргаж тавиад, тэгээд л шүүхийн ерөнхий зөвлөл энэний араас яваад тэр этгээдийг нь нөлөөлсөн этгээдийн зохих хариуцлагыг нь хүлээлгэх. Тэгээд энэ зохицуулалт маань дангаараа бас энэ долоо, найман жилийн хугацаанд олигтой үр дагавар гаргаж чадаагүй байхгүй юу. Тийм учраас энэ өргөн барьсан Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр сүүлд ажлын хэсэг ажиллаад энэ зарчмын зөрүүтэй саналаар далан тавдугаар зүйл дээр маш тодорхой зохицуулалт орж ирж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр хэрэв ер нь бол шүүх хэрэг маргаанаа шийдүүлсэн талууд заргаа алдсан тал бол гомдох хандлагатай байдаг. Энэ бол хүний натур байх. Тэр нь дотроо эрх мэдэлтэй, хөрөнгө чинээтэй, улс төр, бизнес нөлөөтэй хүмүүс бол зохих хэмжээгээр одоо хууль тогтоомж гаргах, зарлиг шийдвэр гаргах замаар бол шүүхэд таалагдаагүй шийдвэр гаргасан шүүгчээс хариуцлага нэхэх ийм хандлага бол байдаг. Өмнө нь гарч байсан.

Тэгэхээр энийг яаж одоо яг тухайлан шууд зохицуулах гэж байгаа вэ гэхээр далан тавдугаар зүйл дээр хэрэв ийм асуудал гарах юм бол шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг байгууллага өөрийнхөө Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж зохих одоо цэцэд юм уу, эсвэл тэр эрүү, иргэн, захиргааны бүх шүүхүүдэд нь хандах замаар явах, хамгаалах ийм үүргийг далан тав дээр маш тодорхой заагаад өгчихсөн байж байгаа юм. Тэгэхээр энд бол ахиц гарна гэж нэгдүгээрт найдаж байгаа. Хоёрдугаарт Ганбаатар гишүүний асуулт буюу тэр нөгөө сахилгын хороотой асуудал дээр ийм тайлбар байна. Шат шатны буюу гурван шатны шүүх байдгийн учир холбогдол бол ер нь бол мэргэжлийн алдааг хүний алдааг засаж залруулахын тулд бол дээд шатны шүүхэд байдаг. Тэгэхдээ энэ нь бол хэргийн оролцогчдын гаргасан гомдол дээр үндэслэдэг. Дээд шатны шүүх өөрөө санаачилгаараа шийддэггүй. Сахилгын асуудал. Хэрэв үнэхээр тэр ажил үүрэгтээ хариуцлагагүй, ёс зүйгүй сахилгагүй хандсан тохиолдолд сахилгын хорооны функц, Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн

дагуу бол одоо тодорхой орж ирж байгаа.

Т.Аюурсайхан: Ажлын хэсэг Энхбаяр Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Ганбаатар дарга их нарийн зүйлийг бас анзаарсан байна. Энэ дээд шатны шүүхүүд нь доод шатныхаа шүүгч нарыг мэргэжил, ур чадварын хувьд хангалтгүй, дутуу байна гээд мэргэжлийн хороо сахилга тооцуулах гэр өгдөг. Төслийн тавин наймдугаар заалт байсан. Энэ бол шууд өөрийнхөө барьцаанд хараат байдалд оруулдаг гол одоо байгаа ийм практик байгаад байгаа юм. Тэгээд энэ заалтыг ажлын хэсэг хасах санал оруулж байгаа юм. Бүхэлд нь хасаж байгаа. Тийм юм байхгүй, одоо тийм үзэмжээрээ хэрэг нөлөөлөх тийм юм бол байхгүй.

Хоёрдугаарт улс төрчдөөс яаж энэ ерөнхий зөвлөлийг хамгаалах талаар, энэ ерөнхий зөвлөл яаж ажиллах вэ гээд. Саналын томьёоллын тавин зургаадугаар зүйлд цоо шинэ концепт орж ирж байгаа юм. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдвал Үндсэн хуулийн цэцэд ерөнхий зөвлөл өгүүлэх талаар Улсын дээд шүүхэд хандана. Яагаад гэхээр Үндсэн хуулийн зааснаар ерөнхий зөвлөл шууд цэцэд гомдол гаргах тийм зохицуулалт Үндсэн хуульд байхгүй байгаад байгаа юм. Дээд шүүхээр дамжина. Эдгээр байгууллагууд мөн шүүхийн бие даасан байдалд халдсан шийдвэрүүд гаргавал мөн цэцэд хандаж хүчингүй болгуулах тийм процессыг бичсэн. Иргэд, байгууллагууд бас яах вэ? Бусад иргэд, байгууллагууд. Жишээлбэл улсын дээд шүүхийн шийдвэрийг бол хүчингүй гээд гаргаж байсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хурал хуралдаад шийдэж байсан тохиолдол байгаа шүү дээ манайд. Сумын иргэдийн хурал гаргаад хуралдаад Улсын дээд шүүхийн шийдвэр бол хүчингүй гэж.

Тэгэхээр ийм одоо бүр даварсан одоо үйлдэл гарах юм бол тэр хүмүүсийг нь одоо тэр эрүү нь байна уу, иргэн нь байна уу, захиргаа нь байна уу тэнд нь өгдөг ханддаг ажлыг одоо шүүхийн ерөнхий зөвлөл хийх юм. Шүүхийн ерөнхий зөвлөл одоо Үндсэн хуульд заасан тэр одоо шүүх бие даасан байдлыг хамгаалах талаар одоо ажиллаж эхэлнэ. Үүрэгжүүлж байгаа.

Т.Аюурсайхан: Ганбаатар гишүүн нэг минут тодруулъя асуултаа. Жамбалын Ганбаатар гишүүн микрофон өгье, асуултаа тодруулъя.

Ж.Ганбаатар: Баярлалаа. За хариулт авлаа, баярлалаа. Гэгэхдээ яах вэ бид нар чинь одоо нэгдүгээр хэлэлцүүлгээ хийж байгаа шүү дээ. Тэгээд хэлэлцэх эсэх дээрээ бол ерөнхий зүйлүүдийг их ярих боломжтой. Нэгдүгээр хэлэлцүүлэг дээр бол шууд одоо тухайлсан асуултуудыг асуудаг гэдгийг бас хариулж байгаа хүмүүс ч гэсэн асууж байгаа хүмүүс ч гэсэн одоо ойлгоорой гэдгийг бас хэлье. Би тэр шүүхийг шүүгчийг сонгон шалгаруулах талаар асуултад хариулт авч чадсангүй. Энэ дээр нэг тодорхой хариултыг өгөөч.

Хоёрдугаарт тэр сахилгын хороо зөвхөн шүүгчийн ёс зүйн асуудлаар л одоо асуудлыг хүлээж авдаг байсан бол одоо ур чадвар, ажлын ур чадвар, ажлын үр дүнгийн асуудлаар гаргаж байгаа шийдвэртэй нь холбоотой асуудлаар сахилгын хороо дээр гомдлыг авах боломжтой болж байна уу гэдгийг хариулж өгөөч. Тэгээд нэг минутад нэлээн багтахгүй юм байна л даа. Баярлалаа. Тодруулга хэллээ.

Т.Аюурсайхан: 80 дугаар микрофон дээр хариулъя ажлын хэсэг.

О.Мөнхсайхан: Ганбаатар гишүүн маш чухал асуулт асуулаа. Тэгээд Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйл дээр бол хуульчаас шүүгчийг шилж олох энэ ерөнхий зөвлөлийн гол функцийг нь зааж өгсөн. Тэгээд урьд өмнө нь бол энэ шилж олох ажлыг бол ерөнхий зөвлөл биш, мэргэжлийн хороо гэж Үндсэн хуулийн биш бүтэц рүү шилжүүлж ирсэн байдаг. Тэгэхээр ажлын хэсгийн саналаар бол энэ ерөнхий зөвлөл арван гишүүнтэй орон тооны ийм гишүүдтэй болж байгаа учраас энэ Үндсэн хуулийн чиг үүргээ маш сайн хэрэгжүүлж, мэдлэг чадвар, ёс зүйн хувьд хамгийн шилдэг тэр хуульчийг одоо шүүгчээр томилохоор сонгон шалгаруулалт тэр нарийвчилсан зохицуулалт орж өгсөн. Энэ дээр бол энэ шалгалтыг яаж авах вэ, сонгон шалгаруулалтыг яаж хийх вэ гэдгийг одоо урьд өмнөх хуулиуд байгаагүйгээр маш нарийн процессжуулж өгсөн. Ил тод болгосон, иргэдийн оролцоо, санал шүүмжийг авах ийм боломжийг олгосон. Энэ дотроо бол шалгалт хоёр түвшинд явагдана гэж ажлын хийхийн саналаар орж ирж байгаа юм. Нэгдүгээрт бол мэдлэг чадвар.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Баделхан гишүүн асуулт асууя.

Х.Баделхан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Нэг гурван асуулт байна. Ер нь жирийн амьдрал дээр бол ер нь шүүхийн талаар улсууд бол гурван асуудлыг үргэлж ярьдаг л даа. Нэгдүгээрт бол анхан шатны шүүх бол шүүхийн шийдвэр их өөрчлөгддөг. Одоо бүх хүмүүс бол энэ гурван шатны шүүх дээр гомдол гаргадаг. Тэгээд анхан шатны шүүхийн шийдвэр бол өөрчлөгддөг. Энэ мэдээллээр бол дээд шүүхэд очсон хэргийн тавин хувь нь бол өөрчлөгдөж байсан гэсэн тийм мэдээлэл байгаа юм байна. Тэгэхлээр энэ анхан шатны шүүхийг бол бэхжүүлмээр байна. Анхан шатны шүүхийн шийдвэр бол шийдвэр баймаар байна л даа. Тэгэхлээр цаашдаа ер нь ингээд иргэн болгон одоо гурван шатны шүүхээр ингээд гомдол гаргаад байх уу? Дээд шүүх хүртэл гэсэн нэг асуудал байна.

Хоёр дахь нь бол шүүгч ингээд гарсан шийдвэрийнхээ төлөө өөрөө хариуцлага хүлээх үү. Тухайлбал Монгол улсын нэрийн өмнөөс гэж шийдвэр гаргачаад тэр гаргасан шийдвэрээ дараа, дараагийн одоо шатны шүүхэд бол ингээд хүчингүй болгож байгаа. Тэгээд тэр шүүх бол ямар нэг хариуцлага хүлээхгүй гэсэн хоёр дахь асуудал байна.

Гурав дахь нь бол шүүхийн шийдвэр хэрэгжихгүй байна. Ялангуяа захиргааны хэргийн шүүх дээр бол шүүхийн шийдвэр хэрэгжихгүй байна. Захиргааны хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл арван хувьтай гэсэн мэдээлэл байна. Одоо энд энийг бол цаашдаа яах вэ. Тухайлбал одоо ажлыг буруу гаргасан, шийдвэр гаргасан хүн бол учирсан хохирлыг нь өөрөө төлөх ёстой тийм хуультай. Гэтэл өнөөдрийг хүртэл энэ хуулийн зардал бол хэрэгжихгүй байгаа. Өнөөдрийн байдлаар улсад хохирол учруулсан гурван тэрбум төгрөг бол төлөгдөхгүй байж байгаа юм байна. Энэ гурван асуудал дээр бол энэ хуулийн заалт дээр бол ямар өөрчлөлт оруулсан, орсон юм байна гэсэн асуулт байна. Баярлалаа.

Т.Аюурсайхан: Ажлын хэсэг Баттөмөр Энхбаяр гишүүн харуулъя. Ажлын хэсэг.

Б.Энхбаяр: Баделхан гишүүний асуултад хариулъя. Их чухал асуулт тавилаа. Үнэхээр одоо улсын дээд шүүх хүртлээ заргалддаг, цаг хугацаа авдаг энэ тохиолдлыг бол халахыг эрмэлзэж байгаа. Манайх шиг ийм гурван шатаараа эцсээ хүртэл явдаг ийм одоо шүүхтэй улс бол бас тогтолцоотой улс бол алга л байна. Одоо нэг тэр лүүгээ оръё гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл одоо анхан болон давж заалдах шатаараа яваад тэгээд ер нь дуусдаг байа. Тэгэхгүй бол ялангуяа энэ

иргэний чиглэлийн эд хөрөнгийн томоохон маргаанууд бол одоо Монголбанкны өгч байгаа судалгаагаар энэ өөрөө найдваргүй өр авлагын чиглэлийн барагдуулж, шүүхээр явахаар дөрөв аравны зургаан жил болж байна гээд байгаа юм. Тэгэхээр ийм их цаг авдаг, барсан, одоо шүүхийн удаан процесстой улсад одоо бас ямар хөрөнгө оруулалт хийх вэ, ямар одоо эрсдэлгүй байх вэ гэдэг асуудал бол байгаа.

Тийм учраас одоо улсын дээд шүүх бол нэн тодорхой хууль хэрэглээний нэгдмэл байдлыг л хангах хүрээнд хуулийн илт тодорхой заалтыг огт өөрөөр хэрэглэсэн хоёр өөрөөр, эсвэл одоо улсын дээд шүүхийн албан ёсны тайлбарыг буруу хэрэглэсэн, зөрчсөн, эсвэл одоо хууль хэрэглээний ноцтой алдаа гаргаад тэр нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн гэсэн ийм гурван үндэслэлээр л хэргийг одоо хянаж үздэг байя. Тэрнээс би бол өөр бусад үндэслэлээр бол хэргийг хянахгүй, тэндээ дуусдаг байх ёстой. Тэгэхгүй бол одоо манай иргэдийн дунд ч гэсэн байгууллагуудын дунд энэ анхан, давж заалдах шатны шүүхийг ер нь шүүх гэж ойлгохоо больчихож. Энэ ингэж л байдаг юм. Энэний хамгийн эцэст нь дээд шүүх дээр очиж байгаад л учраа олчихно гэдэг нэг ийм юм яваад байгаа юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл дээр олон асуудал байгаа. Үүний нэг нь шүүх бас шийдвэрээ нэн тодорхой үндэслэлтэй бас гаргаж байх ёстой гэдэг ийм шаардлагыг бид энэ хуульд тавьж байгаа юм. Өөрөөр хэлбэл, шийдвэрээ хаанаас барагдуулах вэ гэдэг.

Т.Аюурсайхан: Танхимаас Адьшаа гишүүн асуулт асууя.

Ш.Адьяа: Та бүгдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Шүүхийн хуулийг хэлэлцэж байгаатай холбогдуулан гурван асуулт асууя. Өнөөдөр энэ шүүх эрх мэдлийн бие даасан, хараат байдлын амин сүнс болсон Үндсэн хуулийн бүтцийн байгууллага болох шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн сахилгын хороо, хороог эдийн засгийн хараат байдал, боловсон хүчний хараат, боловсон хүчний бодлогын хараат байдалд оруулж, хууль тогтоох байгууллагын харьяанд шахуу авч ирсэн. Харьяанд шахуу авчирсан. Энд бол Улсын Их Хурал бүх төсөв хөрөнгийг нь баталж өгдөг. Тэр шүүгчдийг сонгон шалгаруулдаг, боловсон хүчний бодлогын дагнан явуулдаг энэ үйл ажиллагааг Улсын Их Хурал томилдог, сонгон шалгаруулдаг ийм тогтолцоог энэ хуулиар бий болгож байна л даа.

Тэгэхлээр энэ чинь үнэхээр тэр шүүхийн бие даасан хараат байдлаар ажиллана гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг зөрчиж байгаа. Энэ талаар нэг тайлбар сонсьё. Хоёр дахь асуулт, шүүхийн хуулийг бид маш их хурдан олон цагаар хэлэлцэж, ингэж баталсан. Ийм одоо шаардлага байсан байх, тэрнийг би үгүйсгэхгүй байгаа. Гэхдээ өнөөдөр Үндсэн хуулийн дараа орох туйлын ач холбогдолтой энэ хуулийг хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Адьшаа гишүүнд 1 минут нэмж өгье.

Ш.Адьяа: Мэдээллийн байгууллага, мэргэжлийн холбоо, мэргэжлийн байгууллагын санал дүгнэлт, эрдэмтэн судлаачдын санал, дүгнэлтийг авахгүйгээр яаран сандран баталлаа. Энэ ямар учиртай юм бэ гэдэг нэг асуултыг асууя. Дээр нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ хуулийн наян хувь нь бол өөрчлөгдсөн. Үзэл баримтлалын хувьд ингэж өөрчлөгдсөн хуулийг бид батлах гэж байгаа. Түрүүчийн Нямдорж сайдын бичсэн хууль бол арай сайн байсан гэж бодож байгаа. Гэтэл Энхбаяр бол өнөөдөр өөрийнхөө үзэл баримтлалаар, улс төрийн шийдвэр

гэдгээр энийг энэ Үндсэн хуулийн зөрчилд хамааруулах ийм олон заалтыг оруулж ирж хүчээр батлуулсан шүү. Энэ талаар бас тайлбар сонсьё.

Т.Аюурсайхан: Байнгын хороо Бямбацогт дарга хариулья.

С.Бямбацогт: Улсын Их Хурал Үндсэн хуульд заасан, ер нь бол Үндсэн хууль чинь бас шүүх, гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдлийг хуваарилчихсан байгаа. Улсын Их Хурал бол Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн нэг дээр Монгол Улсын Их Хурал хорьдугаар зүйл Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэж байгаа. Улсын Их Хурлын хорин гуравдугаар зүйл, Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхлэн баримтална гээд. Улсын Их Хурлын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйл дээр Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах одоо онцгой бүрэн эрхийг эдэлнэ гээд ингээд заачихсан. Энэ дотор хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах гэх мэтийн.

Энэ хүрээндээ Улсын Их Хурал хууль баталж байгаа. Улсын Их Хурлаас өөр хэн нэгэн одоо субъект хууль батлахгүй. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар шүүхийн тухай хуулийг санаачилсан. Шүүхийн тухай хуулийг Улсын Их Хурал ажлын хэсэг байгуулаад хэлэлцсэн. Хэлэлцэхдээ хоёр мянга хорин оны дөрвөн сард өргөн барьсан хуулийг сая Тогтохсүрэн гишүүн хэлсэн. Гурав дөрвөн чуулган дамжуулаад хоёр парламент дамжуулаад өмнөх Их Хурал, одоогийн Их Хурал ингээд хэлэлцэж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс саналыг авсан. Ерөнхийлөгчид танилцуулсан. Ардчилсан намын бүлэг дээр бас шүүхийн тухай хууль, ажлын хэсэгт танилцуулсан. Ардчилсан намын бүлгийн хүсэлтээр он дамжуулж бүтэн одоо сар гаруйн хугацаанд завсарлага авсан. Ингэж байж тийм үү харьцангуй одоо юу гэдэг юм маш одоо удаан хугацаанд хэлэлцэж, олон нийтийн санал бодлыг авч энэ хууль маань хэлэлцэгдэн батлагдах гэж байна.

Засгийн газар хууль санаачилсан. Хууль санаачлах, хуулийн төслөө үзэл баримтлалын хувьд өөрчлөгдлөө гэж татахгүй бол Их Хурал буцаах эрхгүй.

Т.Аюурсайхан: Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Адьшаа гишүүн бол манай ажлын хэсгийн гишүүн. Тэгээд ажлын хэсэг дээр одоо асуудлаа яриад явах юм боломжтой. Их цөөхөн ирсэн л дээ. Тэгээд л хэлэлцүүлэхгүй байна гээд л ярьдаг юм. Хоёр сар одоо ажлын хэсэг хуралдаад л явж байхад их өөрөө цөөхөн ирсэн. Хэлэлцээд байгаа шүү дээ уг нь. Өөрөө ажлын хэсгийн гишүүн. Хоёрдугаарт энэ хар хүний өмнөөс шар хүн гэж, одоо хэнээс эрх мэдэл булаах гээд байгаад л нэг ийм гомдоод ч байгаа юм уу ингээд л яваад байгаа юм. Шүүхийн ерөнхий зөвлөл, сахилгын хорооны одоо бүрэлдэхүүнийг одоо бүгдийг нь Ерөнхийлөгч томилж байгаа. Шүүгчдийг томилж байгаа. Ганцхан даргатай болчихсон. Хэн дор эрх мэдэл байна, түүн дор хилэнц бий гэж нөгөө Шопенхауэрийн хэлсэн үг байдаг шүү дээ.

Хэт их эрх мэдлийг өгөхөөр чинь энэ чинь ялзарч байна шүү дээ. Ямар ч сайн хүн байсан. Тэгээд эндээс нь эрх мэдлээ төвлөрсөн эрх биднийг нь задалъя гэж байгаа юм. Тэгээд задалъя гэхээр тодорхой Их Хурал зарим хүнийг нь нээлттэй сонгон шалгаруулалтаар томилъё гэхээр энд л одоо бачимдаад л яваад байгаа юм. Тэгээд өөрт нь ямар хувилбар байна вэ гэхээр одоо одоо байгаагаар нь байлгах гээд л байгаа юм шиг байгаа юм. Тэгээд одоо байгаад болохгүй байгаа учраас өөрчлөх

гээд байгаа шүү дээ, энэ шүүхийн реформыг. Эсвэл одоо тэр Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын ажлаа хийх хэрэгтэй шүү дээ. Нэг хүний төлөөлөл болж энд орж ирсэн юм уу. Нийт ард түмний төлөөлөл болж орж ирсэн юм уу.

Т.Аюурсайхан: Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: За гурван минутаар нэг мөсөн авчихъя даргаа. Шүүхийг шударга болгох ёстой гэдэгтэй бол санал бол нэг байна. Тэр шударга бус шүүх гэж байдаг бол тэрнийх нь одоо золиос болсон амьд жишээ нь би л дээ. Гэхдээ одоо бас нийт одоо шүүгчид бас тийм гэж бас боддоггүй. Хоёр, гурван асуулт байна. Шүүгчдийн нийгмийн хамгаалалтай холбоотой, цалин хөлстэй холбоотой, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой, ээлжийн амралтын хугацаатай тэр холбоотой асуудлыг зохицуулахдаа энэ харилцааг зохицуулсан суурь хуулиудаараа асуудлыг шийддэг одоо баймаар байгаа юм. Тэгэхгүй манайх ингээд л хууль хүчний байгууллагуудын хууль ярихлаар бүгдийг нь одоо ингээд төрийн албанаас, нийгмийн даатгалаас нь ингээд салгаж аваад тухайн хуульд нь хийгээд ингээд тухайн суурь одоо хуулийнхаа харилцаануудыг дордуулаад одоо байгаа юм. Энийг одоо бас анхаармаар байгаа юм Энхбаяр гишүүнээ.

Хоёр дахь асуудал нь зарим одоо асуудлыг нь би бас хүрсэн түвшнээс нь дордуулчихсан байна гэж бол үзэх гээд байна. Шүүгчдэд дөрвөн төрлийн нэмэгдэл олгодог байсан юм. Энэ нэмэгдлийг нь байхгүй болоод ганцхан одоо хоёр хувийн цалинг нь одоо нэмэгдүүлж байна гэсэн заалтууд оруулж ирж байгаа юм. Энэ бол шүүгчдийн цалин хөлсийг дордуулсан заалт болж байна гэж бол би бол үзэж байгаа. Та юу гэж үзэж байгаа юм.

Хоёрдугаарт шүүгч бол төрийн албан хаагч л даа. Төрийн албаны тухай хуулиараа төрийн албаны хаагчийн дээд одоо насны хязгаар жаран тав байна гэсэн. Одоо оруулж ирж байгаа саналаар чинь жар гэж байгаа юм байна. Энэ чинь бас Төрийн албаныхаа хуулийг төрийн албан хаагчдынхаа нөхцөлийг бас дордуулсан зүйл заалт бол болчих гээд байгаа юм биш үү. Энийг бас ажлын хэсэг юу гэж үзэж байгаа юм? Хоёр дахь асуудал нь сахилгын хороо гэсэн Үндсэн хуулийн байгууллагатай бол болж байгаа. Сахилгын хороо шүүгчдэд мэргэжлийн, одоо алдаа гаргасан бол хариуцлага тооцдог болох нь. Мэргэжлийн алдаа гаргасан гэдгийг нь сахилгын хороо яаж одоо тооцож тогтоох юм бэ. Хэрэв сахилгын хороо мэргэжлийн алдаа гаргасан байна гэдгийг нь тогтоох юм бол өөрөө шүүх хуралдааны материалтай танилцдаг, хэргийн материалтай танилцдаг, сахилгын хороо ч ер нь цаашдаа өөрөө шүүх одоо болж бол хувирчих юм биш үү? Би бол бас шүүх шүүх хуралдааныг явуулахдаа мэтгэлцээний зарчмаар явуулдаг. Шүүх тухайн хэргийг хянахдаа хууль тогтоомжид нийцүүлэн өөрийнхөө итгэл одоо үнэмшлээрээ шийдвэр гаргадаг гэж бол ойлгодог. Тэгэхээр энэ одоо ингээд мэргэжлийн алдаа гаргасан байна. Нөгөө сахилгын шийтгэл оногдуулаад сахилгын хороо эхлэх юм бол энэ шүүгч чинь итгэл үнэмшлээр асуудалд хандах асуудал, мэтгэлцээний зарчмаар одоо шүүх хуралдаан явагдах энэ одоо зарчмууд чинь алдагдчих юм биш үү гэсэн ийм бас одоо болгоомжлол байгаа юм. Ажлын хэсэг одоо юу гэж үзэж байна вэ?

Дараагийн нэг асуудал нь сахилгын хорооны шийдвэр эцсийн шийдвэр байна гэсэн заалт явж байсан. Энэ өөчлөгдсөн үү, үгүй юу. Хэрэв ингээд эцсийн шийдвэр гэх юм бол хүн иргэн бүр гэм буруутайгаа шүүхээр тогтоолгоно гэсэн Үндсэн хуулийн одоо заалт одоо бас зөрчигдөхгүй юу гэсэн ийм хэдэн одоо асуултад асуултад хариулт авъя.

Т.Аюурсайхан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Энэ шүүхийн шүүгчийн, ер нь энэ мэргэжил, энэ хариуцлагыг дээшлүүлэх хүрээнд Монгол Улсын Үндсэн хуульд өнгөрсөн онд орсон өөрчлөлт бол энэ хариуцлагыг чангатгах чиглэлд бол гол анхаарсан юм байна лээ. Тийм ч учраас сахилгын хороо гэдэг энэ бүтцийг Үндсэн хуулийн байгууллага болгож одоо баталжээ. Чинзориг гишүүн маань ч гэсэн яг энэ баталчихсан гишүүн. Тэгэхээр энэ бол нэг хороо гэдэг нэртэй боловч энэ бол нэг бодлын бас мэргэжил, ур чадвар тэр нөгөө сахилгын шүүх хашилт дотор хэлж байгаа шүү би. Ийм ойлголт байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл шүүгчид тавьж байгаа тэр одоо мэргэжил, ур чадварт нь тавьж байгаа ийм бас хашилт дотор хэлж байгаа шүүх байхгүй юу. Хороо гэдэг нэртэй. Жишээлбэл цэц бол нэг бодлын Үндсэн хуулийн шүүх шүү дээ. Энэ чинь цэц гэдэг нэртэй шүүх байхгүй юу. Үндсэн хуулийн шүүх. Тэр утгаараа энэ шүүх энэ хорооных нь шийдвэр нь эцсийн одоо байхаар. Өөрөөр хэлбэл нэгэнт Үндсэн хуулийн байгууллага болж байгаа учраас агуулга байсан. Тэгэхдээ ажлын хэсгийн явцад бол одоо энэ тодорхой бас процессын алдаа гаргавал улсын дээд шүүх бас энэ сахилгын хорооны шийдвэрийг авч үзэж хянахаар ийм одоо саналыг бас одоо оруулж ирж байгаа.

Ер нь бол одоо энэ мэргэжлийн хороо гэдэг байгууллага гэх үү, одоо бүтэцгүй энэ Үндсэн хуульд ч байхгүй. Нэг ийм юм байх ёстой гээд энэ манай дээд шүүхийнхэн их ярьдаг юм. Тэгээд энүүгээрээ хариуцлага хүлээж байгаа нь тун бага. Одоо энэ сахилгын хороо гэдэг Үндсэн хуулийн байгууллагыг одоо Улсын Их Хурал байгуулчихсан чинь энэ сахилгын хорооны хяналтад орохгүй гээд л ерөөсөө бүр айж ичээд л зугтчих гээд байгаа. Тийм их нүгэл үйлдчихсэн хүмүүс юм уу, тийм их нүгэл үйлддэг хүмүүс юм уу. Би бол мэдэхгүй. Тэгээд ингээд байгаа юм. Хууль хүчний байгууллага гэж яах вэ энэ Чинзориг гишүүний нэг зарчмын чухал асуудал хөндөөд байгаа юм. Энэ ер нь энэ шүүгчийн одоо нэмэгдэл цалинтай холбоотой асуудлыг энэ гэж. Би бол нэг ийм юм ойлгодог юм. Шүүгчийг би битгий энэ хууль хүчний байгууллага гэдэгт оруулж авч үзэж байгаач. Энэ их буруу практик. Шүүх бол шударга ёсны манаач. Энийг битгий тэр зүгээр тушаал гүйцэтгэдэг хүмүүстэй ингэж тэр хүмүүсийн цалинтай харьцуулж, одоо ингэж ярьдаг, яримааргүй байгаад байгаа юм.

Энэ чинь Үндсэн хуулийн институт байгаад байгаа юм. Манаач байгаад байгаа юм. Шударга ёсыг тогтоодог. Тэр ч утгаараа энэ цалин хангамжийнх нь асуудлыг тусад нь авч үзэж бас ярьдаг, салгадаг ийм баймаар байгаа юм. Яах вэ, төсөлд сая Чинзориг гишүүн бас асууж байна. Шүүгчийн зэрэг дэв гэдэг хэсгийг хасах санал одоо ажлын хэсэг оруулж байгаа юм. Яагаад гэхээр шүүгчдийг дотор нь ингэж эрэмбэлж болохгүй. Чи ахлах түшмэлийн, чи дэс түшмэлийн, чи гутгаар түшмэлийн гэж ингэж шүүгчийг эрэмбэлэх нь өөрөө бас тэр дотор нь эрэмбийг алдагдуулах ийм аюултай.

Т.Аюурсайхан: Ажлын дээд хэсэгт микрофон өгье. Тамгын газрын микрофон. Лүндээжанцан зөвлөх.

Д.Лүндээжанцан: Энэ юуны Байнгын хороо болон ажлын хэсэг дээр хэлэлцэх явцад алийг нь мэргэжлийн алдаа гэж үзэх юм бэ, аль зөрчлийг бол одоо сахилгын зөрчил гэж үзэх юм бэ гэдгийг бол ялгаж зааглах асуудал бол маш төвөгтэй юм байна лээ. Тэгж байгаад бол гарцаагүй мэргэжлийн алдааг байнга л гаргаад байна гэж үзэж болохгүй. Үнэхээр одоо энэ бол сахилгын зөрчил байхаас аргагүй. Зарим зүйлийг нь бол хоёр зүйлийг бол тэр сахилгын зөрчилд хамааруулсан. Хууль зүйн

байнгын хорооны гишүүд бол энэ дээр олон талаас нь ул суурьтай ярина лээ. Тухайлбал тавин хоёрын нэгийн хорин гурав дээр хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах гэж.

Тэгэхээр хуулийн илт тодорхой заалтыг ноцтой зөрчсөн гэж. Энэ бол ноцтой. Зөрчсөн үед нь л энийг бол мэргэжлийн алдаа гэж хэлж болохгүй. Ийм ноцтой зөрчил заримдаа гаргачихдаг юм байна л даа. Ганцхан торгох заалт ялтай ийм зүйл дээр хорих ял нэг жилээр хорих ял оноосугай гээд заачихсаныг чинь ямар мэргэжлийн алдаа гаргалаа гэлтэй биш. Энэ бол сахилгын зөрчил болж байгаа юм гэж ингэж ийм тайлбарууд яригдаад орсон. Тавин хоёрын нэгийн хорин долоо дээр бол шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон гэдэг зүйл орсон. Үгүй ээ, энэ чинь хүнийг шийдэхдээ, шийдвэр гаргахдаа энэ чинь ямар ч байсан үндэслэл заах ёстой биз дээ. Бүгдийг заахгүй юмаа гэхэд энэ огт бичээгүй нь тав, зургаан үндэслэл байлаа гэхэд бол нэг хоёр гурвыг нь бичээд нэг, хоёр, гурав нь үлдчихсэн байлаа гэвэл за энэ дутуу дулимаг болжээ, мэргэжлийн алдаа гаргажээ гэж үзэж болох юм. Гэтэл огт бичээгүй шууд тэрийг иш мухаргүй хариуцлага ногдуулчихсан байхад энийг бол мэргэжлийн алдаа гаргажээ гэж үзэх аргагүй юм. Тэр нь бас дээд шатныхаа шүүхээр тогтоогдсон байвал сахилга.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Арван гурван цаг болсон байна. Зарчмын зөрүүтэй далан хоёр хуудас ийм саналууд байгаа. Хэлэлцэх асуудал маш их байгаа учраас цагаа бүрэн ашиглахын тулд үдийн завсарлагагүй явчих уу гишүүдээ. Гишүүдийн саналаар үдийн завсарлагагүй явъя. Цахимаар Чинзориг гишүүн асуулт асууж хариулт авлаа. Одоо танхимаас Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Өнөөдөр шүүхийн тухай хуулийг хэлэлцэж байна. Энэний ард одоо ямар зүйл явж байгаа юм бэ гэдгийг бас хэлье гэж бодож байна. Хоёр мянга арван зургаан оноос хойш Ардчилсан нам арчаагүй байсныхаа үр дүнд Улсын Их Хурлын сонгуульд Монгол Ардын намд хэт олонхыг алдсан. Үүнээс хойш одоо Монгол Ардын нам дураараа дургих нь бол хэрээс хэтэрч байгаа. Хууль тогтоох байгууллагын одоо Улсын Их Хуралд олонх болсон. Бүх эрх мэдэл тэр цагаан байранд нь оччихсон байгаа. Гүйцэтгэх засаглалыг зуун хувь хэмнэж байна. Цагаан байрандаа асуудлаа ярьж байна. Шүүхийн тухай хуулиар шүүхийн ерөнхий зөвлөл сахилгын зөвлөлд хяналт тавих замаар шүүх эрх мэдлийг цагаан байрандаа аваачиж байна. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулиар орон нутгийн эрх мэдлийг цагаан байрандаа авчирч, дээрээсээ томилдог болгож байгаа, босоо тогтолцоотой болгож байгаа. Олон яамдын орон нутагт байдаг албан тушаалыг яамнаас нь шууд томилдог. Ийм босоо тогтолцоотой болж тэр цагаан байрандаа хэнийг томилохоо ярьдаг болсон.

Албан бусаар дөрөв дэх засаглал гэж яригддаг хэвлэлийнхэн хамгийн их мөнгөтэй цагаан байр луу гүйдэг болсон. Цөөнхийн үгийг дамжуулахаа больсон. Монгол Улсын Ерөнхий сайд чөлөөт зах зээл гэж байхгүй гэж олон нийтийн өмнө амаараа мэдэгдсэн. Хууль зүйн сайд Нямбаатар нь иргэний үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хааж боох хорих ийм хуулийн төсөл дээр саналаа аваад явж байгаа. Өнөөдөр шүүх үг хэлсэн, энэ Ардын намын эсрэг ярьсан тэр хүн болгоныг энэ өөрийнхөө харьяанд байдаг шүүхээр аваачиж хорино. Өнөөдөр нэг хүн үг хэлж байж магадгүй, маргааш нь тэрийг хорилоо гэхэд хүмүүс хамгаалахгүй ээ. Ийм л.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Нэг минут Пүрэвдорж гишүүнд нэмж өгье.

Б.Пүрэвдорж: Ийм коммунизм байгуулах, социализм байгуулах ийм зүйл рүүгээ өнөөдөр Монгол Ардын нам гүн гүнзгий орчихлоо. Энэ нөхцөл байдалд Монголын ард түмэн бас дүгнэлт хийх хэрэгтэй. Ардчилсан нам дүгнэлт хийх хэрэгтэй. Энэ зүйл дээр хатуу байр сууриа эсрэгээр эсэргүүцэж илэрхийлэх ёстой. Бид нар энэ азийн цээжин дээр ардчилсан Монгол улс гэж өнөөдөр хамгийн их зарладаг Монгол ардын нам өнөөдөр коммунизмын бүх бүтэц зохион байгуулалтыг хийж явж байна. Энэний эсрэг тэмцэх хэрэгтэй. Үнэндээ энэ нэг хэдхэн ардчилсан намын цөөнх гэсэн хэдхэн хүн одоо үг хэлээд болохгүй байна. Хэвлэлийнхэн ард иргэд энэ одоо Монгол ардын намынхны хийж байгаа энэ үйлдлийн эсрэг одоо босох цаг болсон гэдгийг хэлмээр байна.

Т.Аюурсайхан: Байнгын хороо Бямбацогт дарга.

С.Бямбацогт: Пүрэвдорж энэ асуултад хариулъя. Өөлөх юм бол өндөг ч өөтэй, өндөг ч өөтэй. Тийм болохоор бас сөрөг хүчин маань цөөнх маань шүүмжилж байгаа шүүмжлэлийг нэг талаасаа хөндөж хүлээж авна. Гэхдээ бас нөгөө хамар дор хагархай байна гээд хэтэрхий бас хаа хамаагүй бас шүүмжилмээргүй байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид нар, Монголын бүх улс төрийн хүчин оролцсон. Хоёр жил гаруй ард түмнээр хэлэлцүүлсэн. Хорин жилийн хугацаанд тав, дөрөв, таван парламент дамжиж ярьж байж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд энэ шүүхийг тийм үү, хуульд захирагдах шүүгчийг хараат бус байх, шударга ёсыг тогтоох энэ өөрчлөлтийг хийсэн. Хүний эрхийн шударга шүүхээр эрхээ хангуулах хүний эрхийн баталгааг хангахын тулд энэ шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж оруулж ирж байгаа. Бусдаар одоо хэн нэгэн эрх мэдлийг авах гээд тэр цагаан байрны асуудлыг шийдэх гээд орж ирж байгаа юм биш.

Түрүүн би хэлсэн шүү дээ. Энэ шүүхийн тухай хуулийн дөчин зургаадугаар зүйл. Далан тавдугаар зүйл. Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндсэн хуульд сахилгын хороо гээд. Хараат бус ажиллах хэн нэгнээс тийм үү хамааралгүй байх энэ зохицуулалтыг бүгдийг нь энэ хуульд анх удаа оруулж ирж байгаа юм. Урьд нь ийм зохицуулалт байхгүй байсан учраас хараат болчихдог. Шударга биш шийдвэр гаргадаг, хэн нэгний нөлөөнд автдаг байсан. Одоо тэгвэл энэ хуулиараа нэг талаасаа хараат бусаар ажиллана. Нөгөө талаасаа хариуцлагатай ажиллана. Хариуцлага алдах юм бол, шударга биш байх юм бол хариуцлагаа хүлээдэг байх энэ зохицуулалт орж ирж байгаа юм. Ийм л зохицуулалт орж ирж байгаа юм. Энгийг бас гишүүд, нийт бас Монголын ард түмэн бас ойлгох хэрэгтэй байгаа юм.

Тэгэхгүй одоо сөрөг хүчин маань ерөөсөө л болохгүй байна, бүтэхгүй байна гээд л яриад байвал сайн юм байна гэдэг талаар бас битгий яриач. Зөв юмыг нь зөв байна, буруу юм нь буруу байна. Энэ дээрээ тийм үү, сайн болж, энэ дээрээ муу болж, энэ дээрээ анхаарчихвал яасан юм бэ гэдэг байдлаар л асуудал хандмаар байна л даа. Тэгэхгүй ерөөсөө л хавтгайд нь харлуулаад л. Уул бол одоо хойд зүгийн хар овоохой гээд л одоо юу гэдэг юм олонхоо бас битгий шүүмжилж хандаач. Энэ дээр бас нэг жоохон авах гээхийн ухаанаар бас нэг жоохон ажил хэрэгч байхыг хүсэн цөөнхөөсөө бас хүсье. Тэгээд өөлөх юм бол өндөг ч бас өөтэй шүү. Пүрэвдорж гишүүнээ.

Т.Аюурсайхан: Энхтүвшин гэсэн асуулт асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Тэгээд энэ шүүхийг шударга байлгах, нээлттэй байлгах энэ зарчмыг бол үндсэндээ бол дэмжиж байна. Тэгээд нэг хоёр асуулт л асууя.

Нэгдүгээр асуулт энэ шүүгчийн туслахтай холбоотой асууд асуудлууд бас энэ нийгэмд бас нэлээн асуудал болж байх шиг байна. Шүүгчийн туслах нь шүүгчийн одоо туслах нь эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан ийм хүн одоо туслагч одоо шүүгчийн туслах байна гэж ингэж заасан байна. Яг өнөөдрийн байдлаар одоо шүүхийн одоо туслах хийж байгаа хүмүүс маань ихэвчлэн эрх зүйн одоо бакалавр боловсролтой, шүүгчийн одоо мэргэжлийн, одоо тэр хуульчийн одоо сонгон шалгаруулалтад ороогүй ийм хүмүүс одоо ажилладаг юм байна. Тэгээд цаашлаад одоо хуульчийн сонгонд орсон, энэ мэргэжлийн одоо үнэмлэхтэй хүн ажиллана гэх юм бол энэ шүүхийн одоо туслагчаар ажиллах хүн олдох юм уу. Одоо энэ ажиллаж байгаа хүмүүс чинь бүгд одоо ажилгүй болчих юм биш үү гэсэн ийм одоо бас эргэлзээ төрж байна. Тийм учраас энэ дээр одоо нэг хариулт хэлж өгөөч гээд.

Хоёр дахь асуудал бол энэ шүүхийн энэ шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаан дээр бас нэлээн тодорхой заалтууд энэ хууль дээр орсон юм болов уу гэж бодож байна. Яагаад гэхээр энэ иргэний хэрэг дээр гарч байгаа шийдвэрүүд бол одоо эд хөрөнгийн маргаантай холбоотой. Мөнгөтэй холбоотой маш олон ийм шүүхийн шийдвэрүүд гардаг. Шүүх шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаан дээр очоод энэ маань хэрэгждэггүй, маш олон жилээр ингэж явдаг. Тийм учраас энэ дээр одоо бас тодорхой хэмжээний ахицтай, ийм заалт одоо орсон уу гэдгийг бас асуумаар байна.

Гурав дахь асуудал болохоор энэ хуулийн зуун гурав, зуун дөрөв дээр одоо гомдол мэдээлэлд заасан үндэслэлээр үндэслэлээр хязгаарлахгүйгээр сахилгын хороо өөрийн санаачилгаараа хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохоор одоо заасан байна. Тийм учраас юу гэдэг юм, иргэдийн гомдол гэхгүйгээр одоо юу гэдэг юм энэ сахилгын хороо шүүгчийг одоо хардах ч гэдэг юм уу, өө сэв хайх ч гэдэг юм уу энэ тохиолдолд бас энэ одоо хэрэг үүсгээд, бас энэ үйл ажиллагааг нь бас хэн шалгах ийм одоо бололцоо боломжийг нь нээж өгсөн юм байна. Энэ бол одоо бас хэр зохимжтой заалт юм бэ?

Т.Аюурсайхан: Ажлын хэсэг хэддүгээр микрофон байна. Наян тав, наян долоо юу, наян долоодугаар микрофон өгчих.

П.Сайнзориг: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Эхний асуудал шүүгчийн туслахтай холбоотой хуулийн төслийн ерэн дөрөвдүгээр заалт дээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэх зөвшөөрөл авсан байхаар нэмэлтээр орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол өнөөдөр шүүхийн захиргааны одоо ажилтнууд, шүүгч, шүүхийн нарийн бичиг, шүүгчийн туслах хоёрыг яг ижил статустай авч үзсэнээр болоод яг энэ шүүхийн бас ачааллын тодорхой хэсэг нь энэ шүүгчид бас одоо тодорхой, одоо туслалцаа үзүүлдэг, дэмжлэг үзүүлж ажилладаг ажилтнууд нь эрх зүйн байдал нь бас тодорхойгүй болчихоод байгаа. Үүнийг шийдэж одоо та эрх, хуульч байх шаардлагыг тавьж байгаа. Тэгэхдээ өнөөдрийн бас энэ ажиллаж байгаа нөхцөл байдлууд дээр харгалзаж, яг энэ заалтыг бас дагаж мөрдөх хугацааны асуудал дээр нь бас уян хатан хандаад хоёр жилийн хугацаанд одоогийн ажиллаж байгаа, одоо шүүгчээр ажиллаж байгаа, туслахаар ажиллаж байгаа энэ залуучуудыг шүүгчийн хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу шалгалтаа өгөх бололцоог нь бол олгож байгаа. Яг юу юугүй бас одоо юу гэдэг юм, энэ шаардлагын дагуу ажилгүй болох гэдэг юм уу, эсвэл энэ хөдөө орон нутгууд дээр туслахын асуудал бас ховордчих вий, олдохгүй байх вэ гэдэг асуудал бол байхгүй гэдэг зүйлийг хэлж байгаа. Цаашдаа бас ингэснээрээ энэ шүүгчийн туслахаар ажиллаж байгаад бас энэ шүүгчийн сонгон шалгаруулалтад орох эрх нь бас нээгдэх ийм давуу талтай байж байгаа юм.

Шүүхийн шийдвэртэй холбоотойгоор бас ер нь бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон шүүхийн энэ шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулалт болоод хууль эрх зүйн орчныг нь илүү их боловсронгуй болгоё гэдэг дээр бол санал нэг байгаа. Ер нь бол маш олон асуудлууд байгаа энэ дээр. Бид хэд бас иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг биелүүлэхийн тулд нэн түрүүнд бас энэ дампуурлын хууль эрх зүйн орчноо шийдэхгүй бол үнэхээр одоо төлбөрийн чадваргүй болчихсон хуулийн этгээдээр л одоо шүүхийн шийдвэрүүд бол гараад л яваад байдаг. Энэ нь угаасаа биелэгдэх боломжгүй байгаа. Түрүүн бас ажлын хэсгийн ахлагч хэлж байсан. Цаашдаа энэ шүүхийн шийдвэрийг илүү их тодорхой болгож яг тухайн хариуцагчийн ямар хөрөнгөнөөс гаргах вэ гэдэг асуудлыг бас илүү их тодорхой шийдвэртэй заадаг болно. Мөн нөгөөтээгүүр бас ер нь бас Засгийн газраас бас хоёр.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Ажлын хэсэг нэмж хариулъя наядугаар микрофон дээр.

О.Мөнхсайхан: Энхтүвшин гишүүнд баярлалаа. Чухал асуулт асуулаа. Хоёр дахь асуултад хариулъя. Тэгэхээр Засгийн газрын өргөн барьсан төслийн суурь үзэл баримтлал заалтаар бол шүүхийн сахилгын хороо зөвхөн иргэний өргөдөл мэдээллээр одоо шүүх сахилгын зөрчил гаргасан эсэхийг хянан шийдвэрлэх тэр зарчим бол хэвээрээ хадгалагдаж байгаа. Бас энэ өргөн барьсан төсөл дотор бол юу вэ гэхээр тэр ирсэн өргөдөл мэдээллийг шалгаад явж байтал тэнд дурдагдаагүй илүү ноцтой ийм одоо зөрчил гараад ирэх юм бол тэрийг цаашаа үргэлжлүүлж шалгана гэдэг ийм заалт бол зуун тавын дөрөвдүгээр дөрөв дээр байж байгаа юм. Тэгэхээр энэ бол өөрөө одоо сахилгын хороо өөрөө санаачилгаараа ингээд одоо энд тэнд явж байгаа мэдээллийг аваад шалгаад байна гэсэн утга ерөөсөө байхгүй.

Тэгээд энэ Монголд гарч байсан кэйс дээр тулгуурлаж бий болсон юм. Өөрөөр хэлбэл нэг шүүгчийн одоо эдийн засгийн ашиг сонирхолтой холбоотой ийм гомдол эрхийг шалгахад, бүр ноцтой зүйл гарч ирээд тухайн үед хуульд ийм зохицуулалт байхгүй учраас ямар ч хариуцлага хүлээгээгүй өнгөрч байсан. Бусад улсад бол яг ийм зүйл дээр бол бас шалгаад шүүхийнхээ шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хамгаалаад явдаг ийм одоо агуулгаар бол энэ заалт орж ирсэн, явж байгаа. Олон улсын туршлага бол бүр иргэн гомдол, мэдээлэл гаргаагүй байхад өөрөө шалгаж хөөж одоо явдаг ийм жишиг байдаг. Тэгэхдээ энэ удаагийн төсөлд бол бас энэ одоо гишүүний хэлж байгаа шиг болгоомжлолоос болоод иргэн хандаагүй байхад бол сахилгын хороо ажиллахгүй. Зөвхөн хандсан тохиолдолд тэрийг бүрэн шалгаад, тэрэнтэй холбоотой гарч ирсэн дараагийн үйл баримт байх юм бол тэрэн дээр сахилгын хэрэг тусгайлан үүсгээд, цаашаа шалгаад нягтлаад мухарлаад явна гэдэг энэ дундын ийм хувилбараар тэгээд өмнө нь гарч байсан энэ одоо буруу тэр жишгийг зассан ийм зохицуулалт Засгийн газрын төсөлд орж ирсэн. Энэ хэвээрээ байгаа. Энэ заалт байснаараа бол цаашдаа одоо энэ сахилгын хороо юм юм руу.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Ерөнхийдөө бол шинэ жилийн өмнө энэ хуулийг батлах гэж явуулах гэж нэлээн оролдсон л доо. Тэгэхээр Ардчилсан намын бүлэг бол одоо ард түмэн шүүмжилдэг. Баярын өмнө ийм хууль батлаад явах нь буруу энэ тэр гэж ярьдаг. Энэ байдлаас бол одоо Ардчилсан намын бүлэг бол аварч чадлаа. Тэгээд энэ хуулийг нэлээн нягт нямбай сайхан хэлэлцээд явах боломжийг нь бүрдүүлж чадлаа гэж үзэж байна. Тэгээд одоо гадаа байгаа нөхцөл байдал энэ зүйлүүдээс болоод их олон юм

ил болж байна. Энэ Ардын нам яаж ялзарсан, энэ улс орон ямар байдалтай байгаа, энэ эрүүл мэндийн тогтолцоо яаж унасан, авлига албан тушаалын хэрэг яаж цэцэглэж байгаа энэ бүгд одоо ард түмэнд ил боллоо.

Монголын нийгэм бол өнөөдөр тэсрэхэд бэлэн болчихсон дарьтай торох шиг л байна. Гурван хүний нэг ядуу байсан бол одоо хоёр хүний нэг нь ядуу, ажилгүй, орлогогүй, олон мянган аж ахуйн нэгжүүд хаалгаа барьж байна. За тэгээд арай гэрэл гэгээтэй юм бол энэ шүүхийг шударга болгох гэж байна гэсэн ийм зүйл яригдаж байгаа. Энд иргэд итгэж хүлээж байна. Засгийн газраас орж ирсэн хуулийг үндсэндээ бараг өөрчилчихлөө. Тэгэхээр энэ ажлын хэсэг бас нэлээн сайн ажиллаад байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд гэхдээ энийг цаг хугацаа харуулна. За хэдийгээр шүүхийнхээ хуулийг сайхан болгосон, сайн болгосон гэдэг зүйл маань дараа цаг хугацаагаар харагдана. Миний үед хоёр мянга арван зургаан онд шүүхийн хараат бус тогтолцоо бол дал, наяд байсан. Одоо зуун хорьд орчихсон байгаа. Яаж муутгасан бэ гэдэг нь энүүгээрээ харагдаж байгаа юм.

Тэгээд энэ хуулийг баталсны дараа нэг их сайн сайхан болно гэсэн хүлээлт байгаа. Тэгээд энэ дээр бол хонх нь дуугарахаар, дамар нь таг, дамар нь дуугарахаар гаар хонх нь.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Ганбат гишүүнд нэг минут нэмж өгье.

Д.Ганбат: Ингэж таг болж болохгүй ээ. Тэгээд энэ чинь иж бүрэн байж ажилладаг юм. Тэгээд одоо, тухайлбал одоо эрүүгийн хуулийг самраад тавьчихаж байгаа юм. Тэгэхээр шүүгч нарын шүүгч нарын хэрэглэдэг хуулиуд нь бас нэлээн сайжирч чадсан уу? Чадаагүй байгаа шүү дээ. Тэгээд буруутгадаг нэг юм байна. Иргэдээ буруутгадаг, ард түмнээ буруутгадаг, шүүгч нарыг буруутгадаг. Ардчилсан намын бүлгийг буруутгадаг, намайг буруутгадаг иймэрхүү маягаар хол явахгүй. Та нарт одоо бүх юм нь байсаар байтал буруу зөрүү юм гаргадаг ийм байна. Би энэ дээр юу хэлэх гэж байна вэ гэхээр 2016 оны Улсын Их Хурлын дөчин хоёрдугаар тогтоол байгаа. Тэрүүгээр зургаан зуун ерэн есөн шүүгч байх ёстой. Гэтэл одоо таван зуун арван найм ажиллаж байна. Тэгэхээр нөгөө хэргийн ачаалал ямар байна. Хоёрдугаарт одоо шүүхийг хамгаалдаг маршалын алба гэж байх ёстой. Шүүхийн барилга байшин байх ёстой. Сүүлийн хэдэн жил шүүхийг дандаа төсвөөр нь.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Байнгын хороо Бямбацогт дарга хариулъя.

С.Бямбацогт: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ер нь бас таны бас хэлж байгаа зарим зүйлтэй санал нэгдэж байгаа. Хонх нь дуугарахаар дамар нь таг. Тийм болохоор бид нар шүүхийн тухай хууль батлагдахдаа хэлэлцэж байгаа одоо анхны хэлэлцүүлэг хийгдээд энэ саналууд гарсан. Саналууд дэмжигдсэний дараа бол тодорхой бас дагаж тодорхой хуулиудын өөрчлөлт оруулах ёстой. Мөн одоо хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийг Монгол Улсын Их Хурал хориос хорин дөрвөн онд одоо ямар Засгийн газар өргөн барьсан, энийг батална. Энэндээ бас ингээд яаж одоо бодлогоо зөв тодорхойлж, бодлогоо зөв, одоо тийм үү, зохион байгуулж хэрэгжүүлэх вэ гэдэг энэ хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллана.

Тэгэхээр шүүхийн тухай хуультай холбоотойгоор яаж иргэдийн одоо шударга шүүхээр эрхээ хангуулах энэ баталгаа хангах тал дээр бас холбогдох хуулийн зохицуулалтыг хийх ёстой. Энд анхаарч ажиллана. Ингэхдээ бас манай цөөнх

маань сөрөг хүчин маань тийм үү, бидэнтэй бас энэ олонхтойгоо бүгдээрээ л Монгол улсын төлөө, Монголын ард түмэн, төр засаг маань сайн сайхан байгаа гэсэн гэж бүгдээрээ л бодож байгаа. Энэ хүрээнд бас хамтарч ажиллаасай. Зөвхөн одоо юу гэдэг юм шүүмжлээд суух биш хамтраад нөгөө бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй гэж ярьдаг. Энэ болгон дээр тийм үү, энэ нь сайн байна, энэ нь муу байна, энэ муугаа ингэж засаж ба сайжруулчихъя, алдаагаа ингээд засчихъя гэдэг дээр бүгдээрээ сайхан хамтарч ажиллая. Ийм байдлаар явах юм бол Монгол улсад хэрэгтэй.,Монголын ард түмэнд хэрэгтэй. Бид ч гэсэн бас одоо олон нийтээс авдаг шүүмжлэл маань бас багасна.

Тийм болохоор энэ болгон дээр одоо бүгдээрээ ажил хэрэгч хандмаар байгаа юм. Зөвхөн одоо шүүмжилдэг биш яаж сайжруулах вэ гэдэг дээр бас нь ажил хэрэг санал гаргадаг байх энэ тал дээр бас Ардчилсан намынхаа бүлгийн саналыг сонсоод, Ардчилсан намын бүлэг дээр манай ажлын хэсэг, одоо Энхбаяр гишүүн олон удаа бас танилцуулга хийгээд та бүхэнтэйгээ бас хамтарч ажиллаж байгаа. Оны өмнө бас хэлэлцье гэж байхад нь хүртэл одоо та бүгдийг хүндэтгээд хоёр удаа завсарлага өгөөд одоо өнөөдрөөс оны дараа хэлэлцээд явж байгаа.

Т.Аюурсайхан: Болчихсон юм биш үү? Ганибал гишүүн асуулт асууя.

Н.Ганибал: Өнөөдөр бас нэлээн чухал хууль хэлэлцэж байна. Тэгэхээр шүүхийн тухай хуулийн гол одоо үзэл санаа бол эндээс томоохон өөрчлөлтүүд орж байгаагаараа бас илэрхийлэгдэж байна. Тэгээд ер нь зүгээр түрүүн Пүрэвдорж гишүүний хэлээд байгаа асуудал бол бас үнэн юм. Үнэн юмыг ярихаар одоо бас тэнд одоо тодорхой, одоо тэнд эгдүүцэх ийм асуудал гараад байгаад нь бас тодорхой хэмжээгээр эгдүүцэж байна. Ерөнхийдөө өнөөдөр бид бүхэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтдөө тойруулж шүүхийн тухай хуульдаа өөрчлөлт оруулж байна. Энэ маань эргээд цаана нь ингээд орж байгаа өөрчлөлтүүдийг нь харахад гарж байгаа юм цааш хийгдэх юмнууд нь яаж явагдаад байна вэ гэхээрээ, за намуудын тухай хуулийн асуудал энэ давхар яригдаад эхэллээ. Дээрээс нь Монгол ардын намын дүрмийн асуудал бас энэ одоо шүүхийн сонгон шалгаруулалтын асуудлуудад оролцоод эхэлнэ.

Мөн одоо Монгол ардын намд удирдах зөвлөл гээд нэлээн одоо нөлөө бүхий эрх бүхий, одоо томилгооны асуудлаа шийддэг ийм байгууллага байдаг. Энэ бас одоо ингээд оролцоод ирэх нь бол тодорхой болж байна. Яагаад гэхээр өнөөдөр шүүхийн ерөнхий зөвлөлийн арван гишүүний одоо тавыг нь бол Улсын Их Хурлын одоо сонсголоор томилгооны сонсохлоор шийднэ. Энэ маань өөрөө юуг хэлж байна вэ гэхээрээ Монгол ардын намын бүлгээс дэмжсэн тэр хүмүүс өнөөдөр шүүхийн ерөнхий зөвлөлийг ахална гэсэн үг. Цаашлаад тэр шүүгчдийн зөвлөл гэдэг асуудал яригдаж байгаа. Шүүгчдийн зөвлөл гэдэг маань бол эргээд одоо бас өөрийн гэсэн дүрэмтэй, өөрийн гэсэн тоглолттой. Энэ шүүгчдийн зөвлөл дотор өнөөдөр бодит амьдрал дээр хуулийн одоо хувийн фермүүд, томоохон аж ахуйн нэгжүүд нөлөөлдөг нь бол одоо бүгд мэдэж байгаа.

Тэгэхээр асуудал маань өөрөө ийм байдал руу явж байгааг бид бүхэн бүгдээрээ мэдсэн. Тэгэхдээ энэ асуудлууд өөрөө тодорхой болоод, хийж байгаа өөрчлөлтүүд маань өнөөдрийнхөө байж байгаа нөхцөл байдлаас дээрдэж байгаасай гэж хүсэж байна. За ер нь бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд гурван асуудал яригдсан шүү дээ. Шүүхийн талаа. Шүүхийн ерөнхий зөвлөл, сахилгын хороо.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Ганибал гишүүнд нэг минут нэмж өгье.

Н.Ганибал: Сахилгын хороо гээд ингээд тойргийн асуудлууд гээд ингээд орж байгаа. Тэгэхээр бид нар бас энэ дээр тэгээд шүүгчдийн зөвлөлийн асуудал дээр одоо тодорхой бас цензур, тэр дотор өнөөдөр намуудын дотор байдаг нөгөө фракцын асуудлууд, одоо тодорхой эрх мэдэл, тодорхой хүмүүсийн одоо бүлэглэлийн одоо гарт орох вэ гэдэг дээр бас ямар хамгаалалтууд байгаа вэ гэдгийг бас асууя. Хоёрт нь би бас Цогт гишүүнийг дээд шүүхийн шүүгчээр томилогдож байхад одоо бас асууж байсан. Энэ асуудал маань ингээд орсон юм байна. Тавин хоёр нэгийн хорин долоо шүүхийн шийдвэрт зайлшгүй шаардлагатай үндэслэлийг огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон бол тухайн шүүгчийн эрхийг түдгэлзүүлэх, одоо огцруулах гээд сахилгын хорооны одоо эрх мэдлүүд нэлээн өндөрт тавигдаж байгаа. Тэгээд нөхцөл байдал маань яг өнөөдөр тэр одоо олон шүүгч нарын сахилгын хорооноос бас хариуцлага үүрэх юм байна. Дээрээс нь тэр үндэслэлээ бичих гээд нэлээдгүй цагийг авах юм байна. Тэгээд тэр үед одоо Цогт гишүүний хариулж байсан хариулт бол ачааллаасаа болоод одоо үндэслэлээ одоо бүрэн төгс бичдэггүй юм. Тэгээд ийм учраас өнөөдөр бол энэ хуулиар бол одоо шүүгч.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энхбаяр гишүүнд микрофон өгье.

Б.Энхбаяр: Ганибал гишүүний асуултад хариулъя. Ер нь шүүхийн асуудал дээр их улс төр бага яримаар байгаа юм. Энэ бол аль нэг намын одоо өмч гэж би хашилт дотор биш. Ер нь шүүхийг шударга ёсны байлгах тухайд үг үйлдлээрээ аль аль намууд хичээл зүтгэл, гишүүд бас гаргаж ирсэн. Би энд Ганбат даргыг бас хэлмээр байгаа юм. Үнэхээр одоо энэ шүүх эрүүгийн процессын хуулиуд Ганбат даргыг Хууль зүйн байнгын хорооны дарга болох үед цогцоороо шинэчлэгдэж батлагдаж байсан. Тэгэхээр үг ярьдаггүй, бас үйлдэл дээр улс төрийн хувьд манлайлна гэдэг бол тэрэнд бол би их хүндэтгэлтэй хандаж явдаг. Тэгэхээр энэ дээр бол одоо аль аль намын улс төрчдийн бас ийм манлайлал байдаг юм.

Одонтуяа гишүүн, Пүрэвдорж гишүүн гээд одоо Ардчилсан намын олон гишүүд энэ хуулиудыг батлахын төлөө ажиллаж байсныг би тухайн үед сөрөг хүчний бүлгийн хуулийн зөвлөх байсан учраас сайн мэднэ. Энэ одоо Монгол ардын намыг эрх мэдэл авах гээд байна гээд зүгээр хоосон хардмааргүй байгаа юм. Сүүлийн арван хоёр жил Ардчилсан намаас нэр дэвшиж сонгогдсон Ерөнхийлөгчид бүх шатны шүүгчдийг томилж ирсэн. Өнөөдөр ажиллаж байгаа таван зуун хорин шүүгчдийн дал орчим хувь нь яг энэ сүүлийн арван хоёр жил буюу ардчилсан Ерөнхийлөгчдөөс томилогдсон шүүгчид байгаа.

Тэгээд энэ шүүхийн эрх одоо шүүх маань ялзарлаа, чадваргүй боллоо, авлигажлаа гэдэг одоо ер нь энэ хэнтэй холбож ярих ёстой юм. Энд Улсын Их Хурал, Засгийн газар ямар ч оролцоо байгаагүй шүү дээ. Бүх эрх мэдлээ өгчихсөн. Тэгээд энэ хүмүүс чинь улс төрийн хариуцлага яривал энэ аль намтай тэгвэл холбогдох вэ? Аль намаас нэр дэвшиж сонгогдсон Ерөнхийлөгчтэй холбож ярих вэ гэдэг улс төрийн хариуцлага ярих гэж байгаа бол одоо би шууд хэлье.

Т.Аюурсайхан: Танхимаас Болорчулуун гишүүн асуулт асууя.

Х.Болорчулуун: Баярлалаа. Нийгмийн шударга ёсны дэнс бол үнэхээр шүүх дээр очоод л гарахдаа нөгөө шүүхийн нөгөө дэнс барьсан Фемида байхаа тэр бурхны дэнс савлачихдаг. Монгол оронд бол үнэхээр шүүхэд итгэх итгэл, ард түмний итгэл байхгүй болсон. Шүүх хонгилын шүүх гэж ярьж байна. Тэрнээс гадна хамгийн гол нь

шүүгч нарын хараат бус байдал гээд шүүгчийг шүүхгүй гээд, шүүгчийн дарханы эрх бол маш өндөр шүү дээ. Шүүх хүний ажил, амьдралаар тогложоод, буруу шийдвэр гаргахад тэрийг хэрэгсдэггүй яг ийм судалгаа байна. Хоёр мянга арван дөрвөөс хоёр мянга арван найман оны дөрвөн жилд 1135 асуудал шүүхийн буруу шийдсэн гэсэн асуудлаар ард иргэд гомдол гаргахад мянга нэг зуун гучин таваас дөнгөж арван тавхан хүнд шүүгчид хариуцлага тооцсон. Энэ бол 01 хувь ч хүрэхгүй болчихож байгаа байхгүй юу.

Тэгэхээр үндсэндээ шүүгч нар бол дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэж ирсэн. Тиймдээ ч янз бүрийн асуудал, бусдын нөлөөнд орох, авлигажих ийм асуудал гарсан. Олон түмний итгэл алдагдсан. Энэ хуулиар бол энэ сайжирна гэж итгэж байна. Ялангуяа Үндсэн хуульд заасан тэр сахилгын хороо байгуулагдсанд бол одоо ард иргэд маш их зөв, шударга Сахилгын хороо байгуулагдаасай гэдэг хүлээлт үүссэн байгаа шүү. Сахилгын хорооны есөн хүнийг дөрвийн шүүгч нараас тавина. Тавыг нь Улсын Их Хурлаас тавина гэж байна. Тэгэхдээ Улсын Их Хурал гэдэг чинь ард түмний төлөөлөл боловч улс төрчид. Улс төрчдийн хараат болгочхов. Тэгэхээр нээлттэй сонгон шалгаруулалтаар тэр таван шүүгч сахилгын хорооны гишүүдийг тавина гэж байгаа. Энэнийхээ тэр.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Болорчулуун гишүүн нэг минут нэмж өгье.

Х.Болорчулуун: Сахилгын хорооны гишүүд гишүүдийг таван гишүүнийг сонгох, тэр Улсын Их Хуралд оруулах энийг одоо сонгон шалгаруулалтыг бол маш шударга, тэр журмыг нь боловсруулах ёстой байна. Наад зах нь намын бүлгээр ордоггүй байх ёстой шүү. Аль аль намын. Шууд Их Хурлаар ордог байх ёстой. Энэ тал дээр ямар одоо шударга гаргалгаа одоо байгаа вэ гэдэг дээр хариулт өгөөч. Энийг л одоо хүсэж байгаа шүү ард иргэд.

Т.Аюурсайхан: Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Баярлалаа. Болорчулуун гишүүн үнэхээр одоо их тийм чухал тоог хэлснийг та бүхэн маань бас анзаарсан байх. Шүүгчтэй холбоотой шийдвэртэй холбоотой ямар их иргэдэд их олон санал гомдол байдаг уу. Гэтэл тэрийг нь одоо шалгаж шийддэг байдал нь яг ямар хувьтай байдаг вэ? Сахилгын хороог одоо чухамхүү энэ хуулиас давсан хууль хэрэгждэггүй, нэг хуулийг бүр хоёр өөрөөр хэрэглэж байгаа шүү дээ. Заримыг нь өөрөө бүр хэрэгсэхгүй болгоод явчхаж байгаа юм. Зарим хүнийг. Заримыг нь бол одоо ингээд бүр тав, арван жилээр хориод явчихна. Тэгээд ийм байж болохгүй шүү, одоо бас тэр ямар ч байсан үндэслэлээ бичнэ шүү. Тэр шүүх шүүх гэдэг бол шийдвэр нь, үндэслэл нь шийдвэрт нь л байгаа.

Тэр шийдвэртээ яагаад, ямар хуулийг хэрэглээд, ямар үндэслэлээр гаргав гэдгээ ойлгомжтой, нэн тодорхой бичиж байх ёстой гэдэг шаардлагыг одоо энэ төслөөр тавих гэж байгаа юм. Тэгэнгүүт, одоо энэ огт үндэслэл бичээгүй гээд л сахилгын хороо бид нарыг одоо чангалах гээд байна гээд л манай шүүхийнхэн яриад байгаа юм. Энэ одоо энэ шүүхийнхэн ерөөсөө огт үндэслэлээ бичдэггүй ийм их гаргадаг байх гээд байгаа байхгүй юу. Үндэслэлээ бичихгүйгээр шийдвэр гаргадаг. Тэрүүгээрээ одоо ингээд энэ хууль хэрэглээнийхээ завхралыг бий болгосон, хулгайгаа хийдэг, хонгилоо үүсгэдэг. Тэгээд одоо, тэрийг нь ингээд Үндсэн хуулиар ингээд бүр Улсын Их Хурал өнгөрсөн онд ингээд нэлээн юм болж байж олонх ингээд баталж, санаачилга гаргаж, улс төрийн манлайлал үзүүлж ингээд сахилгын хороог бий болгосон чинь одоо тэрэнд хянагдахгүй. Бид нарын үндэслэл огт бичээгүй шийдвэрийг хянах гээд байна. Үндэслэл огт бичихгүй гэх гээд байгаа байхгүй юу.

Энэ ерөөсөө. Энэ бол мэргэжлийн алдаа биш энэ чинь санаатай. Яагаад үндэслэлээ бичихгүй байх гээд байгаа юм бэ. Түрүүн бас Ганибал гишүүн бас яг энэ асуудлыг хөндсөн.

Т.Аюурсайхан: Наян зургаадугаар микрофон дээр ажлын хэсэг нэмж хариулъя.

Ц.Цогт: Болорчулуун гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье. Тэгэхээр яах вэ? Өнөөдөр шүүхийн хууль хэлэлцэж байгаатай холбоотой шүүх эрх мэдлийн байгууллагад ажиллаж байгаа бүх хүмүүсийн олон арван жил хөдөлмөрлөж ирсэн хөдөлмөр, тэрний үнэлэмжийн асуудлыг бас давхар ярьж байгаа юм шиг ийм ойлголт харагдаж байна. Тэгэхээр энэ дээр бол бас Улсын Их Хурал гишүүд маань хариуцлагатай тоо баримт ярьж байгаа учраас энэ тоотой холбогдуулаад нэг тайлбар хэлье. Саяын яригдаж байгаа тэр өргөдөл гомдлуудын чинь наян хувь нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гомдол байгаа байхгүй юу. Шүүгчийн ёс зүйтэй холбоотой биш.

Тэгэхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай гомдлыг бол шат шатны шүүхүүд нь, дээд шатны шүүх нь хянаж, тэр гомдлыг үндэстэй юу үндэсгүй юу гэдгийг нь барагдуулдаг. Тэрнээс сахилгын хэрэг, сахилгын хороо хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хянадаггүй. Тэгэхээр энэ дээр бас болгоомжтой тоо хэлэхгүй бол олон нийтэд буруу ойлголт хүрэх вий.

Т.Аюурсайхан: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. За энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Манай Хууль зүйн байнгын хороо ажлын хэсэг нэлээн сайн л ажиллах шиг боллоо гэж ингэж бодож байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу энэ шүүхийн хуульд өөрчлөлт орж байгаа. Тэгэхээр би нэг гурван зүйл асууя. Нэгдүгээрт бол энэ олон жил одоо нэг хүний мэдээлэлд энэ хонгилын одоо түлхүүр гэж яриад байгаа шүү дээ. Хонгилоор чирдэг гулдардаг гээд ингээд яриад байгаа тэр түлхүүрийг болбол нэг хүн мэдэж байсан. Энэ одоо хараат, шүүхийн хараат бус байдлыг бол хангаж чадахгүй байсан учраас тэр нэг хүний мэдлээс түлхүүрийг нь аваад тэгээд одоо шүүхэд өөрсдөд нь өгч байгаа юм байна гэж ингэж ойлгож байгаа юм.

Тэгэхээр энэ шүүх маань бол өөрөө одоо хариуцлагатай байх ёстой. Одоо энэ хуульд бол нээлттэй сонгон шалгаруулалтаар тэр сахилгын хороо, шүүхийн зөвлөл энэ тэрийг бол сонгох нь байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр л ер нь тун анхааралтай байхгүй бол нөгөө нохойны хүзүүнд мах зүүнэ гэдэг шиг ингээд өөрсдөд нь зүүгээд тавьсан энэ бүх шүүгчдийг хэлж байгаа юм биш л дээ. Энэ одоо иргэдийн эрхийг зөрчдөг, хэрэг маргааныг одоо буруу талд нь шийддэг. За бүр одоо цаашлах юм бол авлигал, хээл хахуульд автсан тухай асуудал чинь бол одоо ил нээлттэй болоод байна шүү дээ. Тийм учраас энэ дээр их онцгой анхаарах ёстой. Энд ямар одоо баталгаатай өөрчлөлт оруулсан гэж хэлэх вэ.

За нөгөө нэг юм бол энэ нийгмийн баталгаатай холбоотой асуудал яригдаж байна. Нийгмийн баталгааг нэмэгдүүлэхтэй холбоотой юмыг бол одоо ойлгож байгаа. Гэлээ гэхдээ одоо бусад салбаруудтайгаа хэрхэн яаж уялдах юм бэ? Энэ төрийн албан хаагчдын, одоо нийгмийн баталгаа бол ерөнхийдөө нэг ялгамжгүй байх ийм зарчим байхгүй бол ингээд одоо нэлээн хэдэн жилийн өмнө шүүхийн цалин хангамжийг нэмэгдүүлсэн. Үүнийг дагаад прокурор одоо тэгээд бусад хууль хүчний байгууллагууд бүгд араанаасаа цалин хангамжаа ингээд алаг цоог одоо нэмэгдүүлээд явсан шүү дээ. Тэгээд энэ чинь.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Дараа нь тодруулах юм байлгүй. 80 дугаар микрофон дээр ажлын хэсэг хариулъя. 80 дугаар микрофон өгье.

О.Мөнхсайхан: Бат-Эрдэнэ гишүүн маш чухал зүйл хэллээ. Тэгэхээр шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хамгаалах чиг үүрэгтэй ерөнхий зөвлөлийн болон сахилгын хорооны бүрэлдэхүүн бол одоо шүүгч болон шүүгч биш гишүүдийн тэнцвэртэй төлөөллөөс бүрдэх ийм зохицуулалт бол Засгийн газрын төсөлд өргөн баригдаж орж ирсэн. Энэ төслийг бол үзэл баримтлалыг нь нарийвчилж тодруулсан маш сайн одоо процессжуулан ийм заалтууд орж ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл сахилгын хорооны есөн гишүүний дөрөв нь шүүгч байна. Шүүгчдээсээ сонгогдоно. Гэхдээ энэ дөрвөн шүүгчийг бол урьд өмнөх шиг одоо гэнэтхэн богинохон хугацаанд хуралддаг хаалттай явдаг, иргэдийн санаа бодол тусдаггүй, янз бүрийн фракц одоо бүлэглэл үүсдэг. Тэгээд яг тэр шүүгчдийнхээ итгэлийг хүлээсэн хүнийг гаргаж чаддаггүй. Энэ байдлыг халах зорилгоор ерөөсөө Монгол Улсын нийт шүүгчид одоо нийт шүүгчдийн чуулганаараа хуралдаад одоо тухайн бүрэн эрх нь дуусахаас өмнө 90-ээс доошгүй хоногийн өмнө хурлаа зарлаад, олон нийтийн санаа бодлыг сонсоод, тэр нэр дэвшиж байгаа хүний одоо хэр зэрэг ажиллах вэ гэдэг тэр бүх зүйлийг сонсож асуусны үндсэн дээр шүүгчид нууц санал хураалтаар сонгох ийм зохицуулалт орж ирсэн. Шүүгч биш таван гишүүн сахилгын хорооны шүүгч биш таван гишүүнийг мөн адил нэгдүгээрт бол тал талын төлөөллөөс бүрдсэн иргэний нийгэм, мэргэжлийн холбоо, Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Ерөнхийлөгчийн гэх мэтчилэн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг сонгон шалгаруулна.

Тэгээд энэ сонгон шалгаруулаад оруулсан хүмүүсийг Хууль зүйн байнгын хороо нээлттэй сонсгол хийнэ. Тэгээд Их Хурал томилох эсэхээ шийдэж байгаа юм. Тэгээд эр нь бол зарим хүмүүс их хуралд энийг өгчихлөө гээд байгаа нь бол харьцангуй ташаа гэж ойлгож байгаа юм. Яагаад гэхээр энэ бол хэнийг гаргах вэ гэдгээ Их Хурал шийдэхгүй, тэр хөндлөнгийн ажлын хэсэг гаргаж ирнэ. Дээрээс нь сонсгол хийнэ. Гуравдугаарт яах вэ гэхээр энэ бүх процессыг 4 хуудас процессжуулсан байгааг та бүхэн харж байгаа байх. Энэ ямар нэгэн зүй бус нөлөөлөл.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Энхбаяр гишүүнд микрофон өгье.

Б.Энхбаяр: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ цалин, нийгмийн хангамжийн баталгааны хувьд энэ нэг шүүгч нар гэж нэг ёстой нэг дэлхийд байхгүй цалин урамшуулал авдаг хүмүүс юм шиг нэг ийм ойлголт яагаад төрчихсөн юм. Нэг ийм эсвэл энэ улс төрийн зорилготой байсан байж магадгүй. Зүгээр ингээд хэвлэлээр их яваад. Тэгээд шүүгч нар чинь нөгөө хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлбар өгөх, ярилцлага өгөх, энэ үг хэлэх юм нь хуулиараа угаасаа хязгаартай учраас тайлбар хийж чаддаггүй. Тэгээд нөгөө энэ нэг ийм худлаа ойлголт бий болчихсон юм байна лээ. Тэгээд яг ажлын хэсгийг судлах явцад би бас тийм ойлгож байсан. Энэ шүүгчид ерөөсөө маш их цалин авдаг байх гээд. Тэгээд очоод үзсэн чинь анхан шатны шүүгчийн шүүгч нарын цалин хоёр аравны долоон сая юм байна лээ. Давж заалдах шатны шүүгчийнх болохоор 3 сая юм байна лээ.

Тэр тав зургаан сая төгрөгийн цалин авдаг гэдэг чинь дээд шүүхийн ерөөсөө нэг хорин хэдэн шүүгчдэд л авдаг юм байна лээ шүү дээ. Тэгээд энийг одоо бүгдээрээ авдаг юм шигээр нэг ийм ойлгочихсон. Тэгээд шүүгчдийн шүүхийн нарийн бичиг туслахуудын цалин гар дээрээ авдаг цалин чинь долоон зуун мянга юм байна лээ

шүү дээ. Би бас бүр итгээгүй энэ одоо. Тэгээд бүр тогтворгүй болчихсон ажиллаж байгаа дундаж хугацаа нь нэг жил гэж байна лээ. Ерөөсөө нэг хүн нэг жил ингээд л ажиллаад л за больё гээд ёстой нэг залуу насны ааг омгоор ажилладаг юм шиг байгаа юм. Тэгээд өөрөө ийм шүүх эрх мэдлийн юу чинь ийм хүчгүй, сул дорой болчихсон. Тэгээд тэр нь нөгөө хавтгайдаа их өндөр цалин өгдөг гэсээр байгаад энэ долоон жил ерөөсөө ямар ч юу шийдээгүй.

Тийм учраас энэ шүүгч энэ шүүгчээс гадна энэ шүүх хуралдааны нарийн бичиг туслах гээд энд одоо олон хүмүүс ажиллаж байгаа. Энэ хүмүүсийн бас цалин урамшууллын асуудлыг нэмэх асуудал одоо дэмжигдвэл санал болгож байгаа. Анхан болон давахын шүүгчдийн цалинг нэг таваас арван хувь, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга туслахуудын цалинг хоёр дахин нэмье гэдэг ийм санал оруулж байгаа.

Т.Аюурсайхан: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн нэг минут нэмж өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би нэг зүйл бас нэг орхигдсон юм нэг нэмээд асууя. Энэ одоо шүүхэд гаднаас нөлөөлдөг, нөгөө хараат бусаар шийдвэр гаргахдаа нөлөөлдөг гээд одоо яригдаж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо хэн нөлөөлөөд байна вэ, тэр бол мэдээж одоо улс төрийн хүчнүүд улс төржөөд энэ одоо ихээхэн хөрөнгө мөнгөтэй ийм хүмүүс л нөлөөлж байгаа шүү дээ. Тэгээд тэр хүмүүст одоо тооцдог хариуцлагыг чангатгах талын ийм зохицуулалт орсон уу? Тэгээд нэг ийм асуудал. Нөгөөдөх нэг юм нь бол бас нэг одоо нурууг нь барихгүй бол болохгүй шүү дээ. Та түрүүн Энхбаяр гишүүн бол хэллээ. Ер нь одоо энэ шүүхэд ажиллах шүүхийн туслах нарийн бичгээр ажиллах хүмүүс тэгээд цаашлах юм бол шүүгч ажиллах хүн нэлээн одоо хэцүү юм байна лээ гэж. Тэгээд тогтвор суурьшилтай тэр өргөсөн тангарагтаа үнэнч шударга, одоо ажиллах тийм бололцоо нөхцөлийг бий болгох чиглэлийн зохицуулалтуудыг бас нэлээн оруулсан болов уу даа гэж ингэж бодох юм. Энд хоёр нэмэлт асуулт дээр хариулт өгөх бололцоо байна уу?

Т.Аюурсайхан: Наян зургаадугаар микрофон дээр хариулъя.

Ц.Цогт: Эхний Бат-Эрдэнэ гишүүний эхний асуулттай холбогдуулаад нэг тодруулга хийгээд тэгээд хоёр дахь асуулт руу нь тайлбар хэлье гэж бодож байна. Тэгэхээр шат шатны шүүхийн шүүгчдийн үндсэн цалинг бол Улсын Их Хурлын тогтоолоор баталсан байдаг. За шатлал хоорондын шүүгч нарын үндсэн цалин бол зуун мянган төгрөгийн зөрүүтэй байгаа. Тэгэхээр одоо би бол дээд шүүхэд очоод цалин авч үзээгүй байна. Яагаад гэвэл сар болоогүй учраас. Ер нь бол зарчим бол шатлал хоорондоо зуун зуун мянган төгрөгийн зөрүүтэй ажилласан жилээрээ тухайн шүүгчийн одоо мэдээж хяналтын шатанд очиж байгаа шүүгч нар бол их олон жил ажилласан шүүгч нар байдаг учраас магадгүй ажил ажилласан жилтэй холбоотой нэмэгдэл байдаг байж болзошгүй шүү. Тэгэхээр энэ юуг бас тодруулгыг бас хэлье.

Хоёрдугаарт энэ хуулийн төслийн аравдугаар бүлэгт бол ерөөсөө энэ шүүгчийн хараат бус байдгийг, яг бодит байдлаар яаж хамгаалах юм бэ гэдгийг нэлээн дэлгэрэнгүй тэгээд шүүгч нарт гарч байсан тэр бэрхшээл, шүүгч нарт тулж байсан тэр нөлөөллийн асуудлаас үндэслэн.../минут дуусав/

Т.Аюурсайхан: Баттөмөр гишүүн асуулт асууя.

Б.Баттөмөр: Монгол улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийн шинэчлэлийн нэг нь бол энэ шүүхийн шинэчлэлийн асуудал байгаа юм л даа.

Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн хүрээнд энэ органик хуулиуддаа өөрчлөлт оруулах ийм оролдлогоо хийх гэж байна. Энэ л одоо шүүхийн шийдвэр, шүүхийн тухай хуулийг өнөөдөр бид нар хэлэлцэж байгаа юм л даа. Шүүхийн энэ хуулийг бол мэргэжлийн байгууллагаас санал аваагүй, мэдээллийн хэрэгслээр мэдээлээгүй гээд одоо олон нийтийн сонсгол явуулах ёстой гэсэн ийм байр суурьтай одоо хуульчид ч байна л даа. Шүүхийн статистик мэдээллээр бол эрүүгийн болон анхан шатны давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тавин хувь нь дээд шүүх дээр өөрчлөгдөж байна гэж байгаа юм. Захиргааны хэргийн шүүхийн хорин таван хувь нь дээд шүүх дээр өөрчлөгдөж байна. Энэ яагаад ингэдэг юм бэ? Ямар учир шалтгаан байна? Энийг хариулт өгөөч гэж.

Манай дээд шүүх хорин долоон тийм хорин таван гишүүнтэй. Иргэний хэргийн долоон шүүгч дээр маш их олон мянган хэрэг байдаг гэсэн. Тэгэхээр дээд шүүхийн шүүгч нар хэрэг болгоныг унших биш хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах ёстой юм биш үү. Энэ чиглэлд шинэ хуульд одоо яаж тусгаж өгч байсан бэ? Улсын дээд шүүхийн хэрэг хүлээж авах шалгуур өөрчилж байгаа юу? Тодорхой хэрэг маргаан дээр нэг хуулийн заалтыг хоёр өөрөөр хэрэглэсэн маргааныг улсын маргаан дээр одоо улсын дээд шүүх одоо ажиллах ёстой л доо. Тэгээд энэ чиглэлд одоо юу байна вэ. Шүүхийн бие даасан байдлыг хангах, хамгаалах үүрэг шүүхийн ерөнхий зөвлөлд байдаг. Энэ үүргээ хэр зэрэг биелүүлж байсан юм бол доо? Шинэ хуулийн төсөлд одоо яаж тусгагдсан бэ шинэчлэл. Шүүхийн шийдвэр, шүүхийн ерөнхий зөвлөлийн одоо Үндсэн хуулиар тогтоосон шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчид хариуцлага тооцох эрх бүхий байгууллага энэ төсөлд бол шүүхийн ерөнхий зөвлөл арван гишүүнтэй байна гэж байгаа юм. Таван орон тооны бус байх нь. Тэгэхээр энэ хэр зэрэг оновчтой байдаг юм бол. Энэ бусад орны туршлагууд одоо ямар байна, ямар үндэслэлээр ингэж хийж хийж байгаа юм бэ гэсэн ийм асуулт байна.

Төгсгөлийн асуудал энэ шийдвэр гүйцэтгэлийн ажил одоо хэрэгждэг байх ёстой. Харамсалтай нь бол тийм биш байна л даа. Тухайлбал захиргааны хэргийн шүүхийн арван хувь нь одоо хэрэгждэг гэж байгаа юм. Ерэн хувь нь хэрэгждэггүй. Иргэний хэргийн дөчин хувийг нь одоо дөчин хувийн биелэлттэй. Үлдэж байгаа жаран хувь нь хэрэгждэг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл бол тусдаа хуультай. Тусдаа ажил боловч шүүхийн шийдвэр оновчтой зөв байж байж шийдвэр гүйцэтгэлийн ажил зөв явах ёстой. Тэгэхээр энэ чиглэлд одоо юу хийгдсэн бэ? Бид нар бол нөгөө анх өргөн барьсан хуулийн хэмжээнд л одоо мэдээлэлтэй байгаа шүү дээ. Далан долоон хуудас одоо санал бэлтгэж байгаа гэж байгаа. Зарчмын зөрөөтэй. Тэгэхээр энэ дээр бас өөрчлөгдсөн юмнууд байна уу, үгүй юу гэсэн ийм асуулт.../минут дуусав/

Г.Занданшатар: Наян зургаа Цэндийн Цогт шүүгч.

Ц.Цогт: Эхний асуултад хариулъя. Тэгэхээр яг одоо сүүлийн таван жилийн байдлаар бол эрүүгийн хэрэг дээр бол улсын дээд шүүх тавь аравны нэг орчим хувь бол давж заалдах шатны шүүхийн магадлал тогтоол хэвээрээ үлдсэн. Иргэн дээр бол жаран гурав, захиргаа бол жаран зургаан хувь хүчинтэй үлддэг ийм одоо баримт бол байгаа. Тэгэхдээ энэ дээр яагаад одоо өөрөөр хэлбэл гучин хэдэн хувь өөрчлөгдөөд, эрүү дээр бол одоо дөчин хэдэн хувь энэ тэр өөрчлөгдөж байна вэ гэхээр энэ өөрчлөлтөд бүх төрлийн өөрчлөлт ордог юм. Өөрөөр хэлбэл нэхэмжлэлийг хангачихсан байсан давж заалдах, анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулаад болгоод нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож байгаа өөрчлөлт ч тоологдож байгаа. Хуулийн нэг зүйл заалтын тоо одоо өөрчилж бичсэн өөрчлөлт ч орж байгаа.

Тэгэхээр нийт одоо нөгөө бүх одоо жижиг, том гэлтгүй бүх өөрчлөлтүүд нийлээд ийм хэмжээний тоо зөрүү гарч байгаа. Одоо энэ зарчмын зөрүүтэй саналаар ажлын хэсэг дээр өргөн баригдсан төсөл дээр оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлт юу байна вэ гэхээр энэ хяналтын шатны шүүх, давж заалдах шатны шүүхээр шийдэгдээд гарсан хэргийг бол тодорхой үндэслэлүүдээр бол хүлээж авдаг байя. Энэ нь бол нэг талаас бол хяналтын шатны шүүх өөрөө хууль хэрэглээний нэгдэл байдлыг тогтоох, гаргаж байгаа шийдвэр нь доод шатны шүүхүүдэд ижил төстэй хэргүүд дээр нэг мөр хэрэглэгддэг байх тэр боломжийг хангах үүднээс ийм өөрчлөлт бол орж ирж байгаа. Тэгэхдээ энэ дээр бол бас жаахан болгоомжтой нэлээн ажлын хэсэг сайн ярьж байж энэ хяналтад авах шалгууруудыг бол тодорхой болгохоор бол ингэж ярилцаж байгаа.

Г.Занданшатар: Сайнзориг наян долоо. Пүрэвжавын Сайнзориг гэж дарга.

П.Сайнзориг: Баттөмөр гишүүний хоёр асуултад нь хариулъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг бол арван гишүүнтэй байна гээд Үндсэн хууль дээр заасан. Тав нь орон тооны, тав нь орон тооны бус байдлаар бол Засгийн газар хавар өргөн барьсан боловч сая бас сонгуулийн үр дүнд байгуулахад шинэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт эдгээр одоо арван албан тушаалыг байнгын буюу орон тооны гишүүн байдлаар одоо оруулна гэдэг концепцоо бол одоо өөрчлүүлж Улсын Их Хурал өөрийг нь дэмжиж үйл ажиллагааны хөтөлбөрийг нь баталсан байгаа. Энэ хүрээндээ ч гэсэн энэ ажлын хэсэг дээрээ бол энэ шүүхийн ерөнхий зөвлөлийн арван гишүүн орон тооны, нээлттэй сонгон шалгаруулалтаар орно. Тавыг нь шүүгчдийн чуулганаас, тавыг нь одоо яг энэ хуульд заасан процедурын дагуу сонгон шалгаруулж, нээлттэй сонсгол хийх замаар Улсын Их Хурал томилохоор орж байгаа. Энэ зүйл бол цаашдаа ингээд явна.

Шүүхийн шийдвэрийн гүйцэт биелэлттэй холбоотой бол олон асуудлуудыг эрүү, иргэн, захиргааны чиглэлээр нь ярьж болно. Тэгэхдээ Засгийн газар бас энэ шүүхийн хуультайгаа уялдуулаад яг энэ шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг сайжруулах чиглэлтэй хоёр хуулийн төсөл боловсруулж байна. Энэ хүрээндээ бас иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг шүүх эрх мэдлийн байгууллагын харьяанд шилжүүлэх эсэх асуудлыг бол одоо ажлын хэсэг гаргачихсан бид нар судлаад энэ чиглэлдээ бас ажиллаад явж байгаа. Тэгээд ер нь бол одоо иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг жишээ нь одоо сайжруулах асуудал дээр маш олон хуулиудын асуудал хөндөгдөж байгаа. Ялангуяа дампуурлын хуулиасаа эхлээд, иргэний шүүхийн шийдвэр, иргэний процессын хууль, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хууль дээр шат шатанд нь гомдол гаргаад явдаг энэ асуудлыг халах асуудал бас байж байгаа гэх зэрэг ерөнхийдөө энэ бас одоо бизнес, худалдаа гэдэг юм уу энэ чиглэлийн одоо хууль эрх зүйн орчныг дэмжсэн асуудал дээр бол Засгийн газрын зүгээс тодорхой судалгаа гаргаад холбогдох хуулийн төслүүдийг нь бас ирэх хаврын чуулгануудаар өргөн барьж хэлэлцүүлэхээр бас төлөвлөж байгаа гэдгийг бас танд хэлье.

Г.Занданшатар: Тав дахь асуултад хэн хариулах уу? Одоо эрхэм гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ асуулт асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ Монгол Улсын шүүхийн тухай хуулиас ард иргэд нэлээдгүй зүйлүүдийг харж хүлээж байгаа. Ер нь бол шударга бус шүүхийн шийдвэрээс хэн хохирч байна гэхээр бид одоо энэ цагаан захтан ч гэдэг юм уу аливаа нэг намтай холбоод байх шиг байна. Хамгийн гол хохирч байгаа хүмүүс маань бол ард иргэд,

аж ахуйн нэгжүүд байгаа шүү дээ. Энэ хуулийн шинэчлэлийн гол зорилго бол энэ шударга бус шүүлт, шударга бус шүүх рүү бол хандсан зүйл байгаа юм гэдгийг бас хэлье. Тэгээд бидний хийх гээд байгаа зүйл бол ерөөсөө л хараат бус шүүхийг бий болгох гээд байгаа юм. Хэн нэгэн даргаас хараат бус, хэн нэгэн томилдог хүнээсээ хараат бус ийм шүүхийг бий болгох. Нөгөөтээгүүр дээд шүүх болон шүүгчдээсээ дотоод шүүгчээсээ бол хараат бус энэ байдлыг бий болгох гээд байгаа юм. Тийм биз тийм ээ.

Бас тухайн шүүгч сахилга баттай байх асуудал. Зөв шийдвэр гаргадаг байх асуудал. Хэн нэгнээс айдаг, эмээдэг тухайн одоо хуулиа бол зөв зүйтэй бол тайлбарладаг. Түрүүний тэр яриад байгаа шүү дээ. Тайлбар бичдэггүй гэдэг энэ байдлыг л бий болгох, одоо үгүйсгэх гээд байгаа шүү дээ бид нар чинь. Тайлбар бичдэг болгох гээд байгаа, сахилга баттай бий болгох гээд байгаа юм. Сахилга бат бий болгох гээд байгаа юм. Тэгэхээр өнгөрсөн жил бид нар Үндсэн хуульдаа бол энэ сахилгын хороо гэдгийг бол оруулж ирсэн маш том алхмыг бий болгож чадсан. Одоо энэ сахилгын хороон дээр бол сая өнгөцхөн яриад байх шиг байна. Дөрвөн гишүүнийг бол шүүгчдээс шийдүүлээд томилохоор байж байх тийм үү? Тав нь бол шүүгч биш гишүүдээс. Гэхдээ Улсын Их Хурлаас томилно гээд байгаа юм. Энэ журмыг Байнгын хороо батална гээд байгаа байхгүй юу даа. Дахиад л бид нар нөгөө нэг хонгилынхоо нэг үзүүр дээр бас нэг түлхүүрийг нь дутуу онгойлгочоод байна.

Дахиад Улсын Их Хурлаас эрх мэдэл, ямар нэгэн байдлаар бид нар томилох ийм асуудал гараад байгаа байхгүй юу. Дөрвөн гишүүн бол нууц санал хураалтаар орж ирж байгаа шүү. Шүүгчдээс орж ирж байгаа. Бидний Улсын Их Хуралд томилох гээд байгаа бусад нь бол нээлттэй сонгон шалгаруулалт гээд байгаа юм. Тэгэхээр энд ямар нэгэн бас тийм хэн нэгнээс хараат бус, нөгөө Байнгын хорооноосоо хараат бус хэн нэгэн, одоо энэ Их Хурлын даргаас ч байдаг юм уу, хэн нэгнээс хараат бус байх ийм нөхцөл байдлыг энд энэ журамдаа биш ээ.

Г.Занданшатар: Хариултын дараа, энд эхлээд түрүүний асуултад Цэндийн Мөнх-Оргил гишүүн тэр шүүгчид нөлөөлөх оролдлогыг улс төрчид Үндсэн хуулийн дөчин есөн хоёрт байгаа байх аа, тэрнийг яаж зогсоох вэ гэдэг асуудлаар Мөнх-Оргил гишүүн хариулъя гэж мессеж ирүүлсэн байна. Цахимаар. Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ бид нар Үндсэн хуулиа, бусад хуулиудаараа шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг тунхаглагчаад байдаг. Яг бодит амьдрал дээрээ энэ ямар процессоор ямар дэг журмаар хэрэгжих юм бэ гэдэг заалт нь ерөөсөө орж өгөхгүй хүндрэлтэй асуудлууд байгаад байгаа юм. Тэгээд энэ удаагийн хуулийн төсөл дээр ч гэсэн дараа нь ажлын хэсэг, хуулийн далан тав, дөчин зургаадугаар зүйлүүдэд энэ процессыг нарийсгаж гаргаж өгч байгаа юм. Жишээ нь дөчин зургаадугаар зүйл дээр улс төрийн нөлөө бүхий албан тушаалтнууд шүүгчид өөрсдөө шууд болон бусад хүнээр дамжуулж аливаа ямар нэгэн хэргийн талаар нөлөөлөх гэж оролдох юм бол шүүгч энэ тухай тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэл хөтлөөд гурав хоногийн дотор лацдаад шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх ёстой. Заавал хүргүүлэх ёстой. Хүргүүлээгүй бол шүүгч өөрөө сахилгын зөрчилд хүлээлгэнэ. Шүүгчийн буруу болно. Энэ шүүгчийн ирүүлсэн тэмдэглэлийг шүүхийн ерөнхий зөвлөл хянаж үзээд, хууль хяналтын байгууллагуудад шалгуулж нөлөөлөх гэж оролдсон улс төрийн албан тушаалтнуудад утсаар байна уу, хүнээр дамжуулаад байна уу, уулзаад байна уу, айлгасан, сүрдүүлсэн, амласан, шан харамж амласан ийм арга хэмжээнүүд байх юм бол тухайн улс төрийн албан тушаалтантай хариуцлага тооцдог, албан тушаалтай нь ярьдаг ийм зохицуулалтуудыг оруулж байгаа.

Энэ бол нэг талаас шүүгчийг хариуцлагажуулж байгаа юм шиг мөртөө нөгөө талаас шүүгчийг хамгаалж байгаа заалт. Шүүгч бол одоо хэлнэ шүү дээ. Та надтай уулзах гэж байгаа бол улс төрчөө, даргаа цэргээ хэн байдаг юм. Одоо ийм, ийм хуулийн заалттай шүү. Та хэргийн тухай ярьж, надад хэргийн талаар нөлөөлөх гэж оролдвол би тэмдэглэл хөтөлж шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх үүрэгтэй шүү. Шүүхийн ерөнхий зөвлөл энэ тэмдэглэлийн дагуу арга хэмжээ авах үүрэгтэй шүү гэдгийг нь хэлнэ. Энэ нь өөрөө шүүхийн хараат бус, шүүгчийн хараат бус байдлыг бататгасан шүүгчийг хамгаалсан нөгөө талаас шүүгч нар өөрсдөө хариуцлагатай байдаг, хэнтэй хаана ямар асуудлаар юу.../минут дуусав/

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад ажлын хэсэг Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн сахилгын хороо гэсэн энэ Үндсэн хуулийн хоёр институтийн нөгөө шүүгч биш таван гишүүнийг Улсын Их Хурал нээлттэй сонсголын одоо журмаар томилохоор байгаа. Энэтэй холбоотойгоор бас энэ нөгөө энийг бол нэлээн процессжуулна. Бат-Эрдэнэ гишүүн та энэ саналын томъёоллын тавин наймдугаар саналын томъёоллыг хараарай. Энэ шүүхийн ерөнхий зөвлөл болон сахилгын, дөрвөн хуудас одоо процесс байгаа. Өөрөөр хэлбэл нөгөө ерөнхий зөвлөлийн гишүүн нэр дэвшүүлэх, сонгох тэр журмаа Хууль зүйн байнгын хороо гаргахгүй. Бид нар энэ бүр хуульчилчхаж байгаа юм. Энэ хуульдаа. Яагаад ингэж байгаа юм гэхээр нөгөө Хүний Эрхийн Комисс дээр яах вэ Байнгын хороонд журам гаргаад явчихсан юм байна лээ. Тэгээд энэ дээр бас зарим энэ журамтай холбоотой асуудлууд бас гарч байсныг бол одоо гишүүдээс гарч байсан олон ч гишүүн бас хэлж байсан. Тэгээд энэ санал шүүмжлэлийн дагуу ер нь энэ Байнгын хороо ийм журам бас гаргахгүй. Энэ чинь нөгөө Үндсэн хуулийн байгууллага байгуулах гэж байгаа учраас.

Энэ журмаа өөрөө хуульд нь нарийвчилж зохицуулъя гээд. Ингээд энэ дөрвөн хуудас журам гаргасан байгаа юм. Дөрвөн одоо хуудас. Тэгэхээр энэ журмыг та хараарай энэ дээр одоо ямар хугацаанд зарлах вэ, ямар бичиг баримт, ямар шаардлага тавих вэ, ямар хугацааны дотор нээлттэй сонсгол та явуулах уу, ямар хугацаанд одоо тэр ард иргэдэд танилцуулах уу, ард иргэдээрээ шүүлгэнэ. Ер нь бол шүүсийг нь шахна гэдэг нь Их Хурлын гишүүн шүүх гээд байгаа биш. Ард иргэдээрээ тэр өнгөрсөн амьдрал, замнал, бүх юмыг нь мэдэж байгаа энэ чинь наадах чинь жоохон бүтэхгүй хүн шүү дээ ингэж байсан тэр бүх мэдээллийг нь авна. Тэгээд тэрийг нь Улсын Их Хурал дээр асууна. Тэгээд ер нь нэг жоохон нэг хар бараан намтартай нөхөр бол жоохон ноотой нөхөр бол ер нь энэ танхимд орж ирэх чадахгүй. Орж ирвэл тэгээд би өөрөө больё гээд л гардаг болно. Ийм л одоо процесс.../минут дуусав/

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүн 1 минут тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Хэлэлцэх явцад энийг бас нэг нэлээн тодруулъя хэдүүлээ. Зүгээр над дээр бол Байнгын хороо хуульд нийцүүлэн батална гэхихсэн байна. Нөгөөтээгүүр энэ сахилгын хорооны шийдвэр гарч байгаа тогтоол гарч байгаа. Энд сахилгын хорооны энэ шийдвэрт оролцогч буюу одоо илтгэгч нь арван дөрвөн хоногийн дотор дээд шүүхэд гомдол гаргана гэж байгаа шүү дээ. Энэ дахиад л эрх ашгийн зөрчил бол бий болчих гээд байна. Дээд шатны шүүх одоо хяналтын буюу одоо дээд шүүхийн шүүгч өөрөө энэ сахилгын хороогоор орвол яах вэ? Дахиад өөрийнхөө нөгөө дээд шүүхээрээ энэ чинь асуудал нь шийдэгдэх гээд байна шүү

дээ. Эрх ашгийн зөрчил энэ бий болох гээд байна.

Хоёрдугаарт энэ хяналтын шатны шүүхээр орсон одоо шийдвэрийг сонсоно гэж байгаа юм. Сонсогдсоноос хойш гуч хоногийн дотор дараа баталгаажуулна. Дахиад энийг шүүхийн шүүгчийн зөвлөгөөнөөс дахиад гучин хоногоор сунгана гээд байгаа юм, энэ чинь.../минут дуусав/

Г.Занданшатар: Энхбаяр гишүүн ажлын хэсэг асуултад хариулна.

Б.Энхбаяр: Хууль зүйн байнгын хороон дээр бол ер нь нөгөө хамгийн их цаг барж, ер нь ёстой нэг үзэлцсэн л дээ. Тэгээд энэ манай дээд шүүхийн маш их хүчтэй ийм лобби орж ирээд энэ Үндсэн хуулийн гол амин сүнснийг унагаах гэж үзсэн юм. Яагаад гэхээр энэ сахилгын хорооны шийдвэрүүдийг өөрсдөө хянана гээд. Өөрөөр би энэ сахилгын хороог өөрсдийнхөө ийм доорх байгууллага болгох гээд байгаа байхгүй юу. Хянах гээд бүгдийг нь. Тэгээд өнгөрсөн хугацаа нь гучин жил, Бат-Эрдэнэ гишүүн маш чухал одоо зүйл хэллээ. Дээд шүүхийн нэг ч шүүгч арга хэмжээ авагдаж байгаагүй. Дээд шүүхийн нэг шүүгч дээр асуудал үүсгэж шалгагдаж байгаагүй. Тэгээд энэ чинь болохгүй учраас энэ чинь сахилгын хороо гээд энэ Үндсэн хуулиар байгуулчхаад байна шүү дээ. Энэ чинь Үндсэн хуулийн байгууллага болчихоод байгаа байхгүй юу.

Дээд шүүх чинь бас адилхан л Үндсэн хуулийн байгууллага шүү дээ. Тэгээд шинээр байгуулсан Үндсэн хуулийн байгууллага ингээд өөрсдийнхөө хяналтад байлгах гээд. Ийм л.../минут дуусав/

Г.Занданшатар: Наян зургаа.

Ц.Цогт: Бат-Эрдэнэ гишүүний тэр хоёр асуултад хоёуланд нь хариулах гэж үзье. Тэр гучин хоногоор сунгаж болно гэж байгаа юм. Заавал гучаар сунгана гэсэн үг биш юм шиг байгаа юм. Нөгөө хэрэг маргааны ээдрээтэй шийдвэр, маргаан нь судалгаа ихтэй тийм тохиолдолд бичих бололцоог нь зарим хэрэг дээр тухайн шүүгчийн хүсэлтээр зөвлөгөөн сонгож болно гэж байгаа юм. Тэгэхээр шийдсэн шийдвэрээ гаргах хугацаа гээд л яриад байгаа шүү дээ. Хоёрдугаарт энэ саяын энэ сахилгын хорооны шийдвэрийг дээд шүүхээр хянадаг байх уу, үгүй юу гэдэг бол дээд шүүхийн шүүгч нар өөрийгөө хамгаалах тухай ойлголт биш юм. Энэ бол Монгол улсад маш их хэрүүл маргаан, хараа хяналт талцал дунд хэрэг маргаан шийддэг шүүгчийг аль нэг талынх нь гомдлоор, сахилгын хороо шийдсэний дараа Үндсэн хуулийн тавин нэгийн дөрөвт зааснаар огцруулах шийдвэр гаргаж байгаа тохиолдолд ер нь бол шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэргүйгээр шүүгчийг огцруулж болохгүй шүү дээ.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл асуулт асууна. Бат-Эрдэнэ нар чинь цахимаар гэгчээд эндээс орж ирээд.

О.Цогтгэрэл: Нэг минут бас нэмээд авчихъя. Шүүхийн шинэчлэлт.../үг тасрав/

Г.Занданшатар: Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Байна, явж байна уу. Энэ шүүхийн шинэчлэлтэй холбоотой энэ шүүхийн хуулийг зарчмын хувьд нь дэмжиж байгаа. Ерөнхийдөө тэгээд хүн төрөлхтний бас хөгжил дэвшлийн нэг үнэт зүйл чинь өөрөө хүний эрх, хувийн өмч. Дээр нь нэмээд шударга шүүх байвал өөрөө хөгжчихнэ гэдэг л зарчим дээр хүрсэн

л гэж үздэг. Зарим нэг нь ч яах вэ, төр нь хөгжүүлдэг гэж бас үздэг л байх. Тэгээд энэ шүүхийн хууль дээр нэг асуулт байгаа нь шүүхийн тухай хууль, шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, шүүгчийн захиргаа, шүүхийн захиргааны тухай хууль, иргэдийн төлөөлөгчийн гээд энэ дөрвөн хуулийг яагаад нэг болгож, нэг хууль дор, нэг хавтсан дор ингэж оруулж ирж байгаа юм бэ? Энэ чинь энэ хууль чинь өөрөө багц байдлаар явах ёстой байсан юм биш үү? Хамгийн гол нь эндээс асуух асуулт нь энэ нэг нэгдсэнээрээ яг ямар үр дүн, нэг хавтсан дотор орсноороо ямар үр дүн гарч байгаа юм. Одоо ингээд харахлаар ерөөсөө нэг тийм механик нэгдэл энд харагдаад байна.

Энэ чинь нэг тийм шүүхийн хуулиуд чинь өөрөө нэг эрх, үүрэг заасан тийм материаллаг талын хууль гэхээсээ урдаар процессын шинжтэй ийм олон хуулиудыг нэг дор оруулчхаж. Ер нь шинжлэх ухаанд өөрт нь хими, биологийн шинжлэх ухаанд ч гэсэн амин хүчлийн молекулууд нэгдэж байж ураг үүсдэг, аль эсвэл физикийн шинжлэх ухаанд биетүүдийн болж хүчин нэгдсэнээр илүү үр дүнд хүрдэг гэдэг. Тэгэхлээр яг энэ дээр чинь тэр зарчим өөрөө харагдахгүй л байгаад байна л даа. Дөрвөн том процессын үйлчлэлтэй дөрвөн хуулийг шүүхийн тухай хууль гээд ганц хуулийн дор оруулж ирж байгаа юм. Энд нэг тодорхой хариулт өгөөч.

Г.Занданшатар: Баасандорж 82 байна уу Баасандорж? 83.

Б.Баасандорж: Хууль зүй, дотоод хэргийн яам Баасандорж эрхэм гишүүний асуултад хариулъя. Монгол улсын засгийн газраас хоёр мянга хорин оны дөрвөн сарын аравны өдөр Монгол улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өргөн мэдүүлсэн. Энэ өмнө нь бол хоёр мянга арван гурван онд батлагдсан хуулиар дөрвөн тусдаа хуулиар энэ шүүхийн асуудлыг зохицуулж байсан. Шүүхийн тухай, шүүхийн захиргааны тухай гэх мэт дөрвөн хууль байсан. Хууль санаачлагч буюу Засгийн газар шүүхийн тухай хуулийг нэгтгэж боловсруулахдаа Монгол улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн дөрөвт заасан үндэслэлийг үндэслэл болгосон. Тавин нэгдүгээр зүйлийн дөрөвт Үндсэн хууль Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу одоо шүүхтэй холбоотой хүсэлтээр шүүгчийг огцруулах, эсвэл хүсэлтээр нь чөлөөлөх тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулж болно гээд Үндсэн хуулийн тавин нэгийн дөрөвт заасан энэ үндэслэлийг үндэслэсэн.

Хоёрт нь бол энэ шүүхийн тогтвортой байдлыг, хуулийн тогтвортой байдлыг хангах үүднээс энэ дөрвөн хуулийг нэгтгэж, одоо шүүхийн тухай хуулиараа энэ шүүхийн бүх харилцааг зохицуулах нь зүйтэй гэж үзсэн байгаа юм. Хууль хэрэглээний үүднээсээ.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Хассуурийн Ганхуяг асуулт асууя.

Х.Ганхуяг: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хуулийг хэлэлцэхгүй бол дэмжиж байгаа. Энэ бол шүүхийн үйл ажиллагаа хэдий чинээ шударга байна, үр нөлөөтэй байна, тэр чинээгээрээ улсын эдийн засагт бас эерэг нөлөө үзүүлж байдаг. Ард иргэдийн амьдралд бас эерэг нөлөө үзүүлж байдаг. Энэ олон улсын хөндлөнгийн хараат бус байгууллагуудын хийсэн судалгаануудаас харахад бол жишээлбэл одоо HVI сангаас ирсэн судалгааг харахаар эдийн засгийн эрх чөлөөний индексээр манай улс зуун наян зургаан улсаас зуун хорин тавд орсон байгаа. Үндсэндээ бол яг авторитар дэглэмтэй улсуудын түвшинд байна л гэсэн үг. Энэ чигээрээ манай энэ юуг харуулж байна гэхээр манай шүүх бол одоо хараат бус байдлаа алдчихсан. Бүх шийдвэр бол дээрээс захиалагддаг яригддаг. Мөн одоо

ямарваа нэгэн одоо нөлөөнд автаж байна аа л гэсэн үг л дээ.

Тэгээд би нэг хоёр, гурван асуулт асуух гэсэн юм. Энэ бол шүүхийг бид нар шударгаар ажиллах боломжийг нь олгохын тулд бол зөвхөн одоо хариуцлагын тогтолцоо, хариуцлагын арга хэрэгслээс гадна мөн санхүүгийн одоо арга хэрэгслийг бас ашиглах нь зүйтэй юм л даа. Тийм болохоор миний нэгдүгээр асуудал болохоор энэ шүүгч шүүхийн байгууллагын санхүүгийн хараат бус байдлыг хэрхэн хангаж байгаа вэ? Миний санаж байгаагаар дөрөв, таван жилийн өмнө нэг нэр бүхий банканд банк одоо шүүгч нарын ипотекийн зээлийн асуудлыг шийдэж өгсөн. Манай хэргүүдийг яагаад шийдэхгүй удаад байна вэ? Яагаад ингээд шийдэхгүй байна гэсэн нэг ийм албан бичиг би ингээд хэвлэл мэдээллээс харж байсан л даа. Тэгээд энэ бол үндсэндээ бол шууд шүүгч нарыг бол одоо хараат байдал руу ингээд л оруулж ирж байна гэсэн үг. Нөлөөлж байна аа л гэсэн үг шүү дээ. Нөлөөллийн нэг хэлбэр мөн үү мөн.

Тэгэхээр бид нар энэ шүүгч нарын нэгдүгээрт энэ санхүүгийн хараат бус байдлыг хэрхэн хангаж байгаа вэ? Энэ энэ хуулиар. Мөн энэ бол хуулиас гадна бид нар яг энэ хуулиас гадна одоо шүүгч нарын ёс зүйн дүрэм гэдэг энэ юм орж байгаа юу?

Г.Занданшатар: Ганхуяг гишүүнд нэмэлт 1 минут тодруулна.

Х.Ганхуяг: Асуултаа хурдан явахгүй бол энэ чинь минутад ер нь амжихгүй юм байна л даа. Мөн сахилгын хороотой холбоотой нэг асуулт байна л даа. Бид нар дөнгөж сая Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн. Цагаан захтнуудын одоо хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрэгсэхгүй болгоё гэдэг асуудлыг ярилцсан байгаа. Тэгээд сахилгын зөрчлийг жишээлбэл тавин есийн хоёрт сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш нэг жил, зөрчил гаргаснаас хойш хоёр жилээс илүү хугацаа өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй. Энэ дээр бол яг ингээд л эсрэгээрээ хөөн хэлэлцэх хугацааг одоо ингээд заагаад өгчихсөн байна л даа. Тэгэхээр энэ хоёр хэргийг одоо бид нар хоёр өөрөөр тайлбарлах гээд байна уу? Анхнаасаа энэ хуулийг ингэж оруулж ирвэл бид нар яаж дараа нь одоо энэ шүүх шударга болсон гэж ер нь ярих юм бэ? Шүүхийн шийдвэрээр иргэдийн хөрөнгө, амь амьдрал, гэр бүл гээд бүх.../минут дуусав/

Г.Занданшатар: Энхбаяр гишүүн Баттөмөрийн Энхбаярын гишүүн.

Б.Энхбаяр: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Шүүгчид сахилгын хэрэг үүсгээд тохиолдолд хөөн хэлэлцэх хугацаа нь нэг, хоёр жил гэсэн. Сая яг таны хэлснээр төсөл нь бол орж ирсэн юм Засгийн газраас. Тэгээд ажлын хэсэг дээр энийг бүр таван жил болгочихсон. Өөрөөр хэлбэл огцруулах одоо хэмжээний ийм ноцтой зөрчил дээр бол тэр нэг хоёр жил бол бага байна. Таван жил нэгдүгээрт. Хоёрдугаарт яг сахилгын хэрэг үүсгэсэн тохиолдолд тэр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг нь бас зогсоочхож байгаа зогсоо. Өөрөөр хэлбэл тэр таван жил байна уу хамаагүй. Ингээд ийм хоёр зарчмын одоо саналыг дэвшүүлсэн байгаа. Шүүхийн энэ эдийн засгийн бие даасан байдлыг хангах чиглэлд бол үнэхээр анхаарахгүй бол бас болохгүй. Сүүлийн долоон жил хөрөнгө оруулалт ноль. Яагаад гэхээр энэ чинь шүүгч гоё өрөөнд суугаад гоё тавилга хэрэглэх гээд байгаа асуудал биш. Энэ чинь дандаа шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдийн асуудал байгаад байгаа юм.

Жилдээ одоо тэр далан мянган хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх, тэр шударгаар шийдвэрлүүлэх, тэр одоо боломж нөхцөлийг хангах хүрээнд бол үнэхээр анхаарах ёстой юм байна лээ. Тийм учраас одоо хоёр дахь хэлэлцүүлэг дээр бол одоо Улсын

Их Хурлын бас тогтоолын төслийг бас ажлын хэсэг боловсруулж бэлтгэж байгаа. Ялангуяа энэ одоо шүүхийн байр савтай холбоотой асуудлыг нэг таван жилийн дотор бол шийдчих юм байна лээ. Энэ дээр бол их мөнгө ч орохгүй юм байна лээ. Энэ цалин хангамж яриад байгаа. Энэ ерөөсөө их мөнгөний асуудал биш. Жишээлбэл цалингийн нэмэгдэл гээд шүүгчдийн хоёр хувийн нэмэгдэл нь ердөө тавин мянган төгрөгийн л асуудал байхгүй юу. Энэ ерөөсөө сарын их мөнгөний асуудал бас яриад байгаа гэж иргэд маань бас ойлгож болохгүй. Би түрүүн хэлсэн шүү дээ. Туслах нарийн бичиг нь долоон зуун мянган төгрөгийн цалинтай.

Тэгээд хүн ажиллахгүй тогтохгүй байгаад байгаа байхгүй юу. Ажлын хэрэг гээд тэрэн дээр нөгөө ирэхгүй. Тэр хуульч мэргэжилтэй залуучууд ийм болчихсон юм байна лээ. Тийм учраас үнэхээр одоо таны хэлсэн энэ одоо эдийн засгийн бие даасан байдлыг нь бас нэг хангах дээр нэг анхаарчихмаар болчихсон юм байна лээ.

Г.Занданшатар: Сайнбуянгийн Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Нэгдүгээрт энэ нэгдүгээрт энэ шүүгчийн алдаа зөрчлөөс үүдэн хүн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр хариуцна гэдэг ийм сонин заалт явж байгаа. Энэ ямар учраас шүүгчийн гаргасан алдааг төр хохирлыг нь барагдуулах. Тийм бол бид одоо шүүгчийн хариуцлага ярих ийм шаардлагагүй болж таарах гэж байна шүү дээ. Хэрэв төр бүгдийг нь хариуцаад, хохирлыг нь барагдуулаад байвал нэгдүгээрт. Хоёрдугаарт энэ хууль шүүх шударга ёсны шүүлтүүр болсон шүүхийн хараат бус байдал алдагдсан гэдэгтэй бүгд санал нэг байгаа. Энийг засах олон чухал зүйл заалтууд энэ шүүхийн тухай хууль дагалдан одоо өөрчлөгдөж байгаа хуулиуд дээр орж ирж байгаа. Энэ бол маш одоо сайн өөрчлөлт болж байгаа гэж бодож байгаа юм. Гэхдээ энэ шүүхийн хуулийн үг, үсэг, зүйл заалт бүхэн маш тодорхой байх ёстой.

Жишээ нь, Үндсэн хуульд Улсын Их Хурал шүүгчид нэр дэвшигчид танилцах сонсгол хийнэ гэж байгаа юм. Хэрэв хийхгүй бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Ерөнхийлөгчид бичгээр хүргүүлнэ гэсэн ийм хоёр салаа утгатай заалт байгаад байгаа юм. Үндсэн хуульд сонсоно гэж заасан л бол Улсын Их Хурал энэ үүргээ биелүүлж ер хоногийн дотроо сонсох ёстой. Тэгэхээр энэ заалт одоо ингэж өөрчлөгдөхгүйгээр явах нь зөв үү гэдэг хоёрдугаар асуулт байгаа юм.

Гуравдугаарт нь мэдээж сахилгын хороо, сахилгын хороо гэдэг энэ бүтэц, байгууллага Үндсэн хуулиар бий болж байгаа. Хариуцлага алдаа дутагдал гаргасан шүүгчтэй хариуцлага тооцох механизм улам бүр нарийн болж байгаа. Тэр хэрээрээ энэ байгууллагын эрх үүрэг онцгой одоо чухал болж байгаа юм. Гэхдээ сахилгын хорооны гишүүдтэй тооцох хариуцлагын асуудал, дахиад сахилгын хороонд хяналт тавих, ерөнхий зөвлөлийн үүрэг хариуцлага, тэдгээрийн уялдаа холбоо, бие биеэсээ хараат бус байх тэр боломж, нөхцөлийг өшөө нарийн бий болгож өгөх зайлшгүй шаардлагатай байна.

Г.Занданшатар: Амарсайхан гишүүн 1 минут тодруулъя.

С.Амарсайхан: Тийм учраас энэ зүйл заалттай холбоотой олон зүйлүүд дээр бас цаашдаа анхаарч асуудлуудыг бас тодорхой болгох хэрэгтэй. Байнгын хороон дээр бид бас нэлээн ярьсан. Гэхдээ энэ дээр мэргэжлийн алдаа юу, үнэхээр ёс зүй, сахилга хариуцлагын алдаа юу гэдгийг бас ялгаж салгадаг байхгүй бол сахилгын хороо гэдэг шүүхээсээ илүү давсан эрх мэдэлтэй, шүүгчдээ шүүх нэрээр шүүхийн жинхэнэ одоо хараат байдлыг тогтоодог. Ингээд дийлэшгүй нэг газар гараад ирчих

ийм асуудал руу бид нар оруулж ирж болохгүй учраас би энэ дээр бүр онцлон тэмдэглэж хэлж байгаа юм. Одоо ингээд шүүгчийн сахилга, хариуцлагатай холбоотой бүх асуудал сахилгын хороогоор орно. Асар их ачаалал бий болно. Гэхдээ энэ дотор ажлаа шударгаар хийж байгаа шүүгчид бас хохирч болохгүй. Шударга бусаар хийж байгаа, ажил гүйцэтгэж байгаа алдаа гаргаж байгаа шүүгчдээ бол асар одоо хатуу хариуцлагыг нь тооцох ёстой. Энэ бүхний ялгааг гаргах зүйл бол саяын ярьдаг тэр сахилгын хорооны гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага.../минут дуусав/

Г.Занданшатар: Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Амарсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Амарсайхан гишүүн бас Байнгын хорооны хурал дээр их олон чухал асуудлыг хөндсөн, хөндсөн. Сая одоо жишээлбэл энэ Улсын Их Хурал, Улсын дээд шүүхийн шүүхэд шүүгчид нэр дэвшигчтэй танилцаж, тэгээд Ерөнхийлөгч томилно гээд энэ Үндсэн хуульд байгаа заалт байгаа. Тэгээд энэ нь танилцах гэдэг тэр нөгөө процессыг нь ер нь хуульд сайн нарийвчилж тусгаагүй байсан юм байна лээ. Тэгээд энэтэй холбоотой жишээлбэл одоо жишээлбэл Цогт шүүгч танилцагдсан, бас нэг банкны төлөөлөл болоод байгаа гээд Батхүлэг гэдэг хүнийг одоо болтол Улсын Их Хурал танилцаагүй ч гэдэг юм уу. Тэгээд ажлын хэсэг дээр бас ярьсан. Энэ дээр бас нөгөө Улсын Их Хурлын гишүүдийн ч гэдэг юм уу бас ингээд тайлбарлагдаад дур зоргоор тайлбарлагдаад ингээд ийм жиш буруу жишиг тогтоож бас болохгүй. Нэгэнт Үндсэн хуульд байгаа заалт учраас энэ танилцах процессыг бас дэлгэрүүлж бичье. Ер хоногийн хугацаанд бол Улсын Их Хурал танилцдаг байх ёстой. Хууль зүйн байнгын хороо ямар хугацаанд танилцдаг байх юм.

Тэгэхдээ танилцах сонсгол гэдэг зүйлийг заавал хийдэг байя. Улсын Их Хурал, энэ дээд шүүхийн нэр, шүүгчид нэр дэвшигчид. Тэрнээс биш гэнэт Байнгын хороо юм уу чуулган хуралдах гэж байхад өглөө нь ширээн дээр нь анкет нь тавигдаад л. Тэгээд энэ чинь юу билээ? Хаана харсан хүн билээ гэж байтал алх тогшоод ингээд яваад байж бас болохгүй. Яагаад гэхээр тухайн хүн гишүүд танилцах гээд байгаа биш, Улсын Их Хурлаар дамжуулж ард түмэнд танилцуулах гээд байгаа юм. Ард түмэнд танилцуулах гээд байгаа байхгүй юу. Ийм хүн дээд шүүхийн шүүгч болох гээд байгаа юм байна гэж. Тэгэхгүй бол өнөөдөр жишээлбэл зүгээр тэрүүгээрээ шууд Ерөнхийлөгч дээр хэрэв очдог байсан бол хаана ямар хүн юу болж байгааг бас мэдэхгүй л байх байсан.

Тийм учраас энэ дээр бол бас ийм танилцах процесс хийе. Тэгээд тэр хугацаа нь өнгөрвөл танилцсанд тооцдог байя гэдэг ийм бас одоо Улсын Их Хуралдаа бас шаардлага тавьсан.../минут дуусав/

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Сайнхүүгийн Ганбаатар.

С.Ганбаатар: Энэ хууль санаачлагч Энхбаяр гишүүнээс асууя. Энэ бол захиалгын хууль байна. Энэ хуулийг баталснаараа Ардын намын зарим удирдлагууд одоо шоронд байгаа. Энэ цагаан захтны арван гурван том бүлэг гэмт хэрэгт нь Оюу толгой дөчин есөн хувь гээд. Эд нар шоронгоос суллагдана. Ийм л аюултай үр дүн гарна гэж би харж байна. Тэгэхлээр би гаргалгаа гарцаа яриад байгаа шүү дээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл дээр ирж энэ шүүгч нарын асуудлыг сахилгажуулах асуудал ярьж байж энэ одоо хүмүүс тогоо чөлөөлж байгаа, энэ өнөөдрийн Салхитын орд гээд нааштай зүйлүүд гарч байгаа. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдүүлдэг энэ механизмыг яагаад халж байгаа юм бэ?

Захиалгаар орж ирж байгаа. Үндсэн хуульд тэгж заагаагүй байж болно. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд Үндсэн хуулийн байгууллагууд. Миний энэ асуултад хариулаач. Энэ миний саналыг яагаад авсангүй вэ? Эцсийн эцэст шүүгч нарыг шүүдэг хариуцлагатай байлгадаг хүмүүс чинь хар толгойгоороо хариуцлага үүрдэг. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Их Хурлын дарга гурав. Эзэн биегүйдүүлж байна. Одоо далан зургаа, одоо дөрвөн зуун тавин шүүгч дундаасаа гаргана. Дөрвөн зуун тавин суугчийг дараа нь хариуцлага тооцох юм уу? Далан зургаа дотор бол энэ бүлэглэлийн толгойлогч нар л энийг шийднэ.

Та нар түрүүн их гоё нээлттэй хэлэлцүүлэг, нээлттэй процедур их олон ярилаа, өглөөжингөө ярилаа. Олон нийтийн радио телевизийг өнөө өглөө сонгосон нэг хүнийг. Яг энэ арваад жилийн өмнө энэ хууль ийм зузаан хууль байгаа. Нээлттэй сонсоно ард түмнээрээ хэлэлцүүлнэ. Олон нийтийн радио телевизээс ямар ялгаа байгаа юм. Олон нийтийн радио телевизийн эздийг эрх баригчид тавьдаг, эрх баригчдын эрх ашгийг гүйцэлдүүлэхээр ажилладаг. Тэр бидэнд бол пад байхгүй. Олон нийтийн радио, телевизийн энэ үндэсний зөвлөлтэй утга нэгээр гарч ирнэ. Хариуцах эзэнгүй болно. Энэ шүүгч нарыг шүүдэг хүмүүс эзэн биегүй болно. Жинхэнэ манай шүүгч нар.../минут дуусав/

Г.Занданшатар: Энхбаяр гишүүн ажлын хэсэг асуултад хариулъя.

Б.Энхбаяр: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Манай Ганбаатар гишүүн бол тэр хэлбэр хийц бол үнэхээр л нэг шударга ёсыг тогтоох гэж байгаа юм шиг хэлбэртэй. Тэгээд яг ярьж байгаа юм нь нөгөө хонгилоо авч үлдэх юм ярьж байгаа байхгүй юу. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл одоо энэ шүүгч нарыг халж сольдгийг хэвээр нь авч үлдье гэж ярьж байгаа байхгүй юу. Энэ чинь Үндсэн хууль зөрчиж байгаа шүү дээ. Үндсэн хуулиар энэ чинь шүүгчийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр сахилгын хороо огцруулж, чөлөөлдөг болно гээд Үндсэн хуульд өөрчлөлт орчихсон шүү дээ. Тэгэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтийн Үндсэн хуулийн эсрэг санал яриад байгаа байхгүй юу. Энэ нөгөө хонгилын эрх мэдлийг одоо би яагаад авч үлдэх гээд ийм юм яриад байгааг ерөөсөө ойлгохгүй. Яг нөгөө улс төрийн асуулт тавьсан учраас би бас улс төрийн үг хэлье гэж бодож байгаа юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчид Улсын Их Хуралд суудалтай нам нэр дэвшүүлдэг. Монгол ардын хувьсгалт нам бол Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх Үндсэн хуулийн эрхтэй нам. Хэн дэвших гээд, бас тэнд юм, юу харагдаад, тэр эрх мэдэл нь Ерөнхийлөгчийн эрх мэдэл байхгүй болох гээд байхаар тэнд нь бас нэг эрх мэдэл үлдээчих гээд юм бодож санаад ингээд яриад байдаг юм болов уу хүртэл гэж одоо би бодох юм. Одоо бүр. Улс төрийн асуулт асуухаар улс төрийн л юм боддог юм байна шүү дээ, энэ чинь тийм. Тэгээд Үндсэн хуулийн хүрээ Үндсэн хуулиа хэрэгжүүлье гэхээр үндсэн хуулиа битгий хэрэгжүүл гээд байх юм. Үндсэн хууль гэдэг чинь ард түмэн шүү дээ, тийм. Тэгэхээр ард түмний тэр үзэл санааны үнэт зүйлийг яг ярьж байгаа юм нь эсрэг юм яриад байх юм. Энэ хонгилоо нураалгахгүй байлгах тухай, авч үлдэх тухай.../минут дуусав/

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн нэмж хариулъя. Дараа нь.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр би энэ нэг энэ асуултыг, энэ удаа дараа энэ зарим гишүүд яриад байна л даа. Энэ Улсын Их Хурал чинь шийдээд байдаг болчихдог нь буруу шүү дээ гээд одоо яриад байгаа юм. Улсын Их Хурал нэг нам олонх боллоо гэдэгтэй их холбож яриад. Энэ улсад чинь хууль тогтоох цорын ганц, одоо эрх мэдэл чинь энэ Улсын Их Хуралд хадгалагдаж байгаа шүү дээ. Энэ Улсын Их Хуралд байгаа

гишүүд гэдэг чинь ард түмний төлөөлөгчид. Бид нар Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөөг шинэчилсэн. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ бол энэ бол энэ Улсын их хурал гэдэг бол цаашдаа ард түмний төлөөлөгчдийн байгууллага болж, тэр тусмаа ард түмний засаглах бүрэн эрхийг хангадаг энэ байгууллага болж төлөвшиж явна гэж алсын хараа, эрхэм зорилгоо тодорхойлчихоод явж байна.

Тэгээд албан ёсны шийдвэр гаргадаг энэ байгууллага чинь оруулаад тэр улсуудаа томилж байгаа юм. Тэр нэг хэсэг хүмүүс нь сахилгын хороон дээр жишээ шүүгчдийнхээ дотроос гарч ирж байгаа чинь тэр шүүхийн дотоод ардчиллын үүднээс шүүх өөрөө өөрийнхөө хүрээнд зохион байгуулаад төлөөлөгчийгөө оруулж ирж байгаа юм. Ардчилал гэдэг бол хяналт тэнцвэр шүү дээ. Тэгээд яагаад энэ бол түрүүний, тэр Ганбаатар гишүүний яриад байна шүү дээ. Ерөнхийлөгчид Их Хурлын дарга, Ерөнхий сайдад ойлгомжтой хүмүүст байсан чинь эзэн биетэй хүмүүсээс хариуцлага хүлээх хүнгүй болчихлоо. Хариуцлага хүлээх хүн тодорхой. Монгол Улсын Үндсэн хуульд хуулийн биелэлтийг Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын өмнө хариуцан заасан. Энэ яагаад хамтын удирдлагатай байгууллага болгож, шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн сахилгын хороог ингэж өргөтгөж ес, арван хүнтэй болгож байгаа юм бэ гэхээр эрх мэдлээ энэ ажлын хэсгийн алхагч удаа дараа хэлээд байна шүү дээ. Энэ шүүхийн системд хонгил үүсээд байгаа чинь улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, бүх шатны ерөнхий шүүгч, гадна талд нь Ерөнхийлөгч гэдэг босс ийм улсууд энэ эзэн биетэй гээд нэг хариуцлага хүлээдэг улсууд чинь энэ. Монгол улсын шүүх чинь дэлхийд зуун дөчөөс зуун хоёрдугаарт орчихоод байгаа. Улс төрийн нөлөөнд автаад байна гэж байгаа юм. Дотор талаасаа далд ийм сүлжээ ажиллаад байна гэж.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганбаатар гишүүн 1 минут.

С.Ганбаатар: Энхбаяр гишүүн миний асуултад хариулсангүй л дээ. Энэ шүүхийн энэ шинэчлэлийн реформ хийснээрээ ийм цагаан захтнууд дээр хариуцлага тооцдог, ийм улам сахилгатай, хариуцлагатай болох уу гэж би асуусан. Өөдөөс энэ ямар жижигхэн юм асуудаг юм бэ. Намайг Монгол Улсын Ерөнхийлөгч болохын тулд болчихно гэж бодоод ийм юм яриад байна гэж бодож байна уу. Ийм жижиг юм ярьж байхаа боль. Болох болохгүй бол Монголын ард түмэн шийддэг юм. Чи ч шийддэг юм биш. Тэгэхлээр шүүгч нарыг шүүдэг хүмүүсийг татдаг хүмүүс нь Улсын Их Хурал дотор байгаа бүлэглэлийн толгойлогч нар болох гээд байна л гэж би хариулсан. Энэ дээр ямар гарц гаргалгаа байгаа. Олон нийтийн радио телевизийн удирдах зөвлөлийг тавихдаа одоо мөн ямар гоё процессууд ярьж байж тавилаа, тэр хэрэгжиж байна уу гэдгийг л би ярьсан. Дээр нь нэмээд өнөөдөр шүүх ер нь яг нарийн яривал маш хараат бус ажиллаж байгаа шүү дээ. Манай шүүх гайхамшигтай.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганбаатар гишүүн ээ, энэ манай шүүхийн хариуцлагатай байдал, хараат бус байдал гэдэг хоёр бол нэг зоосны хоёр тал л даа. Тэгээд энэ байдлаараа дэлхийн улсуудаас зуун хорьд явж байгаа учраас асуудал нь хүндэрсэн, ард түмний дунд нэр хүндээ алдсан учраас үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр шийдвэрлэдэг хуулийг Улсын Их Хурал баталсан. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр дөчин есийн хоёр, дөчин есийн тавыг хэрэгжүүлэх зорилгоор бол сахилгын хороо гэж байгуулж байгаа учраас шүүх өөрөө өөрийгөө бие даасан, засаглалын хувьд авлигал, хээл хахууль болон хариуцлагагүй байдлаас сэргийлэх ийм хороотой болж байгаа учраас тийм учраас мэргэжлийн алдагч алдааг ч гэсэн оруулж засъя энэ тэр гээд ингээд нарийн техникийн асуудал руу ороод байна шүү дээ. Зүгээр шүүх яаж асуудал шийдэж байсан, маш олон практик дээр мэргэжлийн

алдаа нэрийн дор ёс зүйн алдаа нарын дор зүгээр өнгөрдөг байсныг чинь одоо ингээд сахилгын хариутай болж цэгцэлж байгаа учраас тэр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр оруулдаг асуудал өөрөө хүчингүй болж байгаа юм. Авлигын хуулиар энэ хүчингүй болчихсон. Ингээд л энэ хууль бол үндсэндээ ингээд энэ механизм нь бүрдэж байгаа. Үндсэн хуулийн механизм бүрдэж байгаа учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу энэ хүний эрхийг хангахын тулд энэ гурван засаглал бие биеэ хянаж байх ёстой энэ нөхцөлийг бүрдүүлж байгаа учраас тэр хууль хүчингүй болж байгаа юм гэдгийг та бас ойлгохыг хүсэж байна аа? За одоо ингээд эрхэм гишүүн Тогмидын Доржханд асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа нэг минутаа нэмээд авчихъя даргаа. Тэгэхээр Монгол Улсын эдийн засаг агшиж байгаа. Сүүлийн арван жил ердөө арван тэрбум доллар одоо агшаа л байгаа шүү дээ, агшаа л байгаа. Тэгээд энийг чинь тэлдэг зүйл нь юу юм бэ гээд тэгэхлээр гадна дотнын хөрөнгө оруулалт юм. Гэтэл гадна дотнын хөрөнгө оруулагч нарыг бүгдийг нь барьж хорьсон ийм сүүлийн арван жил боллоо. Өнөөдөр Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой нэг ч хүн байхгүй шүү. Өнөөдөр тухайлбал Английн нэг хөрөнгө оруулаад арван жилд явсан хүн шоронд байж л байна. Яагаад вэ гэхлээр тодорхой нэг улс төрд бол нөлөөтэй эрх мэдэлтэй болохлоор өөрийнхөө өрсөлдөгчийг шүүхээрээ захиалгаа өгөөд л хорьчихдог. Тэгээд тэр хүн чинь бусад нөгөө хөрөнгө оруулагчид хэлээд байна шүү дээ. Монголд ерөөсөө хөрөнгө оруулж болохгүй шүү гээд. Тэгээд энэ чинь юу гэсэн үг вэ гээд тэгэхлээр шүүхийн тогтолцоо чинь болохгүй байна шүү дээ.

Хэчнээн эдийн засгийн зөв сайн бодлого явууллаа гээд шударга шүүх байхгүй тохиолдолд хэн энэ эдийн засаг чинь хөрөнгө оруулж, хэн нэгнийг хэчнээн сайхан бодлого явуулаад үр дүн гарах юм бэ? Тэгээд ийм болохлоороо миний хувьд бол эдийн засагч хүний хувьд бол энэ одоо буруу бодлого байсан уу гэвэл байсан гэж боддог. Өмнөх Ерөнхийлөгч бол энэ хонгилыг үүсгэсэн гэдэгт итгэж явдаг. Одоогийн Ерөнхийлөгч түүнийг цементэлж байгаа гэдэгт бүр их итгэлтэй байгаа. Тийм болохоор энэ хуулийг бол дэмжиж байгаа. Шинэчлэлийг бол хийх хэрэгтэй. Харин тэгэхдээ нэг дайснаас айгаад нөгөө дайсанд ч гэдэг юм уу эрх мэдлийг шилжүүлэх нь зөв үү, буруу юу гэдэг дээр харин дүгнэлт хийгээрэй гээд. Тэгээд үүнтэй холбоотойгоор нэг гурван асуудал байна. Нэгдүгээрт энэ шүүхийн сахилгын хороо гээд есөн хүний бүрэлдэхүүнтэй байгуулж байгаа юм байна. Дөрвийг нь шүүгчид өөрсдөө түүгээрээ, тавыг нь болохоор улс төрчид шийдэх юм байна. Энэ таван хүнийг их хурал дээр бол ярих юм байна. Тэгэхдээ ярих, хэлэлцүүлэг хийхдээ олон нийтэд нээлттэй хэлэлцүүлэг хийгээд нийтийн сонсгол дээр үндэслээд за иргэний нийгмийн төлөөллүүдийг оролцуулаад шийдэх ийм хувилбар байна уу? Энийг бодож үзсэн үү нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарх нь шүүгчийг нэг удаа сонгоод л энэ их мундаг шүүгч байна гээд л ингээд цементлээд хаядаг. Гэтэл нөгөөдөх нь үр дүн нь өөр байдаг. Энийг өөр байдлаар хийж шийдэж болохгүй. Тухайлбал Холбооны Герман Улсад бол гурваас таван жил тухайн шүүгчийг ажиллуулаад туршилтын журмаар болж байна гэж үзэх юм бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Доржханд гишүүн нэг минут нэмж өгье.

Т.Доржханд: Болж байна гэж үзсэн тохиолдолд түүнийг нь насан туршид нь ингээд эрхийг нь өгөөд шүүгчээр ажиллуулаад явдаг ийм системийг хийж болох уу? Дараачийнх нь Үндсэн хуулийн цэц бол шүүх юм гээд ажлын хэсгийн ахлагч ярьж байна. Би бас санал нэг байна. Тэгвэл энэ шүүх чинь хамгийн их улс төрөөс хараат

ийм байгууллага болчихоод байна шүү дээ. Тэгээд энийг өөрчлөх талаар улс төрөөс хамааралгүй болох талаар ямар нэгэн бодлого төлөвлөж байгаа зүйл байна уу? Миний хувьд бол энэ Ерөнхийлөгчийн сонгууль бол бүрхэг заалттай болсон. Нэг удаа Ерөнхийлөгч зургаан жилээр сонгогдох заалтыг Их Хурал тодруулж өгөөгүй. Тийм болохоор би энийг Үндсэн хуулийн цэцэд бол хандана. Ирэх долоо хоногт би хандана гэж бодож байгаа. Яг эндээс яг улс төр нь нөлөө байна уу, үгүй байна уу гэдэг нь тодорхой болно. Тэгээд ийм болохлоороо яг энэ хамгийн их хамааралтай хэсгүүд дээрээ бид нар гол одоо одоо цэгээ харж ажиллах шаардлагатай. Энэ дээр бол Зөв хүн электорат эвслийн хувьд энийг төлөөлж байгаа гишүүний хувьд бол энэ тал дээр бол хамаатай байр суурь.../минут дуусав/

Г.Занданшатар: 80 Мөнхсайхан, доктор.

О.Мөнхсайхан: Доржханд гишүүн маш чухал зүйл хэллээ. Тэгээд одоо Засгийн газрын өргөн барьсан төсөл бол энэ шүүхийн сахилгын хорооны шүүгч биш таван гишүүнийг тодорхой хэмжээнд сонгон шалгаруулах ийм үзэл баримттай орж ирсэн. Ажлын хэсэг энийг тодруулж, түрүүн одоо гишүүд хэлээд байгаа дөрвөн хуудас процесс бичсэн. Энэ дээр бол ерөөсөө яах вэ Их Хурал бол ард түмнээ төлөөлж байгаа учраас легитим шинжийг нь хангах үүднээс сонгон шалгаруулагдаад гарч ирчихсэн хүмүүсийг хүлээн зөвшөөрөх асуудлыг л эцсийг нь энэ нэгдсэн хуралдаан дээр хийх юм. Энэ нь улс төрийн зүй бус нөлөөлөл бүх дур зоргыг хаасан маш нарийн процессыг хийхээс гадна энд түрүүн таны хэлдгээр иргэний нийгэм, мэргэжлийн холбоодын оролцоог бол маш сайн хангаж өгсөн ийм санал орж ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл хэн сахилгын хорооны шүүгч таван гишүүн байх вэ гэдгийг арван нэгэн хүний бүрэлдэхүүнтэй мэргэжлийн хөндлөнгийн ажлын хэсэг шийдэх. Энэ дотор хоёр мэргэжлийн холбоо, хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбоо, хүний эрхийн үндэсний комисс, хууль зүйн их дээд сургууль, Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Ерөнхийлөгч гээд яг тал талын төлөөлөлтэй ийм ажлын хэсэг байгуулна. Эд нарын бараг тавин хувь нь мэргэжлийн энэ иргэний нийгмийн төлөөлөл орж байгаа учраас энэ дээр зүй бус нөлөөлөл орж, аль нэг нь давамгайлах ийм боломж бол хязгаарлагдаж байгаа юм.

Эндээс олонхын санал авсан таван хүн гарч ирнэ. Энэ дээр Хууль зүйн байнгын хороо бол яг америкийн дээд шүүхэд сая есөн сард хийсэн шиг маш том нээлттэй сонсгол хийнэ. Иргэд сонирхсон этгээдүүд саналаа өгөх, үг хэлэх асуултаа өгөх ийм боломжтой. Энэ дээр Их Хурал дахь олонх, цөөнхийн бүх төлөөллүүд тэнцүү байдлаар оролцож хэн нь хэн бэ, үнэхээр сайн хүн гаргаж уу гэдэг нь шүүх ийм боломж бүрдэж байгаа. Тэгээд Их Хурал руу ороод Их Хурал тэрийг дэмжих эсэх шийдвэрийг гаргаж байгаа. Тэгээд ер нь бол европын ийм шүүхийн сахилгын хороо, ерөнхий зөвлөлд энэ загваруудад бол шүүгч гишүүдийг нь шүүх дээр сонгуулж байгаа юм. Хараат бус байдлыг нь хамгаалах, зүй бус нөлөөллийг нь сааруулах үүднээс. Бусад гишүүдийн энэ ардчилсан зарчмаар парламент нь гаргаж ирдэг нь бол дийлэнх сайн жишиг. Ингэхдээ саяынх шиг зүй бус.../минут дуусав/

Г.Занданшатар: Ер нь дэлхийн улсууд Америкт хүртэл одоо сенатаараа сая шүүгчдийг хүртэл томилж байгаа шүү дээ. Тэгэхдээ манайх шинээр энэ сонгон шалгаруулалтын засаглал буюу одоо энэ нээлттэй сонгон. Сая хүний эрхийн үндэсний комиссын гишүүдийг сонгон шалгаруулдаг, илүү процессыг нь нарийвчлаад, ингээд хараат бусаар иргэний нийгмийн ч гэсэн оролцоотой ийм жишгийг манай парламент одоо анх бий болгосон. Одоо энийг л улам цаашаа зөөлрүүлэх шаардлагатай. Үндсэн хуулийн дагуу төрийн эрх барих дээд байгууллага учраас. Үндэсний олон нийтийн радио телевиз ч гэсэн тийм болно. Сая

бол сонгон шалгаруулалт анх удаа хийж үзлээ шүү дээ. Юу нээлттэй сонгон зарлалаа шүү дээ. Тэрүүхэн хавьдаа л ингээд томилдог байсан. Эрхэм гишүүн Цэвэгдоржийн Туваан, байж байгаарай. Сүүлчийн асуултад Энхбаяр гишүүн бас хариулна гэсэн. Туваан гишүүн.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ цэцийн бол үнэхээр шүүх олон хуулиар олон сайхан юмыг бид бид бас хийж чадна. Хийхийг хүсэж байгаа. Их Хурлын дарга маань бас хэлээд байгаа шүү дээ энэ эрх зүйн хувьсгал хийнэ гэж. Эрх зүйн хувьсгал гэдэг маань юу яриад байна вэ гэхээр энэ чинь цогц реформ хийхийг хэлээд байгаа юм. Энэ дотор Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжийн шинэчлэл хүртэл багтах ёстой. Тэгэхгүй бол одоо жишээлбэл өмнө нь хоёр мянга арван хоёроос арван зургаан онд одоо Ганбат дарга Хууль зүйн байнгын хорооны даргаа. Маш олон хуулиудыг баталсан. Гучин одоо гол суурь асуудлуудыг цэц нухаад уначихсан байхгүй юу, хүчингүй болгочихсон. Тэгээд ямар ч сайхан юм бодоод бид энд баталдаг. Тэнд нэг ямар нэгэн жижиг улс төр ингээд ороод нөгөө цэцээр аваачаад хамаг юмнуудыг нь тасдаад, тасдаад нэг жижигхэн эрх мэдэлтэй байх гэсэн, өөртөө нэг хаан болох гэсэн ийм одоо сонирхлуудаар цэц дээр үгүй хийсэн байхгүй юу.

Тийм учраас бид нар одоо энэ удаагийн хуулийг хийхдээ ажлын хэсгийн тухайд тэр олон цэцийн шийдвэрүүдийг бас үзсэн. Яг ямар үндэслэлээр цэц шийдвэрүүдээ гаргаж байсан байна? Одоо бол Үндсэн хуулийн цэц дээр очоод бол унахааргүй. Тэр одоо судалгаа юмнуудыг хүртэл одоо тооцож. Энэ чинь одоо бүгдийг сайнаар бодохоос гадна бүгдийг бас муугаар бодох ёстой юм байна шүү дээ. Хууль хийхэд чинь. Аль аль талаар нь бодож. Тэнд чинь нэг хүн байгаа гэж бас хүртэл бодож. Тэр хүн нь бас жижигхэн, сонирхолтой байж магадгүй гэж хүртэл бодож ингэж одоо хийх ёстой юм байна лээ. Тэгээд Үндсэн хуулийн бас цэцийн хууль тогтоомж бол бас цаашдаа үргэлж үргэлжлүүлээд болж шинэчлэгдэх байх гэж ингэж бодож байгаа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Ардчилсан намын хувьд бол шударга ёсыг хамгийн их ярьдаг. Энэ шударга ёсыг хэрэгжүүлэх газар нь бол улсын хувьд шүүх эрх мэдэл, шүүх засаглал байдаг. Тэгэхээр энэ хууль дээр бол Ардчилсан нам маш анхааралтай хандаж оролцож байгаа гэдгийг бас энд хэлье. Энэ зарчмын зөрүүтэй саналын Байнгын хорооны санал, дүгнэлтийн цаасыг үзсэн чинь арван найм дээр нь улс төрийн намын бүртгэл хөтлөх гээд орчихсон байна. Энийг тодорхой хүмүүс Энхбаяр ажлын хэсгийн дарга, улсын дээд шүүхийн төлөөлөл, энэ ажлын хэсгийн гишүүн хэн хаачсан. Баасандорж билүү? Энэ хүмүүсээ дуудаарай. Эд нар тодорхой хариултууд өгөөрэй. Энэ ямар асуудал болоод хаанаасаа хаашаа шилжиж ийм зарчмын зөрүүтэй санал орж ирж байгаа юм бэ?

Энэ Дамдинням гишүүн сая бас овоо босгож байна л даа. Овоо босгоогүй шаазгай хаанаас суух вэ. Энэ дээд шүүхийн дээр юу гээд биччихсэн байна гээд. Тэр нь одоо буруу ч юм шиг ийм байдлаар ийм овоо босгоод байх юм. Ардчилсан нам бол энэ бүх асуудлаа тэвчээртэй харж байгаа. Бид хэд бол шүүхэд асуудлуудаа өгчихсөн. Дээд шүүхийн захиргааны хэргийн шүүхийн асуудлуудаа л харж байгаа, тэвчээртэй хүлээж байгаа. Тэгэхээр аливаа юманд улс төрийн соёл гэж байх ёстой. Улс төрийн бас нэг улс төрчдийн жудаг гэж юм байх ёстой. Бид хэдийг тэвчээртэй байж байхад энэ мэтчилэн ингэж хатгах хэрэггүй. Хэн, хэн, хэний хатгалгаар, хэн оролцоод, юу яваад байгааг бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Цаг нь болохоор энийг гаргаж хэлнэ. Ардчилсан намын амин сүнс бол тамгандаа байдаггүй юм. Үзэл баримтлалтай байдаг юм, үнэт зүйлтэй байдаг юм. Хоёр зуу гаруй мянган гишүүддээ байдаг юм.

Дээрээс нь ардчилалд хайртай Монголын ард түмэн бас бид нарыг ойлгож дэмжих үедээ дэмждэг юм.

Тэгэхээр энэ нэг тамга дээр ач холбогдол өгөөд байгаа юм байхгүй юу. Бид нар шүүхүүд шүүхийн одоо энэ шийдвэрүүд.../минут дуусав/

Г.Занданшатар: Туваан гишүүн нэг минут.

Ц.Туваан: Тэгэхээр бас бие биедээ хүндэтгэлтэй хандсан нь зөв байх. Тэгээд ерэн онд бас манай ахмадууд ярьдаг энэ тэр үед бас адилхан тэгээс эхлээгүй шүү. Нэг нь үргэлжлүүлээд нэг нь тэгээсээ эхлээд ингээд явсан. Монгол Улсын Ерөнхий сайд сөрөг хүчиндээ хүндэтгэлтэй хандана л гэсэн. Өнөөдөр арай ингэж хүндэтгэлтэй хандаагүй байх гэж би ингэж бодож байна. Энэ дээр бол бас Лүндээжанцан дарга энэ тэр орж ирчихсэн байгаа, бас саналаа хэлбэл зүгээр байна.

Тэгээд энэ ажлын хэсгийн дарга маань ингээд улс төрийн хариулт руу ингээд ороод явж болдог юм уу? Энэ хүнийг Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга болгоод л зарим хүнийг хонгилчин болгоод ингээд бас нэг жоохон шударга жудагтай баймаар байна. Ингээд ер нь бол бас бид нар тэвчээртэй хүлээж байгаа гэдгээ хэлье. Хууль зөрчиж асуудал яриад байгаа нөхдүүдтэй эцсээ хүртэл ярина, тэмцэнэ. Монголчууд бол дандаа олонхын талд ордоггүй шүү, бас цөөнхийн талд ордог цаг байдаг шүү. Тэгэхээр энэ дээр бас нэг нэгнийхээ асуулт.../минут дуусав/

Г.Занданшатар: Нямбаатар сайд асуултад хариулъя.

Х.Нямбаатар: Туваан гишүүний асуултад хариулъя. Одоо улсын дээд шүүхийн иргэний танхим дээр улс төрийн намуудын бүртгэл хийгдэж байгаа. Улс төрийн нам бол угтаа бол энэ нийтийн эрх зүйн субъект байгаа. Яг энэ утгаар нь харьяалж улс төрийн намын бүртгэлийг хийе гэвэл захиргааны хэргийн шүүх захиргааны танхимд бүртгэлжүүлэн харайлах учиртай юм шиг байгаа юм. Тэгээд бид нар яагаад энэ саналыг оруулж ирсэн бэ гэвэл цаашид энэ Монгол Улсад ардчиллын үнэт зүйлийн гол баталгаа нь олон намын тогтолцоо юм. Олон намын тогтолцоо, тэр дундаа улс төрийн намыг бүртгэх, улс төрийн намын дүрмийг баталгаажуулах энэ зүйлд аль нэг улс төрийн хүчин, эрх баригчид оролцохгүй байх үүднээс улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар энэ улс төрийн намын бүртгэлийг хийлгэх нь зөв юм. Энэ нь өөрөө ардчиллын баталгаа болно гэж бид ярилцаж оруулж ирсэн юм.

Хоёр гэвэл та бүхэн санаж л байгаа байх. Улс төрийн намуудын тухай хуулийг зөрчиж хоёр мянга арван нэгэн онд Монгол ардын хувьсгалт нам гэдэг нэрийг дахиж хорин дөрвөн жилийн хугацаанд аль нэг нам, улс төрийн хүчинд өгөх ёсгүй байтал мөн улсын дээд шүүхийн иргэний танхим дээр Монгол ардын намын, одоо тэр уугуул нэрээ сэргээсэнтэй холбоотой хувьсгалт нам гэдэг нэрийг Монгол ардын хувьсгалт намд өгч байсан. Ийм зүйл цаашид бүү давтагдаасай гэдэг үүднээс. Цаашид бусад улс төрийн намууд, эрх баригч нь сөрөг хүчнээ одоо өөрсдийн тэр сүр хүчээр далайлган, намын дотоод хэрэгт оролцдог явдлыг таслан зогсоох үүднээс энэ өөрчлөлтийг бид нар оруулж ирж байгаа.

Хорин найман оноос эхлээд шинэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу улс төрийн намуудын тухай хууль шинээр үйлчилж эхэлнэ. Өөрөө улс төрийн нам нь өөрөө гишүүнчлэлийн тоо үүний хувьд нэлээн тийм өргөдсөн, ийм хэд хэдэн улс төрийн намууд шинээр бүртгэгдэх учиртай. Энэ тохиолдолд бид нар нийт шүүгчид маань өөрсдөө шударга ёсны баталгаа болно гэж үзсэний үндсэн дээр энэ

өөрчлөлтийг оруулсан гэдгийг танд хэлье.

Г.Занданшатар: Лүндээжанцан гишүүн, зүүн жигүүрийн Тамгын газрын микрофон.

Д.Лүндээжанцан: Тэгэхээр энэ дээр энэ бүхэн бол бас тал талаасаа сайн ярих шаардлагатай л асуудал л даа. Нямбаатар гишүүн санал гаргасан. Тэр дээд шүүхийн нийт шүүгчдийн одоо зөвлөгөөнөөс бүртгэж байх тухай. Тэгэхээр яах вэ манай одоо өнөөгийн нөхцөлд бол хорь, гучин нам байгаа. Тэр болгоны өөрчлөлтийг шүүгчдийн зөвлөгөөнөөс шууд тэр болгоныг хэлэлцээд байвал одоо ямархуу их ачаалал үүсэх вэ гэдэг асуудал бол яригдсан. Би бол тухайн үедээ тэгж ойлгож байсан. Гэхдээ энэ чинь манай Байнгын хорооны гишүүд, Их Хурлын гишүүд ч л тал талаасаа ярьж байгаад шийдсэн шүү дээ. Ер нь би энийг юу гэж ойлгосон бэ гэхээр Нямбаатар гишүүний энэ санал бол хорин найман оноос нийт одоо сонгуулийн насны хүн амын нэг хувийн дэмжлэг авсан, одоо гишүүнчлэлтэй юм уу, дэмжигчидтэй нам сая улс төрийн нам болж одоо төлөвших процессын асуудлыг бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд суулгаж өгсөн учраас энийг дагаж мөрдөх, шүүхийн хуулийг дагаж мөрдөх журмын хуульдаа бол үйлчилж эхлэх хугацааг бол одоо тусгайлан тогтоож өгөх юм байна гэж ингэж бол ойлгосон байгаа гэдгийг хэлье.

Энэ хэлэлцүүлгийн явцад бол нэлээн сайн яригдах байх. Ер нь бол энэ улс төрийн намын бүртгэл хаана байх вэ, шүүх дээрээ байх уу, өөр газар байдаг юм уу, Үндсэн хуулийн шүүх дээр ч байдаг юм уу гэдэг ингээд л олон юм яригдсан л даа. Тэгээд одоогийн нөхцөлд бол энэ бол бүртгэлийн үйл ажиллагаа юм. Бүртгэлийн хуулиараа зохицуулагдаж байгаа юм. Улс төрийн намын хуулиар зохицуулагдаж байгаа юм. Тэгэхээр энэ бол хуулийн этгээдийн бүртгэл л дээ нэг ёсондоо. Ийм учраас энэ асуудлуудыг бол тал талаасаа яриад, хэрэгжих хугацааг нь, хэрэв ингэж орвол хэрэгжих хугацааг нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? 87 Сайнзориг. Пүрэвжавын Сайнзориг Хууль зүйн бодлогын газрын дарга.

П.Сайнзориг: Туваан гишүүний асуултад хариулъя. Одоогийн өнөөдрийн хууль эрх зүйн орчноор улс төрийн намын бүртгэл бол улсын дээд шүүх харьяалан шийдэж байгаа. Энэ асуудлаа бол улсын дээд шүүхийн иргэний танхим нь одоо голчлон буюу энэ асуудлыг хариуцаад явж байгааг өргөжүүлэх замаар иргэний танхим бус юм. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэх нь зохистой юм гэдэг байдлаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд бол Нямбаатар гишүүн гаргасан байж байгаа. Энэ бол нөгөө улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагаанаас бусад чиг үүрэг буюу бүрэн эрх дээр нэмэгдэж орж байгаа ийм заалт байж байгаа.

Улсын бүртгэлийн байгууллага бол сүүлд бол энэ бүртгэлийнх нь дагуу тэндээс тамга тэмдэг авах ч гэдэг юм уу, ийм зүйлүүд дээр бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулиараа оролцдог. Ийм л зүйл байж байгаа юм.

Г.Занданшатар: Нямбаатар, Хишгээгийн Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Энэ удаагийн энэ шүүхийн шинэчлэл бол их өргөн хүрээнд хийгдэж байгаа. Түрүүн зарим гишүүдийн үг дотор гарч байсан. Дөрвөн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцаануудыг өнөөдөр та бүхэн төрөлжсөн нэг хуулиар зохицуулах гэж байна. Энэ дээрээ ийм суурь судалгаа хийгдсэн үү гэдэг талаас ярьж байна лээ. Зүгээр өнгөрсөн хорин найм, хорин есөн жилийн хугацаанд шүүхийн

захиргааны байгууллага буюу хуульчдаас шүүгчдийг сонгон шалгаруулдаг энэ шүүхийн ерөнхий зөвлөл маш олон байршлаа сольсон. Улсын дээд шүүхийн дэргэд нэг байж үзсэн. Хууль зүйн сайд толгойлж нэг үзсэн. Сүүлд нь хоёр мянга арван гурван онд шүүхийн захиргааны байгууллагын тухай хуулиар бие даасан байгууллага болгосон. Ингэхдээ дутуу хийсэн гэж үздэг судлаачид ч тэр. Тэр нь юу вэ гэвэл шүүхийн захиргааны байгууллагын томилгоо Ерөнхийлөгчид шууд оччихсон. Өөрөөр хэлбэл хуульчдаас шүүгчийг шилж сонгон шалгаруулдаг байгууллагыг нь Ерөнхийлөгч томилдог. Тэндээс нэр дэвшүүлж байгаа хүнийг мөн Ерөнхийлөгч томилдог.

Энэ тогтолцоогоор бид өнгөрсөн одоо найм, есөн жил яваад ингээд болохгүй нь гэдгийг бид тал талаасаа ярилцаад, шинэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр өнөөдрийн энэ одоо шүүхийн багц хууль батлагдах эрх зүйн үндэс тавигдсан. Бидний энэ шүүхийн захиргааны байгууллагын загвар бол энэ баруун европын загвар. Ерөөсөө огт бид нар гаднын улс орны шүүхийн энэ хөгжил дэвшил рүү илүү их явсан улс орнуудын загварууд дээр бид нар бас тодорхой хугацаанд ажиллаж судалгаа хийсний үндсэн дээр өнөөдрийн энэ загварыг бий болгож байгаа юм. Тэгээд энэ загвар бол энэ зарим гишүүд буруу жишээ аваад байна л даа. Нөгөө радио, телевизийн зөвлөлийг сонгон шалгаруулахтай адилхан нээлттэй сонгон шалгаруул ч гэдэг юм уу. Энэ бол шал ондоо, тусдаа нээлттэй сонгон шалгаруулалт хийх. Нээлттэй тэр хүний талаар томилох байгууллага болон олон түмэн мэдээлэл авах, энэ замаар энэ шүүхийн захиргааны байгууллага бүрэлдэхээр болж байгаа.

Г.Занданшатар: Нямбаатар гишүүн санал хэлчихлээ дээ. Ажлын хэсэгт ажиллаж байгаа. Бямбацогт гишүүн Сандагийн Бямбацогт гишүүн Байнгын хорооны дарга өөрөө асуухгүй. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа нь асуудал дээр бол бүрэн дэмжиж байгаа. Энэ шударга ёсыг тогтоох, шүүхийн шинэчлэлийг хийх энэ асуудал бол нэг талдаа одоо иргэдээс нийгмээс аж ахуйн нэгжүүдээс энэ шударга ёсны нэхэлтэй холбогдуулж үүсэж байгаа л асуудал. Өнөөдөр нийгмийн хамгийн үнэт зүйл бол хууль ёсны асуудал. Хууль мөрдөгдөх үү, үгүй юу гэдэг асуудал. Шударга ёсны асуудал байгаа. Өнөөдөр үнийг тогтоох, үнэнд хүргэх гол ганц зам бол ерөөсөө шүүх л байгаад байгаа юм. Шударга ёсыг тогтоох зам бол ерөөсөө шүүх л байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ шүүхийг энэ улс төрийн дарамт шахалтаас нэгдүгээр салах асуудал.

Хоёрдугаарт ямар нэгэн нөлөөлөл буюу хараат байдлаас өнгө мөнгөний нөлөөллөөс салгах асуудал бол байгаа. Хоёр дахь нь. Гурав дахь нь бол энэ шүүхийн өөрийнх нь төлөөллөөс салгах асуудлууд байгаа. Шүүхийн өөрийнх нөлөөнөөс салгах асуудал. Өнөөдөр ний нуугүй хэлэхэд бол тодорхой хэмжээнд бол хэрэг төвөг бол өнгө мөнгөтэй нөлөөтэй хүмүүсийн бол талд шийдэгддэг гэдэг яриа байдаг. Энэ бол үндэслэлгүй зүйл бол биш. Өнөөдөр гаднын хөрөнгө оруулагч нар энийг хүсэж байна. Гаднын аж ахуйн нэгжүүд энийг хүсэж байна, дотоодын аж ахуйн нэгжүүд энийг хүсэж байна. Бизнес эрхлэгчид энийг хүсэж байна. Энгийн иргэд ч гэсэн энийг хүсэж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ дээр бол хаана хаанаа бол хариуцлагатай байж, энэ шүүхийг шударга байлгах, хараат бус байлгах энэ өөрчлөлтийг бол хийх ёстой гэж харж байгаа юм. Энэ хүрээнд бол тодорхой заалт бүх юмнууд бол би орсон гэж бол харж байгаа юм.

Хоёр, гурван заалтуудаар би тодорхой саналыг асуух гэсэн юм. Би арав гаруй саналыг одоо заалтыг бол санал болгож бол тавьсан. Шүүхийн шийдвэртэй

холбогдуулж, за ер нь шүүгч нар дээр хориглох асуудлыг бид нар тодорхой зааж өгсөн. Шүүгч нар хориглох асуудлыг зааж өгсөн. Тавин хоёр дээр дөч гаран заалтууд орсон. Энэ бол хангалттай болсон гэж харж байгаа. Гэтэл бусад хууль хүчний байгууллагууд алдаа оноотой хэрэг хянан шийдвэрлэсэн нөгөө хонгил руу чинь чирсэн энэ асуудлууд гаргавал яах вэ? Тэр байгууллагууд дээр бид нар ямар хариуцлага тооцох вэ? Шүүхийн шийдвэр.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Баттөмөрийн Энхбаяр ажлын хэсгийн ахлагч хариулна.

Б.Энхбаяр: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Тэмүүлэн гишүүн одоо арав гаруй саналыг бас ажлын хэсэгт ирүүлсэн. За энэ дотор ер нь шүүгч нараас гадна энэ шүүх эрх мэдлийн систем буюу энэ мөрдөгч прокурор, энэ байгууллагууд одоо бусдын тэр нөлөөлөлд ордог барьдаг, тэгээд ийм одоо хууль бус шийдвэр гаргадаг. Үүний одоо үр дагаврыг яаж одоо арилгах юм бэ? Нэгэнт өнгөрсөн, одоо хорвоо гээд ингээд уучлаарай гээд нэг ийм амаар төр хэлээд ингээд өнгөрдөг байх уу үгүй юу гэдэг олон асуудлуудыг бас ирүүлсэн. Нэгэнт одоо энэ маань зөвхөн нөгөө шүүгч, шүүхийн тухай хууль учраас Засгийн газраас бол орж ирээгүй байгаа прокурор ч гэдэг юм уу, мөрдөх байгууллагуудын хууль. Тэгэхээр ажлын хэсгийн түвшинд нөгөө хөндөж чадахгүй байгаа. Тэгэхдээ энэ ажлын хэсгээс оруулж байгаа жишээлбэл хариуцлагыг сахилгыг өндөржүүлэхтэй холбоотой, нөгөө хараат бус байдалд нь бас халдаад байвал яах вэ гэдэгтэй холбоотой. Товчдоо бол ер нь шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг л дээ.

Энэ үйл ажиллагааг хариуцлагыг бас чангалах тай холбоотой энэ дэвшилтэт саналуудыг бас анхны хэлэлцүүлгийн явцад хурал даргалагч бас чиглэл өгвөл би бол одоо дэгийн хуулийн дагуу бас прокурорт жишээлбэл тэр шаардлагыг тавьж болох байхгүй юу. Нөлөөлбөл яах вэ, нөлөө тийм ээ, хууль бус шийдвэр гаргаад байвал яах вэ? Тэр хэрэгтэн болоогүй байхад нь одоо дөнгөж одоо хэрэг үүсгэхээд л, зарлаад л, тунхаглаад л, олон нийтэд хэрэгтэн болгоод л, яллаад л, суурь бэлдээд л, ингээд л байгаа үйлдлүүдийг жишээлбэл ингээд хараад байгаад байх уу гээд. Энэ бүх асуудлуудыг бол одоо бас чиглэл өгвөл би бол дэгийн хуулийн дагуу бас засах бололцоо бол тухай тухайн үед нь бас гарах байх гэж ингэж бодож байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийг тодруулаад тусгаснаа Байнгын хороон дээр оруулсан билүү, яалаа тэр. Үдсэн хуулийн дөчин есийн нэг, дөчин есийн хоёрыг үндэслэн гээд би нэг бичиж өгсөн шүү дээ. Мөнхсайхан доктор 80 дугаар микрофон.

О.Мөнхсайхан: Энэ дээр Улсын Их Хурлын даргын өгсөн чиглэл бас Байнгын хороон дээр одоо гарсан чиглэлийн дагуу шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд ноцтойгоор одоо халдсан хамгийн ноцтой үйлдлүүдийг эрүүгийн хуульд гэмт хэрэг болгож заах ийм чиглэлийн дагуу томьёоллууд гарчихсан явж байгаа. Одоогийн эрүүгийн хуульд бол яг шүүгчийн тусгайлан шүүн таслах ажилд зүй бусаар нөлөөлсөн, дарамталсан бол гэмт хэрэг. Энэнээс гадна юу нэмэх боломжтой тодруулга явж байна гэх жишээлэх юм бол шүүгчийн сонгон шалгаруулах томилгоонд хууль бусаар одоо нөлөөлж оролцсон дарамт үзүүлсэн үйлдэл гэх мэтчилэн ийм асуудал бол эрүүгийн одоо хууль руу орох боломжтой юм гэдгийг бол тал талаас ярьсан. Ийм томьёолол явж байгаа. Тэгээд хэрэв зарчмын хувьд шүүхийн тухай хуулийн төслийн одоо тэр Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйлд заасан шүүгчийн хараат бус байдал руу халдахыг хориглосон зохицуулалтууд

нарийвчилсан процесс энэ дэмжигдээд явах юм бол араас нь одоо эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тэр одоо төслийн томьёолол бол нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг нь хийгдээд гарна гэсэн ийм ойлголттой байж байгаа.

Г.Занданшатар: Лүндээжанцан гишүүн тодруулж харж хэлье.

Д.Лүндээжанцан: Хууль зүйн байнгын хороон дээр бид нар нөгөө ажлын хэсгийн дэд хэсгийн хувьд оролцож байхад энэ Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйлийн нэг дэх, хоёр дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор энэ бол одоо тэр хараат бус байдал байгаа юм. Шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах нөлөөлөх санаархлыг шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хуулиар зохицуулна гэдэг ийм заалт яригдаад протоколд ороод. Тэгээд энэ далан тавдугаар зүйлийг ярилцах үед энэ бол одоо нээлттэй үлдээд Их Хурлын дарга чиглэл өгүүлээд ингээд эцсийн хэлэлцүүлэг дээр үед эрүүгийн хуулийн заалт болгож одоо боловсруулж оруулж ирье гэдэг байдлаар одоо энэ асуудал яригдсан байгаа юм.

Өөрөөр хэлбэл тэр шүүгч шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн субъект бол шүүгч байхаас гадна шүүхэд нөлөөлж байгаа тэр хүмүүс өөрсдөө зөвхөн одоо хэдийгээр Үндсэн хуульд бол хориглоно гээд заачихсан боловч энийгээ улам одоо амилуулах үүднээс бол энэ шүүхэд, хэрэв одоо хууль бусаар ингээд нөлөөлөх юм бол санаархах юм бол энэ бол гэмт хэрэг шүү гэдгийг бол одоо зааж өгье гэж ингэж байгаа юм.

Г.Занданшатар: Тэр Үндсэн хуулийн дөчин есөн хоёр дээр бол Ерөнхийлөгч, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн, тэгээд нам, төрийн олон нийтийн байгууллага, иргэн гээд бүгдээрээ энэ хэвлэл мэдээллээр хүртэл ингээд урьдчилан яллаад хүнийг, тэгээд шүүх ажиллагаанд зарим талаар одоо нийгмийн шахалт үзүүлж дарамт үзүүлдэг энэ тэр бүх хэлбэрийг л шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэж үзэж үзнэ гэсэн тэр европын Венецийн комиссын тэр зарчмыг л уул нь тусгачихвал зүйтэй байх юм. 80 Мөнхсайхан доктор.

О.Мөнхсайхан: Уучлаарай түрүүн нөгөө яг энэ асуулт гарч ирнэ гэж бодоогүй байсан учраас нөгөө одоо гарсан томьёоллын одоо төслийн саналыг бол хэлж чадаагүй байсан. Тэгээд одоо би гарчихсан явж байгаа зүгээр хувилбар байж байгаад чиглэлийн дагуу гарсан. Энэ дээр жишээлбэл эрүүгийн хуулийн хорин нэгдүгээр зүйл дээр ийм гэмт хэрэг орж болох юм гэж байгаа. Шүүгчийн бүрэн эрх, шүүхийн хараат бус байдалд халдах нэг. Өөртөө болон бусдад давуу байдал бий болгох, нөлөөлөх зорилгоор шүүхэд хэрэг нэхэмжлэл, гомдол хүсэлтийг хуваарилах, шүүх бүрэлдэхүүн нэг томилох журмыг зөрчсөн бол гэдэг нэг гэмт хэрэг байж болж байгаа юм. Энэ чинь санкцыг нь бол заачихна. Хоёрдугаарт хуульд заасан шүүгчийн бүрэн эрхийн баталгаа, хараат бус байдалд халдаж халдаж шүүгчийг хууль бусаар чөлөөлсөн, огцруулсан шүүгчийн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн томилсон, сэлгэн ажиллуулсан бол ийм, ийм ялтай гэж заах ийм боломжтой.

Гуравдугаарт шүүгчийн сонгон шалгаруулах томилгоонд хууль бусаар оролцсон, нөлөөлсөн давуу байдал бий болгосон, эсвэл бий болгох амлалт өгсөн бол гэсэн иймэрхүү байдлаар зүгээр дэд хэсгийн хүрээнд томьёоллын санал явж байгаа. Тэгээд ерөнхий байдлаар одоо ажлын хэсэг маань энийг одоо шүүхийн тухай хуулийн төслийн энэ үзэл баримтлал хэлэлцэгдсэний дараа бол одоо энэ зөв үү, нарийвчлах уу яах вэ, аль нь орох вэ гэдгийг шийдээд явна гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Энэ ялын бодлогын чадах гэж мана юм байна лээ. Ганзоригийн

Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр шүүх бол ерөөсөө бид нар энэ хонгилыг нураах ч дөнгөж эхэлнэ гэж харж байгаа. Бусад хуулиуд дээр бусад тэр одоо хонгилыг чинь үүсгэдэг, хаалгыг нь онгойлгож өгдөг, хонгил руу чинь чирдэг тэр мөрдөн байцаагч, прокурорууд байна шүү дээ. Эд нар дээр бид нар бол тодорхой хариуцлагыг ярих шүүхийн шийдвэртэй уялдуулж, шүүхийн шийдвэр хэрэв гэм буруугүй хүнийг хариуцлага татсан бол, буруугаар шийтгэсэн бол бид нар тэр хүмүүс дээр хариуцлага татдаг энэ тогтолцоо бол байх ёстой гэж хардаг.

Хоёр дахь асуулт нь сахилгын хороо бол бол энэ чухал үүрэгтэй. Энэ сахилгын хороон дээр бид нар сахилгын хорооны гишүүдэд тавих шаардлага дээрээ мэргэжлийн ёс зүйн зөрчилгүй гэдэг үгийг нэмэх ёстой юм биш үү? Хэрэв тэгэхгүйгээр бол одоо юу гэдэг юм бид нар тодорхой нэг ёс зүйн зөрчил гаргасан гишүүдийг дэвшүүлээд байж болохгүй шүү дээ. Анхан шатандаа тодорхой хэргүүд дээр буруугаар шийдвэрлэгддэг. Давах дээр, дээд шүүх дээр ингээд дандаа одоо юу гэдэг юм тухайн тэр шийдсэн хэргүүд нь унадаг байвал тэр шүүгчийг бид нар дэвшүүлээд байж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ асуудал дээр бол та бүхэн бас ямар бодолтой байгаад байгаа юм? Сахилгын хорооны гишүүдийг зургаан жилээр гэгчихсэн байгаад байгаа юм. Энэ хэтэрхий урт биш шүү. Гурван жилээр автоматаар ингээд байнга солигдоод яваад байх энэ нөхцөлийг хийж өгвөл нөлөөлөл бага болох биш үү? Тэгэхээр энэ асуудлууд дээр та бүхэн бас нэг тайлбар хариулт өгөөч гэж хэлэх гээд байгаа юм.

Хоёрт саяын шатлан дэвших шүүгч нарын одоо юу гэдэг юм анхан шатны шүүхээс давахын шүүх болоод дээд шүүхийн шүүгчид одоо шатлан дэвших энэ мерит зарчим дээр ер нь юу гэж үзэж байгаа юм бэ? За анхан шатны шүүх дээр хэргүүд нь удаа дараа унаж байсан шүүгч нарыг бид нар давах болоод дээд шатны шүүх рүү дэвшүүлээд байх энэ асуудлыг яах вэ? Хэрэв удаа дараа хуулийг илт буруу зөрчсөн гэдэг юм уу, илт буруугаар тайлбарласан, хэрэглэсэн гэдэг юм уу энэ шүүгч нар дээр бол бид нар хариуцлага тооцох ёстой шүү дээ. Ямар хариуцлага санкцууд байх вэ? Хариуцсан одоо энэ шатлан дэвших асуудал дээр бид нар тодорхой хязгаарлалт тавих энэ асуудлууд байх ёстой асуудал биш үү? Түрүүний Их Хурлын даргатай хэлдэг асуудал дээр бол би санал нэг байгаад байгаа юм. Сая тэр хууль хүчнийх нь тэр улс төр хийдэг, хэвлэлээр ярьдаг асуудлууд дээр бол хязгаар тавих ёстой шүү. Мөрдөн байцаагч нар шүүхийн шийдвэр гаргаагүй байхад прокурорынхон гэдэг юм уу, хэвлэлээр ялладаг.../минут дуусав/

Г.Занданшатар: 86 энэ гүйцэтгэх ажлын ч юм уу, мөрдөн байцаалтын нууц задлаад нийгэмд нөлөөлдөг тэр юмыг бас хэлээд байна шүү дээ Тэмүүлэн гишүүн.

Ц.Цогт: Тэр нэг дэх асуудал дээр Мөнхсайхан доктор хариулах хариулъя гэнэ. Би тэр Тэмүүлэн гишүүн бас чухал зүйл хөндөж байгаа. Энэ давах хяналтын шатны шүүх дээр очоод шүүхийн шийдвэр өөрчлөгддөг зүйл гараад байна. Тэгээд энэ өөрчлөгдөөд байгаа хүмүүсийг шатлан дэвшүүлэхэд яах юм бэ гэж. Тэгэхээр энэ шүүгчийн үйл ажиллагаа гэдэг бол өөрөө их онцлог, хууль хэрэглэдэг одоо ийм ажил байхгүй юу. Тэгэхээр энэ бол заавал тэр анхан шатны шүүхийн шүүгчийн хууль хэрэглэсэн байдал дээд шатан дээр очоод өөрчлөгдөхөөр тэр анхан шатны шүүхийн шүүгч бол одоо буруу, сахилга хариуцлага хүлээх ёстой гэсэн үг биш л дээ. Өөрөөр хэлбэл шүүгч өөрийн итгэл үнэмшлээр тогтоогдсон үйл баримт дээр хуулийг хэрэглэх ёстой. Мэдээж хуулийн хэрэглэхдээ зах замбараагүй хэрэглээ гэж байхгүй.

Тэгэхдээ итгэл үнэмшил буюу хууль хэрэглээний одоо тэр асуудал бол байж болдог, зөрүү байж болдог. Энэ бүхэн нь өөрөө тухайн хүнийг сахилгын шийтгэл ногдуулах юм уу, эсвэл энэ хүнийг ахиж дэвшихгүй байх тэр үндэслэл бол болдоггүй. Энэ бол мэргэжлийн хувьд бол ийм боломж байхгүй. Зүгээр ганц тоо хэлэхэд бид нар анхан шатны шүүх өнгөрсөн гурван жилийн хугацаанд хорин оны гуравдугаар улирлын байдлаар нийтдээ хоёр зуун ерэн мянган хэрэг шийдсэн байна. 290 мянга 634 хэрэг. Тэгээд энэний гурав аравны таван хувь нь буюу 10232 хэрэг л хяналтын шатны шүүхэд одоо хянагдсан байгаа байхгүй юу. Тэгэхээр маш их олон тооны хэрэг шийдэгддэг. Энэ хэрэг шийдэлт дотор олон одоо тийм өөрчлөлт залруулга юмнууд хийгддэг. Ер нь бол давах, хяналтын шатны шүүх гэдэг бол өөрөө тэнд гарч байгаа алдааг туршлагын үүднээс засаж залруулах хэрэв байвал. Тийм үүрэгтэй учраас энэ бол зүй ёсны байх ёстой шатлал буюу залруулга байдаг юм.

Г.Занданшатар: 80 Мөнхсайхан доктор.

О.Мөнхсайхан: Тэмүүлэлийн гишүүн маш чухал зүйлүүд асууж байна. Нэгдүгээрт бол шүүхийн сахилгын хороо бол Үндсэн хуулийн чиг үүргийнхээ дагуу шүүгчид сахилгын арга хэмжээ авах ийм функцтэй. Энэ өндөр итгэл хариуцлагыг одоо даах хүмүүс ийшээ томилох бол маш чухал байж байгаа. Тэгээд Засгийн газар өргөн баригдсан төсөл дээр бол тэр өндөр шаардлага бол ерөнхийдөө тусчихсан. Өөрөөр хэлбэл шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүдийг бол дөрвөн гишүүнийг нь шүүгчид сонгоод тэр итгэл даах юугаар гаргачихна. Шүүгч биш тав нь бол нэгдүгээрт мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан хүн байна. Хоёрдугаарт сүүлийн таван жил улс төрийн ямар нэгэн алба хашаагүй байх ёстой. Гуравдугаарт хууль зүйн өндөр мэргэжилтэй гээд заасан. Хууль зүйн өндөр мэргэжилтэй гэдгийг тодруулсан журмыг бол бас энэ дээр гаргахаар зохицуулалт явж байгаа. Тэр нь юу гэсэн үг вэ гэхээр нэгдүгээрт энэ ажлыг хийх өндөр мэдлэг чадвар ёс зүйн хандлагатай байх ёстой гэдэг энэ агуулга бол явж байгаа. Энэ хүний эрхийн үндэсний комиссын гишүүнийг сонгон шалгаруулах журамд бас энүүгээр нарийвчлагдаад орчихсон.

Тэгэхээр энэ хүрээндээ бол тэр сахилгын арга хэмжээ авагдаж байгаагүй гэсэн шаардлага бол багтаж байгаа. Тэгээд тэр нарийн сонгон шалгаруулалтын процессоор үнэхээр энийг хангаж байна уу үгүй юу гэдэг нь шигшигдээд гарчихдаг жишиг орчихсон. Хоёр дахь зүйлийн хувьд тэр зургаан жилээр нэг удаа гэж байгаа нь бол энэ хараат бус байх байдлыг нь хангаж байгаа юм. Ер нь бол одоо өмнөх ёс зүйн хороо энэ юун дээр бол гурван жилээр ахиад томилогдох ийм боломжтой зохицуулалтууд явж байсан. Олон улсын жишгээр бол энийг бас байж болохгүй. Өөрөөр хэлбэл нэг бол бүрэн эрх ажиллачхаад, дахиад ажиллана гэдэг бол илүү томилж байгаа тэр субъектээс хараат болох ийм эрсдэлтэй гэж байгаа юм. Тийм учраас зургаан жилээр зөвхөн нэг удаа томилно гэдэг нь үнэхээр энэ итгэл дааж байгаа ажлаа хийгээд байх юм бол хараатаар ажиллана гэдгийг нээж өгч байгаа.

Нөгөө талаар энэ хугацаандаа ноцтой зөрчил гаргавал огцруулах үндэслэлийг нь маш нарийн зааж өгсөн. Жишээлбэл энэ эрх мэдлээ дамжуулж шүүгчийн хараат бус байдалд нөлөөлсөн ч юм уу энэ процессыг нарийн зааж өгсөн. Дээрээс нь энэ Улсын Их Хурлын одоо дөрвөн жилийн хугацаа гэсэн энэ бүрэн эрхтэй зөрүүлж байгаа. Ер нь бол хараат бусаар ажиллах чиг үүрэгтэй сонгуулийн ерөнхий хороо.../минут дуусав/

Г.Занданшатар: Тэр шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн өргөн утгаар нь тэр одоо ойлгох ёстой юм байна лээ шүү. Ингээд дараагийн хүн асуултаа асууна.

Одоо эрхэм гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан.

Б.Дэлгэрсайхан: Сонсогдож байна уу?

Г.Занданшатар: Сонсож байна.

Б.Дэлгэрсайхан: Энэ шүүхийн тухай хуулийг шинэчлэх асуудлыг бол дэмжиж байгаа. Энэ бол зөв. Гэхдээ энэ олон үг хэлж байгаа хүмүүсийг ингээд сонсоод байхаар хуульд захирагддаггүй тавьсан хүндээ үйлчилдэг гэж баахан ярьцгаалаа. Тэгэхлээр бид нарын одоо өнөөдрийн санаачлаад хийх гэж байгаа хууль бол шүүгч нарыг одоо буруутгахаасаа илүү шүүгч нарт нөлөөлөөд байгаа улс төрийн нөлөөллийг одоо хааж өгөх нь энэ хуулийг чинь гол амин сүнс гэж ойлгож байгаа шүү дээ. Тийм учраас бол ер нь ямар бэрхшээл, амьдрал дээр энэ хуулийг хэрэгжүүлэхэд тулгардаг юм яадаг гэдэг юм гэдгийг нь энэ шүүгч нарын үгийг нэлээд сонсох ёстой байсан юм. Тэгэлгүй одоо ингээд л бид нар бол одоо онолын, олон улсад ч тийм байдаг, энд ч ийм байдаг гээд одоо эрдэмтний үгээр ингээд хууль хийж байгаа.

Тэгээд энийгээ уул нь бас эргэж харахгүй бол энэ шүүгч нарын үг сонсохгүй бол наад чинь бас л амьдрал дээр гараад хэрэгжихэд бас нэлээн хэцүү хууль болох вий дээ. Энэ юугаар харагдаж байна вэ гэхлээр зэрэг бид өмнө нь байцаан энэ эрүүгийн хуулийн хянан шийдвэрлэх зөрчлийн хуулийг хянан шийдвэрлэх гээд нэг баахан процессын хууль баталсан шүү дээ. Одоо энэ хуулийг чинь ингээд амьдрал дээр хэрэгжүүлж байгаа хууль хяналтын байгууллагуудад бол улам хүндрэлтэй болсон, бүр хэцүү болсон. Бүгдээрээ мэдэж байгаа. Тэр одоо ийм хууль болчих юм биш биз дээ. Гоё ярих бол амархан шүү дээ, попрох энэ тэр бол. Дараа нь яг амьдрал дээр яаж хэрэгжүүлэх юм бэ гэдэг асуудлууд аягүй чухал шүү. Тийм учраас бол энэ хуульд бол зарим нэг тиймэрхүү төвөгтэй заалтууд бол нэлээн байгаа. Тийм учраас би энэ дараа нь заалт бүрээр нь санал хураах үед бол өөрийнхөө саналыг хэлье гэж бодож байгаа юм.

Ер нь бол онол ярихаасаа илүү амьдрал дээр одоо яг энэ хуулийг хэрэгжүүлж байгаа шүүгч нарынхаа үгийг сонсож, тэгээд яг юу нь болохгүй болоод ингээд энэ шүүх муухай харагдаад байгаа юм гэдгийг.../минут дуусав/

Г.Занданшатар: Энхбаяр ажлын хэсгийн ахлагч.

Б.Энхбаяр: Дэлгэрсайхан гишүүний санаа зовж байгаа шаардлагыг хүлээж авч байна. Ажлын хэсэгт шүүгч нарын төлөөлөл орсон, таван шүүгч ажилласан, зургаан шүүгч ажиллаж байгаа. Дээд шүүхийн дөрвөн шүүгч, давж заалдах шатны анхан шатнаас гээд олон чухал саналууд тавьсан. Хүлээж авсан. Гарцаагүй хүлээж авахгүй байгаа нэг, хоёр гурван л юм байгаа. Тэр нь бол яг одоо шүүхийнхний, одоо тэр эрх мэдлээ авч үлдэх гэсэн гол амин судаснууд байгаа. Бусад бүх саналыг нь хүлээж авсан. Шүүгчийн санал гэхээр л одоо бас би ч одоо бас цагаахан л байж, ажлаа бодоод л улс орноо одоод санал өгдөг юм байх гээд л. Тэгээд л тэр дотор чинь жишээлбэл шүүгчдийн холбоо гээд л нэр бариад л хувийн төрийн бус байгууллагынхаа нэрээр энэ ерөнхий зөв сахилгын хорооны бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт манай холбооны төлөөлөл байя гээд л. Тэр нь одоо тусгагдаагүй ороогүй болохоор миний саналыг авсангүй, шүүхийн санал авсангүй гээд л ярьж байгаа шүүгчид байгаа.

Ер нь шүүгч хүн төрийн бус байгууллага байгуулж болдог юм уу? Энэ хуулиар

хориглож байгаа. Тийм улс төрийн шинжтэй үйл ажиллагаа явуулахыг нь хориглож байгаа. Тэгэнгүүт өөрийнхөө төрийн бус байгууллагыг одоо татан буулгах гэж байна, би ер нь одоо бас улс төр хийж чадахгүй болчихлоо гээд л тэр заалтаа хүртэл хасуулах гээд л бариад л явж байгаа ийм шүүгч хүртэл байна. Тэгээд энэ чинь их олон сонирхол хөнддөг юм байна шүү дээ. Гишүүдийнхээ саналд хүндэтгэлтэй хандаж олон асуудал дээр бол бас буулт хийсэн. Яг энэ орж ирж байгаа ажлын хэсгийн санал маань бол үнэхээр үүнээс цааш ухрах, хойш болох боломж байхгүй гээд л орж ирж байгаа.

Г.Занданшатар: Дэлгэрсайхан гишүүн нэг минут.

Б.Дэлгэрсайхан: Би жишээлбэл юу хэлээд байгаа вэ гэхлээр зэрэг энэ заалт бүр дээр эргээд бид үг авч ярилцах байх л даа. Гол нь бол одоо энэ сахилгын хороо зөрчил болоод энэ мэргэжлийн алдаа хоёр гэдгийг нэлээн сайн ялгаж зааглахгүй бол бас тэнд нэг улс төрчдийн төлөөлөл суугаад, тэгээд нэг эргээд шүүх нь ажил хийх ч хэцүү, байх ч хэцүү бас л нэг ийм төвөгтэй заалтууд бас байгаа шүү. Тийм учраас л би энэ шүүгч нарын үгийг нэг сонсох ёстой юм байна лээ. Яг алийг нь мэргэжлийн алдаа гэж үзэх юм? Энэ хуульд нэг бүрчлэн заах арга байхгүй шүү дээ. Тийм учраас бол энийгээ бас тун ялгаатай. Жишээлбэл одоо ер шүүхийн ерөнхий зөвлөл нь эхэлж одоо шүүгчийн гаргасан алдааг мэргэжлийн алдаа юм уу, мэргэжлийн алдаа биш юм уу гэдгийг нь ялгаж заагдаж байж дараа нь сахилгын хороонд очдог ч юм уу. Энэ яаж хийх нь зөв юм. Зүгээр олон гишүүд санал бодлоо уралдуулж, дээр нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Тэр мэргэжлийн илт тодорхой алдаа гэдгийг дундын хувилбараар найруулж янзалъя гээд Байнгын хороо хэлэлцэх үед нь энэ асуудлаа ярьж болох байх. Байнгын хороон дээр найруулж янзалсан байгаа. Энийг та бас Дэлгэрсайхан гишүүн үзэж танилцаарай. Эрхэм гишүүн Жамъянгийн Мөнхбат.

Ж.Мөнхбат: Би гурван минутаа нэг мөсөн аваад ярья. За энэ их чухал хууль ярьж байгаа. Шүүгчийг шударга, шүүхийг шударга байлгах, хараат бус байлгах, хариуцлагатай байлгах асуудал яригдаж байгаа юм. Тэгээд энэ сая одоо бид нар манай гишүүд яриад байна. Энэ сахилгын хорооны асуудлыг. Жишээлбэл энэ хуулийн төслийн тавин хоёрын нэг дээр дөчин зүйл заалтаар шүүгчийг одоо хориглох зүйлсийг зааж өгч байгаа юм. Гэтэл энэ дээр нэг зүйл дутуу байна. Жишээлбэл энэ төслийн жарын нэгийн зургаа дээр байгаа энэ дөчин зүйл заалтыг зөрчсөн шүүгчид ямар хариуцлага оногдуулах вэ гэхээр ерөөсөө л цалингийн хорин хувийг нь хасах, гурван сар хүртэл шүүгчээс нь татгалзуулж давтан сургалтад суулгана гэсэн байгаа юм. Энэ бол дутуу болж байна. Энийг бол бүр огцруулах хэмжээнд арга хэмжээ авдаг болох хэрэгтэй.

Хуулийн цагаан дээр хараар бичсэн зүйл заалтыг зөрчсөн шийдвэр гаргаж байгаа шүүгчийн оногдуулах хариуцлага өндөр байх ёстой гэж бодож байгаа юм. Одоо бид нар бүр олон улсын хэмжээнд очих нэг кэйстэй болсон. Улсын Их Хурлын гишүүнийг хууль зөрчөөд шууд баривчлаад шийдвэр гаргаад явчихсан. Нэр дэвшээд явж байсан хүний Сонгуулийн ерөнхий хороо нь мэдэгдэхгүйгээр шүүх шийдвэр гаргаад явчихсан. Тэгэхээр энэ асуудал өнөөдөр олон улсын парламентын түвшинд яригдаж, олон улсын парламентын хоригт орох хэмжээнд асуудал өндөрт авчихсан байж байна. Монголын шүүх дэлхийн хэмжээнд ийм байдалд хориг тавиулах хэмжээндээ бол очиж болохгүй гэж бодож байгаа юм. Тийм учраас бол энэ анхан шатан дээр дунд шатан дээр гарсан энэ алдааг дээд хяналтын шатных нь шүүгч засаж чаддаг, зоригтой шийддэг байгаасай, тийм болоосой гэж хүсэж байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол энэ дээр би Эрдэнэбат гишүүний асуудлыг ярьж байгаа юм. Тэгэхээр энэ анхан шатан дээр дунд шатан дээр алдаа гарсан байж болно. Гэхдээ дээд шатан дээр хяналтын шатан дээр энийгээ зоригтой шийдэж чаддаг, алдаа гаргасан шүүгчдээ хариуцлага оногдуулж чаддаг ийм байдлыг одоо бид бол цаашдаа энэ Монголын энэ шүүхийн хуульд бол суулгаж өгөх ёстой гэж бодож байгаа. Тийм учраас бол энэ дээр ч гэсэн одоо би жишээ болгож энийг одоо албан ёсоор хэлж байна. Тийм учраас бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Мөнхбат гишүүн 1 минут.

Ж.Мөнхбат: Хяналтын шатны дээд шатныхаа одоо өмнө х шатандаа гарсан алдааг засаж байж, ингэж одоо энэ Монголын шүүх өөрөө өөрийнхөө нэрийг бас нэр хүндийг өргөж, өөрөө өөрсдийнхөө алдааг засаж залруулж явах ёстой гэж ингэж бодож байгаа шүү. Тийм учраас бол би бас энэ дээр албан ёсоор энэ Эрдэнэбат гишүүний энэ кэйсийг би хэлмээр байгаа юм. Энэ бол Монголын хуулийн сургуулиудын оюутнуудад цаашдаа дандаа орохоор ийм кэйс болж байгаа. Тийм учраас бол энэ алдааг дээд шатны одоо хяналтын шатны шүүх зоригтой шийдэж, засах ёстой гэсэн, ийм болоосой гэсэн ийм одоо саналтай байгаа юм. Тийм учраас бол энэ алдаа гаргасан, цаашдаа алдаа гаргаж байгаа шүүгч нарт тавьдаг энэ хариуцлагыг бол чангатгаж өгөх хэрэгтэй. Жаран нэгийн зургаа дээр бол энэ алдааг бүр огцруулах хэмжээнд хүртэл хэмжээнд байлгах ёстой гэсэн ийм саналыг бол би гишүүний зүгийн хувиас гаргаж байгаа юм.

Г.Занданшатар: Цогт шүүгч наян зургаа.

Ц.Цогт: Шинэ хуулийн төслөөр бол хууль зөрчсөн, сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нартаа өмнө нь ч байсан. Сахилгын зөрчлийн шинж байдлаас хамаараад олон төрлийн одоо сахилгын шийтгэл ногдуулах ийм зохицуулалт орж ирж байгаа. Түүний дотор бол огцруулах сахилгын шийтгэл байгаа. Тэгэхдээ огцруулах сахилгын шийтгэлийг бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт болоод Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж гарсан Улсын Их Хурлын хоёрдугаар тогтоолд заасанчлан тухайн зөрчлийн шинж байдал олон давтан үйлдэгдсэн зэргээс харгалзуулж тэр шийтгэлийг ногдуулах ийм зохицуулалт бол хуулийн төсөлд бол орж ирсэн байгаа.

Г.Занданшатар: Ер нь энэ хууль хэрэглээний алдааг яах юм бэ гэж асуусан шүү дээ. Ёс зүйн зөрчил гэж түрүүний нөгөө мэргэжлийн алдаа гэдэг дээр чинь энэ асуудал. Мэргэжлийн алдаа гэж үзэх юм уу, аль эсвэл?

Ц.Цогт: Ер нь бол шүүгчийн хуулийг зөв хэрэглэсэн үү, буруу хэрэглэсэн үү гэдгийг бол зөвхөн дээд шатны шүүх хянаж, засаж залруулах ийм эрхтэй. Тэрнээс энийг хууль зөв буруу хэрэглэсэн гэдгийг сахилгын хорооны гишүүд ч гэсэн, сахилгын хороо ч гэсэн энийг бол хэлэлцэж шийдвэрлэх эрх хэмжээ байхгүй. Сахилгын хорооны өөрийнх нь мандат бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бол хууль зөрчсөн, сахилгын, одоо зөрчил гаргасан тохиолдолд тэрэнд нь тохирсон хариуцлага хүлээлгэх л ийм зохицуулалттай байгаа. Тэгэхээр ер нь бол хууль хэрэглээний алдаа гэдгийг бол давах, хяналтын шатны шүүх нь тогтоодог. Ийм л зарчим олон улсад ч тэр, Монгол улсад ч тэр үйлчилдэг.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Мөнхбат гишүүнтэй санал нэг байна, баярлалаа. Одоо энэ шүүх өөрөө өөрсдийгөө хянаад, шүүрдээд явж байсан юм бол манай шүүгч ингэтлээ ялзрахгүй л байх байсан байх. Сая одоо Мөнхбат гишүүний хэлж байгаа жишээ бол энэ Монгол улс зүгээр ердийн хууль биш Үндсэн хууль зөрчсөн асуудал яриад байгаа байхгүй юу. Цэцийн шийдвэрээр бүр тогтоогдчихсон. Өөрөөр хэлбэл энэ чинь нөгөө шүүгч чинь зүгээр ердийн хууль байтугай Үндсэн хуулийг нулимж байна шүү дээ. Үндсэн хуулийг нулимж байна. Үндсэн хуульд байгууллыг нулимж байгаа байхгүй юу. Энэ чинь хуулийн дээр гараад суучихсан. Хуулийн, хуулиа барьж биш, эзнийхээ үгээр захиалгаар шийдвэр гаргадаг. Хуульд биш хүнд таалагдах гэж шийдвэр гаргадаг болж байна шүү дээ. Тэгээд энэ чинь хариуцлагатай байхгүй юм уу, үгүй юм уу гэдэг ийм зарчмын асуудал ярьж байна гэж би ойлгосон.

Тийм учраас энэ чинь хариуцлагатай байх ёстой гэж би үзэж байгаа юм. Хариуцлагатай байх тухайд ингээд ажлын хэсэг ажиллаад томъёолол бичингүүт манай шүүхийнхэн бол яг хэлж байна шүү дээ. Эсрэгээрээ гишүүдийг лоббидож байгаа. Бүр хариуцлагагүй болгох. Олон гишүүн Байнгын хороон дээр одоо нэлээн би хаалтан дотор хэлчихье. Гишүүд хоорондоо үзэлцэн, ноцолдсон асуудал бол энэ шүүхийнхэн өөрсдөө энэ одоо хариуцлагагүй байх, хариуцлагатай байх тэр заалтыг нь авч хаях ийм санал гаргасан. Тэгээд хариуцлага гэж байхгүй юм бол шүүх гэж байгаад яах юм. Шүүх хэнд ч шүүгдэхгүй байх гээд байгаа юм уу. Хуулиас давсан шүүх шүүгддэг байх ёстой шүү дээ. Хуулийг нулимж байгаад шүүгч шүүгддэг байх ёстой шүү дээ. Энэ чинь шударга ёс шүү дээ. Ард иргэдээс шударга ёсыг нэхдэг. Өөрсдөөс нь шударга ёс нэхэхээр биднийг хэнд ч шүүх ёсгүй. Бид бол хууль юм. Одоо энэ дээр гишүүд.../минут дуусав/

Г.Занданшатар: Лхагвын Мөнхбаатар гишүүн.

Л.Мөнхбаатар: Сонсож байна уу?

Г.Занданшатар: Сонсож байна, сонсож байна.

Л.Мөнхбаатар: Гишүүдийнхээ амрыг эрье. Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль зүйн байнгын хороо, мэргэжлийн Байнгын хорооны хувьд бол нэлээд нухацтай авч хэлэлцэж, нийтдээ арван долоон цаг хэлэлцсэн л дээ. Зүйл заалт бүрээр нь олон талаас нь шинэ дэгийнхээ хуулийн дагуу мэтгэлцэх зарчмын хүрээнд одоо олон талаас нь хэлэлцсэн юм байгаа юм. Шүүхийн тухай энэ хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бол Хууль зүйн байнгын хороо одоо олонхын салаар бүрэн дүүрэн дэмжсэн.

Тийм учраас одоо тухайн үед бол одоо би бол зарчмын зөрүүтэй бас тодорхой саналууд байсан. Түүнийгээ илэрхийлээд, түүнээс гадна дэмжсэн саналууд байна. Бас дэмжигдээгүй боловч цөөнх болсон учраас одоо олонхоороо дэмжсэн учраас яг тодорхой заалтуудын талаар бол одоо энэ дээр хэлэх зүйлүүд бол зүйлээ товчилъё гэж бодож байна. Цагийн хувьд бас. Хоёрдугаарт харин ингээд дагаж мөрдөх журмын хууль байгаад байгаа юм. Дагаж мөрдөх журмын хууль дээр харин нэг хоёр зүйлийг тодруулаад орхиё. Ялангуяа одоо би хуралдаан даргалагчаас бас чиглэл авах нь зүйтэй юм болов уу гэж бодогдоод байгаа юм. Яагаад гэхээр одоо шүүхийн ерөнхий зөвлөлийн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсны дагуу шүүхийн зөвлөлийн гишүүдийг одоо сонгох энэ талаар зарчмын том өөрчлөлт гарсан. Таван шүүгчдээсээ тав нь одоо нээлттэй сонгон шалгаруулалтаар гэж байгаа юм. Энэ бол зүйтэй. Энэ бол энэнийхээ дагуу энэ зохицуулалтад орчихсон.

Гэхдээ одоо шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа хүмүүс байна. Таван гишүүний гурав нь одоо бүрэн эрх нь хэрэгжиж байна. Хоёр нь бол хугацаа нь дууссан байх. Энэ хүмүүсийн хугацаа бол одоо нэг жил юм уу, магадгүй жил хагасын дараагаар дуусах байх. Гэхдээ бид одоо ингээд шүүхийнхээ хууль болон дагаж мөрдөх журмын хуулиараа энэ асуудлыг шийдээд тодорхой асуудлыг шийдэж өгөхгүй бол хуулиар одоогийн бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Батбаяр, Атарцэцэг, Цогтсайхан нарын асуудал байгаа. Энэ асуудлыг хуулиар эрх зүйн байдлыг нь дордуулж болохгүй. Гурван жилийн хугацаатай томилогдчихсон байдаг. Өмнө нь хүчин төгөлдөр үлдэж байсан хуулийнхаа дагуу Үндсэн хуулийн дагуу томилогдсон ийм хүмүүс. Энэ хүмүүс маань бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй байхад одоо дараагийн хууль хүчин төгөлдөр болж хэрэгжих гээд байна шүү дээ. Энэ асуудлыг дагаж мөрдөх журмын хуулиараа энэ хүмүүсийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх талаар дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулах нь зүйтэй. Энэ чиглэл талаар.../минут дуусав/

Г.Занданшатар: Мөнхбаатар гишүүн нэг минут.

Л.Мөнхбаатар: Ийм учраас одоо ажлын хэсэг болон одоо хууль санаачлагчийн зүгээс энэ хүмүүсийн одоо хуулиар хүний эрх зүйн байдлыг дордуулж болохгүй шүү дээ. Тийм учраас энэ тодорхой хугацаа нь дуусаагүй байгаа энэ гишүүдийн энэ асуудлаар тодорхой болгоод Их Хурал бол тодорхой болгож өгөх нь үүрэгтэй гэж би бодож байгаа юм. Ингээд дагаж өгөгдөх журмынхаа хуулиар энийг зохицуулж болно л доо. Шүүхийн шүүхийн тухай үндсэн хууль маань бол угаасаа гараад явчихна. Тийм учраас дагаж мөрдөх журмын хуулиараа энэ асуудлыг оруулъя. Ингэхийн тулд хуралдаан даргалагч ч одоо Занданшатар дарга бас тодорхой чиглэл өгчих юм бол эцсийн хэлэлцүүлэг дээрээ энэ чиглэлээр манай ажлын хэсэг, Энхбаяр гишүүн, Сүхбаатар гишүүд нар бол томьёолоод ороод ирэх боломжтой байгаа юм. Энэ зүйлийг бол бас хууль хүн бүрд одоо эрх тэгш үйлчлэх ёстой гэдэг энэ агуулгаар нь оруулах нь зүйтэй гэж үзэж байгаагаа хэлье. Энэ талаар бас одоо хариулт авъя.

Г.Занданшатар: Мөнхбаатар гишүүнээ Хууль зүйн байнгын хороон дээр шүүхийн тухай багц хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэлэлцэхэд тэр нэр, тогтоолыг тогтоол бас дагаж батална. Хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол батлах тухай. 87 Сайнзориг.

П.Сайнзориг: Энэ асуудлыг бас тал талаас нь л ярих хэрэгтэй асуудал байх гэж бодож байгаа. Тэгэхдээ мэдээж эцсийн хэлэлцүүлэг дээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээрээ энийг ярих нь чиглэлтэй байх. Ер нь бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт өнгөрсөн онд батлагдсан гэдгийг бас одоо гишүүд маань бас анхаараасай гэж хүсэж байгаа. Өөрөөр хэлэх юм бол энэ шүүхийн ерөнхий зөвлөл арван гишүүнтэй байна. Эргээд энэ бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. За шүүгч нар дотроосоо тавыг нь бусад тавыг нь нээлттэйгээр ингээд. Энэ өөрөө эргээд энэ өмнөх гишүүдээсээ одоо энэ шинэ хуулиар сонгогдох гишүүд маань өөр процедур, өөр томилгооны одоо субъект дээр одоо бүрэн эрх нь баталгаажиж орж ирж байгаа. Тэгэхээр уг асуудлыг бас холилдуулан одоо шийдэх одоо хэр зохимжтой байдаг юм байгаа юм, зүгээр ер нь мэдээж дагаж мөрдөх журмын хуулиа шилжилтийн зохицуулалтыг хийх бололцоотой боловч бас энэ Үндсэн хуулийнхаа бас нэмэлт, өөрчлөлтийг үзэл санаанд нийцүүлэхгүй бол бас болохгүй гэдэг зүйлийг л одоо бас анхаараасай л гэж хүсэж байгаа юм. Тийм.

Г.Занданшатар: Тилеуханы Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. За шүүхийн тухай хууль бол яах аргагүй одоо чухал хуулиудын нэг. Бас манай залуучууд маань энэ хуулийг одоо чамбайруулж гаргахыг хүсэж байгаад бас талархалтай байгаа. Монгол улсын иргэн аж ахуйн нэгж шүүх дээр л очиж эцсийнхээ хариултыг дэнсэлдэг ийм чухал одоо байгууллага шүүх гэдэг бол. Шударга, шуурхай, нээлттэй хараат бус шүүхтэй болох шийдлийг олж харах нь бол бидний үүрэг. Тийм учраас энэ дээр нэг олон юм асуухгүй цаг бага учраас. Хоёрхон асуулт байна. Шүүх хараат бус байхыг бол дэмжиж байгаа юм. Маш чухал зүйл. Хараат бус байх. Яг энэ хараат бус байхтайгаа зэрэгцээд шүүхийн нээлттэй байдлын асуудлыг ер нь яг энэ хууль дээр яаж оруулж ирж байгаа юм бэ. Одоо байгаа зохицуулалтаар бол шүүх одоо иргэдийн төлөөллийг оруулах, шүүх.мн дээр бол шүүхийн шийдвэрийг тавихаас нэг их хэтрэхгүй байгаа юм шиг надад санагдаад байгаа юм. Шүүх хаалттай хаалганы цаана зөвийг буруутгаад бурууг зөвтгөөд суухыг бас үгүйсгэхгүй. Тийм учраас нээлттэй байна гэдэг маань өөрөө тухайн шүүх байгууллага, шүүгч маань өөрөө зөв шийдвэр гаргах, бас нэг сэдлийг төрүүлэх бас нэг элемент мөн үү гэвэл мөн. Тийм учраас энэ одоо нээлттэй байлгах тал дээр энэ төсөл дээрээ яаж орж ирж байгаа вэ Энхбаяр гишүүнээ нэгдүгээр асуулт байна.

Хоёрдугаар асуулт маань прокурор шууд дээд шүүхийн шийдвэрт эсэргүүцэл бичиж орж ирдэг л дээ, прокурор. Гэтэл прокурор нь зөвхөн яллах талыг л барьж орж ирдэг. Гэтэл нөгөө иргэн, аж ахуйн нэгжийг маань өмгөөлөгч талын маань санал яг энэ прокурорын эсэргүүцэлтэй ижил түвшинд тавьж өгч чадаж байгаа юу, үгүй юу. Ер нь бол прокурор бичдэг, эсэргүүцэл бичдэг уламжлал бол хэвээрээ байгаад байгаа юу? Яагаад гэвэл прокурор бол зөвхөн яллах талыг барьж орж ирдэг шүү дээ. Өмгөөлөгч талын маань одоо эрх ашиг нь энэ дээрээ яг чухам яг яаж орж ирж байгаа вэ гэсэн хоёр асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 80 Мөнхсайхан доктор.

О.Мөнхсайхан: Нэгдүгээр асуултад хариулъя. Чухал зүйл хэллээ. Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр бол яг тэр шүүхийн шийдвэрүүд цахим байрлуулах, хэвлэх тэр суурь зохицуулалт орж ирсэн. Энэ бол өөрөө одоо ил тод байдлын хамгийн чухал зүйл. Өөрөөр хэлбэл хувь хүн нь байгууллагын нууцад хамаарахаас бусад бүх шүүхийн шийдвэр шүүх.мн дээр цаг тухайдаа тавигддаг. Зарим нь үлддэг биш байх энэ зохицуулалт өргөн баригдсан. Энэ дээр нэмээд ажлын хэсэг бол тодруулж дээд шүүхийн шийдвэрийг төрийн мэдээлэл эмхэтгэлд заавал нийтэлнэ гэдгийг зааж өгсөн. Энэ бол өөрөө бас ил тод байдлыг хангаж байгаа. Дээд шүүх бол өөрийнхөө шийдвэрийг хэвлэхгүй байх одоо тэр байдлаас сэргийлэх, тэгээд ил тодоор хэвлэдэг байх энэ одоо чухал заалт орж ирсэн.

Хоёрдугаарт энэ хорин хоёрын ес дээр олон нийтийг мэдээллээр хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тайлбарлах зорилгоор шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлнэ гэдэг ийм шинэ зохицуулалт ажлын хэсгээс нэмсэн.

Гуравдугаарт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүх, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэрийг тухай бүр ойлгомжтой байдлаар бичгээр болон биечлэн тайлбарлана гэдэг тодорхой заалт орж ирсэн байж байгаа. Эцэст нь бол улсын дээд шүүхийн шүүгч тусгай саналаа цахим хуудаст байрлуулж нийтлэх эрхтэй гэдэг маш чухал зохицуулалт орж ирсэн. Цэцийн шийдвэрт нийцүүлээд. Юу байх вэ гэхээр улсын дээд шүүх бол өөрөө онолын шүүх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах ийм чиг үүрэгтэй. Тэгэхээр энэ одоо хуулийн хамгийн сайн зөв тайлбар юу вэ гэдэг дээр маргаж байгаа тэр цөөнх нь тэр шийдвэрээ хэвлэх боломжийг нь нээж өгч байгаа

юм. Цэц бол өмнө нь яасан бэ гэхээр хэвлэх үүрэгтэй байдлаар зохицуулсан нь Үндсэн хууль зөрчсөн, эрхтэй байх нь боломжтой Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн учраас тэрэнд тохируулсан. Тэгээд энэ бол өөрөө жишээлбэл судлаачийн хувьд ингээд харахад яг дээд шүүхийн яг адилхан бүрэлдэхүүн ороод адилхан заалтын эсрэг эсрэг тайлбарлаад байдаг. Тэгэхээр энэ жишээ нь илчлэгдэж хэн нь ямар бодолтой байгаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 137 санал байгаа. 137 саналаар санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдээрэй. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэснийг хасаж, 3.1.5, 3.1.6 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.5 дахь заалт, мөн зүйлийн 43.5 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 44 дүгээр зүйл болгож, 74 дүгээр зүйлийн 74.1.3 дахь заалтын “сэлгэн ажиллуулах,” гэснийг хасах: Одоо бүртгэлийн санал хураалт явуулна. Энэ эрүү, иргэн, захиргаа зэргээ хасахаа. Биш энэ нөгөө 44 дүгээр зүйл шүүгч нарыг уг нь мэргэшүүлэх нь зүйтэй гэдэг ийм. Тест санал хураалт явуулна. Бүртгэл. Энэ 34 гишүүн бүртгэлд ороогүй байна Тогтохсүрэн даргаа бүртгэлд ороогүй байгаа энэ та ороогүй байна. Мөнх-Оргил, Цогтбаатар, Мөнхбаатар сая байсан улсууд Бямбацогт, Баттөмөр дарга сая байсан. Яагаад санал чинь авахгүй байна вэ? Эсэргүүцээд байна уу, үгүй юу? Дагнасан шүүх гэдгийг хасдаг нь яаж байгаа юм бэ тэгээд?

3.1.2 чинь дагнасан шүүх гэсэн тодорхойлолттой өөрчлөн найруулахаар болон бусад дагнан гэдэг үгнүүдээ оруулаад. Энэ бодвол нөгөө нэг гэр бүлийн ч юм уу бусад дагнасан шүүх гарахыг хязгаарлачихна гэсэн байлгүй. Гэхдээ зэрэг гэж байгаа шүү дээ зэрэг гээд тэгэхээр чинь бусад дагнасан шүүхүүд ч гэсэн байж болно гэсэн үг шүү дээ. Энийг хасахаар чинь ерөөсөө дагнасан шүүхүүд байхгүй юм шиг энгийн ухамсрын түвшинд ойлгогдоод байна шүү дээ. Санал хураахаас өмнө эцсийн найруулга дээр тэр 1 дүгээр хэсгийг нь анхаармаар байна. Энэ хоёрыг чинь 2 салгаж хурааж болохгүй. 44 дүгээр зүйлийн нөгөө шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулахтайгаа хамт явж байгаа учраас багцлаад явсан юм байна л даа. Хууль зүйн техникийн хувьд ингээд багцлаад явчихаар хэцүү болчихоод байна. 3.1.2-оо Үндсэн хуулийн дагуу Үндсэн хуулиа эшлээд өөрчлөн найруулах чиглэл өгч байна. Хасаж байгаа чинь бол мэргэшсэн дагасан шүүхээсээ татгалзаж байгаа юм шиг хэрэг болж байна. Зэрэг гэдэг үгийг та нар бас зэрэг болон бусад гэдэг юмаа оруулаад л найруулчих.

Ингээд одоо Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “эрүү, иргэн, захиргаа зэрэг” гэснийг хасаж, 3.1.5, 3.1.6 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.3.5 дахь заалт, мөн зүйлийн 43.5 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 44 дүгээр зүйл болгож, 74 дүгээр зүйлийн 74.1.3 дахь заалтын “сэлгэн ажиллуулах,” гэснийг хасах:

“44 дүгээр зүйл.Шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

44.1.Шүүхийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, тухайн шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг

үндэслэн орон тоо дутуу байгаа адил шатны шүүхэд, адил шатны шүүхэд орон тоо байхгүй бол доод шатны шүүхэд шилжүүлэн томилж болно.

44.2.Шүүгчийг энэ хуулийн 44.1-д заасан үндэслэлээр шилжүүлэн томилуулах тухай саналаа Ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх бөгөөд саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тухайн шүүгчийг шилжүүлэн томилно.

44.3.Шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүгчийг адил шатны шүүхэд хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.

44.4.Энэ хуулийн 44.3-т заасан үндэслэлээр шүүгчийг сэлгэн ажиллуулах журмыг Ерөнхий зөвлөл батална.

44.5.Шүүгч энэ хуулийн 44.3-т заасан сэлгэн ажиллах хугацаа дууссанаар урьд ажиллаж байсан шүүхэд эргэн ажиллах баталгаагаар бүрэн хангагдана.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр, Ширнэнбаньдын Адьшаа, Норовын Алтанхуяг, Цэндийн Мөнх-Оргил, Шатарбалын Раднаасэд, Цэндийн Сандаг-Очир, Жамъянхорлоогийн Сүхбаатар цаашид “Ажлын хэсэг” гэнэ. Тэгээд Мөнхсайхан доктороо Энхбаяр хаачсан бэ? Цогт шүүгчээ энэ дээр тэр дагнасан шүүхдээ ажиллахгүй бол сэлгэн ажиллуулахдаа тэгээд иргэнийхийг эрүү рүү шидээд л ингээд тийм нугалаа гардаг шүү. Тэгэхээр энэ чинь дагнасан шүүх гэдгээрээ дээд тал чинь алга болохоороо цаана нь бас ийм юу нуугдаж байх вий. Тийм. Ингээд Мөнхбат гишүүн суу. Санал хураалт. Санал хураалтад 69 гишүүн оролцож 50 гишүүн дэмжиж 72,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Адил шатны шүүх гэдгээ тухайн дагнасан гэж тодруулах боллоо.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.4.шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Үндсэн хуулийн 16 дээр уг нь нөгөө өмгөөлөх эрхээр хангагдах энэ тэр гээд нөгөө шардга шүүхээр шүүлгэх эрх чинь нэлээн тодорхой болсон. Тэрнийгээ эшилсэн бол. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж 76,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйл, 14 дүгээр зүйлүүдийг нэгтгэж, доор дурдсанаар өөрчлөн найруулж, 14 дүгээр зүйл болгох:

“14 дүгээр зүйл.Шүүхийн тогтолцоо

14.1.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулсан шүүх хэрэгжүүлнэ.

14.2.Монгол Улсын шүүхийн тогтолцоо зохион байгуулалтын хувьд бие даасан байх бөгөөд Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

14.3.Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

14.4. Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг тойргийн зарчмаар байгуулахад энэ хуулийн 15.4-т заасныг харгалзахаас гадна иргэний шүүхэд хандах эрхийн баталгааг хангах, шүүхийн үйлчилгээг иргэнд хүртээмжтэй хүргэхэд чиглэсэн байна.” Санал гаргасан Ажлын хэсэг. Тогтохсүрэн гишүүн, Ганбат гишүүн, Оюунчимэг гишүүн 3 үг хэлнэ. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би энэ 14 дүгээр зүйл дээр санал хэлэх гээд байгаа юм. Сая Их Хурлын дарга хэлсэн. 14.3 дээр бол тэр шүүхийг эрүү, иргэн, захиргааны гэсэн төрлөөр дагнан байгуулж болно гэдэг санал би 14.3 дээр орно гэж ойлгож байгаа. Сая бол үндсэндээ бид нар 1 дүгээр санал буюу тэр 3.1.2 буюу нэр томьёоны бүлэг дээр бол ярьсан учраас би орно гэж ингэж ойлгож байна. Энэ Үндсэн хуультай асуудал.

2 дахь нь 14.4 байгаа юм. Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн журмаар байгуулна гэж. Одоо бол Монгол Улсад засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгжээ дагаж байгуулагдаад явж байгаа. Цаашдаа бол зарим шүүх нь бол тойргийн журмаар байгуулагдах юм байна гэж ойлгож байгаа юм. Гэхдээ бид нар нэг зүйлийг сайн бодолцож байх хэрэгтэй. Шүүх бол ер нь иргэдтэйгээ л ойрхон л байвал зөв шийдвэр нь гардаг. Тойргийн журмаар их олон болоод ирэх тусмаа л шүүхийн шийдвэрт янз бүрийн алдаа дутагдал гаргадаг. Анхан шатны шүүхийн хувьд бол би орон нутаг дээр бол захиргааны шүүхийг бол тухайлбал би тойргийн журмаар би байгуулж болно гэж боддог юм.

Иргэн болон эрүүгийн шүүхийг бол тойргийн журмаар байгуулахаар байгаа. Иргэд өөрөө чирэгддэг байхгүй юу. Араас нь маш олон иргэний чирэгдэл үүсдэг учраас бол цаашдаа би энэ хуулийн хүрээнд энэ заалтыг бол дэмжээд байгаа юм. Гэхдээ хэрэгжүүлэх явцдаа бол энэ заалт их бодолцож үзэх ёстой юм. 2012-2014 онд билүү бас нэг аймгуудад энэ давахын шүүхүүдийг тойргийн журмаар байгуулсан. Энийг дагаад иргэдийн эрх бас нэлээн зөрчигдсөн. Иргэд чинь нөгөө чирэгдэл ихтэй зардал өндөртэй ингээд болоод ирэхээр зэрэг давж заалдах эрхээ хангахгүй байх эд нар явдлууд бол маш их гарч байсан юм. Тийм учраас би энэ асуудлыг цааш нь хэрэгжүүлэх явцад нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөр гишүүнээ 3.1.2 чинь шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулсан шүүхийг гэж байгуулагдсан шүүхийг гэж байгаа юм чинь зэрэг гэж байгаа юм чинь гэр бүлийн байна уу, бусад төрөл нь дагнан байгуулагдаж болно гэсэн утга нь байгаа юм чинь 3.1.2-оо үлдээгээд энэ 14 дүгээр зүйл дээрээ бол энүүгээрээ байж болох юм байна. Тогтохсүрэн даргаа. 14 дүгээр зүйлээ хөндөхгүй. Энэ 14 дүгээр зүйлд бол дагнан байгуулж болно гэдгээ л зааж байгаа юм чинь. Тойрог бол Үндсэн хуульд орсон юм байгаа юм тойргийн шүүх бол. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Үндсэн хуульд орсон тойргоор байгуулах тэр нь их зөв зүйтэй юм болчихжээ. Энийг оруулах гээд чадахгүй байсаар байгаад едий хүргэсэн юм. Тэгээд энэ шүүх шүүгчийг л бид нар буруутгаад байдаг. Шүүх шүүгчийг өмөөрч байгаа тэрний ажлын хүнд байгаа байдал нь яагаад ийм байдалд оруулсан бэ гэдгийг ярьж байгаа хүн алга.

Тухайлбал иргэний хэргийн нэг шүүгчийн дунджаар 400 хэрэг очиж гэж байна. Улаанбаатар хотын иргэний хэргийн шүүгч дээр бол овоорч байгаа байх. Тэгээд бид нарын шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ тэр чанартай хуулийн дагуу шүүхийн

үйлчилгээг авах иргэдийн эрх хохирч байна. Нэг их олон хэргээр дарсан тийм шүүгч дээр хэргээ шийдүүлж байна. Тэгэхээр ядаж тэр 699 хүнийг ажиллуулаад өөр нэг шүүгч дээр хэчнээн хэрэг байх ёстой юм тэр юмыг нь тооцоолсон тэр юмаа гаргах ёстой. Нөгөө талаар энэ шүүхийн ёс хараат бус байдлыг тогтоох энэ юм бол тэр хонгил гэдэг юмнаас л эхлээд яваад байгаа шүү. Өмнө нь яахаа алдсан бас тийм байгаагүй. Сүүлийн 4, 5 жил ийм болсон. Тэр нь өнөөдөр 120-т хараат байдлаараа орж байгаараа илэрч байгаа.

Ингээд АТГ ямар ч авлигаар шийтгэдэггүй тэндээс. Энийг маань хууль хяналтын байгууллагыг хянадаг. Дээр нь Дээд шүүхийн шүүгч нараар дамжуулаад хонгил үүсгээд байдаг байсан. Одоо сахилгын ерөнхий хороогоороо бас дамжуулаад шүүгч нараа хянаад бас хонгил үүсгээд байх боломж үүсэх вий. Тэгэхээр шүүгч ч гэсэн хүн. Тэр хүмүүс маань ямар ч байсан тэр хяналтын шатаар дээр шүүх дээрээ бол яг хууль хэрэглэх тэр юм дээрээ бас хянуулдаг барьдаг байсан нь дээр байх. Тэр одоо бас.../минут дуусав/

Г.Занданшатар: 1 минут гэж байхгүй. Энэ санал дээр хэлж байгаа. Таныг сүүлийн 3 секундэд нь яг энэ заалттай холбоотой юм хэлэх юм болов уу гэж мөн ч их хүлээлээ. Даанч хэлсэнгүй.

Одоо ингээд Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Би яг энэ Ганбат гишүүний хэлснийг үргэлжлүүлж хэлэх гэж байна. Одоо энэ дүүргийн шүүхүүд дээр нэг хүнд бүр хавтаст хэрэгтээ дарагдаад тэгээд бөөн стресс нөгөө хүн чинь шударга үнэнээр шүүж чадахгүй. Нөгөө шүүгдэж байгаа хүн нь өмгөөллөөр юм уу өөрийнхөө эрхийг Үндсэн хуулиар заасан эрхээ эдэлж чадахгүйгээс болоод олон иргэд хохирдог. Ялангуяа санхүү мөнгөний боломж муутай жирийн иргэд бол маш олноор хохирч байна гээд бид чинь бас иргэдтэйгээ уулзаж байхад энэ дүүргийн шүүхүүд энэ нэг хүн дээр асар их ачаалал үүрэгдсэн. Тэгээд заримыг нь бараг л нэрээ тоомсоргүй хальт уншсан болдоггүй. Эсхүл одоо шударгаар үнэхээр шүүх тэрэнд хариуцлагатай хандах энэний ард хүн байгаа, хүний ард хүний амьдрал байгаа гэсэн асуудлууд байгаа. Тэгээд энэ дээр.../үг тасрав/

Г.Занданшатар: Шүүхийн ачаалал биш шүүхийн тогтолцоотой холбоотой санал хураалтынхаа зарчмын зөрүүтэй саналын томьёололтой л холбогдуулж үг хэлнэ шүү. 120, 137 санал хураалт явуулна. Холбоотой үгээ л хэлье.

М.Оюунчимэг: 1 дүгээр энийг хэлье гэж бодсон юм. 2 дугаарт түрүүн Тогтохсүрэн даргын хэлдэг үнэн шүү. Иргэдэд хүнд суртал чирэгдэл учруулахгүй байх тал дээр тойргоор явахаар бас иргэдэд нэлээн хүндрэлтэй байдаг гээд. Бид нар бол өмнө нь бол ийм зөндөө сонсож ярьж байсан. Тэгэхээр энэ дээр бас Үндсэн хууль тойргоор зарчмаар явна гээд заасан ч гэсэн тэр дотоод журам дээрээ ч юм уу өөрчлөлт энэ дээр анхаарахгүй бол бас асуудал байгаа шүү гэдгийг хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: 14.4 дээр заасан байна л даа. Шүүхийн үйлчилгээний хүртээмжийг хангахад чиглэгдэнэ. Шүүхэд хандах эрхийг баталгаатай байлгахыг хангана. Тэгээд энэ дээрээ үндэслэж тойргийн шүүх байгуулна гээд заасан байна шүү дээ. Санал хураалт. 42 гишүүн дэмжиж 61,8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6.1 дэх хэсэг болгож, 6.4 дэх хэсгийн “тухайлсан” гэснийг, 6.5 дахь хэсгийн “гадаад, дотоодын хүн, хуулийн этгээдээс аливаа” гэснийг хасаж, 6.7 дахь хэсэгт “Шүүхийн төсвийн урсгал зардлын хэмжээг төсвийн хэмнэлтээс бусад

тохиолдолд өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмж, 6.11 дэх хэсгийн “шүүн таслах ажиллагаанаас” гэснийг “шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхээс” гэж өөрчлөх:

“6.1.Шүүх нь шүүх эрх мэдлийг аливаа этгээдээс хараат бусаар хэрэгжүүлнэ.” Үндсэн хуулийн 49.1-д байгаа л заалт. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж 72,1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсгийн “мэдээлж болно” гэснийг “мэдээлнэ. Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг Ерөнхий зөвлөл батална.” гэж, 13.6 дахь хэсгийн “дамжуулах” гэснийг “нэвтрүүлж болох” гэж өөрчлөх. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 68 оролцож 51 гишүүн дэмжиж 75,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсгүүдийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 15.3 дахь хэсэг болгож, 15.4 дэх хэсгийн “тоог” гэсний өмнө “төрөл,” гэж нэмэх:

“15.3.Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, түүний байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 52 гишүүн дэмжиж 75,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Засгийн газар л өргөн мэдүүлдэг болгохыг дэмжиж байгаа юм байна.

7.Төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “шүүн” гэсний өмнө “шүүгчийн” гэж нэмж, 16.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 16.4, 16.5 дахь хэсэг болгож, 16.5 дахь хэсгийн “Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.” гэснийг “Томилолтоор ажиллахтай холбоотой харилцааг хэрэг, маргаан хянан шийдвэрлэх холбогдох хуулиар зохицуулна.” гэж өөрчлөх:

“16.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн Ерөнхий шүүгч томилогдох хүртэл хугацаанд түүнийг хамгийн олон жил шүүгчээр ажиллаж байгаа танхимын тэргүүн орлоно.

Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд, эсхүл сул орон тоо гарсан тохиолдолд дараагийн Ерөнхий шүүгч сонгогдох хүртэл хугацаанд түүнийг шүүгчээр хамгийн олон жил ажиллаж байгаа танхимын тэргүүн, эсхүл шүүгч орлоно.” Санал гаргасан Ажлын хэсэг. Найруулга дээр анхааръя. Түүнийг гэдэг үг чинь илүүдээд байна шүү. Санал гаргасан Ажлын хэсэг санал хураалт. Түүнийг гэхээр найруулга нь уншигдахгүй байна. Угаасаа ерөнхий шүүгчийн тухай ярьж байгаа юм чинь. 46 гишүүн дэмжиж 67,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Раднаасэд гишүүн ажлын хэсэг энэ санал гаргачхаад эсрэг гараад байна шүү. Цогтбаатар, Мөнхбаатар, Дамдинням, Болорчулуун, Батлут нарын гишүүд эсрэг гараад байна шүү энэ чинь.

8.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “түүний” гэснийг хасаж, 17.1.6 дахь заалтын “тусгай” гэсний өмнө “хууль хэрэглээний талаар” гэж, 17.1.9 дэх заалтын “Ерөнхий шүүгч,” гэсний дараа “танхимын тэргүүн,” гэж тус тус нэмж, 17.1.7, 17.1.11 дэх заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 17.1.10 дахь заалтын “Шүүгчдийн зөвлөлийн төлөөлөгч,” гэснийг, “мэргэшлийн болон” гэснийг тус тус хасаж, 17.2 дахь хэсгийн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь оролцогчдын

хүсэлтээр зохих” гэснийг “хэрэг, маргаан хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар” гэж өөрчлөх:

“17.1.7.энэ хуулийн 20.1-д заасан Нийт шүүгчийн чуулганд оролцох;”

“17.1.11.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 47 гишүүн дэмжиж 69,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.3 дахь заалтын “шүүх хуралдааныг даргалах,” гэснийг хасаж, 18.1.4, 18.1.5 дахь заалтуудыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.4 дэх заалт болгож, 18.1.7, 18.1.8 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 18.1.7-18.1.9 дэх заалт болгож, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмж, 30 дугаар зүйлийг хасах:

“18.1.1.тухайн шүүхийг бүрэн эрхийнхээ хүрээнд төлөөлөх;

18.1.4.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд Тамгын газраас хариу өгч байгаа ажиллагаанд хяналт тавих;

18.1.7.танхимын тэргүүний ажлыг уялдуулах;

18.1.8.шүүхийн практик, тоон мэдээлэлд үндэслэн шүүн таслах ажиллагааны чанар, үр дүн, хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтын талаар Зөвлөгөөнд мэдээлэл хийх;

18.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.”

“18.2.Ерөнхий шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй.” Санал гаргасан Ажлын хэсэг. Тогтохсүрэн гишүүн, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүд үг хэлнэ. Цахимаар үг хэлэх гишүүн байна уу?

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би 18 дугаар зүйл үг хэлнэ. Жишээ нь 18.1.1, 18.1.4, 18.1.5 дээр Засгийн газраас өргөн барьсан төсөл дээр 2 чухал заалт байсан юм. Энэ 18 дугаар зүйл бол анхан шатны болон давах шатны шүүхийн ерөнхий шүүгчийн чиг үүрэг байхгүй. Нийтлэг чиг үүрэг. Гэтэл энэ дотор нь энэ иргэдтэй харилцах энэ 2 чухал харилцааг хассан байгаа байхгүй юу ажлын хэсэг. 18.1.4 нь иргэдийг хүлээн авах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах. 18.1.5 нь иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах. Энэ хэргийн оролцогчтой холбоотой асуудал биш юм байгаа юм.

Түрүүн асуух явцад хэргийн оролцогчтой холбоотойгоор ойлгож тайлбарлаад байна лээ энэ 18 дугаар зүйлийг. 18 дугаар зүйл бол ерөнхий шүүгчийн өөрийнх нь бүрэн эрхтэй холбоотой асуудал байгаа юм. Тийм учраас би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр дараагийн хэлэлцүүлэг дээр энийг иргэд рүү чиглэсэн ийм ажиллагаа хийгдэж байхгүй бол иргэдээсээ холдоод шийдвэр нь цаг үеэ мэдрэхгүй ийм шийдлүүд гараад байгаа юм. Тийм учраас бол энэ ерөнхий шүүгч хүний хувьд бол орон нутгийнхаа цаг үеийнхээ нөхцөл байдлыг мэдрэх үүднээсээ тухайн нутгийн ард иргэдийн санал бодол гомдлыг сонсдог бас зарим асуудлыг нь шийдвэрлэдэг ийм чиглэл рүү явахгүй бол манай шүүх чинь сүүлийн жилүүдэд хүнтэй уулзахаараа хараат бус болно гэдэг ийм байдлаар ханддаг болчихоод байгаа юм.

2 дугаарт нь ажлын ачаалалтай холбоотой асуудлаар олон гишүүн яриад олон гишүүн яриад байгаа юм. Ер нь бид нар энэ хуулийг гарсны дараа нэг шүүгчид ноогдох ажлын ачаалал нь норм нормативыг тогтоож өгөөд шүүгчдийнх нь тоог болохгүй бол нэмбэл яасан юм бэ. Баахан ачаалал ихтэй шүүгчдээр юм хийлгээд

дараа нь алдаа гарсан гээд ингээд байдаг байхгүй юу. Тийм учраас энэ асуудлыг ч гэсэн ажлын хэсэг дараагийн хэлэлцүүлэг дээрээ би анхаарах хэрэгтэй юм болов уу гэж ингэж бодоод байгаа юм.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Би энэ 18.1.8-тай холбоотой зүйл асууя гэж бодож байна. Ер нь энэ дэлхийн улс орнуудад шүүх хуралдааныг мэдээллийг олон нийтэд үнэн зөв өгөх шүүн таслах ажиллагаа яг шударга зөв явж байна уу үгүй гэдгээр маш ил тод байдаг тэр хуралдааныг телевизээр юм уу ил явуулдаг. Манайд ихэнх энэ шүүх хуралдаанууд дандаа хаалттай явдаг. Заримдаа бол бараг өмгөөлөгч оролцохгүйгээр сүүлийн үеийн шүүх хуралдаанууд явж байна гэсэн ярианууд хүртэл маш их гараад байгаа л даа.

Энэ бүхний ард бол дандаа хүний эрхтэй холбоотой асуудал байгаа. Тэр хүн гэмт хэрэг үйлдсэн байлаа ч гэж бодсон тэр бол эрхээ эдлэх үүрэгтэй. Тэгэхээр энэ дээр ер нь энэ шүүх хуралдааныг телевизээр ч юм уу ил тод явуулах мэдээлэл хийдэг байх энэ нэг шинэ урсгал руу уг нь энэ шүүхийн шинэчлэлийн хуулийн хүрээнд орчих их зөв юм шиг санагдаад байгаа юм. Бусад улс оронд яадаг тэр байгаа юу? Тэрний талаар нэг мэдээлэл би авчихмаар байх юм. Саяын тэр Тогтохсүрэн даргын хэлдэг нэг шүүгчид ноогдох хэргийн дээд тал нормативыг нь тогтоож өгөөд шүүгчдийн орон тоог нэмэх асуудал бас чухал байгаа шүү гэдгийг хэлье. Асуулт асуухгүй. Ерөнхий санаа нь зөв л юм байна шүү дээ тэр чинь. Санал хураалт. 46 гишүүн дэмжиж 67,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төсөлд доор дурдсан агуулгатай 19 дүгээр зүйл нэмж, 31, 33 дугаар зүйлүүдийг хасах:

“19 дүгээр зүйл.Танхимын тэргүүний бүрэн эрх

19.1.Танхимын тэргүүн энэ хуулийн 17.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.1.1.танхимыг тэргүүлж, шүүх хуралдааны бэлтгэл ажлыг хангахад танхимын шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг уялдуулан зохион байгуулах;

19.1.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамааралгүй асуудлаар иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхэд Тамгын газарт туслалцаа үзүүлэх;

19.1.3.хуульд заасан бусад бүрэн эрх.

19.2.Танхимын тэргүүн шүүн таслах ажиллагаанд оролцохдоо давуу эрх эдлэхгүй.

19.3.Танхимын тэргүүн бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж гаргана.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 48 гишүүн дэмжиж 70,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Шүүгчдийн зөвлөгөөн

19.1.Шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн Зөвлөгөөн ажиллана.

19.2.Зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

19.2.1.тодорхой хэрэг, маргаан хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн дотоод ажлын зохион байгуулалт, журмыг хуульд өөрөөр заагаагүй бол тогтоох;

19.2.2.шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох;

19.2.3.шүүгчийг мэргэшүүлэх сургалтын саналаа энэ хуулийн 24.1-д заасан Хүрээлэнд хүргүүлэх;

19.2.4.тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийг шүүгчид дотроосоо сонгох;

19.2.5.энэ хуулийн 19.3-т заасан нөхцөл, шаардлага болон энэ хуулийн 20.2.4-т заасан нийтлэг журамд үндэслэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг батлах;

19.2.6.энэ хуулийн 18.1.8-д заасан мэдээлэлтэй танилцах;

19.2.7.хуульд заасан бусад бүрэн эрх.

19.3.Энэ хуулийн 19.2.5-д заасан журам нь хуваарилагдах шүүгчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг хангасан байх бөгөөд дараах шаардлага хангасан программ хангамжийг ашиглана:

19.3.1.шүүх хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, Зөвлөгөөний шийдвэргүйгээр өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдэд шууд өгөх боломжтой байх;

19.3.2.цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн солигдох бусад нөхцөлд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.

19.4.Энэ хуулийн 19.2.5-д заасан журам олон нийтэд нээлттэй байна.

19.5.Зөвлөгөөн ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус зөвлөгөөнийг тухайн шүүхийн шүүгчдийн гуравны нэгийн, эсхүл танхимын, эсхүл Ерөнхий шүүгчийн саналаар хуралдуулна.

19.6.Шүүгч Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцах, санал гаргах, хуралдаанд оролцох тэгш боломжоор хангагдах бөгөөд шийдвэр гаргах үйл явц нь нээлттэй, шуурхай, үндэслэл бүхий байна.

19.7.Зөвлөгөөн хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

19.8.Тухайн шүүхийн шүүгчдийн дийлэнх олонх оролцсоноор Зөвлөгөөнийг хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуулийн 19.2-т заасан асуудлыг Зөвлөгөөнд оролцсон шүүгчдийн олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт. Батбаатараа, 49 гишүүн дэмжиж 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хэл найруулга бас анхаармаар юмнууд байна шүү.

12.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“20 дугаар зүйл.Нийт шүүгчийн чуулган

20.1.Бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн хуралдааныг /цаашид “Нийт шүүгчийн чуулган” гэх/ дөрвөн жил тутам зохион байгуулна.

20.2.Нийт шүүгчийн чуулганаар дараах асуудлыг шийдвэрлэнэ:

20.2.1.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, огцруулах;

20.2.2.шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг Улсын дээд шүүхэд уламжлах;

20.2.3.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсох;

20.2.4.энэ хуулийн 19.2.5-д заасан хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журмыг батлах;

20.2.5.шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг авч хэлэлцэх, зөвлөмж гаргах.

20.3.Нийт шүүгчийн чуулган хуралдааны дэгээ өөрөө тогтооно.

20.4.Нийт шүүгчийн ээлжит бус чуулганыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн, эсхүл бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн гуравны нэгийн, эсхүл нийт шүүгчийн тавны нэгээс доошгүйн саналаар хуралдуулна.

20.5.Нийт шүүгчийн олонх оролцсоноор чуулганыг хүчинтэйд тооцох бөгөөд асуудлыг чуулганд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэнэ.

20.6.Нийт шүүгчийн чуулганд шүүгч биечлэн оролцох боломжгүй тохиолдолд түүнийг цахимаар санал өгөх боломжоор хангана.

20.7.Ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчийг нууц санал хураалтаар сонгоно.

20.8.Нийт шүүгчийн чуулганы шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

20.9.Нийт шүүгчийн чуулганыг Улсын дээд шүүхийн Зөвлөгөөнөөс сонгосон хоёр, нийслэлийн эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Зөвлөгөөн тус бүрээс сонгосон нэг, дүүргийн анхан шатны шүүхээс шүүгчээр хамгийн олон жил ажилласан хоёр шүүгч, Ерөнхий зөвлөл дотроосоо сонгосон шүүгч хоёр гишүүнээс бүрдсэн ажлын хэсэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ зохион байгуулна.

20.10.Ажлын хэсэг Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулж дуусах хүртэл ажиллах бөгөөд ахлагчаа дотроосоо нууц санал хураалтаар сонгоно. Ерөнхий зөвлөлийн ажлын алба хуралдааны зохион байгуулалтын асуудлаар Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх бөгөөд хуралдааны материал архивлах асуудлыг хариуцна.

20.11.Нийт шүүгчийн чуулган даргалагчаа дотроосоо сонгоно.

20.12.Нийт шүүгчийн чуулганаар хэлэлцэх асуудлын саналыг тоолох тооллогын комисс ажиллана. Комиссын бүрэлдэхүүнд хяналтын болон давж заалдах шатны шүүхээс тус бүр хоёр, анхан шатны шүүхээс гурван шүүгчийг Нийт шүүгчийн

чуулганаас нууц санал хураалтаар сонгох бөгөөд даргыг дотроосоо сонгоно.” Санал гаргасан Ажлын хэсэг, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар. Чинзориг гишүүн үг хэлнэ. Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ. Ингээд 2 гишүүнээр тасаллаа. Одоо шуурхай л явмаар байх юм. Тогтохсүрэн гишүүн.

С.Чинзориг: Шүүгчид чинь нөгөө хариуцлага тооцох сахилгын шийтгэл оногдуулах эрхийг нь Үндсэн хуулийн байгууллага болоод байгууллага болсон ингээд сахилгын хороонд өгчихдөг. Гэтэл нийт шүүгчдийнхээ чуулганаас сахилгын хорооны тайланг хэлэлцэнэ гэдэг чинь хэр энэ зарчимдаа Үндсэн хуулийнхаа зарчимд нийцэж байгаа юм бэ? Сахилгын хороо чинь бол Үндсэн хуулийн байгууллага болсон. Тэгээд шүүгчдэд сахилгын шийтгэл оногдуулах эрхтэй ийм субъект болж байгаа. Гэтэл нийт шүүгчдийнхээ чуулганаас сахилгын хорооны тайланг авч хэлэлцэнэ гэдэг чинь Үндсэн хуулийнхаа байгууллагыг шүүгчдийн одоо орон тооны бус чуулганаар тайланг нь сонсоод санал, дүгнэлт гаргаад тэгээд наад сахилгын хороог чинь нөгөө шүүгчийн төлөөллөөс орох гишүүдийг сонгох огцруулах ийм асуудал яригдаад явах нь л дээ.

Тэгэхээр энэ чинь одоо тэгээд Үндсэн хуулийнхаа агуулгатай зарчимтай хэр нийцэж байгаа юм бэ гэсэн ийм л зүйлийг нэг анхаармаар байна. Энэ бол миний хувьд бол энэ сахилгын ерөнхий хорооны тайланг Үндсэн хуулийн байгууллага субьектийн тайланг шүүгчдийн чуулганаар сонсоно гэдэг чинь бол зарчимтайгаа бас нийцэхгүй болов уу гэсэн ийм саналтай бол байна.

Г.Занданшатар: Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Би 20.2.1 ерөнхий зөвлөл сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, огцруулах гээд. Энэний ард чөлөөлөх гэдгийг заавал оруулж өгөхгүй яагаад заавал огцруулах. Огцруулж бол мэдээж болно. Чөлөөлөх асуудал нь байхгүй байгаа байх. Амьдрал баян, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж болно. Эрүүл мэндийн шалтгаан байж болно. Эд нар нь бүгд байхгүй байгаа л байхгүй юу. Тийм учраас дараагийн хэлэлцүүлэг дээр энийг анхаарч өгөөч гэж. 2 дугаарт нь саяын Чинзориг гишүүний хэлдэг 20.2.3-г хасах саналтай байгаа юм. Ерөнхий зөвлөл сахилгын хорооны тайланг шүүгчдийн зөвлөл хэлэлцэж болохгүй. Энэ 2 байгууллага чинь 1 дүгээрт Үндсэн хуулийн байгууллага нөгөө талаас нь бүрэлдэхүүнийх нь үндсэндээ 60 орчим хувь нь сонгон шалгаруулалтаар Их Хурлаас томилогдож байгаа байгууллага. Тийм учраас түүнийг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцээд байх юм бол цаашдаа нөлөөллийг бий болгох гэж байгаа хэлбэр учраас би 20.2.3-ыг хасах саналтай байгаа юм.

29 дээр заавал ингэж нэг баахан нийслэл хурал бүрийг ер нь нийслэл зохион байгуулдаг болох юм байна л даа. Орон нутгийн оролцоо байхгүй. Тэгэхээр 20.9-ийг заавал ингэж нэг тодорхой заах хэрэг байгаа юм уу? Нийслэлээс, Дээд шүүхээс тэд зүгээр л хурал зохион байгуулах ажил байна шүү дээ энэ чинь. Тэгвэл орон нутгийн оролцоог бий болгох хэрэгтэй. Дандаа нийслэлийнхэн орсон байх юм. 100 хувь. Хуульд Дээд шүүх нь тэд байна, нийслэлийнх байна. Дүүргийнх байна. Аймаг, нийслэл сум байхгүй байгаа байхгүй. Тийм учраас энд бас орон нутгийн оролцоог бий болгох чиглэлд нь хэрэв заавал байна гэвэл орон нутгийн оролцоог бий болгох чиглэлд нь анхаарч өгөөч гэдэг ийм л 3 санал байгаа юм.

Г.Занданшатар: Яваандаа энэ нийт шүүгчийн чуулганы тухай хууль гэж тусдаа процессын хуулиуд ингэж салж явахгүй бол бүх юмыг нэг доор оруулчихаар процесс энэ тэрээр яачихаар ингээд деталь руу орохоор их маргаанууд гарна л даа. Гэхдээ

энэ нь бол ингэж явахаас өөр замгүй. Сонсоно гэж байгаа болохоос тайланг сонсоод ямар яах биш. Тайлан сонсох бол байж болох л үзэгдэл дээ. Хариуцлага тооцно гэж байгаа биш. Мэдээлэл өгч байхад болохгүй юм байхгүй ч байж магадгүй. Гэхдээ энэ процесс. Санал хураалт. 48 гишүүн дэмжиж 70,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “бэлгэ тэмдэг,” гэснийг, мөн зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 50 гишүүн дэмжиж 73,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.3, 22.8, 22.9, 22.10 дахь хэсэг, 22.5 дахь хэсэгт “Хяналтын шатны шүүхийн шүүгч нь тусгай саналаа уг шүүхийн цахим хуудаст байршуулж, нийтлэх эрхтэй.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмэх:

“22.3.Шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал нь шүүхийн шийдвэрийн бүтэц, төрөл, агуулга, хэл найруулга, хууль зүйн техник, шүүхийн шийдвэр эшлэхэд тавих шаардлага, талуудын шаардлага, татгалзал, тайлбарт маргаж байгаа үйл баримт болон хууль зүйн үндэслэл бүрд бүрэн дүгнэлт өгөх арга зүйг агуулсан байна.

22.8.Улсын дээд шүүхийн шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтэлнэ.

22.9.Олон нийтийг мэдээллээр хангах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг тайлбарлах зорилгоор шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой байдлаар мэдээлнэ.

22.10.Хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн шүүхийн шийдвэрийг тухай бүр, ойлгомжтой байдлаар бичгээр болон биечлэн тайлбарлана.” Санал гаргасан Ажлын хэсэг. Шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал энэ тэр чинь тэр шүүхийн шийдвэр гаргах журам энэ тэр гэж харах юм байна лээ шүү дээ. Тэрийг чинь яахгүй бол хэтэрхий детальчлаад. Үгүй үгүй Улсын дээд шүүхийн шийдвэрийг Төрийн мэдээлэлд эмхэтгэл нийтэлнэ гэж байгаа шүү дээ. Та битгий үймүүлээд бай, санал хураалт. 49 гишүүн дэмжиж 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Сүүлдээ энэ тусдаа хуулиуд л болж задрахгүй бол бас л.

15.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн

24.1.Шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, шүүн таслах ажиллагааг сургалт, судалгаа, мэдээллээр хангах, Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад шаардагдах судалгаа хийх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал бэлтгэх, шүүхийн шийдвэрийн хураангуйг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн /цаашид “Хүрээлэн” гэх/ Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.

24.2.Хүрээлэн нь сургалтын хөтөлбөрийг боловсруулах чиг үүрэг бүхий бүх шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөл, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийнн төлөөллөөс бүрдсэн орон тооны бус хороотой байна.

24.3.Хүрээлэнгийн бүтэц, орон тоо, ажиллах журам, шүүгчийн сургалтын хөтөлбөрийг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батална.

24.4.Зөвлөгөөн болон шүүгчийн өөрийнх нь саналыг үндэслэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг зургаан сар хүртэлх хугацаагаар судлаачаар ажиллуулж болох бөгөөд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгож, шүүгчээр ажилласанд тооцно.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 79,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “зэрэг” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 25.3 дахь хэсэг нэмж, 25.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “Ерөнхий шүүгч, шүүгч” гэж өөрчилж, 25.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 25.6, 25.7 дахь хэсэг болгох:

“25.3.Улсын дээд шүүх нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана.”

“25.6.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.6.1.хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

25.6.2.энэ хуулийн 25.6.1-д заасан болон хуульд заасан үндэслэл, журмын дагуу давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх;

25.6.3.хуульд заасан үндэслэлээр Улсын дээд шүүхийн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох;

25.6.4.хуулиар харьяаллыг нь тогтоогоогүй эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоох;

25.6.5.Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг дараах тохиолдолд хяналтын журмаар хянан шийдвэрлэх:

25.6.5.1.анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;

25.6.5.2.хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;

25.6.5.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн.

25.7.Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагаанаас бусад асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.7.1.хуульд тусгайлан заасан тохиолдолд Улсын дээд шүүхэд хэрэг, маргааны төрлөөр дагнасан танхим байгуулах, бүрэлдэхүүнийг батлах;

25.7.2.давж заалдах шатны шүүхэд шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхим байгуулах асуудлыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн хэлэлцэж, шийдвэрлэх;

25.7.3.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төсөлд саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;

25.7.4.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг танхимын саналыг үндэслэн гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх;

25.7.5.хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

25.7.6.энэ хуулийн 75.2-т заасан Ерөнхий зөвлөлийн саналын дагуу, эсхүл энэ хуулийн 7.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;

25.7.7.Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, эгүүлэн татах хуульд заасан үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор санал гаргах;

25.7.8.хуульд заасан бусад бүрэн эрх.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Одонтуяа гишүүн үг хэлнэ.

С.Одонтуяа: Би энэ 25.6 дээр ажлын хэсгийн ахлагчаас асуумаар байна. Ажлын хэсгийн ахлагчийн байр суурь яагаад энд ингээд үндсээрээ өөрчлөгдсөн бэ гэдгийг. Өөрөөр хэлбэл төсвийн тодотголыг хэлэлцэх үед яг энэ заалт дээр ерөнхий шүүгчид эдлүүлэх бүрэн эрх гээд хуулийн төсөл орж ирэхэд та бол маш ихээр эсэргүүцэж байсан хуульч гишүүний нэг. Тэгэнгүүт энийгээ Улсын дээд шүүх гэж нэрийг нь өөрчлөөд ороод ирж байгаа юм. Дээрээс нь энэ чинь шүүх бүрэлдэхүүн хүрэлцээгүй гэж үндэслэлээр эрх мэдлийг өгөхөөр өөрт ашигтай шийдвэр гаргуулахаар тэр шүүх бүрэлдэхүүнийг яаж томилж болох юм ашиг сонирхлыг зөрчил үүснэ. Тэгэхээр та яагаад энэ үзэл санаанаасаа ухарсан юм бол.

Дээрээс нь эрүү, иргэн, захиргааны гээд ингээд төрөлжсөн дагнасан байхад захиргааны шүүгч нь гүйж очоод тэр шүүх бүрэлдэхүүн нь хүрэхгүй байна, хүрэлцэхгүй байна гээд эрүү дээрээ очоод тэр хэргийг нь шүүгээд байх юм уу. Тэгэхээр энэ асуудал бол ийм их эргэлзээтэй юм орж ирсэн учраас энэ асуудлыг асууж болох билүү даргаа? Болохгүй юу? Тэгвэл энэ асуудлыг бол дэмжихгүй байна.

Г.Занданшатар: Адьшаа гишүүн үг хэлнэ. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн дараа нь Энхбаяр гишүүн саналын томъёоллоо дэмжиж хэлнэ.

Ш.Адьшаа: Би сая тэр 24 дээр нэг үг хэлэх гээд өнгөрчихлөө. Энэ шүүхийн сургалт судалгаа мэдээллийн хүрээлэн гэдэг энэ байгууллагыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд байгуулна гээд Энхбаяр гишүүн санал гаргаад би зарчмын зөрүүтэй санал гаргаад энэ Дээд шүүхийн дэргэд байгуулъя гээд оруулж ирсэн. Гэтэл Энхбаяр гишүүн энийг шууд засаад оруулж ирсэн байсан. Засаад оруулж ирсэн. Өөрөө тэр одоо дээр орон дотроо хууль заслаа гээд Их Хурлын дарга огцорч байсан шүү дээ. Гэтэл өнөөдөр хуулийн ажлын хэсэг дээр санал хураалгаад тэр нь дэмжигдээгүй саналыг оруулж ирээд ингэж болдог юм уу.

Тэгээд энэ хуралд суудаггүй, энэ тэр гээд надыг янз бүрийн доромжлоод байх юм. Ингэж болдог юм уу ер нь. Ажлын хэсэг дээр унасан саналыг дэмжсэнээр би зориулж ирээд Хууль зүйн байнгын хороон дээр хэлсэн чинь надыг зүгээр шоолоод даапаалаад өнгөрсөн шүү дээ. Гэтэл өнөөдөр энэ ажлын хэсгийн саналыг ингэж 4, 5 санал зассан байгаа юм. Тэгээд Энхбаяр засчихдаг. Тэгээд энийг Байнгын хороон дээр хэлэхээр шоолоод л орсон бол сайн хэрэг шүү дээ. Баярлаж яв гэж хэлсэн шүү дээ намайг. Ингэж засаж болдог юм уу би Их Хурлын даргаас асууя энийг.

Г.Занданшатар: Дэмжсэн дэмжээгүй үг л хэлнэ. Асуулт байхгүй. Асуудал байгаа бол ажлын хэсэг дээрээ ярь. Байнгын хороон дээрээ ярь. Энхбаяр Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Энэ ажлын хэсгийн хуралдаа суугаагүй болохоор л суудаггүй болохоор ингээд мэдээллээс хоцроод байгаа юм. Тэгээд л энэ чинь нэг ажлын хэсэг дээрээ хуралдана. Дараагийн 2 дахь удаа энэ чинь 7 удаа хуралдсан шүү дээ. Дараа нь дахиж гишүүд бас санал гаргаад ингээд хураагаад яваад байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь нөгөө мэдээллээс хоцрохоороо ганц суусан хурлынхаа ойлголтоор ингээд яриад байх юм.

2 дугаарт энэ Одонтуяа гишүүн энэ нөгөө Улсын дээд шүүхийн танхим хооронд бүрэлдэхүүн батлаад байгаа шүү дээ. Энийг та уншаарай. 25.7 Улсын дээд шүүх одоо шийдэх гэж байгаа байхгүй юу. Өмнө нь ерөнхий шүүгч ганцаараа шийддэг болох гэхээр тэгж болохгүй ерөнхий шүүгч ганцаараа энэ аль шүүгчээ аль танхимдаа хуваарилах вэ гээд ганцаараа мэдээд байх чинь аюултай байна гээд. Энэ дээд шүүхэд нь өгч байгаа байхгүй юу. Нөгөө 25 шүүгч өөрсдөө сууж шийдэх болж байгаа юм. Тийм агуулга байгаа шүү. 25.7.1 Дээд шүүх өөрөө танхимаа байгуулж байгаа.

Г.Занданшатар: Цогт шүүгч явсан уу. Энэ санкцыг нь тодорхой заахгүй бол жишээлбэл Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг эгүүлэн татах томилох үндэслэл бий болсноос хойш 30 хоногийн дотор гээд хаячихдаг. Одоо ч гэсэн энэ практик одоо бараг ингээд яваад Улсын Их Хурлаас 4, 5 бичиг явуулсан. Хамгийн сүүлд би бичиг явуулсан. Тэгээд санкц байхгүй болохоор хуулийг санкцтай баймаар байна. 30 хоногийн дотор ирүүлэхгүй бол Улсын Их Хурал Хууль зүйн байнгын хороо нэр дэвшүүлж томилно гээд. Ерөөсөө хугацаандаа хийхгүй бол болохгүй. Та дуугүй бай ингээд битгий хурал.

2 дугаарт нь тэр Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарлана гэж Үндсэн хуульд заасан байгаа. Тэрнийг бүр хязгаарлаад танхимын саналыг үндэслэн биш энэ хууль тогтоогчийн протокол агуулгыг үндэслэж л тайлбарла даа. Тэгээд танхимын саналыг үндэслэж хууль тайлбарлахаар хийж байгаа энэ тэр бас зөрчилтэй байж болзошгүйг эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарахыг чиглэл болгож байна. Ингээд санал хураалт ажлын хэсэг. 30 хоногийн дотор гээд уг нь хугацаа байгаа байхгүй юу Үндсэн хуулийн цэцийн гишүүд. Одоо жил өнгөрч байна Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн асуудал хууль зөрчигдөж байна.

17.Төслийн 25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсгийн “хорин дөрвөөс доошгүй” гэснийг “хорин дөрвөн” гэж өөрчлөх. Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар. Санал хураалт. Энэ 24-өөс доошгүй л гэж байгаа. Энийг 13 болгоно гэж байгаад тэгээд яг 24 гэж яг зааж байгаа. 24-өөс доошгүй гэхээр хэдтэй ч байж болохоор агуулагдаад байгаа юм. Ер нь тохирсон саналууд. 51 гишүүн дэмжиж 75 хувийн саналаар санал дэмжигдэж байгаа. Дэмжлээ.

18.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.7.8 дахь заалт нэмэх:

“25.7.8.улс төрийн намын бүртгэл хөтлөх;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар. Энийг бусад хуультай уялдуулж Байнгын хороон дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Ер нь бол улс төрийн намын бүртгэл бол Дээд шүүхийн асуудал бол Сонгуулийн ерөнхий хороо бүртгэдэг. Улс төрийн асуудал руу орж байна.

19.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “25.6.3, 25.6.4, 25.6.5, 25.6.6, 25.6.7, 25.6.8, 25.6.9, 25.6.10-г” гэснийг “25.6.3, 25.6.4, 25.7-д” гэж, 26.2 дахь хэсгийн “түүний түр эзгүйд,” гэснийг “эсхүл энэ хуульд заасны дагуу түүний” гэж өөрчилж, 26.4 дэх хэсгийн “асуудлыг” гэсний дараа “нийт шүүгчийн” гэж нэмэх. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж 77,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч энэ хуулийн 18.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөн зарлах, бэлтгэлийг хангах, даргалах;

27.1.2.Улсын дээд шүүхийг гадаад харилцаанд төлөөлөх;

27.1.3.Улсын дээд шүүхийн шүүгчид гадаад, дотоод ажлын томилолт олгох;

27.1.4.танхим хоорондын ажлыг уялдуулан зохион байгуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад шаардлагатай гэж үзсэн асуудлыг хэлэлцүүлэхээр танхимд хуваарилах;

27.1.5.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн зөвлөгөөнд танилцуулснаар Тамгын газрын дарга, Хүрээлэнгийн захирлыг томилох, чөлөөлөх;

27.1.6.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөнөөс гаргасан шийдвэрийн дагуу Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газартай Улсын дээд шүүхийг төлөөлөн харилцах;

27.1.7.хуульд заасан бусад бүрэн эрх.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 51 гишүүн дэмжиж 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.1.5 дахь заалт нэмэх:

“27.1.5.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан иргэний өргөдөл, гомдолд албан бичгээр хариу өгөх; ” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж. Энэ чинь иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дэх заалттай зөрчилдөж байна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж санал хураалт. Энэ аягүй өргөн эрх нээж байна шүү. Энэ ерөнхий шүүгчид өгч байгаа эрх шүү дээ Улсын Их Хурлын чинь. 49 гишүүн дэмжиж 72,1 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн 28 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн танхимын бүрэн эрх

28.1.Улсын дээд шүүхийн танхим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиар тогтоосон журамд нийцүүлэн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллыг тогтоох;

28.1.2.хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол залруулга хийх;

28.1.3.шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Монгол Улсын Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанд оруулах;

28.1.4.Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаан, Зөвлөгөөн зарлан хуралдуулах талаар Ерөнхий шүүгчид санал гаргах;

28.1.5.хуульд заасан бусад бүрэн эрх.” Санал гаргасан Ажлын хэсэг.

Санал хураалт. 52 гишүүн дэмжиж 76,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Пүрэвдорж, Тогтохсүрэн, Ганбаатар гишүүн суудалдаа сууна шүү.

23.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 29.5.1 дэх заалтын “хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийг үндэслэн” гэснийг “хуульд заасны дагуу” гэж, 29.4 дэх хэсгийн “шүүгч” гэснийг “Ерөнхий шүүгч, шүүгч” гэж тус тус өөрчилж, 29.5.3 дахь заалтын “мэдээлэл, зөвлөмж гаргуулах,” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай 29.5.3 дахь заалт нэмэх:

“29.3.Давж заалдах шатны шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхимтай байж болно. Танхимыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн батална.”

“29.5.3.хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллын талаар доод шатны шүүх хооронд гарсан маргааныг шийдвэрлэх;” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Энэ их маргаантай асуудал. 54 гишүүн дэмжиж 79,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Өргөдөл гомдлын тухай хуулиар ерөөсөө бүх өргөдөл гомдолд 30 хоногийн дотор хариу өгөх үүрэгтэй байдаг шүү дээ Пүрэвдорж гишүүнээ.

24.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “дүүргийн” гэсний дараа “шүүх” гэж нэмж, 32.3 дахь хэсгийн “тодорхой хэрэг, маргааны төрлөөр” гэснийг “шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан” гэж өөрчилж, 32.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 32.5 дахь хэсгийн “нүүдэллэн ажиллаж” гэснийг “шүүх хуралдааныг шүүхийн байрнаас бусад газарт хийж” гэж өөрчлөх:

“32.4.Энэ хуулийн 32.3-т заасан танхимыг тухайн шүүхийн Зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн батална.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 50 гишүүн дэмжиж 73,5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тэр Пүрэвдорж гишүүний саналыг Пүрэвдорж гишүүнээ Үндсэн хуулийн 16.12-т иргэн төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах эрхтэй. Өргөдөл гомдлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх үүрэгтэй гэсэн ийм тал. Тэрэнтэйгээ уялдуулаад. Одоо өнгөрсөн.

25.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтын “гэмт хэрэгт холбогдоогүй буюу” гэснийг хасаж, 34.2 дахь хэсгийн “жагсаалтыг” гэснийг “жагсаалт болон энэ хуулийн 41.2.2-т заасан эрүүл мэндийн шалтгааныг тогтоох журмыг” гэж, 34.4 дэх хэсгийн

“шаардлагыг” гэснийг “шаардлагын аль нэгийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 34.4.3 дахь заалт нэмж, 34.5, 34.6 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.4.3. магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан.”

“34.5. Сүүлийн зургаан жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан хүнийг шүүгчээр томилохыг хориглоно.

34.6. Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн гуравны хоёроос доошгүй нь энэ хуулийн 34.4.1-д заасан шүүгч байна. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан байна.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж 72,1 хувийн саналаар дэмжигдлээ. Тэр 34.6 дээр 34.4.1-т заасан шүүгч байна гэхээр эвгүй сонсогдоод. 10-аас доошгүй жил ажилласан шүүгч байна гээд заачихад болох байх. Шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан. 34.4.1 тийм. 49 гишүүн дэмжиж 72,1 хувийн саналаар санал дэмжигдсэн.

26. Төслийн 35 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35 дугаар зүйл. Шүүгчийг сонгон шалгаруулах журам

35.1. Хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах, шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг Ерөнхий зөвлөл нээлттэй, ил тод, хараат бус байх, хууль дээдлэх зарчмыг баримтлан зохион байгуулна.

35.2. Ерөнхий зөвлөл дараах хугацаанд шүүгчийн сонгон шалгаруулалтын зарыг өөрийн цахим хуудас болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ:

35.2.1. шүүгч энэ хуулийн 49.6-д заасны дагуу өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол тэтгэвэр тогтоолгох өдрөөсөө 120-оос доошгүй хоногийн өмнө Ерөнхий зөвлөлд мэдэгдэх бөгөөд орон тоо гарахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө;

35.2.2. шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээр байгаа бол орон тоо гарахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө;

35.2.3. энэ хуулийн 35.2.1, 35.2.2-т зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн сул орон тоо гарсан бол тухайн өдрөөс хойш 14 хоногийн дотор.

35.3. Энэ хуулийн 35.2-т заасан зард шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх болзол, шаардлага, өргөдөл, хавсралт баримт бичгийг хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон байна.

35.4. Энэ хуулийн 35.2-т заасан зарыг тухайн шүүгчийн ажиллах аймаг, нийслэлийн өдөр тутмын хэвлэлд нийтэлж болно.

35.5. Ерөнхий шүүгч тухайн шатны шүүхийн шүүгч, эсхүл өөрөө шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээс 120-оос доошгүй хоногийн өмнө, бусад тохиолдлоор шүүгчийн сул орон тоо гарсан бол Ерөнхий зөвлөлд ажлын таван өдрийн дотор мэдэгдэнэ.” Санал гаргасан Ажлын хэсэг. Дэлгэрсайхан гишүүн, Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн цахимаар.

Б.Дэлгэрсайхан: Байна уу?

Г.Занданшатар: Сонсож байна Дэлгэрсайхан гишүүнээ яриарай.

Б.Дэлгэрсайхан: Би энэ саналаа хойшлуулъя. Дараагийн 28 дээр хэлэх саналыг андуурч оруулсан байна даргаа.

Г.Занданшатар: Боллоо тэгвэл. Санал хураалт явуулна. Пүрэвдорж гишүүн Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Их Хурлын даргаа 27.1.5 дээр би нэг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан өргөдөл гомдолд албан бичгээр хариу өгөх гэдэг энэ саналыг гаргаад сая дэмжигдсэн. Энэ дээрээ бас нэг чиглэл өгүүлмээр байна. Та бас сая хэлж байх шиг байна. Тэгэхээр энэ иргэний хэрэг хянан шийдвэрлэх маргаантай холбоогүй бусад асуудлаар дээд шүүх тамгын газраараа дамжуулаад иргэдийн өргөдөл гомдолд хариу өгч байгаа. Харин хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой энэ асуудал дээр Дээд шүүхийн ерөнхий шүүгчээр заавал албан бичгээр хариу өгүүлэх тухай асуудлыг би энд яриад байгаа юм. Тэгэхээр 66.3 дээр Үндсэн хуулийн 66.3 дээр ийм заалт байгаа.

Тэгэхээр 2002 оноос хойш бүхэл бүтэн 10 хэдэн жилийн турш иргэний хэрэг хянан шийдвэртэй холбоотой аливаа өргөдөл гомдолд Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Ерөнхий прокурор хоёр ерөөсөө албан бичигт хариу өгөхөө больсон. Яахаараа эд нар ингээд ийм хэрэв албан бичигт хариу өгчихвөл тэрнийх нь дагуу Дээд шүүхэд асуудал тавьчихвал Дээд шүүх тэр хүний албан тушаалыг хууль зөрчсөн эсэхийг шийдэх боломжтой болж байгаа байхгүй юу. Тэгэнгүүт энэ хүмүүс энэ Дээд шүүхийн ерөнхий шүүгч Улсын ерөнхий прокурор хоёр яаж байна вэ гэхээр дандаа орлогчоороо юм уу эсхүл Дээд шүүхийн танхимын шүүгчээрээ хариу өгүүлдэг. Тэгээд энэ нөгөө нэг хууль одоо энэ Цэц дээр хууль зөрчсөн эсэх асуудлаар нь асуудал тавих боломжгүй болгодог.

Өөрөөр хэлбэл тэр орлогч шүүгчийг ч юм уу орлогч прокурорыг Үндсэн хуулийн цэц авч хэлэлцэх тухай асуудал ерөөсөө байхгүй. Тэгээд.../минут дуусав/

Г.Занданшатар: 1 минут гэж байхгүй. Өөр асуулт энэ асуудалтай холбоогүй асуудал байна. 1 минут байхгүй. Санал хураалт. 1 минут. Энэ зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, дэмжээгүй л үг хэлнэ. Тэгээд хэлэлцээд дууссан. Хууль зүйн байнгын хороон дээр дэг зөрчиж болохгүй. Санал хураалт явуулъя. Ер нь найруулгыг нь анхаараарай. Пүрэвдорж гишүүний яриад байгаа тэр юун дээр бол. Наадах чинь ерөөсөө стандартын заалт болчихоод байгаа юм. Санкц юу энэ тэр байхгүй. Тийм. Тэр чинь олон улсын конвенц энэ тэртэйгээ хүний эрхийн конвенц энэ тэртэй Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1 энэ тэрд уг нь заасан байдаг юм. Наадахтайгаа уялдуулаад тэр Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай үзэх хэрэгтэй. Үндсэн хуульд бол шүүгчийг шилж сонгох гэж байгаа энэ дээр яах вэ сонгон шалгаруулах. Шүүхийн ерөнхий зөвлөл шилж сонгох ажлыг хэрэгжүүлнэ гэж байгаа. 45 гишүүн дэмжиж 66,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн 36 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийг өргөн мэдүүлэх

36.1.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 89.8-д заасан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор тухайн эрэмбийн дагуу зарлагдсан орон тоогоор анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг шүүгчээр томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах тухай албан бичгийг Улсын Их Хуралд холбогдох баримт бичгийн хамт хүргүүлнэ.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 50 гишүүн дэмжиж 73,5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Төслийн 37 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 37.2 дахь хэсэг нэмж, 37.2 дахь хэсгийн “хуульд” гэснийг “энэ хуулийн 34 дүгээр зүйлд” гэж өөрчилж, 37.4-37.6 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 37.4-37.8 дахь хэсэг болгох:

“37.2.Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй дараах журмаар танилцана:

37.2.1.шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурал чуулганы үеэр хүлээн авсан бол 14 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ нэр дэвшигчийн талаарх танилцах сонсголын товыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлаж, нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй;

37.2.2.энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу танилцах сонсголын товыг нийтэд зарласнаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд шүүгчид нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Байнгын хороонд ирүүлж болох бөгөөд нэргүй асуулт, саналыг хүлээн авахгүй;

37.2.3.Байнгын хороо энэ хуулийн 37.2.2-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор танилцах сонсголыг зохион байгуулах;

37.2.4.энэ хуулийн 37.2.3-т заасны дагуу танилцах сонсгол зохион байгуулснаас хойш 14 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигч болон сонсголын тайланг Байнгын хороогоор хэлэлцэж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах;

37.2.5.энэ хуулийн 37.2.4-т заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын дарга нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсан талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх;

37.2.6.энэ хуулийн 37.2.1-д заасны дагуу шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга, холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор Улсын Их Хурал танилцах сонсгол зохион байгуулж танилцаагүй бол тухайн нэр дэвшигчийг танилцуулсанд тооцох бөгөөд уг хугацаа дууссан өдрөөс хойш 7 хоногийн дотор Ерөнхий зөвлөлийн дарга шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсанд тооцсон талаар Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх.”

“37.4.Энэ хуулийн 37.2.3-т заасан танилцах сонсголыг зохион байгуулах журмыг

Байнгын хороо батална.

37.5.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүх санал болгосноос хойш Ерөнхийлөгч 14 хоногийн дотор зургаан жилийн хугацаагаар, зөвхөн нэг удаа томилно.

37.6.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар олонхын саналаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно.

37.7.Энэ хуулийн 37.6-д заасны дагуу Ерөнхий шүүгчид нэр дэвшээгүй бол шүүгчээр хамгийн олон жил ажилласан шүүгчийг гурван жилийн хугацаагаар тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс томилно.

37.8.Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Зөвлөгөөн дотроосоо нууц санал хураалтаар, гурван жилийн хугацаагаар сонгох бөгөөд түүнийг нэг удаа улируулан сонгож болно.” Дэлгэрсайхан гишүүн үг хэлнэ гэсэн. Пүрэвдорж гишүүн хоёроор тасаллаа. Байна яриарай.

Б.Дэлгэрсайхан: Энэ 37.8 дээр нэг ийм заалт байгаа юм. Танхимын тэргүүний тухайн шүүхийн шүүхийн зөвлөгөөн дотроосоо нууц санал хураалтаар 3 жилийн хугацаагаар сонгох буюу түүнийг нэг удаа улируулан сонгож болно гэдгийг танхимын тэргүүн хүний танхимын шүүхийн шүүгч нар дотроосоо гэж өөрчлөхгүй болохоор бид бол захиргааны, эрүүгийн, иргэний гээд хэргүүдийнхээ ангиллаар танхимаа байгуулсан учраас танхим дотроос нь ингэж сонгоно гэж оруулахгүй бол энэ нөгөө зөвлөгөөнөөр гэхээр бүх шүүгч нар орох юм шиг харагдаад байгаа юм.

Тэгэхээр зэрэг зөвлөгөөнөөр гэвэл эрүүгийн танхимын шүүгч захиргааны танхимын тэргүүн болдог ч юм уу ийм болж магадгүй магадлалтай учраас энийг бүр нарийвчлаад цаашдаа ч гэсэн Энхбаяр гишүүн ажлын хэсгийн дарга өөрөө мэдэж байгаа. Цаашдаа ч гэсэн бид шүүхийг олон төрлөөр дагнана гэж яриад байгаа шүү дээ. Тийм учраас бол энийг яг танхимын тухайн танхимынх нь шүүгч нар дотроос нууц санал хураалтаар гэж үг үсгийн өөрчлөлт оруулах нь зөв болов уу гэдэг ийм санал гаргаж байгаа юм.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Дарга энэ дэгийн тухай хууль ингээд надаас болдог юм уу яадаг юм ингээд өөрчилсөөр байгаад зүйлээр нь нэг санал хураадаг болгоод хаясан. Энэ дотор чинь надад миний итгэл үнэмшлийн эсрэг зөндөө олон заалтууд байж байна шүү дээ. Би тэгээд бүгдийг нь зөвшөөрч санал өгөх үү, эсэргүүцэж санал өгөх аймаг төвөгтэй байдалд орж байна. Жишээ нь ингээд ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч 14 хоногийн дотор томилно гэсэн. Та нар болохоор нэгжийн тухай хуулиар Ерөнхий сайдад аймгийн Засаг даргыг нэг удаа буцааж болно гэдэг эрх өгдөг биз дээ. Тэрэнтэй адилхан тэр Ерөнхийлөгчид яагаад буцаах эрх өгөхгүй байгаа юм бэ? Тэгээд 6 жилийн хугацаагаар гэж байна би 5 жил болгомоор байна. Дээрээс нь танхимын тэргүүнийг 5 жилээр нэг удаа сонгоод улираахгүй баймаар байна.

Одоо юу байдаг юм ийм зөндөө олон асуудлууд байгаад байна. Энэ дотор чинь тэгээд алийг аль дээр нь би санал өгөх үү. Тэгэхээр бүгдийг нь эсэргүүцэж санал

өгөхөөс өөр аргагүй. Дотор нь миний дэмжихгүй байгаа саналууд ингээд орж ирээд энэнээсээ болоод би санал өгөх тийм боломжоо хязгаарлуулаад байна шүү дээ. Тийм учраас энэ юу яадаг юм тэр Нямбаатарын оруулж ирсэн тэр Раднаасэд энэ тэрийн оролцсон хөөн хэлэлцэх хугацааг сэмхэн оруулаад будилуулдаг шиг ийм юм дотроо ингээд оруулсан би тэрэн дээр кноп даараад зөвшөөрөөд кноп дарсан байвал би дараа нь зөндөө асуудалд орно шүү дээ.

Тийм учраас энэ зүйл болгоноор шууд ингээд санал хураадаг энэ явдал чинь дотор нь байгаа заалтууд дотор зөндөө сөрөг асуудал гарах учраас би энэ асуудлыг чинь яриад байгаа юм. Ийм хүнд нөхцөл байдал руу оруулж байна шүү дээ. Энэ наадахаа энэ Дэгийн тухай хуулиа хармаар юм уу яамаар юм бэ? Та.../минут дуусав/

Г.Занданшатар: Дэгийн тухай хуульд бол зарчмын зөрүүтэй саналын томъёолол тус бүрээр нэг бүрчлэн санал хураагаад олонхын санал авсан томъёоллоор бүлэглэн санал хурааж болно гэсэн тэр заалтын дагуу л бүлэглэсэн. Гэхдээ энэ дотор хууль зүйн хувьд бас Үндсэн хуулийн зөрчилтэй байж болзошгүй бас бусад хуультай уялдуулах заалтууд их байна шүү. Чиглэл бол өгөхгүй эцсийн хэлэлцүүлэгт анхаараарай. Танилцах сонсгол гэж бол байхгүй. Нийтийн сонсголын тухай хуульд томилгооны сонсгол гэж л байгаа. Танилцах сонсгол гэж шинэ юм болгож байна. Ерөнхий шүүгч томилдог байсныг танхимын тэргүүнийг томилдог болгосныг зөвлөгөөнөөр томилдог болж байна. Гэхдээ зөвлөгөөн танхим танхимаараа байх юм уу нийтээр байх юм уу түрүүн процессыг маш нарийн хийсэн байсныг энэ дотор тэгээд эцсийн хэлэлцүүлэг дээр Үндсэн хууль болон бусад хуультай уялдуулж хэрэг зөрчил гаргахгүй байхаар сүүлд нь бас магадлалтай юм хийгээрэй. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулъя. Нийтийн сонсголын хууль дээр дагуулж өөрчлөлт танилцах сонсгол гэж оруулахгүй бол хуульд байхгүй юу болоод байгаа байхгүй юу. Бусад хуультай уялдуулах. Ер нь бас л юутай л байна шүү. 46 гишүүн дэмжиж 67,6 хувийн саналаар дэмжигдлээ. Найруулгын юун дээрээ.

29.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “мэргэшүүлэх” гэсний өмнө “гурван сар хүртэлх хугацаагаар” гэж нэмэх. Санал гаргасан:Ажлын хэсэг. Санал хураалт. 47 гишүүн дэмжиж 69,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “орон тооны” гэснийг хасаж, 40.5 дахь хэсгийн “сэргээнэ.” гэснийг “даруй сэргээж, энэ тухай Ерөнхий зөвлөлд мэдэгдэнэ.” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.5 дахь хэсэг нэмэх:

“40.5.Энэ хуулийн 40.4-т заасан үндэслэлээр бүрэн эрх нь түдгэлзсэн шүүгчид уг хугацаанд цалин хөлсийг 90 хувиар тооцож олгоно.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Энэ чинь тэгээд буруу шийдвэр гаргасан сахилгын хороо нь төлөх болж байна уу, энэ чинь нэг хуулиар буруу шийдвэр гаргасан албан тушаалтан төлнө гэсэн ийм практик бас байгаад шүү дээ. Түр түдгэлзсэн хугацаанд.

31.Төслийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэг, 41.2.9 дэх заалт, 41.5 дахь хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулж, 41.2.2 дахь заалтын “болон хүндэтгэн үзэх бусад” гэснийг хасаж, 41.2.3 дахь заалтын “өөр” гэснийг “өөрийн хүсэлтээр энэ

хуулийн 40.1-д зааснаас бусад” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 41.6 дахь хэсэг нэмэх:

“41.1.Шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн, эсхүл шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдөж болно.”

“41.2.9.шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн.”

“41.5.Шүүгч огцорсон бол түүнийг шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.”

“41.6.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх бол хүсэлтээ Улсын дээд шүүхийн Зөвлөгөөнд гаргах бөгөөд Зөвлөгөөн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл Ерөнхийлөгчид уламжилна. Ерөнхий шүүгч албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийн үндэслэлээ олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.” Санал гаргасан Ажлын хэсэг. Чинбүрэн гишүүн үг хэлнэ. Чинзориг гишүүн. Содномын Чинзориг, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүд үг хэлнэ. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Энэ 41.1 дээр 2 асуудал байгаа юм. 41.1 дээр шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол чөлөөлөгдөж болно гэж байгаа юм. Тэгэхээр энэ бол өмнөх хуулиасаа дордуулсан зүйл байна. Нийгмийн даатгалын тухай хуулиар чинь өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэрт гарах насанд хүрвэл өөрөө хүсвэл тэтгэвэртээ гарч болно гэсэн ийм заалттай. Энэ заалттай бол зөрчилдөөд байгаа юм. Ажил олгогчдод ингээд тэтгэврийн нас хүрсэн гэдгээр шууд захиргааны санаачилгаар ажлаас нь чөлөөлөөд тэтгэвэрт нь гаргах ийм эрх бол олгож болохгүй.

2 дахь асуудал нь энэ тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой асуудлыг ингээд салбар салбарын хуульд нь оруулж зохицуулдгийг бол болимоор байгаа юм. Тэр суурь харилцааг зохицуулж байгаа хуулиар нь зохицуулаад явах юм бол хэн хэндээ бас хэрэгтэй нөхцөл дордохгүй байх ийм боломж бүрдэнэ. 2 дахь асуудал нь тэр шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно гэж байгаа юм. Энэ бол одоогийн мөрдөж байгаа Нийгмийн даатгалын хуультайгаа зөрчилдөж байгаа асуудал ийм заалтууд оруулж болохгүй. Манай энэ хуулийнхан ярихаар цагдаа цэргийн албан хаагчтайгаа адилтгаад барьцаад ийм юм оруулаад байгаа юм. Цагдаа цэргийн албан хаагчид чинь өөр шүү дээ. Цагдаа цэргийн албан хаагч чинь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй юм. Шимтгэлийг нь өөрөө хариуцаж явдаг. Төр өөрөө шимтгэлийг нь хариуцаж байгаа учраас эрт гаргах, тэтгэврийг нь илүү өндөр тогтоох тэр санхүүжилтээ өөрөө хариуцаж байгаа болохоор тэр бол төрийн асуудал учраас бол болж байгаа юм.

Шүүх прокурор өөрсдөө нийгмийн даатгалын шимтгэл төлдөг албан хаагчид. Тийм учраас бол нийтийн тэр нийгмийн даатгалын сангаас ингээд 25 жил ажилласан бол эрт тэтгэвэрт нь гаргана гэсэн ийм зохицуулалт энэ салбарын хуулиар зохицуулж болохгүй. Тийм учраас би энэ саналыг дарга эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ сайжруулж бусад хууль тогтоомжуудтай уялдуулах гэсэн сайжруулсан чиглэл өгөх юм уу. Хэрэв тийм чиглэл өгөх боломжгүй бол энийг дэмжих боломжгүй байгаа юм. 1 дүгээрт Нийгмийн даатгалын хуулийг зөрчиж байна. Одоогийн байгаа нөхцөлийг нь дордуулж байна. Өөрийн хүсэлтээр биш нас нь тэтгэврийн нас нь болсон бол шууд захиргааны санаачилгаар чөлөөлөх нөхцөл ороод ирж байна. 2 дугаарт 22 жил ажилласан шүүгч тэтгэвэрт гарна гэж болохгүй.

Г.Занданшатар: Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Би энэ Чинзориг гишүүний гаргаж байгаа саналтай яг ижил саналтай байна. Уг нь бол Засгийн газрын оруулж ирсэн томьёолол дээр бол 65 нас гэж байсан. Эсхүл 65 насаар нь байлгах хэрэгтэй. Эсхүл ялангуяа би Байнгын хороон дээр бол дээд шүүхийн шүүгчийг насаар нь гэж санал оруулаад дэмжигдээгүй. Тийм учраас бол энэ Засгийн газрын анх оруулж ирсэн төслийн 65 нас гэдгээр нь байлгахгүй бол ер нь яагаад энэ бид нар бас энэ манай ажлын хэсэгт тэр шүүгч эрдэмтэн мэргэд байгаа. Өөрсдөө мэдэж байгаа. Гадаад орнуудын жишгийг их авч ярьдаг улсууд.

Жишээлбэл одоо Америкт шүүгчийг бүх насаар сонгодог барьдаг гээд европ ч гэсэн адилхан. Жишээлбэл саяхан гэхэд шинээр Ерөнхийлөгчөөр сонгогдох гэж байгаа Жо Байден чинь одоо зөвхөн Сангийн сайдаараа гэхэд 80 настай хүн тавина гээд зарлаж байх жишээний. Яагаад ингэж байгаа юм гэхээр чинь ядахдаа ийм насны улсуудын хор нь гарсан, эрээн бараан юм сонирхоо больсон зөвхөн төрийн төлөө ажиллах ийм насанд очсон улсуудыг ингээд эрт тэтгэвэрт гаргадаг. Бусад төрийн байгууллагатай адилхан ингэж хандаж болохгүй. Энэ чинь төрийн тусгай байгууллага шүү дээ. Үндсэн хуулийн байгууллага шүү дээ.

Тийм учраас энийгээ бас эргэж харж Засгийн газрын оруулж ядахдаа Засгийн газрын оруулж ирсэн томьёоллоор нь 65 нас гэдгээр нь оруулах нь зөв байх гэдэг ийм саналтай байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Тогтохсүрэн даргаа санал хураалт. Энэ чухал асуудал шүү. 46 гишүүн дэмжиж 67,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Төслийн 42 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгчийн” гэснийг “Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн, шүүгчийн” гэж өөрчилж, 42.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 42.1, 42.2 дахь хэсэг болгох:

“42.1.Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох хугацааг шүүгч өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн бол уг насанд хүрэх сарын сүүлийн өдрөөр, бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэр гарсан бол уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр тоолно.

42.2.Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний бүрэн эрх дуусгавар болох хугацааг сонгогдсон хугацаа дуусгавар болох өдрөөр тоолно.” Санал гаргасан Ажлын хэсэг. Цэдэвийн Сэргэлэн гишүүн үг хэлнэ.

Ц.Сэргэлэн: Баярлалаа. Би уг нь энэ өмнөх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын үеэр үг хэлье гэж хүссэн юм. Тэгээд энэ нэг л будилаан үүсээд сая үг хэлэх зөвшөөрөл өгч байна. Баярлалаа. Энэ 35, 36 дугаар зүйл дээр зарчмын хамгийн чухал амин сүнс явж байгаа. Ер нь шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг энэ зорилтыг хангахад бол энэ манай хуулийн зорилт энэ шүүхийн хуулийн гол зорилт явж байгаа юм.

Шүүх хараат бус байх нээлттэй байх шударга байх үнэн бодитой шийдвэр гаргана

гэдэг бол ер нь миний ойлгож байгаагаар 1937 оныг дахин давтуулахгүй байх баталгааг бий болгоход томоохон алхам хийж байна гэж хэлж болно. Тэгэхээр энэ шүүгчийг томилох асуудал сонгон шалгаруулах асуудал энэ дээр энэ салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй энэ хүмүүсийг гаргаж ирэх асуудал энэ 36 дугаар зүйл дээр хамгийн тодорхой бичсэн байгаа юм. Төрийн байгууллагын аль ч салбар байсан ер нь бол тухайн салбарын мэргэшсэн ноён нуруутай хүлээн зөвшөөрөгдсөн онолын хувьд мэдлэгтэй практиктай энэ хүнийг бол тухайн салбарынхан л мэднэ. Шүүхийн салбарынхан л энэ хүнээ гаргаж ирж чадна. Энэ бол хамгийн шударга зарчим гэж би ойлгодог.

Ийм учраас би дэмжиж энийг үг хэлж байгаа юм. Би тэр сүүлд 1937 он гэж хэллээ. Энэ бол хэлмэгдлийн тухай асуудлыг хэлж байна. Хүнд ер нь хамгийн хүндээр тусдаг асуудал бол энэ хэлмэгдсэн асуудал. Хэлмэгдэх асуудал. Хийгээгүй хэргийнхээ төлөө шүүгдэх асуудал. Хардагдах сэрдэгдэх асуудал, гүтгүүлэх асуудал. Тэгээд энийг нь байхгүй болгоход энэ хуулийн гол амин сүнс яваа гэж би ойлгож байгаа юм. Тэнгэр хол газар хатуу ийм үе хүнд тохиолдвол хамгийн хэцүү үе энэ. Хэлмэгдүүлэх үе байдаг. Тэгэхээр үнэний шалгуур бол практик.

Г.Занданшатар: Үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Чинзориг гишүүний хэлээд байсан юм бол бас байна. Тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн бол гэж, уг насанд хүрэх сарын сүүлийн өдөр шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох гэхээр. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж 74,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд” гэснийг, 43.3.4 дэх заалтын “эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн” гэснийг тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 43.3.6 дахь заалт нэмэх:

“43.3.6.шүүгч өөрийн хүсэлтээр ахисан түвшинд мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор хоёр жил хүртэл хугацаагаар гадаад улсад суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдах.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 50 гишүүн дэмжиж 75,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төслийн 44 дүгээр зүйлийн гарчгийг “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага” гэж өөрчилж, Арван зургадугаар бүлэгт шилжүүлэх.Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 48 гишүүн дэмжиж 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Төслийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсгийн “Мэргэшлийн болон” гэснийг, “ашгийн төлөө бус хуулийн этгээд, бусад” гэснийг, 45.5 дахь хэсгийг тус тус хасаж, 45.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“45.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 11.1.6, 11.1.7, 11.1.8, 12.1.4-т заасан этгээд нь шүүгчтэй албан ажлаар уулзах тохиолдолд тэмдэглэл хөтөлж, баталгаажуулан тухайн байгууллагын нууцын асуудал хариуцсан албан тушаалтанд ажлын гурван өдрийн дотор өгөх үүрэгтэй. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэх болон албан ёсны тэмдэглэл хийгдэх бусад үйл ажиллагааны явцад шүүгчтэй уулзсан тохиолдолд тэмдэглэл хөтөлж, баталгаажуулах үүргээс чөлөөлөгдөнө.” Санал гаргасан Ажлын хэсэг. Тодруулах юм байхгүй. Дэмжсэн дэмжээгүй үг хэлнэ. Санал

хураалт. Заавал гуравдагч хүнтэй уулзах ёстой. Гэрчтэй л уулзах ёстой гэж байгаа юм л даа. 48 гишүүн дэмжиж 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Юу ч гээд бичиж өгнө л дөө. Тэгэхээр заавал гэрчтэй уулзах ёстой. Гэрчгүй уулзсан тохиолдолд баталгаажуулсан тэмдэглэл хөтөлнө гэж байдаг юм байна лаа. 48 гишүүн дэмжиж 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Төслийн 46 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 46.8-46.10 дахь хэсэг нэмэх:

“46.8.Шүүгч энэ хуулийн 46.1-д заасан нөлөөллийн мэдүүлгээс гадна энэ хуулийн 45.2-т заасан этгээдтэй уулзсан, харилцсан бөгөөд уг этгээд өөрөө, эсхүл бусдаар дамжуулан тухайн шүүгчид аливаа хэлбэрээр нөлөөлсөн, нөлөөлөхөөр оролдсон, үүрэг, чиглэл өгсөн бол энэ талаарх бүхий л мэдээллийг агуулсан тэмдэглэл үйлдэн Ерөнхий зөвлөлд битүүмжлэн ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх үүрэгтэй.

46.9.Ерөнхий зөвлөл энэ хуулийн 46.8-д заасны дагуу битүүмжлэн ирүүлсэн тэмдэглэлийг хадгалах бөгөөд эрх бүхий байгууллага, эсхүл шүүгчийн хүсэлтээр холбогдох этгээдэд гарган өгнө.

46.10.Энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй нь шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэл болно.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 78,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 52 гишүүн дэмжиж.

37.Төслийн 47 дугаар зүйлийн гарчгийн “Шүүгч” гэсний өмнө “Шүүх,” гэж нэмж, 47.2, 47.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 47.8 дахь хэсгийн “журам, шалгуур үзүүлэлтийг” гэснийг “шалгуур үзүүлэлт, шүүгчид нэмэгдэл урамшуулал олгох” гэж өөрчлөх:

“47.2.Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн албанд ажилласан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ. Шүүгчийн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэнэ.”

“47.5.Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэл, энэ хуулийн 16.5-д заасны дагуу томилолтоор ажиллах болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.” Санал гаргасан Ажлын хэсэг. Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн үг хэлнэ. Чинзориг гишүүнээр тасаллаа.

Т.Аюурсайхан: Төрийн албан хаагчид бүгдээрээ цалингийн нэг шатлал зэрэглэлтэй. Энэ бол шүүгчид төрийн тусгай албад ордог. Төрийн албаны тухай хуулиараа. Тэгээд бүх нийт төрийн албан хаагч нар нэг хууль журмаар цалинг нь зохицуулаад байхад шүүгч нар өөр хуулиар зохицуулж болохгүй. Энэ чинь Үндсэн хуулийн 14.1 дээр Монгол Улсад оршин суугч хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна гэж байгаа юм. Тэгэхээр өөр хуулиар өөр эрх эдэлж болохгүй. Тэгээд энэ жил болгон 2 хувиар 6 дахь жилээсээ эхлээд цалингаа нэмүүлж болохгүй шүү дээ. Шүүгч нар чинь чамгүй өндөр цалинтай. Би буруу санаагүй бол дээд тал нь 8 сая төгрөгийн цалин авч байгаа. Ингээд аль шатанд ажиллаж байгаа шүүгчээсээ хамаараад.

Ингээд 25 жил ажиллах юм бол жишээлбэл энэ чинь 40 хувь цалин нэмэгдээд энэ чинь 11 сая гаруй төгрөгийн цалин авна. Үүнээсээ тэтгэвэр нь тогтоогдоно. Тэтгэвэр нь бас энэ хуулийн дагуу бусад бүх иргэд нийгмийн даатгалаас авах тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиараа 45 хувиар тогтоогдож байхад шүүгч нар 80 хувиар

тогтоогдох гэж байна. Тэгээд энэ нэмэгдэлтэйгээ нийлээд ажилласан жилээсээ болоод 100 гаруй хувь цалингаасаа илүү тэтгэвэртэй. Энэ бол 10 хэдэн сая төгрөгийн тэтгэвэр ингэж авч өөр эрх эдэлж болох юм уу. Би бол болохгүй гэж бодож байна. Энэ бол Үндсэн хуулийн 14.1-ийн зөрчлийн асуудал. Чамгүй цалин авч байгаа. Цалингаа битгий гол. Насаараа ажилласан асрагч сувилагч эх баригч нар 400 гаруйхан мянган төгрөгийн тэтгэвэр авч байна. Маш бага цалин авч байгаа. Тэгээд энийг яагаад ингэж өөрөөр энэ хууль болгонд ийм юм шургуулж болохгүй. Нийтлэг нэг хуулиараа бүх л албан хаагчид бүх иргэд зохицуулагдах ёстой. Хууль болгонд ийм ашиг сонирхлын юм шургуулж болохгүй.

Г.Занданшатар: Дэмжихгүй үг хэллээ. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Энэ 47 дугаар зүйл дээр би бас Аюурсайхан гишүүнтэй адилхан зарчмын байр суурьтай байгаа юм. Би сая тэтгэвэрт гарах настай холбоотой тэр 25 жил ажилласан бол тэтгэвэрт гарна энэ тэр гээд ийм тэтгэврийнхээ зарчмыг зөрчсөн хуультай зөрчилдсөн юмнууд ингээд шургуулаад байж болохгүй. Энд 47 дээр ч гэсэн тэр цалинг нь тодорхойлоод байгаа юм. Цалинг чинь бид хөдөлмөрийн хуулиараа ийм, ийм бүтэцтэй байна гээд ингээд тодорхойлсон байгаа шүү дээ. Энэ Хөдөлмөрийнхөө хуулиараа Төрийн албаны тухай хуулиараа зохицуулагдана гээд ингээд оруулчихад бол болохгүй юм байхгүй.

2 дахь асуудал нь Энхбаяр гишүүн шүүгчдэд зэрэг дэв өгч болохгүй гээд хасчхаад байгаа юм байна лээ. Тэгээд ингээд жил тутам цалинг нь 2 хувиар нэмэгдүүлнэ гээд. Одоо шүүгчид чинь хуулиараа бол зэрэг дэвийн нэмэгдэлтэй байна гээд 25-35 хувийн нэмэгдэл авч байгаа байхгүй юу. Энэ зэрэг дэвийн нэмэгдлийг нь байхгүй болгоод жил тутам цалинг нь автоматаар 2 хувиар нэмэгдүүлж байгаа асуудал. Энэ чинь ингээд энэ хууль хэрэгжиж эхлэх юм бол 1 дүгээрт тэр 25-аасаа 35-аасаа 25-35 хувийн зэрэг дэв нэмэгдэл авна гэдгээс энэ чинь эхний хэдэн жилдээ доогуур нэмэгдэл аваад, цалин аваад. 1 дүгээрт энэ чинь бол нөхцөлийг нь дордуулж байгаа юм. 2 дугаарт төрийн албан хаагчдын цалинг бид нар жил тутам нэмэгдүүлж чадахгүй байхад чинь шүүгчдийн цалинг шүүхийн хуулиар нь жил тутам нэмэгдүүлнэ гэж байж болохгүй. Энэ хуульд чинь шүүгчдийн цалинг Улсын Их Хурал тогтооно гээд байгаа шүү дээ.

Тэр зарчмаараа л тэгээд л тэр нийтлэг зарчмаараа цалинг нь тогтоогоод явж байх ёстой. Ийм зарчим алдагдуулсан хууль зөрчсөн асуудлууд ингээд оруулж болохгүй. Төрөө төрийнхөө албан хаагчдаа ижил тэгш хандах ёстой. Энэ бол хатуу хуулийн зарчим шүү. Үндсэн хуулийн ч гэсэн зарчим. Тийм учраас энэ зүйлийг эцсийн найруулга үгүй бол засах сайжруулах чиглэл өгөх хэрэгтэй байна. Хэрэв тийм боломжгүй бол энэ заалтыг дэмжих боломжгүй болоод байгаа юм.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ шүүгчийн цалин бусад төрийн албан хаагчийнхаас их өөр юм. Би 2 жишээ хэлье. 1 дүгээр зэрэг дэв буюу дотор нь эрэмбэлдэг дээш нь доош нь байдаг тэр зэрэг дэвийн нэмэгдэл байхгүй. Төрийн захиргаа төрийн тусгай

албан хаагчид шиг 20-25 хувийн нэмэгдэл байхгүй юу. Тэгэхээр нөгөө бусад албан хаагчдад тэр зэрэг дэвийн нэмэгдлээ авчхаад дээр нь 2 хувийн нэмэгдэл авах гээд байгаа биш. Угаасаа 20-25 хувийн нэмэгдэл байхгүй.

2 дугаарт нь зөвхөн ажилласан сая хэлж байгаа шүү дээ зөвхөн цолны нэмэгдэл байхгүй. Тусгай албан хаагчид шиг. Цэргийн цол байхгүй. Одоо тэр цэргийн цолоо аваад зэрэг дэвээ авахаараа тэр төрийн албан хаагч чинь үндсэн цалингийнхаа бүр 50 хувиар авчихдаг байхгүй юу. Шүүгчид өөр нэмэгдэл байхгүй. Шүүгчийн үндсэн цалин нь хэд вэ гэхээр Улсын Их Хурал тогтоодгоороо тогтооно. Энэ хуулиар тогтоох гээгүй. Тусдаа Улсын Их Хурал тогтооно. Хамгийн сүүлийн тогтоосон Улсын Их Хурлын би тогтоолыг 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 101 дүгээр тогтоолоор бүх шатны шүүгчдийн цалинг тогтоосон байна Их Хурлын. Энд зааснаар анхан шатны шүүхийн шүүгч 2,7 сая, анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч 2,8 сая, давж заалдах шатны шүүхийн шүүгч 2,9 сая, давж заалдах шатны ерөнхий шүүгч 3 сая, хяналтын шатны шүүхийн шүүгч 3,2 сая, хяналтын шатны шүүхийн ерөнхий шүүгч 3,3. Ийм 8 сая төгрөгийн цалин авдаг юм байхгүй. Энэ Улсын Их Хурлын хүчинтэй хамгийн сүүлийн тогтоол шүү.

Өөрөөр хэлбэл 2,7-3,3 сая төгрөгийн л цалинтай байгаад байгаа байхгүй. Өөр энэ дээр зэрэг дэвийн нэмэгдэл гэж байхгүй угаасаа. Цэргийн цол гэж тийм нэмэгдэл байхгүй. Тэгээд ингээд олон нийт болохоор 10 хэдэн сая төгрөгийн цалин авдаг юм шиг ийм ойлголт л бий болсон.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Би энэ Төрийн албаны хууль Үндсэн хууль зөрчигдөх тухай яриад байна. Би бас захиргааны эрх зүйн мэргэжилтэй юм. Тэгээд манай Төрийн албаны хуулийн систем ер нь зөв үү гэдэг асуудал байдаг юм. Нэгдсэн ийм цалингийн шатлалаар явж байгаа одоо үнэн. Энэ бол яах вэ шилжилтийн үеийн хямралтай үед бол ингээд юмаа нэг цэгцтэй явуулах үүднээс ингээд төвлөрсөн нэг ийм системд явж байгаа. Бусад улс орнуудын шүүгч шүүхийн салбарын шүүхийнхээ парламентын албан хаагчид бол тусдаа төрийн албаны ийм нэгдсэн цалин хөлсний шатлалд ордоггүй юм.

Ер нь энэ гаднын улс орнуудын жишгээр явна гэх юм бол парламент шүүх эрх мэдэл чинь тус тусдаа ийм эрх мэдлийн хэсэг байхгүй юу. Гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа. Тэр нэгдсэн шатлал чинь гүйцэтгэх эрх мэдэл дээр илүү явдаг байхгүй юу. Засгийн газрын. Энэ цаашдаа дандаа ингэж явахгүй. Энэ Үндсэн хууль зөрчигдөж юм байхгүй. Шүүх эрх мэдэл дээр бид нар маш их том хязгаарлалтуудыг энэ хууль хийж өгч байгаа юм. Шүүгч нарт тавих чангалах сахилга хариуцлага өчнөөн юм бид нар түрүүн ярьсан. Баахан шүүмжилсэн.

Гэхдээ бид нар төр баталгаагаар хангах үүргээ хүлээж байгаа байхгүй юу. Энэ дотроо тэр зэрэг дэвийн нэмэгдэл гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ Үндсэн хуультай зөрчилдөж цаашдаа энэ Төрийн албаны хууль чинь энэ системээр явахгүй.

Тэр бусад улс орон чинь Герман энэ тэр чинь нийтийн алба гэж явдаг байхгүй юу. Нийтийн алба гээд одоохондоо бол яах вэ энэ асуудлуудыг ярих гэхээр юм задлах гээд байна, замбараагүй болгох гээд байна гэдэг ийм юм яваад байгаа юм. Гэхдээ бид нарын цаг үе өөрчлөгдөж байгаа энэ нэгдсэн энэ цалин хөлсийг ингэж нэг юманд аваачиж хайрцагладаг явдал бол цаашдаа байхгүй болно. Ялангуяа хууль тогтоох шүүх эрх мэдэл бол өөрөө цалингийн сүлжээний асуудал гэдэг энэ давхар одоо явж ирж байгаагаасаа өөрчлөгдөнө.

Энийг бол тэгж би бас хэлмээр байна. Энэ бол бас манай төрийн захиргааны системд энэ үйлчилж байгаа юмыг бас урд нь үзэж харж байсан хүний хувьд хэлэхэд дандаа энэ Хөдөлмөрийн хууль, дандаа энэ Төрийн албаны хууль гэдэг юмаар чинь явахгүй шүү дээ. Бусад улс орнууд европын орнуудыг та бүхэн хараарай.

Г.Занданшатар: Төрийн ёслол хүндэтгэлийн зардал гэж одоо. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 33 гишүүн дэмжиж 50-аас дээш буюу олонхын санал авсангүй. Энэ санал дэмжигдсэнгүй. Эцсийн хэлэлцүүлэг дээр санхүүгийн тооцооллыг нь хийж гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Энэ санал дэмжигдээгүй. Шүүгч бол ярьдаг хууль. Хууль бол ярьдаг шүүгч байх хэрэгтэй гэж байгаа. Тэгэхээр хууль бол яг шүүгч шиг л тодорхой л байх ёстой.

38.Төслийн 47 дугаар зүйлийн 47.9.1, 47.9.2 дахь заалтуудыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 47.9.1-47.9.3 дахь заалт болгох:

“47.9.1.Улсын дээд шүүх өөрийн, Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхээс бусад шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх;

47.9.2.Улсын дээд шүүх, Ерөнхий зөвлөл Байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх;

47.9.3.Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 49 гишүүн дэмжиж 75,4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Шүүхийн дээд байгууллага бол Дээд шүүх гэж Үндсэн хуульд байгаа. Тэгээд ер нь нэг 2 толгойтой юм шиг л саналуудаа хүргүүлээд.

39.Дээрх 37 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 48 дугаар зүйлийг хасах. 37 дахь санал дэмжигдээгүй учраас энэ санал хураалт явахгүй. 48 бол шүүгчийн зэрэг дэв гэсэн ийм. Энэ санал хураалт явахгүй учраас түрүүн хураагдсан 37 дахь саналтай уялдуулж унасан учраас гүйцээн боловсруулах дахин боловсруулах чиглэл өгч байна.

40.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан. Санал хураалт. 51 гишүүн дэмжиж 78,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.2.1 дэх заалтын “өв залгамжлагчид” гэснийг “гэр

бүлд” гэж өөрчилж, 49.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 49.7, 49.8 дахь хэсэг болгох:

“49.7.Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгох бөгөөд өндөр насны тэтгэврийн хэмжээг түүний авч байсан сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно. Шүүгчийн өндөр насны тэтгэвэртэй холбоотой бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

49.8.Шүүгчийн ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралтын хугацааг энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд шүүгчээр ажилласан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгоно.” Санал гаргасан Ажлын хэсэг. Аюурсайхан, Тогтохсүрэн, Оюунчимэг, Чинзориг гишүүнээр тасаллаа. Аюурсайхан гишүүн.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Энэ шүүгч нарын авч байгаа цалингийн талаар сая шатлалыг нь Энхбаяр гишүүн танилцууллаа. Яг гар дээрээ авч байгаа цалинг нь бид нар бас яг энэ хувь хүний нууц учраас тодорхой мэдэхгүй. Зарим шүүгч нар бол 3 сая гаргаж дээд шүүхийнх авч байгаа. Ийм мэдээллийг надад бас сая хэлж байна.

Тэгэхээр ер нь юу хэлэх гээд байгаа вэ гэвэл харьцангуй бусад төрийн албан хаагч нараасаа бодох юм бол өндөр цалинтай. Дээр нь сарын тэтгэврийг нь тогтоохдоо дундаж цалингийн 80 хувиар тогтоож болохгүй. Бусад бүх иргэд Монгол Улсын нийт иргэд цалингийнхаа тодорхой жилийн дунджийн 45 хувиар тогтоолгодог тэтгэврээ. Нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд ингэж зохицуулсан байгаа. Бүх иргэд энэ хуулийн дагуу үйлчлэлээр тэтгэвэр авч байгаа. Энэ шүүгчдийн авч байгаа тэтгэвэр нийгмийн даатгалаас олгож байгаа шүү дээ. Өөр эх үүсвэрээр өөр юмнаас авч байгаа хамаа алга. Тийм учраас энэ хууль нэг хуульдаа л захирагдах ёстой.

Үндсэн хуулийн 14.1 дээр Монгол Улсад оршин суугч хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна гэж байгаа. Нийт иргэд энэ хуулиараа 45 хувиар тогтоогдоод шүүгч нар 80 хувиар тогтоож болохгүй. Энэ чинь хуулийн өмнө тэгш байх өөр хуулиар ингэж үйлчилж болохгүй. Тэгээд энийг ер нь хуульд ийм юм хавчуулж явдгаа болих хэрэгтэй. Энэ цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хуулиараа өмнө ялгаагүй ингээд 80 хувь болгосон юм. Ийм нэр буруу жишиг тогтоогоод яваад байгаа юм. Гэтэл энэ Монгол Улсад ажиллаж байгаа оршин сууж байгаа хөдөлмөрчид чинь бүгдээрээ л тодорхой хэмжээгээр улсынхаа аюулгүй байдал тусгаар тогтнолд хувь нэмрээ оруулж байгаа шүү дээ.

Энэ эрүүл мэндийн асуудал чинь иргэдийн эрүүл мэндийн чинь үндэсний аюулгүй байдлын асуудал мөн. Эдийн засгийн аюулгүй байдлын асуудал мөн. Энэ хөдөлмөрчид бүгдээрээ хувь нэмрээ оруулж байгаа. Тэгэхээр ингэж ялгаварлаж бол болохгүй. Би хэлээд байгаа шүү дээ насаараа эх барьж байгаа асрагч сувилагч хийсэн хүн.../минут дуусав/

Г.Занданшатар: Дэмжээгүй санал хэллээ. 1 минут байхгүй дэмжээгүй санал учраас 5 минутаар явсан. Тогтохсүрэн гишүүн. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр энэ 49 дүгээр зүйл бол нийгмийн даатгалын болон Хөдөлмөрийн хуулиар зохицуулах харилцаа байгаа юм. Ингээд салбарын хууль

бүрт ийм харилцаанууд ороод байх юм бол энэ 2 хуулийн хэрэг байхгүй болох юм. Тэгэхээр би бол ингээд байгаа юм. Манайхан сонсоорой. Энхбаяр гишүүнээ 47 дугаар 49 дүгээр зүйлийн 49.7 эхний хэсэг бол байх ёстой зүйл. 36 сарын тэтгэмж бол байх ёстой зүйл.

Харийн тэр 80 хувиар тэтгэвэр тогтоолгоно гэдэг бол байж болохгүй. Энэ шүүгч нарын бид нэг юм ойлгох ёстой юм. Шүүгч нарын төлж байгаа шимтгэл нийгмийн даатгалынхаа санд орж байгаа. Цэргийн албан хаагчийн төлж байгаа тэтгэвэр улсын төсвөөс төлж байгаа юм. Шал ялгаатай байхгүй юу. Тэгэхээр нийгмийн даатгалын сангаас гаргах мөнгийг бид нар 80 хувиар тогтоож олон нийгмийн даатгалын сангаас бүрдэж байгаа тэр олон ажил сан бүрдүүлж байгаа шимтгэл төлөгч нарын эрхийг хохироож болохгүй. Хамгийн том юм нь энэ юм байгаа юм шүү. Их Хурлын даргаа. Энэ чинь ийм байхгүй юу. Цэргийн тэтгэврийнхэн чинь бол улсын төсвөөс авч явдаг юм.

Энэ шүүгч нарын чинь тэтгэвэр гарахад нь сангаасаа авч явна. Сан чинь 45 хувиараа явдаг байхгүй юу. Энэ чинь цаана нь аягүй том юм, үгүй ээ тэр цалинг нь бол нэмэх дээр би дэмжиж байгаа юм. Тэтгэврийг бол бид нар тэр ирээдүйн юмнууд орж ерөөсөө ирээдүйд бид нар хүний юм руу орж ерөөсөө болохгүй байхгүй юу. Тэтгэврийн тэр сан буюу нийгмийн даатгалын сангийн том тогоо чинь хүн бүр 45 хувиараа тэтгэвэр тогтоолгоод явж байх ёстой юм дээр нэг нөхөр нь орж ирээд 80 хувиар аваад илүү аваад явж байгаа байхгүй юу.

Энэ чинь бидний төсвийн мөнгө биш. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн сан байхгүй юу.

Г.Занданшатар: Энэ Хууль зүйн байнгын энэ ингээд утга агуулгын хувьд өөр асуудлуудыг ингээд бүлэглэхээр тэр 41 дүгээр заалт бол өв залгамжлагчид гэдгийг 15 жил ажилласан 15 жилийн юуг нь бол гэр бүлд нь өөрчилж болж байгаа юм ингээд. 41-ийг дэмжмээр байдаг. 49.7 бол төслийн заалт нь илүү сайн заалт байгаа байхгүй юу. Гэтэл 49.8 болохоор, Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Пүрэвдорж гишүүнээ би үг хэлье. Энхбаяр гишүүний 1 зүйлтэй бол санал нэг байгаа. Яагаад гэвэл бид нар шүүгчийн хараат бус байдлыг өнөөдөр энэ танхимд байгаа хүн бүхэн ярьж байгаа учраас энийг эдийн засгийн хараат бус байдалтай нягт холбоотой гэж бодож байгаа. Ер нь явж, явж бүх юм төсөв мөнгөтэйгөө уялдаж явдаг учраас төсөв мөнгөний асуудал дээр бол бодолцох ёстой.

Тэгээд шүүгчдийн талаар их буруу мэдээлэл явдаг юм байна. 7 сая, 8 сая төгрөгийн цалин хөлстэй маш өндөр цалинтай гэдэг. Сая Энхбаяр гишүүний хэлдгээр 2,7-3 сая орчим авдаг гээд л ярьж байна л даа. Тийм учраас энэ 47.2 түрүүний зүйл дээр өөрчлөлт оруулаад энэ цалинг нь нэмэгдэл зэрэг дэв байхгүй тохиолдолд цалинтай холбоотой асуудлыг нь харин бид нар үлдээгээд шийдэх нь зөв болов уу гэж бодож байна. Харин 49.7 дээр би бас Тогтохсүрэн гишүүний хэлдэгтэй санал нэг байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа газраас 80 хувиар нэг байгууллагынх нь

ажилтнууд аваад явчихна гэхээр энэ чинь өөрөө болохгүй болоод байна л даа.

Хортой нөхцөлд ажилладаг хүмүүс юм уу эсхүл нөгөө цэргийн албан хаагчид гээд тэр тусгай онцгой бол тэрийг хуулийн заалтаар шүүгчид хортой нөхцөлд ажилладаг гэдэг юм уу тэгж оруулж ирэхгүй бол энэ өөрөө хуулиа зөрчиж байгаа Нийгмийн даатгалын. Шимтгэл төлчхөөд дээрээс нь сарын дундаж цалингийн 80 хувь өгнө гэвэл энэ бол арай л болохгүй байна. Тийм учраас энэ дээр бид нар эргэж харж өөрчлөлт хийх ёстой. Харин 47.2-г бол үлдээгээд энэ цалин хөлстэй холбоотой юм дээр нь анхаарч шүүгчдийнхээ цалин хөлсийг бол нэмэх тал дээр би санал нэг байна. Яагаад гэвэл хараат бус байж л энэ хүмүүс бас хамаг цагаа зарцуулаад шударга ажиллах бололцоо бүрдэнэ. Энэ 49.7-г арай л болохгүй. Энэ нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой асуудал. Нийгмийн даатгалын тогтолцоотой холбоотой асуудал учраас энэ дээр бол эргэж харах ёстой гэсэн байр суурьтай байна.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Ээлжийн амралтай холбоотой асуудлуудыг тэр нийгмийн даатгалын хууль, хөдөлмөрийн хуулиар нь зохицуулаад явах нь зүйтэй л дээ. Би дахин хэлээд байгаа юм. Шүүгчдийн цалинг нэмэгдүүлэхгүй гэж байгаа юм биш. Засгийн газрын өргөн барьсан хуульд чинь шүүгчид зэрэг дэвтэй байна гээд өмнөх хуулиараа бол шүүгчид зэрэг дэвтэй байгаад 25-35 хувийн нэмэгдэл авдаг байсан юм. Тэрийг нь манай Энхбаяр гишүүн эд нар шүүгчдийг эрэмбэлж болохгүй зэрэглэж болохгүй гээд тэр зэрэглэлийн нэмэгдлийг нь байхгүй болгочхоод байгаа юм.

Тэгээд түүнийхээ оронд тэр цалинг нь жил тутам нэмэгдүүлж байна гэж асуудал оруулж маргаан үүсгээд байгаа юм. Тэгэхээр энийг шийдчих боломжтой. Шүүгчид чинь онцгой нөхцөлийн нэмэгдэл гээд 15 хувийн нэмэгдэл өгч байгаа юм. Их Хурал тогтоол өгсөн. Хэрэв тэр зэрэг дэвийн нэмэгдэл байхгүй болж байгаа бол тэр жил тутам цалинг нь нэмнэ гэж хэрүүл болох биш онцгой нөхцөлийнх нь нэмэгдлийг л нэмээд өгчих хэрэгтэй шүү дээ. Ингэх юм бол шүүгчдийн цалин хөлсний асуудлыг шийдчих юм боломж бол гарц бол байгаа юм.

2 дугаарт би энэ тэтгэврийг 80 хувиар тогтоож болохгүй гэдгийг яагаад эсэргүүцээд байгаа вэ гэхээр цэргийн албан хаагчидтай шүүгчдийг адилтгаж болохгүй. Би түрүүн ч хэлсэн. Цэргийн албан хаагчдын шимтгэлийг төр өөрөө хариуцаж явдаг. Төр өөрөө санхүүжилтийг нь тэтгэврийнх нь санхүүжилтийг өөрөө хариуцаж явдаг. Тийм учраас бол цэргийн албан хаагчдын тэтгэврийг 80 хувиар тогтооно гээд ингээд хуульд нь орсон яваад байгаа. Тэрэнтэй адилтгаж болохгүй.

Шүүгчид чинь өөрөө нийгмийн даатгалын шимтгэл төлөгч. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авна. 20 жил шимтгэл төлсөн хүн 45 хувиар, 20-иос дээш жил бол ажилласан хүн жил тутам 1,5 нэмэгдэл гээд 30 жил ажилласан хүн бол цалингийнхаа 65 хувиар тэтгэврээ бодуулж авдаг ийм л хуультай шүү дээ. Тийм учраас бол Нийгмийн даатгалын хуулиар нь зохицуулаад явах бүрэн боломжтой. 2

дугаарт тэр амралыг 5 жил тутам 3 хоногийн нэмэлт амралт гэж бас салбарын хуулиар зохицуулж болохгүй. Ерөөсөө суурь харилцааг зохицуулж байгаа хуулиуд хуулиараа л энэ харилцаануудаа зохицуулаад явдаг байх ийм л зарчим баримтлахгүй бол бид нар ингээд салбар болгоны хуульд ингээд үндсэн суурь харилцааг зохицуулж байгаа хуулиудаа дордуулсан өөрчилсөн ийм заалт оруулаад байж болохгүй. Тийм учраас энэ зарчмыг 49.2.1.../минут дуусав/

Г.Занданшатар: Тэгвэл ашиг сонирхлын зөрчилтэй юм байна. Энэ Хууль зүйн байнгын хороо ингээд бүлэглээд байна шүү дээ яагаад ийм одоо жишээлбэл утга агуулгын хувьд 49.2.1 дэмжих хэрэгтэй байдаг. Гэтэл 49.7 нь дэмжмээргүй, 49.8 дэмжмээр байна гээд. Тэгээд энийг яагаад бүлэглэж ингэж санал хураалгаад байгаа юм бэ? Зарчмын зөрүүтэй саналын томъёолол тус бүрээр нэг бүрчлэн санал хураалгана гэж байгаа шүү. Тэгээд дэмжсэн тохиолдолд бүлэглэнэ гэж байгаа. Санал хураалт явуулъя. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Тогтохсүрэн, Чинзориг гишүүн хоёрын хэлээд байгаа юм бол тэгээд холбогдох хуулиар зохицуулна гэж төсөл дээрээ байсан байна шүү дээ төрийн холбогдох хуулиар. Чинзориг гишүүн бол 15 хувийн нэмэгдэлтэй гээд Нийгмийн хамгааллын сайдаар ажиллаж байсан учраас нөхцөл байдлыг нь илүү сайн мэдээд байна. Санал хураалт. Энэ санал дэмжигдсэнгүй. Төслөөрөө үлдлээ. 65 гишүүнээс 32 гишүүн дэмжиж 49,2 хувийн.

42.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“49.6.Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа. Чинзориг, Сүхбаатар гишүүн нар үг хэлнэ. 2 гишүүнээр тасаллаа. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Энэ 49.6тай бас өмнөх хэлж байсан зарчимтай ойролцоо санал хэлэх гээд байгаа юм. Бид ингээд салбар салбарын хуулиар тэтгэвэрт гарах насыг тогтоож болохгүй. Тэтгэврийн чинь насыг нийгмийн даатгалынхаа хуулиар тогтоосон харилцаа байгаа. Тэр суурь харилцаагаар нь зохицуулах ёстой. Нөгөө талаасаа шүүгч гэдэг бол хэдийгээр төрийн тусгай албан хаагч гэсэн төрийн албан хаагч шүү дээ. Төрийн албаны тухай хуулиараа бид нар чинь төрийн албан хаагчийн насны дээд хязгаар 65 байна гээд хуульчилсан. Тийм учраас бол төрийн нийгмийн даатгалынхаа хуулиараа тэтгэврийн нас нь байна. Гэхдээ дээд хязгаар нь тэр Төрийн албаны тухай хуулиар зохицуулагдсан 65 нас байна гэдгээр нь зохицуулаад явчих хэрэгтэй.

Тэгэхгүй ингээд бид нар чинь салбарынхаа хуулиар шүүгчдийн насны дээд хязгаар нь 60 байна гээд дараа нь Алтанхуяг гишүүн 55 байна гээд ингэж бид өөрсдөө оньсого тааж байгаа юм шиг ингэж тэтгэврийн нас тогтоож болохгүй.

2 дугаарт тэр 25 жил ажилласан бол тэтгэвэрт гарна гэж байж болохгүй. Цэргийн тэтгэврийн албан хаагчидтай адилтгаад байх юм. Би дахин хэлээд байгаа цэргийн тэтгэврийн албан хаагчид чинь шимтгэл төлдөггүй юм. Төр хариуцаж явдаг юм. Тэтгэврийнхээ санхүүжилтийг нь төр хариуцаж яваа юм. Тийм учраас 25 жил

ажилласан бол тэтгэвэрт гарч болно, 80 хувиар тэтгэврээ авч болно гээд ийм хууль үйлчлээд байгаа юм. Шүүгч бол өөрөө нийгмийн даатгалын шимтгэл төлөгч. Тийм учраас бол шүүгчийн тэтгэвэрт гарах насыг нийгмийн даатгалын хуулиараа зохицуулна. Дээд насны хязгаарыг нь бол төрийн албаны хуулиараа зохицуулаад явчихад бол бүр илүү оновчтой болно. Ингээд бид шүүгчдийн тэтгэврийн насыг өөрсдөө оньсого тааж байгаа юм шиг 55, 60, 30 гэж энд тогтоож болохгүй. Энийг бол би бас дэмжихгүй байна.

Г.Занданшатар: Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Энэ гишүүдээ бас нэг ийм юмыг бодооч. Энэ шүүхийн хууль бол салбарын хууль биш. Энэ шүүх эрх мэдэлтэй холбоотой хууль байхгүй юу. Тэр хөдөлмөр нийгмийн хамгааллын ч гэдэг юм уу тус тусад салгадаг тэр салбарын хуулиуд биш. Энэ түрүүнээс хойш гишүүд асуугаад байгаа юм. Энэ 4, 5 хууль яагаад нийлүүлсэн бэ гээд. Энэ шүүхийн эрх зүй гэж бас байдаг юм. Энэ эрх зүй чинь өөрөө хөгжлийн шаттай байхгүй юу. Одоо энэ Улсын Их Хурал 4, 5 хуулиа нийлүүлж байгаа чинь эрх зүйн тодорхой одоо ингээд нийлүүлээд ирэхээр шүүхийн эрх зүй гэж нийтийн эрх зүйн нэг ийм салбар бий болгож байгаа юм.

Энэ шүүхийн эрх зүйн дотор энэ шүүхийн хууль дотор чинь материаллаг хэмжээ процессын хэмжээ аль аль нь ордог. Энэ бол үндсэндээ эрх зүйн нэг том салбараа бүлэглэж ингэж кодексжилдог байхгүй. Төрөлжүүлэн хуульчилна гэж нэг арга байдаг. Тэр бүлэг бүх харилцааг процесс материаллаг хэмжээг нийлүүлээд явуулдаг. Одоо Оросууд бол судебное право гэж ярьдаг юм. Тэгэхээр энэ утгаар нь энэ бол шүүхийн байгаль орчны эрх зүйн гэдэг шиг байгаль орчны хууль гэдэг шиг энэ бол бүхэлдээ шүүхийн асуудлыг ингээд багцаар нь зохицуулж байгаа ийм төрөлжсөн ийм хууль байхгүй юу.

Энэ Их Хурал чинь тодорхой шүүхийн эрх зүй гэдэг энэ дараагийн шатанд оруулж ирэх үүднээс энэ төрөлжүүлэн хуульчилж байгаа ийм арга хэрэгсэл юм. Энэ дотор бүх бүлэг харилцааг зохицуулж байгаа. Шүүх эрх мэдлийн үндсэн прокуророос бусдыг нь зохицуулж байгаа харилцаа байхгүй юу. Энэ үүднээсээ ойлгохгүй бол энэ зүгээр нэг тийм нийлүүлээд хэдэн юм хийж байгаа энэ тэндээс салгаад аваад бусад юмтай адилтгах гээд байгаа юм биш. Цаашдаа ч гэсэн парламент гэж байхад парламентын эрх зүйн үүднээс Улсын Их Хуралтай холбоотой энэ нэг бүлэглэсэн харилцаанд оруулаад ирэхээр бусад хөдөлмөрийн тэтгэврийн асуудлууд ч гэсэн тусдаа ороод явна. Яг өнөөдрөөр ингэж явна гэж бодож болохгүй. Энэ чинь ийм юм шүү дээ парламентын эрх зүйн гэж байдаг. Шүүхийн эрх зүйн гэж байдаг. Энэ бусад нөгөө салбар юмнуудтай адилтгаад байж болохгүй.

Энэ чинь эрх зүй чинь тодорхой түвшинд орохоор салбар эрх зүй болоод хөгжчихдөг. Энэ шүүх эрх мэдэл хууль тогтоох мэдэл чинь бусад юмтай адилтгаж болохгүй ийм харилцаанууд байхгүй юу даа цаашаа хөгжихөд. Гүйцэтгэх эрх мэдэлтэй адилхан биш шүү дээ энэ чинь тусдаа бие даасан төрийн эрх мэдлийн салаа мөчир юм. Энийг чинь ингэж нийлүүлж ингэж нэгтгэснээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Энэ шүүхийн эрх зүй гэдэг чинь шүүхийн тогтолцоо шүүхийн процесс бүх юмаа хамаарсан л ойлголт л доо. Нийгмийн даатгалтай бас, нийгмийн даатгалын эрх зүйтэйгээ бас бусад нь уялдах ёстой л доо энэ. Санал хураалт. Энэ гэхдээ одоо ч гэсэн байгаа шүү дээ. 55 нас хүрсэн бол тогтоолгож болно гэж байгаа шүү дээ. Тэтгэвэртээ гарч болно гэж одоогийн хуульд ч байгаа хуулийн төсөлд ч байгаа. Ганцхан 25 жил гэсэн тийм юм биш. Санал дэмжигдлээ. 37 гишүүн дэмжиж 56,9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

43.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсэгт “Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн 2 дахь өгүүлбэр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг. Санал хураалт. 64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ тэгээд Үндсэн хуулийн Цэц дээр л очихгүй байвал гэж бодож байна. Цаашаа явъя.

44.Төслийн 51 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 51.2.3 дахь заалт нэмж, мөн зүйлийн 51.9 дэх хэсгийг хасах:

“51.2.3.ажил хэргийн нэр хүнд;” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 70,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45.Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Шүүгчид дараах зүйлийг хориглоно:

52.1.1.албан тушаалын байдал, эрх нөлөөгөө урвуулан ашиглаж өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох;

52.1.2.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн нууцыг задруулах; төрийн болон хувийн нууцыг ч гэсэн.

52.1.3.албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн албаны, байгууллагын, хувь хүний нууцыг задруулах;

52.1.4.шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааны талаар шүүхийн шийдвэр гарахаас өмнө өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлэх, илэрхийлэх;

52.1.5.албан ажлын хэрэгцээнд зориулсан материал, техник хэрэгслийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар ашиглах;

52.1.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн аливаа мэдээллийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зорилгоор ашиглах;

52.1.7.шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хуульд зааснаас бусад хэлбэрээр оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх;

52.1.8.шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон бусад иргэн, хуулийн этгээдээс шууд ба шууд бусаар тусламж авах, үйлчлүүлэх, давуу байдал, хөнгөлөлт, мөнгөн болон бусад урамшуулал, хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авах;

52.1.9.өөрийн, гэр бүлийн гишүүний, төрлийн хүний, эсхүл албан байгууллагын эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байх, хууль зүйн зөвлөгөө өгөх;

52.1.10.тухайн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчтэй гэр бүл, эсхүл төрөл, садангийн холбоотой талаар Ерөнхий зөвлөлд мэдэгдэхгүйгээр ажиллах;

52.1.11.өөрөө, эсхүл итгэмжлэгдсэн этгээдээр дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, тэдгээрийн холбоо, нэгдлийн удирдах бүрэлдэхүүнд орох, зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах;

52.1.12.Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр багшлах, эрдэм шинжилгээний болон бусад ажил эрхлэх, гадаад улсад зорчих;

52.1.13.гадаад улсын төр, олон нийтийн болон бусад байгууллагын шинжлэх ухааныхаас бусад хүндэт, тусгай цол, шагнал, одон, тэмдэг авах;

52.1.14.төрийн дээд одон, медаль, шинжлэх ухааныхаас бусад хүндэт, цол, шагнал, одон, тэмдэг авах;

52.1.15.Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаад улсын холбогдох шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин байгаа гадаад улсын болон олон улсын байгууллага, түүний салбар нэгжийн удирдах бүрэлдэхүүнд орох;

52.1.16.багшлах болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

52.1.17.улс төрийн байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага, улс төрийн сонгуульд нэр дэвшигчийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийн сурталчилгаанд оролцох, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт, хандив өгөх;

52.1.18.хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах, харилцах;

52.1.19.хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн дотно харилцаа тогтоох;

52.1.20.хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах, эсхүл хуралдааны дэг сахиулах хүрээнд бусдын зүй бус авирыг таслан зогсоох талаар шаардлага тавих үүргээ биелүүлэхгүй байх;

52.1.21.хуульд заасны дагуу олгосон бие хамгаалах тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах;

52.1.22.энэ хуулийн 19.2.2, 19.2.5-д заасан дараалал, журмыг санаатай зөрчих;

52.1.23.хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс

үйлдэхүй гаргах;

52.1.24.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан ажлаа удаа дараа таслах;

52.1.25.шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлгийн товыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчих;

52.1.26.шүүхийн шийдвэр гаргахтай холбоотой хуульд тодорхой заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа 30 хоногоос дээш хугацаагаар, эсхүл нэг удаа 60 хоногоос дээш хугацаагаар зөрчих;

52.1.27.шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон;

52.1.28.хуульд заасны дагуу татгалзан гарах үүрэгтэйгээ мэдсээр байж татгалзан гараагүй;

52.1.29.ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэхдээ согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх, эсхүл ийм байдалтай ажилдаа ирэх;

52.1.30.шүүгчийн сахилгын хэрэг шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах;

52.1.31.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэх;

52.1.32.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа шүүх, шүүгчийн нэр хүндэд харшилсан, эсхүл шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дууны, дуу-дүрсний бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл тараах, байршуулах;

52.1.33.шийдвэр гаргахаар зөвлөлдөх явцад бусадтай аливаа хэлбэрээр харилцах, зөвлөлдөх тасалгааны нууцыг задруулах;

52.1.34.шүүх хуралдааны явцад гар утас хэрэглэх зэрэг хэрэгт хамааралгүй өөр бусад үйл ажиллагаа явуулах;

52.1.35.шүүхийн ажилтан болон өөрийн удирдлага дахь этгээдэд албан үүрэгт нь хамааралгүй үүрэг даалгавар өгөх;

52.1.36.шүүгч өөрөө гэрчээр дуудагдсан, эсхүл өөрийн удирдлага дахь ажилтны талаар тодорхойлохоос бусад тохиолдолд хүний зан байдал, ёс зүй, нэр төр, ур чадварын талаар тодорхойлох;

52.1.37.албан үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглан өөртөө давуу байдал бий болгох, хувийн хэрэгцээнд шүүгчийн үнэмлэх, тэмдэг ашиглах, барьцаа болгон үлдээх;

52.1.38.хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн талаар эргэлзээ

төрүүлэхүйц ойлголтыг бусдад өгөх, нийтэд мэдээлэх;

52.1.39.энэ хуулийн 46.8-д заасан үүргээ биелүүлээгүй;

52.1.40.энэ хуулийн 68.7-д заасныг биелүүлээгүй.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Хэн, хэн үг хэлнэ гэнэ ээ? Мөнхцэцэг, Амарсайхан гишүүн үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн л үг хэлж болно. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ, байна уу сонсогдож байна уу?

Г.Занданшатар: Пүрэвдорж, Адьшаа, Ганбат гишүүнээр тасаллаа.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ хараат бус хариуцлагатай шүүхийг бий болгох энэ шүүхийн тухай хуулийн энэ 52 дугаар зүйл бас их чухал заалтууд байгаа. Энэ шүүгчийн хориглох зүйлийг бид нар нийтдээ бараг 40 гаруй төрлөөр ингэж тодорхой зааж өгч байна. Энэ маань бол ерөөсөө олон улсын жишгээр шүүхийн хориглох сахилгын зөрчлийг ингэж тодорхой дэлгэрэнгүй заах ёстой. Ингэж байж бид нар 2 төрлийн эерэг үр дагавар гаргана. 1 дүгээрт нь бол энэ сахилгын зөрчлийг ингэж тодорхой зааж өгснөөрөө бас Сахилгын хорооны зарим шийдэл төлөөлөл субъектив байдлаар гарах, эсхүл ямар нэгэн байдлаар шүүгчид үндэслэлгүйгээр шийдвэр ноогдуулахаас хамгаална.

Мөн тухайн шүүгчийн хувьд үйл ажиллагаандаа хориглох зүйлүүдийг ил тодорхой байдлаар ингэж урьдчилан мэдэх боломж бий болгож байгаа. Тэгэхээр Хууль зүйн хороон дээр энэ асуудлыг хэлэлцэх үед яг 2 төрлийн заалт дээр маргаан мэтгэлцээн өрнөсөн байгаа. Тухайлбал ил тод тодорхой заалтыг ноцтой эсхүл удаа зөрчсөн үйлдэл хийсэн эс үйлдэхүй, мөн одоо шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй нь Дээд шатны шүүхээр тогтоогдсон хэмээх энэ заалтуудыг хасах саналыг зарим гишүүд гаргасан.

Энэ бол хасаж болохгүй заалт байгаа. Ерөөсөө одоо шүүгч ер нь шүүгчдээс өдөр тутам хэрэг маргаан болгоны хувьд хийдэг хэн ч ойлгомжтой тодорхой мэргэжлийн ур чадвар туршлага шаардахааргүй үйлдэл эс үйлдэхийг сахилгын зөрчилд тооцдог олон улсын жишиг байгаа. Тийм учраас бид нар энэ 52 дугаар зүйлийн бүх заалтуудыг дэмжиж саналаа өгөх нь зүйтэй. Ингэж байж бид нар одоо хариуцлагатай шүүхийн тогтолцоог бий болгоход бас дэвшил гарна гэж үзэж байгаа.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Шүүхийн шийдвэрт үндэслэл бичихгүй гэж ийм заалтыг оруулах гээд өөрөөр хэлбэл энэ шүүхийн шийдвэрт үндэслэл бичээгүй огт бичээгүй нь дээд шатны шүүхээр тогтоогдсон гэдэг энэ заалтыг хасах гэж дээд шүүхийнхэн Байнгын хороон дээр лоббидсон бараагүй. Барахгүй. Энэ шүүгч нар би зарим талаараа эд нарын цалинг нэмэгдүүлэх хараат бус байлгах энэ явдлыг нь дэмждэг. Гэхдээ зарим шүүгч дэндүү хараат байгаад би харамсдаг. Энэний нэг жишээ бол Ж.Эрдэнэбат гишүүнийг хорьсон явдал. Өөрөөр хэлбэл тэр шүүхийн үндэслэл дээр юу гэж бичсэн

бэ гэхээр Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдал гэж байхгүй. Улсын Их Хурлын халдашгүй байдал байгаа л гэж бичсэн байгаа юм.

Улсын Их Хурал гэдэг чинь тэгээд энэ байшин юм уу. Энэ ширээ юм уу, энэ сандал юм уу? Улсын Их Хурал гишүүдээс бүрддэг. Ард олноо олны саналаар сонгогдож гарч ирдэг халдашгүй бүрэн эрхтэй ийм хүмүүс байгаа. Гэтэл энэ хүнийг хорьсон нь бол дэндүү шүүх хараат болсны илрэл болчихоод байгаа юм. Өнөөдөр зарим хүмүүс дээшээ заагаад тэр Ерөнхийлөгч энэ тэр рүү заагаад байх шиг байгаа юм. Сонгуулийн өмнө ирээдүйнхээ өрсөлдөгчийг Хүрэлсүх гэдэг хүн намнасан тэрийг нь шүүгч биелүүлсэн ийм л зүйл шүү дээ. Энэ хүнийг дараагийн шатны шүүх нь суллах ёстой.

Шүүхийн дээр энэ ард түмний бага ард түмэн бол төрийн дээд байгууллага болсон Их Хурал байгаа гэдгийг л анхаарах хэрэгтэй. Миний үгийг хасаж болно. Хааж болно. Танай намынхан тэр Ерөнхий сайдаасаа.../үг тасрав/

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн. Ер нь байна шүү дээ, Адьшаа гишүүн байж байгаарай. Үндсэн хуульд Монгол Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж заасан. Улсын Их Хурлын гишүүний санал халдашгүй дархан байна гэж заасан. Сонгуульд нэр дэвшигч ингээд процесс та нар чимээгүй байхад одоо 6 сарын 14-ний өдөр би мэдэгдэл гаргасан. Энэ Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль холбогдох хуулийг зөрчиж байна гэж. Шүүх бол энийг процессын хуулиар тайлбарласан. Олон улсын парламентын холбоо хэрэг үүсгэснээ албан ёсоор мэдэгдсэн. Энэ бол манай шүүхийн практикт гарч байгаа тохиолдлыг шүүгч хууль буруу хэрэглэж гаргасан. Энэ асуудлыг бол энэ шүүхийн сахилгын хороо байгуулагдахаараа хянаж үзнэ би итгэж байна. Адьшаа гишүүн, Пүрэвдорж гишүүн дуугүй суу.

Ш.Адьшаа: Энэ би 52.1.27 талаар ярих гэж байгаа юм. Тэр 52.1.27 талаар тэр дээд шүүхийнхэн лоббидсон мэтээр Пүрэвдорж юу яриад байна вэ. Энэ дээр бол маш их маргаан дагуулсан асуудал байсан. Энэ дээр хэлэлцүүлэг хийсэн. Тэгээд энэ Энхбаяр юм уу Бямбацогт хоёр энэ дахиад нэг юм хасаад хаясан байх юм. Энэ зайлшгүй шаардлагатай юуг бид нар тохироод оруулсан шүү дээ Лүндээжанцан дарга тийм биз дээ. Гэтэл огт бичигдээгүй гэдэг ийм юм байхгүй шүү дээ энэ шүүхийн шийдвэрт. Огт бичигдээгүй гэж тийм ямар юм байдаг юм бэ та нар. Тийм юмыг ингээд байж байгаад энэ засаад оруулаад ирээд байх юм.

Энэ чинь бүр 30 мин хэлэлцүүлэг хийсэн. Тэгээд ийм байж болдог юм уу, энэ Хууль зүйн байнгын хорооны дарга хаана байна вэ, энэ чинь зайлшгүй шаардлагатай гэдэг юмыг нэмж оруулъя гээд та өөрөө Лүндээжанцан зөвлөх та хагалж энэ үгийг хэлсэн биз дээ. Энэ чинь юу болж байгаа юм бэ. Энэ баахан дээд шүүхийн лобби. Энд бол ганцхан юмыг ярья. Энэ шүүхийн сахилгын хороо гэдэг бол шүүхийн дотор шүүх шүү. Тэгэхээр энэ 1 талыг бариад ингээд хүний буруутгах ямар ч аргаар буруутгах ийм юмыг энэ Улсын Их Хурал гаргаж болохгүй гэдгийг та өөрөө тийм санал гаргаад тэгж

бид тохирсон шүү дээ. Тэгээд цаашаа явсан биз дээ. Дахиад л Энхбаярын бичсэн тэр огт бичигдээгүй нь дээд шатын шүүхээр нотлогдсон гэж юмыг оруулж ирж байна. Үгүй ээ үгүй та зайлшгүй шаардлагатай гэж огт гэдгийн төлөө маргаан болсон шүү дээ бүгд байж байсан. Энэ чинь ямар юм болоод байна вэ.

Г.Занданшатар: Шүүхийн шийдвэр чинь тогтоох хэсэгтээ үндэслэлээ заавал бичиж байгаа шүү дээ. Тэгээд тэрнийг нь бичихгүй бол дээд шатны шүүх нь өөрөө тогтоохоор л тогтоогдсон болохоор болсон байна шүү дээ. Илт тодорхой гэдгээ бол харин цэгцэлсэн юм байна. Санал хураалт явуулна. Энэ их чухал заалтууд энэ Мөнхсайхан доктор. Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ. Асуулдалтай холбогдолтой үг хэлнэ шүү эхний 3.

Д.Ганбат: Намайг л ярихаар ингээд хачин юм болоод байх юм. Би энд үнэн л үг хэлээд байх шиг байх юм тийм ээ. Үнэн үг хэлсэн хүнд юу ч дургүй билээ тийм ээ. Ялангуяа энэ гэмт хэрэгтэн байсан юм уу байх улсууд их дургүй байх шиг байна. Энэ 52 дугаар зүйлээр бол шүүгчид их олон зүйлийг хориглож байгаа юм. Тэгээд манай гишүүд бас ойлгохгүй байх шиг байна. Нөгөө шүүгч шүүгчийг л хардаад ад үзээд л ингээд байх юм. Шүүгч шүүхийг өмөөрч байгаа энэ хууль зүйн нөхцөл байдлыг ойлгуулж байгаа хүн бол энэ Энхбаяр гишүүн, Сүхбаатар гишүүн хоёр л байх шиг байна.

Бусад нь бол үгүй байна. Зүгээр нэг сүргийн сэтгэхүйгээр л байна шүү дээ та нар. Ингэж болохгүй. Ийм олон зүйлээ хориглуулаад энэ шүүх шударга шийдвэр гаргахын төлөө явдаг юм. Засаглалын нэг тулгийн чулуу нь энэ ардчиллын. Тэгэхээр энэ дээр бас ойлгож яримаар юм байгаа юм. Одоо энэ шүүхийн хууль батлагдаад ингэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл маань шинэчлэгдэнэ. Сахилгын хороо гэж Үндсэн хуулийн байгууллага орж ирнэ. Үүний дараагаар хамгийн ил болгох ёстой даваа бол дээд шүүхийн шүүгч нар. Тэрийг шинэ нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулаад бид нар нийтийн сонсгол хийх хэрэгтэй Улсын Их Хурал бол. Сонсох ёстой. Яагаад тийм хонгил байгуулаад байсан юм, яагаад тийм хонгил хийгээд байсан юм. Энэ юмыг сонсох нь зөв байх. Энэ хуулийн зүйл заалтыг шаардлагатай бол энэ дагаж мөрдөх журмаараа ч юм уу ингэж оруулсан нь дээр. Дээд шүүхийн шүүгчийг нэг бүрчлэн бид нар нийтийн сонсголоор Улсын Их Хурал дахь сонсголоор сонсож ингэж явахгүй бол цаашдаа тэр хонгил нь хэвээрээ үлдэнэ. Шударга ёс тогтохгүй. Тэгж байж гүйцэт хийх ёстой гэж үзээд байгаа юм.

Тэр тэтгэврийн тэр буруу зөрүү яриад л байна лээ. 80 хувь энэ тэрээр тогтоох хэрэгтэй. Насыг нь жаахан уртасгаж өгөх хэрэгтэй. Тэрийг нь бол саяын тэр бүх шүүхийн шүүгч, дээд шүүхийн шүүгч нарыг Улсын Их Хурал.../минут дуусав/

Г.Занданшатар: Сайнбуянгийн Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Энэ шүүгчийн шүүн таслах үйл ажиллагаа явуулах хэрэг маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх үүрэг хариуцлага бусад энэ хориглох зүйлүүд гээд энийг бүгдийг нь ерөнхийд нь дэмжиж байгаа. Гэхдээ ганц хоёр асуудал байна.

Бид нар чинь ерөөсөө энэ Үндсэн хуулийг эрх тэгш хэрэгжүүлэх хүний эрх, эрх чөлөө, хүнийг ажил гарал үүсэл эрхэлж байгаа ажлаар нь ялгаварлан гадуурхахгүй ийм л шударга эрх тэгш нийгмийн бий болгохын тулд энэ шүүхийн шинэчлэлийг хийж байна гээд байгаа шүү дээ.

Тэгээд энэ хууль дээр зөрчилдөөнтэй хэдэн асуудал байна. Ялангуяа энэ шүүгчдэд эхийн одонгоос өөр төрийн дээд одон медаль гардуулж өгч болохгүй, авч болохгүй гээд. Тэгсэн хэр нь 52.1.31 дээр нь шүүгч өөрөө хүний гарал үүсэл ажил төрөл тэгээд өнгө яс үндсээр нь гадуурхаж болохгүй гээд. Тэгээд энэ шүүгч гэдэг хүн чинь өөрөө хүн биш болж таарч байгаа юм уу гэдэг зүй ёсны асуулт гарч ирж байгаа юм.

Хэрэв төрийн өндөр дээд одон медаль гэж байгаа бол тэрийг Монгол Улсны иргэн аль ч салбарт юу ч хийж байсан бай авах эрх нь нээлттэй байж Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх ёстой. Хэрэв өгөхгүй гэж байгаа бол тэр төрийн одон медаль өгдөг хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах ёстой. Одоо энэ дээр байж байгаа шүү дээ хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авахыг хориглоно гэж байгаа. Тэгэхээр одоо энэ эхийн одонгоос эхлээд бусад одон медаль чинь бүгд л хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн байгаа шүү дээ. Харин энэ хуулиар хориглох юм бол энд нөгөө хүнийг ялгаварласан гадуурхсан асуудлуудаар жинхэнэ нөгөө хатуу шаардлага тавьж байгаа ялгаж гадуурхаж болохгүй гэдэг шүүгчид дээрээ гаргаж байгаа төрийн буруу бодлого болж таарах гээд байна шүү дээ. Тэгэхээр би энэ заалтуудыг хасъя гэсэн саналтай байгаа юм. Энэ дээр ажлын хэсгийнхэн бас анхаарах ёстой.

Г.Занданшатар: Гишүүдээ, Ганбат гишүүнээ ер нь бол Үндсэн хуульд дурдсан бүх байгууллагыг Үндсэн хуулийн байгууллага гэж тооцох уу үгүй юу гэдэг дээр бол судлаачид маргаантай байдаг юм. Сумын Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бүгд Үндсэн хуульд тусгагдсан. Тэр хэмжээгээр бүгд Үндсэн хуулийн байгууллага гэж бас үзэх үү үгүй юу гэсэн асуудалтай. Шүүхийн дээд байгууллага бол дээд шүүх байна гэж л Үндсэн хуульд байгаа. Тэгээд энэ Амарсайхан гишүүнээ төрийн одон медаль бол зөвшөөрөгдөж байгаа шүү. 52.1.14 дээр зөвшөөрөгдөж байгаа. Хуучин төсөл дээрээ хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авах гэж заалт байгаа юм.

Ер нь бол 52.1 толгой нь бол шууд хориглоно гэсэн байгаа. Уг нь бол нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуульд заасан хориглолт хязгаарлалтаас гадна дараах зүйлийг хориглоно гээд. Гэхдээ зарим нь бол урьдчилж мэдэгдэх ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй байдлаас мэдэгдэх энэ тэр байдлаар зохицуулахгүй бол. Ганбат гишүүнээ энэ бол шүүгчийг хориглох гэхээсээ илүү хамгаалж байгаа заалт гэж манай эрдэмтэн судлаачид Мөнхсайхан, гадаадтай хүмүүс хэлж байгаа. Тэгэхгүй бол шүүхийн сахилгын хороо чинь дуртай үзэмжээрээ хариуцлага тооцоод шүүгчийг огцруулаад асуудал үүсгээд байвал бүх юм нээлттэй орхичихно. Тийм учраас яг энэ асуудлаар ингэж нэг талаасаа хашиж өгч байгаа ийм заалт. Тэгээд санал хураалтын өмнө бол бас энэ гишүүдийн хэлсэн саналыг эцсийн

хэлэлцүүлэг дээр анхаарч найруулах чиглэл өгч байна. Бусад хууль тогтоомжтой уялдуулж нийтийн болон хувийн ашиг сонирхлыг хязгаарлах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуультай уялдуулах, тэр хуульд заах байдлаар илүү зохицуулалтуудыг илүү боловсронгуй болгоход анхаарах чиглэл өгч байна. Тэгээд дэмжээд явъя гэсэн ийм саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. 66-аас 43 65,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Тэгээд энэ ийм юм болохгүй шүү гэдгээ шүүгчид ч мэдэж байх ёстой. Сахилгын хороо нь ч гэсэн энэ хүрээнд л ажиллана гэдгээ бас ойлгож байх ёстой гэдэг утгаар нь бас гүйцээн боловсруулж найруулах энийг засах чиглэл өгсөн. Энийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Одоо 46 дугаар санал.

46.Дээрх 45 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсгийг хасах. Санал хураалт. 53 гишүүн дэмжиж 79,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6 цаг өнгөрсөн байна. Маргаашийн ажлын тэгье. Ингээд талдаа ортол буюу 19 цаг хүртэл хуралдаад завсарлая гэсэн ийм маргааш үргэлжлүүлье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Цагаа сунгаад гэхдээ санал хураалт үргэлжлүүлэх бол санал хураалт явуулах ёстой. Нэг мөр олуулаа байгаа дээр санал хураалт явуулъя. 19 цаг хүртэл сунгаж хуралдъя. 19 цагаас завсарлаад маргааш үргэлжлүүлж хуралдъя гэсэн маргааш үргэлжлүүлж шүүхийн тухай хуулийнхаа санал хураалтыг явуулъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Маргааш дуусна. Үдээс өмнөдөө дуусна. 48 гишүүн дэмжиж 71,6 хувийн саналаар саяын санал дэмжигдлээ. Ингээд.

47.Төслийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 56.1, 56.2 дахь хэсэг болгож, 56.2 дахь хэсгийн “алдаа” гэсний өмнө “мэргэжлийн үйл ажиллагааны” гэж нэмж, 56.3 дахь хэсгийг хасах.

“56.1.Шүүгч зөвхөн хуульд захирагдах бөгөөд зөрчсөн бол хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

56.2.Шүүгчид зөвхөн энэ хуульд заасан үндэслэл, журмаар сахилгын шийтгэл оногдуулна.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 55 гишүүн дэмжиж 82,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

48.Дээрх 47 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 57 дугаар 57.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“57.1.Шүүхийн сахилгын хороо энэ хуулийн 52, 53.1, 54, 55 дугаар зүйлд заасан хориглосон, хязгаарласан, үүрэг болгосон зохицуулалтыг зөрчсөн /цаашид “сахилгын зөрчил” гэх/ шүүгчид сахилгын шийтгэл оногдуулна.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 52 гишүүн дэмжиж 77,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

49.Дээрх 48 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 58 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Энэ заалт хасагдсантай холбогдуулаад шүүгчийн мэргэжлийн алдаа ёс зүйн зөрчил хоёрыг ялгаж салгах асуудлыг бас эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарах чиглэл өгч байна. Цаашаа.

50.Төслийн 59 дүгээр зүйлийн 59.1.3, 59.1.4, 59.6.1 дэх заалтуудыг доор дурдсанаар, мөн зүйлийн 59.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 59.2-59.5 дахь хэсэг болгож, 59.4 дэх хэсгийг хасах:

“59.1.3.цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

59.1.4.шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;”

“59.6.1.энэ хуулийн 59.1.1, 59.1.2-т заасан шийтгэл оногдуулах зөрчлийг 10-аас дээш удаа, эсхүл энэ хуулийн 59.1.3, 59.1.4-т заасан шийтгэл оногдуулах зөрчлийг таваас дээш удаа гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн;”

“59.2.Энэ хуулийн 59.1.5-д зааснаас бусад шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш нэг жил, зөрчил гаргаснаас хойш хоёр жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.3.Энэ хуулийн 59.1.5-д заасан шийтгэл оногдуулах сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш хоёр жил, зөрчил гаргаснаас хойш таван жил өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.4.Шүүгчид сахилгын хэрэг үүсгэснээр энэ хуулийн 59.2, 59.3-т заасан хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно.

59.5.Энэ хуулийн 59.1.4-т заасан шийтгэл оногдуулсан шүүгчид сургалтад суух хугацаанд албан тушаалын цалинг 50 хувиар тооцож олгоно.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 49 гишүүн дэмжиж 74,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

51.Төсөлд доор дурдсан агуулгатай 60 дугаар зүйл нэмэх:

“60 дугаар зүйл.Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах

60.1.Энэ хуульд заасан сахилгын зөрчил гаргасан шүүгчид дараах сахилгын шийтгэлийг энэ хуулийн 59.5-д заасныг баримтлан оногдуулна:

60.1.1.энэ хуулийн 52.1.5, 52.1.21, 52.1.34, 52.1.35, 52.1.36, 52.1.37, 52.1.38, 52.1.40-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах;

60.1.2.энэ хуулийн 52.1.13, 52.1.14, 52.1.20, 52.1.25, 52.1.29, 52.1.32, 52.1.33, 53.1-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

60.1.3.энэ хуулийн 52.1.3, 52.1.4, 52.1.9, 52.1.28-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах;

60.1.4.энэ хуулийн 52.1.18, 52.1.19-д заасан зөрчилд нээлттэй сануулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.5.энэ хуулийн 52.1.22, 52.1.26, 52.1.31-д заасан зөрчилд нээлттэй

сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.6.энэ хуулийн 52.1.15, 52.1.17, 52.1.23, 52.1.30, 55.1-д заасан зөрчилд цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах;

60.1.7.энэ хуулийн 52.1.6, 52.1.10, 52.1.12, 52.1.39, 54.1-д заасан зөрчилд хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.8.энэ хуулийн 52.1.8, 52.1.16, 52.1.24-д заасан зөрчилд цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.9.энэ хуулийн 52.1.7, 52.1.11, 52.1.27-д заасан зөрчилд шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах;

60.1.10.энэ хуулийн 52.1.1, 52.1.2-д заасан зөрчилд огцруулах.” Санал гаргасан Ажлын хэсэг. Мөнхбат, Чинзориг гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүний энийг Зөрчлийн хуульд яг л ийм санкц хиймээр байгаад байгаа юм даа. Сануулах сургалтад суулгах энэ тэр гээд. Жамъянгийн Мөнхбат гишүүн.

Ж.Мөнхбат: Энэ зүйл заалт дээр бол би түрүүн маргаан болоод байна л даа. Шүүхийн шийдвэрт үндэслэл огт бичээгүй бол гээд. Энэ асуудал дээр огцруулах шийтгэл бол орж ирж байгаа тийм үү. Гэтэл энэ 52.1.23 дээр чинь огцруулах шийтгэл байхгүй байгаад байгаа юм. Хуулийн илт тодорхой заалтыг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл эс үйлдэхгүйг гаргах гэж байгаа юм. Жишээлбэл энэ дээр би өдөр ярьсан. Нөгөө Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд халдаад шийдвэр гаргасан. Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэхгүйгээр нэр дэвшигчийг барьж хорих шийдвэр гаргасан. Энэ чинь бол маш тодорхой илт тодорхой заалтыг зөрчсөн л байгаа байхгүй юу.

Эрдэнэбат гишүүний хувьд бол яриад байна. Одоо энэ асуудлаас болоод өнөөдөр ингээд шүүх маань янз бүрийн нэр хоч байгаад л ингээд энд тэнд л ингээд яригддаг бол болж эхэлж байна. Сүүлдээ бүр ингээд Олон улсын парламентын холбооны хориг хүртэл ингээд яригдаж байна. Олон улсын хэмжээнд Монголын шүүхийн нэр хүнд яригдах асуудал болж байна. Тэгэхээр энэ алдаа гаргасан ийм хуулийн маш тов тодорхой ил тодорхой зүйл заалтыг ноцтойгоор зөрчсөн энэ шүүгчид бол огцруулах хүртэл арга хэмжээ авдаг энэ заалтыг бол энэ 60.1 дээр оруулж өгөх хэрэгтэй.

Ингэж байж өөрсдөө энэ цаашаа нэлээн хариуцлагатай болж ингэж явах байх гэсэн ийм саналтай байгаа юм. Тийм учраас бол зөвхөн 52.1.27 дээр биш энэ 52.1.23 дээр манай Хууль зүйн байнгын хорооныхон манай ажлын хэсгийнхэн Энхбаяр гишүүн та бүхэн маань цаашаа энэ дээр анхаараарай. Энэ бол цаашдаа бол Монголын шүүхийн нэр хүндийг нь улам өргөх ийм заалт болж өгнө шүү. Янз бүрийн эрсдэлээс

хамгаалах.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Сахилгын шийтгэл нь асар их тийм зөрүү ихтэй л юм шиг санагдах юм. Манай ажлын хэсэг юу гэж үзэж байсан юм бол. Түдгэлзүүлээд сургалтад суулгахыг даалгах гэдэг чинь тэгээд түдгэлзүүлж байгаа нь сахилгын шийтгэл болж байгаа юм уу сургалтад суулгаж байгаа нь сахилгын шийтгэл болж байгаа юм уу? Хэрэв сургалтад суулгахыг сахилгын шийтгэл гэж байгаа бодож байгаа бол энэ чинь бас л тийм сонин ойлголт болох нь л дээ. Түдгэлзүүлээд сургалтад суулгах л юм шиг л байх юм.

2 дахь асуудал нь энэ сахилгын шийтгэлүүд чинь хоорондоо асар их зөрүүтэй байна Энхбаяр гишүүнээ. 3 сар хугацаагаар түдгэлзүүлээд сургалтад суулгахыг даалгах эсхүл огцруулах тэгээд. 3 сар түдгэлзүүлээд сургалтад суулгахыг даалгах, эсхүл огцруулах гэдэг энэ юу чинь хоорондоо асар том зарчмын зөрүүтэй шийтгэлүүд шүү дээ. Тэр 3 сар түдгэлзүүлэх сургалтад суулгахыг аль бол огцруулах гээд ингээд ялгахаар чинь их л зөрүүтэй л тодорхой заалтуудаа их зөрүүтэй тийм шийтгэлийн санкцууд л орж ирэх нь л дээ. Тэгэхээр ийм зөрүүтэй заалтууд байх юм уу, эсхүл тэр түдгэлзүүлээд сургалтад суулгахыг даалгах гэдэг нь тусдаа огцруулах гэдэг нь тусдаа байхгүй бол 3 сар түдгэлзүүлээд сургалтад суух эсхүл огцруулах гэдэг чинь бол асар тийм хоорондоо их зөрүүтэй том ийм ялгаатай шийтгэлүүд л явах нь дээ. Энийгээ цаашдаа анхаармаар юм уу яамаар юм бэ. Тийм их зөрчил, асар их хоорондоо зөрчил ялгаатай л одоо ийм шийтгэлүүд л яваад байх юм.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт. 45 гишүүн дэмжиж 67,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

52.Төслийн 65 дугаар зүйлийн 65.5 дахь хэсгийн “үзэх шалтгаантай” гэснийг “шүүх хуралдаанд оролцох боломжгүй” гэж өөрчилж, 68 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 68.3-68.8 дахь хэсэг нэмэх:

“68.3.Иргэдийн төлөөлөгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүхийн хуралдаанд оролцохдоо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

68.3.1.шүүх хуралдааны үед тодруулах асуулт тавих замаар нотлох баримт шинжлэхэд оролцох;

68.3.2.шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, зохигч, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, гэрч, шинжээчид асуулт тавих;

68.3.3.хэргийн үйл баримтад үнэлэлт өгч, шүүгдэгч, зохигчийн гэм буруутай эсэх талаар бичгээр дүгнэлт гаргах;

68.3.4.хуульд заасан бусад бүрэн эрх.

68.4.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 68.3.3-т заасан дүгнэлтийг бичгээр гаргах боломжгүй бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлж, дүгнэлтийг амаар гаргаж болно.

68.5.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 68.3.3-т заасан дүгнэлтээ шүүх хуралдаанд

уншиж сонсгоно.

68.6.Шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахдаа иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзнэ.

68.7.Шүүх бүрэлдэхүүн иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулгыг шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт бичиж, уг дүгнэлтийн талаарх үндэслэлээ үндэслэх хэсэгт тодорхой тусгана.

68.8.Давж заалдах шатны шүүх хуульд заасан тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг харгалзан үзэж, энэ хуулийн 68.7-д заасны дагуу шийдвэртээ тусгана.

68.9.Шүүх бүрэлдэхүүн энэ хуулийн 68.7-д заасныг биелүүлээгүй бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 49 гишүүн дэмжиж 73,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

53.Төслийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсгийн “шүүгч” гэсний өмнө “шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах,” гэж, 72 дугаар зүйлийн 72.1 дэх хэсгийн “зорилго” гэсний өмнө “, хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах” гэж тус тус нэмж, 72.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 72.2.3 дахь заалтын “эрх” гэснийг “хараат бус байдлыг хангах” гэж өөрчлөх:

“72.2.1.шүүхийн бие даасан байдлыг хангах,” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 56 гишүүн дэмжиж 83,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

54.Төслийн 73 дугаар зүйлийн гарчгийг “Шүүхийн бие даасан байдлыг хангах” гэж, 73.1 дэх хэсгийн “захиргааны удирдлагын” гэснийг “шүүхийн бие даасан байдлыг хангах” гэж, 73.1.1 дэх заалтын “шүүх эрх мэдлийн” гэснийг “шүүхийн бие даасан, шүүхийн хараат бус байдлыг хангах” гэж, 73.1.2 дахь заалтын “Засгийн газар болон Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Улсын Их Хуралд” гэснийг “Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Засгийн газарт” гэж өөрчилж, 73.1.23 дахь заалтыг 73.2 дахь хэсэг болгон шилжүүлж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 73.1.26, 73.1.27 дахь заалт нэмэх:

“73.1.26.хэргийн хөдөлгөөний удирдлагыг хэрэг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, үзүүлэлт, ажиллагаанд байгаа хэргийн насжилт, тодорхой хэргийн хөдөлгөөний талаар хяналт-шинжилгээ хийх болон хуульд заасан бусад аргыг ашиглан хэрэгжүүлэх;

73.1.27.хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт болон шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг тогтоосон журмын дагуу хуваарилсан, томилсон эсэхэд хяналт тавих, улирал бүр нийтэд мэдээлэх, хүсэлт гаргасан этгээдэд уг мэдээллийг гаргаж өгөх;” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 53 гишүүн дэмжиж 82,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

55.Төслийн 74 дүгээр зүйлийн 74.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 74.1.5 дахь заалтын “болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар дүгнэлт гаргах журам, шалгуурыг Мэргэшлийн хороотой хамтран” гэснийг “журам” гэж өөрчлөх:

“74.1.4.шүүгчийг сэлгэн ажиллуулах шийдвэр гаргах; Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 55 гишүүн дэмжиж 82,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

56.Төслийн 75 дугаар зүйлийн гарчгийн, 75.1 дэх хэсгийн “эрх” гэснийг “хараат бус байдлыг хангах” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 75.2-75.4 дэх хэсэг нэмэх:

“75.2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй үйл ажиллагаа явуулсан бол Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах саналыг Улсын дээд шүүхэд хүргүүлнэ. Улсын дээд шүүх Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлнэ.

75.3.Энэ хуулийн 75.2-т зааснаас бусад этгээд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд Ерөнхий зөвлөл даруй хуралдаж, дээрх шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалахад зайлшгүй шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу хүсэлт, гомдол, нэхэмжлэл, мэдэгдэл гаргах зэрэг хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.

75.4.Шүүгчийн эрх ашгийг зөрчсөн, хараат бус байдлыг алдагдуулсан талаар шүүгчээс Ерөнхий зөвлөлд хандан гомдол, хүсэлт гаргасан бол уг асуудлаар шүүгчийг төлөөлөн гомдол, нэхэмжлэл гаргах зэргээр холбогдох этгээдэд хандаж хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 47 гишүүн дэмжиж 70,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

57.Төслийн 78 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“78 дугаар зүйл.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа

78.1.Ерөнхий зөвлөл орон тооны 10 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.

78.2.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд хяналтын шатны шүүхээс нэг, давж заалдах болон анхан шатны шүүхээс тус бүр хоёр шүүгчийг Нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож, Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.

78.3.Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүд нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

78.4.Ерөнхий зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно. Ерөнхий зөвлөлийн даргын сул орон тоо гарснаас хойш 14 хоногийн дотор даргыг сонгоно.

78.5.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх сонгогдож, томилогдсоноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

78.6.Ерөнхий зөвлөлийн нөхөн сонгогдсон, томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

78.7.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хуулиар тогтоосон хугацаанаас өмнө дуусгавар болсон бол өөр хүнийг энэ хуульд заасан журмын дагуу нөхөн сонгох, эсхүл нөхөн томилно.

78.8.Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

78.9.Ерөнхий зөвлөлийн гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд тохирсон цалин хөлс, зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж, хуульд заасан баталгаагаар хангагдана.

78.10.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тус зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.” Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ. Нямаагийн Энхболд гишүүнээр үг тасаллаа.

Н.Энхболд: Сонсож байна уу даргаа?

Г.Занданшатар: Сонсож байна.

Н.Энхболд: Би түрүүчийн санал дээр үг хэлэх гэж байгаад тэгээд хоцорчихлоо. Би гэхдээ нөхөөд хэлье. Тэр одоо буруу шийдвэр гаргасан шүүгч нарыг огцруулах арга хэмжээ авах зүйлүүдээ бас араас нь тэр буруу шийдвэр гарснаас болоод хохирсон хүний асуудал байгууллагын асуудал тэрний үр дагаврыг арилгах талын юмнуудыг нь аль хуулиар яаж зохицуулах тал дээр их тодорхой тусгах хэрэгтэй байна.

Мөнхбат гишүүний байнга яриад байгаа зүйлтэй бол би санал нэг байгаа. Үнэхээр ямар ч аль талаас нь харсан болохгүй шийдвэр гаргасан тэрнээс нь болоод нэг хүнийг баривчлаад хорьсон ийм тохиолдол Их Хурлын гишүүнд нэр дэвшсэн хүнийг гарлаа шүү дээ. Тэр хүнийг зүгээр огцруулаад орхих эсхүл үр дагаврыг нь тооцоод дахиад тэрний үргэлжлүүлээд шүүгчээс нь огцруулсан нь өөрөө тэгээд том шийтгэл болоод үлдэх юм уу, тэр буруу шийдвэр гаргаснаасаа болоод хүн хохирсон гэмт хэргийн дараа нь яаж хэн шүүж тунгааж шийтгэл ноогдуулж байх юм бэ гэдгийг нь аль нэг газар их тодорхой тусгах хэрэгтэй байна. Дараа дараагийн хэлэлцүүлэг дээр энэ дээр олон нийтэд сайн мэдээлэл өгч би ажлын хэсгийнхнийг яриасай гэж бодож байна.

Чинзориг гишүүний хэлээд байгаа бас адилхан. 3 сар шүүгчийн ажил хийлгэхгүй байх огцруулах хоёр чинь шал өөр асуудал. 3 жил шоронд суулгах уу бүх насаар нь шоронд суулгах уу гэдэгтэй ийм адилхан ийм хол зөрүүтэй шийтгэлүүд байж таарахгүй. Тэгэхээр ажлын хэсэг дараагийн хэлэлцүүлэг дээр энэ зүйлүүдийг бас нэг аваад огцруулах юмнуудыг тусад нь заалт гаргаж хийсэн нь зөв байх гэсэн ийм байр суурьтай байна. Энийг бас нэг та чиглэл болгож өгвөл сайн байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Энэ саналуудыг түрүүний огцруулах юуны саналуудаа нээрээ Үндсэн хуультай нийцүүлж Нямаагийн Энхболд гишүүн энэ тэрийн хэлээд байгаа саналыг бас эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарах чиглэл өгч байна. Улсын дээд шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна гэж байгаа. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 48 гишүүн дэмжиж 71,6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ерөнхий зөвлөлөө баталсан.

58.Төслийн 79 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“79 дүгээр зүйл.Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох, сонгох журам

79.1.Улсын Их Хурал Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг дараах журмаар нээлттэйгээр нэр дэвшүүлж, томилно:

79.1.1.Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч биш гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 120-оос доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын гурван өдрийн дотор Байнгын хороонд болон олон нийтэд энэ тухай мэдэгдэх;

79.1.2.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор, хэрэв чуулганы чөлөө цагт эдгээр нөхцөл бий болсон бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Байнгын хорооноос Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

79.1.3.иргэн сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт Байнгын хороонд хүргүүлэх:

79.1.3.а.Ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар;

79.1.3.б.төрийн албан хаагчийн анкет;

79.1.3.в.мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга;

79.1.3.г.нийгмийн даатгалын дэвтэр, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

79.1.3.д.энэ хуулийн 78.3-т заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг.

79.1.4.Байнгын хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг байршуулах;

79.1.5.Байнгын хороо энэ хуулийн 79.1.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээдээс нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй;

79.1.6.Байнгын хороо энэ хуулийн 79.1.2-т заасан зарыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор сонгон шалгаруулалтыг хараат бусаар зохион байгуулах чиг үүрэгтэй ажлын хэсэг байгуулах.

79.2.Ажлын хэсэг нь Улсын Их Хурал дахь олонх, цөөнх, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургалт, судалгааны байгууллага, хууль зүйн их, дээд сургуулийн санал болгосон төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар томилсон Улсын Их Хурлын гишүүн ахална.

79.3.Ажлын хэсэг энэ хуулийн 79.1.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 60 хоногийн дотор сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгоно.

79.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг дараах журмаар зохион байгуулна:

79.4.1.энэ хуульд заасан шаардлагыг хангасан нэр дэвшигчийг бүртгэн нийтэд мэдээлэх;

79.4.2.нэр дэвшигчийг тохиолдлын журмаар ажлын хэсгийн гишүүдэд тэнцвэртэй хуваарилж, илтгэгч гишүүнийг томилох;

79.4.3.илтгэгч гишүүн нь нэр дэвшигчийн баримт бичиг, олон нийтээс ирүүлсэн саналыг судлах, нэр дэвшигчтэй болон бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр мэдээллийг бүрдүүлж, тухайн нэр дэвшигч Ерөнхий зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дэлгэрэнгүй тайлан бичих;

79.4.4.ажлын хэсгийн гишүүд илтгэгч гишүүний тайлан болон холбогдох бусад баримт, мэдээлэлд үндэслэн нууцаар санал хураах;

79.4.5.энэ хуулийн 79.4.4-т заасан санал хураалтын дүнгээр ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тоогоор болон дараагийн олонхын санал авсан хоёр хүртэлх хүний хамт нэр дэвшүүлж, Байнгын хороонд тайлангийн хамт ажлын гурван өдрийн дотор хүргүүлэх.

79.5.Байнгын хороо энэ хуулийн 79.4.5-д заасны дагуу ирүүлсэн тайланг хүлээн авснаас хойш дараах ажиллагааг хийнэ:

79.5.1.хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг агуулсан тайланг ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах;

79.5.2.энэ хуулийн 79.5.1-д заасны дагуу тайланг байршуулснаас хойш ажлын таван өдрийн дотор томилгооны сонсголын товыг зарлах;

79.5.3.тайланг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй;

79.5.4.энэ хуулийн 79.5.3-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор хуульд заасны дагуу томилгооны сонсголыг зохион байгуулах.

79.6.Энэ хуулийн 79.5.4-т заасны дагуу томилгооны сонсголыг хийснээс хойш ажлын таван өдрийн дотор нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилох

эсэх талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

79.7.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилно.

79.8.Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилохоос татгалзсан бол ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчдээс дараагийн хамгийн олон санал авсан хүнийг энэ хуулийн 79.4.5-д заасны дагуу Улсын Их Хуралд нэр дэвшүүлнэ.

79.9.Энэ хуулийн 79.8-д заасан нөхцөлд ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигч байхгүй бол ажлын таван өдрийн дотор Байнгын хороо сонгон шалгаруулалт явуулах тухай зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, 90 хоногийн дотор энэ зүйлд заасан журмын дагуу сонгон шалгаруулалтыг дахин явуулна.

79.10.Улсын Их Хурлаас татгалзсан нэр дэвшигчийг дахин нэр дэвшүүлэхгүй.

79.11.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулахтай холбоотой журмыг энэ хуульд нийцүүлэн Байнгын хороо баталж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна.

79.12.Нийт шүүгчийн чуулган Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг дараах журмаар нэр дэвшүүлж, сонгоно:

79.12.1.Ерөнхий зөвлөлийн дарга тус зөвлөлийн шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 90-ээс доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсноос хойш ажлын таван өдрийн дотор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх;

79.12.2.Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсноос хойш 14 хоногийн дотор Нийт шүүгчийн чуулганы товыг энэ хуулийн 20.4-т заасны дагуу зарлаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх бөгөөд нийтэд мэдээлснээс хойш 45 хоногийн дараа Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах;

79.12.3.Нийт шүүгчийн чуулганы товыг нийтэд мэдээлснээс хойш 21 хоногийн дотор шүүгч Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтээ дараах баримт бичгийн хамт энэ хуулийн 20.9-д заасан ажлын хэсэгт хүргүүлэх:

79.12.3.а.Ерөнхий зөвлөлийн гишүүний хувьд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ бичсэн тайлбар;

79.12.3.б.мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга.

79.12.4.ажлын хэсэг хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах;

79.12.5.мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд

нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг ажлын хэсэг хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй.

79.13.Нийт шүүгчийн чуулганд нэр дэвшигч нь хийх ажил, нэр дэвшсэн үндэслэлээ танилцуулж, оролцогчийн асуултад хариулна.

79.14.Нэр дэвшигчийн танилцуулга хийх дарааллыг тохиолдлын журмаар тогтоож, танилцуулга хийх, энэ хуулийн 79.12.5-д заасны дагуу ирүүлсэн асуултад хариулах ижил хугацааг нэр дэвшигч бүрд олгоно.

79.15.Нийт шүүгчийн чуулганд оролцогчид нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах бөгөөд санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно.

79.16.Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын санал авсан нэр дэвшигчдийг саналын дарааллаар эрэмбэлж, сул орон тоо гарсан тоогоор Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгогдсонд тооцно. Санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч оролцогчдын олонхын санал аваагүй бол дахин санал хураалт явуулж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцно.

79.17.Ажлын хэсэг энэ хуулийн 79.16-д заасан санал хураалт дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор Нийт шүүгчийн чуулганы тогтоол, тэмдэглэлийг үйлдэж, Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

79.18.Энэ хуулийн 79.12.3-т заасан хугацаанд хүсэлт гаргаагүй шүүгчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр сонгохыг хориглоно.

79.19.Ерөнхий зөвлөлийн гишүүнд шүүгчийг нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд шүүгчийн хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах, үүссэн асуудлыг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай бусад асуудлыг энэ хуулийн 20.3-т заасан дэгээр зохицуулна.” Санал гаргасан Ажлын хэсэг. Адьшаа гишүүн үг хэлнэ. Адьшаа гишүүнээр тасаллаа. Энэ чинь ер нь тэгээд ерөнхий зөвлөлийн гишүүнийг сонгох журмын тухай хуулийг нэгхэн санал хураалтаар явуулж байна. Хууль зүйн байнгын хороо ингэж бөөнд санал хураалтыг Дэгийн хуулиар зохицуулахгүй бол энэ. Үндсэн хуульд нийцүүлэх үүрэгтэй Улсын Их Хурлын дарга. Улсын Их Хурлын үйл ажиллагааг Үндсэн хуульд нийцүүлэх үүрэгтэй. Миний үүрэгтэй зөрчилдөж болзошгүй учраас энийг залруулах чиглэл өгч байна. Дэгийн хуультай.

Ш.Адьяа: Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн шүүхийн сахилгын хорооны гишүүдийг томилох энэ асуудал Үндсэн хуулийн зөрчилд хүргэж бас болзошгүй асуудал учраас би энд санал хэлж байгаа юм. Хууль зүйн байнгын хороон дээр ч энийгээ ярьсан. Улсын Их Хурал бол хууль тогтоох хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ийм Үндсэн хуулийн байгууллага. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн сахилгын хороо бол сая Үндсэн хуулийн өөрчлөлтөөр орсон Үндсэн хуулийн бүтцийн байгууллага байгаа.

Гэтэл энэ дээр би түрүүнээс яриад байгаа. Төрийн эрх мэдлийн хуваарилалт хууль дээдлэх зарчим энд алдагдаад байгаа юм. Өнөөдөр шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн сахилгын хороо гэдэг энэ байгууллага бол шүүх эрх мэдлийн амин сүнс болсон ийм 2 байгууллага байгаа. Гэтэл өнөөдөр энэ 2 байгууллагыг Улсын Их Хурал боловсон хүчний хувьд ч сонгож томилдог хөрөнгө санхүүгийн хувьд ч шийдвэрлэдэг ийм байдлыг энэ хуулиар бий болгож байна. Ингээд энэ асуудал

үнэхээр энэ хэлбэрээр явагдвал Үндсэн хуулийн зөрчил болно. Энэний томилгооны асуудал дээр бүр олны анхаарал татаж байгаа. Улсын Их Хурлын нэг гишүүн ахалж энэ шүүхийн ерөнхий зөвлөл сахилгын хороог томилно гэж байгаа. Энэ чинь Улсын Их Хурал чинь хууль тогтоох, хуулийн хяналт тавих байгууллага шүү дээ.

Тэгээд сүүлд нь бид нар одоо тендер шалгаруулна гэх юм уу одоо яах юм бэ энэ чинь бүр. Бас энэ дээр бол нухацтай хандаарай. Энэ их үр дагавартай асуудал шүү. Үнэхээр одоо Улсын Их Хуралд энэ шүүхийн сахилгын хороо шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг томилдог юм бол тэр олонх цөөнх бусад байгууллага оролцуулаад.../минут дуусав/

Г.Занданшатар: 5 минутаар үг хэлж байгаа. Асуулт дээр л 1 минут байдаг. Гэхдээ ер нь том хууль явж байгаа учраас ойлгож байна. Гэхдээ цаашдаа бол ерөнхий зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журмыг хуулиар тогтооно гээд ингээд тусдаа хууль бараг баталж ингэж явахгүй бол энэ дотор зарим нь дэмжихээр зарим нь дэмжихгүй юм байж болно шүү дээ. Нэг санал хураалтаар ингээд бүх юм асуудал ингээд явж байдаг бол хууль тогтоох ажиллагаанд буруу практик хэрэглэж байна. Санал хураалт. Процессыг зүгээр хуульчлаад явахдаа бол бөөндөөд явж байна шүү дээ. Энэ чинь сүүлд нь процессын алдаа аягүй том алдаа болдог шүү. Процесс дээр л асуудал гардаг шүү. Санал хураалтад 67 гишүүн оролцож 49 гишүүн дэмжиж 73,1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дараа нь их л ажил гарах юм байна даа бас.

59.Төслийн 80 дугаар зүйлийн 80.4 дэх хэсгийн “архив, бүх шатны шүүхийн тамгын газарт түүний салбар” гэснийг хасаж, 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсгийн “хэлэлцэн” гэсний дараа “ил санал хураалт явуулж” гэж нэмж, 81.4 дэх хэсгийн “тав” гэснийг “гурав” гэж өөрчилж, 81.6 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 81.8 дахь хэсэг нэмэх:

“81.8.Ерөнхий зөвлөл хуульчдаас шүүгчийг шилж олох, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбогдуулан гаргасан шийдвэрээ тухай бүр, ажлын тайланг жил бүр өөрийн цахим хуудаст байршуулна.” Энэ чинь бас нэг дээд танилцуулах ёстой нэг юм байгаа шүү. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 67 гишүүн оролцож 48 гишүүн дэмжиж 71,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Бид нар энд шүүхийн хууль баталж байна. Америкийн сенатад Цагаан ордон руу дайрч байна. CNN л тэгж байна. Цагаан ордон биш, танхим руу сенат руу байх л даа. Аягүй бол сенат руу дайрч байгаа байх. Тэр яах вэ ер нь энэ ажлаа шуурхайлъя.

60.Төслийн 82 дугаар зүйлийн 82.1.1 дэх заалтын “удирдах” гэснийг “уялдуулан зохицуулах” гэж, 82.1.11 дэх заалтын “Шүүгчдийн зөвлөлд” гэснийг “Нийт шүүгчийн чуулганд” гэж тус тус өөрчилж, 82.4 дэх хэсгийн “түр” гэснийг, “орон тооны” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. 45 гишүүн дэмжиж 67,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

61.Төслийн 83 дугаар зүйлийн 83.1.1 дэх заалтын “орон тооны гишүүний хувьд” гэснийг хасаж, 83.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 83.1.6, 83.1.7 дахь заалт нэмэх:

“83.1.6.Ерөнхий зөвлөлийн хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө холбогдох баримт бичгийг урьдчилан хүлээн авч танилцах;

83.1.7.хүндэтгэн үзэх шалтгаантай бол Ерөнхий зөвлөлийн хуралдаанд цахим

хэлбэрээр оролцох, эсхүл саналаа бичгээр өгөх;" Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Материаллаг хууль органик хуулиа барих ёстой биз дээ. Санал хураалт 66 гишүүн оролцож 50 гишүүн дэмжиж 75,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Гэхдээ энэ хууль бүгдээрээ нэг цогц болохоор бүгдээрээ материаллаг болно шүү дээ процесс орж байгаа учраас.

62.Төслийн 84 дүгээр зүйлийн 84.2.1 дэх заалтын "энэ хуулийн 20.2.3-т заасны дагуу сонгогдсоноос бусад гишүүн" гэснийг, 84.2.6 дахь заалтын "хороо болон Шүүхийн мэргэшлийн" гэснийг тус тус хасаж, 84.2.1 дэх заалтын "гурван" гэснийг "нэг" гэж, 84.2.2 дахь заалтын "үүсэхээс урьдчилан сэргийлэх" гэснийг "үүсгэх" гэж тус тус өөрчилж, 84.2.7 дахь заалтын "авах" гэсний дараа ", өөртөө аливаа давуу байдал бий болгохыг шаардах" гэж нэмж, 84.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 84.2.5-84.2.7 дахь заалт болгох:

"84.2.5.шүүн таслах ажиллагаа, шүүгчийн хараат бус байдалд нөлөөлөх, хөндлөнгөөс оролцох;

84.2.6.нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын болон үнэлгээ, шалгалтын баримт бичгийг урьдчилан ил болгох, тодорхой нэр дэвшигчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх;

84.2.7.нэр дэвшигчийн үнэлгээг үндэслэлгүйгээр өөрчлөх;" Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 52 гишүүн дэмжиж 78,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

63.Төслийн 85 дугаар зүйлийн гарчгийн "эгүүлэн татах" гэснийг, 85.7 дахь хэсгийн "эгүүлэн татах," гэснийг тус тус хасаж, мөн зүйлд дараах агуулгатай 85.2.3 дахь заалт нэмж, 85.3, 85.4, 85.5 дахь хэсгүүдийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 85.3-85.8 дахь хэсэг болгох:

"85.2.3.энэ хуулийн 89.3-т заасны дагуу хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй байх, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг зөрчсөн, эсхүл шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг задруулсан;"

"85.3.Энэ хуулийн 85.2-т заасан зөрчил гарсан тухай өргөдөл, мэдээллийг Сахилгын хороонд гаргана.

85.4.Сахилгын хороо Ерөнхий зөвлөлийн гишүүний талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сахилгын хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Сахилгын хэрэг үүсгэсэн бол тухайн өргөдөл, мэдээллийн үндэслэлийг шалгах хараат бус шинжээч /цаашид "шинжээч" гэх/-ийг Сахилгын хороо томилно.

85.5.Шинжээч томилогдсоноосоо хойш 30 хоногийн дотор өргөдөл, мэдээлэлд дурдсан зөрчлийн талаарх баримт, мэдээллийг цуглуулж, хууль зүйн дүгнэлт гаргах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

85.6.Шинжээч энэ хуулийн 85.2-т заасан сахилгын зөрчил гарсан байх үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Сахилгын хороо уг дүгнэлтийг эрх бүхий этгээдэд даруй хүргүүлж, Ерөнхий зөвлөлийн гишүүнийг огцруулах эсэх асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

85.6.1.Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг огцруулах асуудлыг энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан журмын дагуу хуралдааныг зохион байгуулж, Нийт шүүгчийн чуулганд оролцогчдын олонхын саналаар, нууцаар санал хурааж, шийдвэрлэх;

85.6.2.Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг огцруулах асуудлыг Байнгын хороогоор хэлэлцэж, санал, дүгнэлтээ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх;

85.6.3.гэмт хэргийн шинжтэй бусад үйлдэл, эс үйлдэхүйг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

85.7.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний энэ хуулийн 84.1, 84.2-т заасныг зөрчсөн үйлдэлд огцруулах шийтгэл оногдуулахааргүй бол зөрчлийн шинж, хэр хэмжээнд тохируулан хаалттай, эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Ерөнхий зөвлөл оногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд тухайн гишүүнийг оролцуулахгүй.

85.8.Сахилгын хороо энэ хуулийн 84.1, 84.2-т заасныг зөрчсөн талаарх өргөдөл, мэдээллийг хүлээн авах, сахилгын хэрэг үүсгэх, шалгах, хянан шийдвэрлэх журмыг хараат бус, бодитой байх зарчимд нийцүүлэн батална.” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 49 гишүүн дэмжиж 74,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дэгийн хуульд өөрчлөлт оруулах санал чиглэл өг гэж хэлсэн бэ? Сайнзориг хэлсэн үү? Засгийн газар Улсын Их Хурлын үйл ажиллагаанд Засгийн газрын албан тушаалтан чиглэл өгөхгүй. Оролцохгүй, санал өгөхгүй Улсын Их Хурлын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглоно. Та дэг зөрчиж байна шүү. Гэхдээ энэ Чуулганы дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй юм байна. Тийм чиглэл өгч байна. Сүүлд нь яг энэ юун дээр очихоор байна Цэц. 49 гишүүн дэмжиж 74,2 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн.

64.Дээрх 8 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 87 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 49 гишүүн дэмжиж 74,2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

65.Төслийн 88 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 36 дугаар зүйл болгон Наймдугаар бүлэгт шилжүүлэх:

“36 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх

36.1.Энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан гэж үзсэн иргэн энэ хуулийн 35.2-т заасны дагуу зарыг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасны дагуу өргөдөл гаргагч нь энэ хуулийн 34 дүгээр зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан тухай баримтыг өргөдөл, анкет, мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн болон эд хөрөнгийн эрхийн лавлагаа, Монгол Улсын иргэний үнэмлэх, мэргэжлийн боловсролын диплом, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хөдөлмөр эрхлэлтийн талаарх болон бусад баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт Ерөнхий зөвлөлд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

36.3.Ерөнхий зөвлөл өргөдөл гаргагчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан шалгаж, шүүгчид нэр дэвшигчээр бүртгэсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан тухай тогтоол гаргана.

36.4.Энэ хуулийн 36.3-т заасан тогтоол гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор нэр дэвшигчийн баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

36.5.Энэ хуулийн 36.4-т заасан мэдээллийг байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхсон этгээд нэр дэвшигчээс асуух асуулт, саналаа Ерөнхий зөвлөлд ирүүлэх бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг хүлээн авахгүй.

36.6.Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн мэдээллийг тухайн шүүхийн болон нутгийн захиргааны байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

36.7.Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тавих болзол, шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх баримт бичиг болон бүртгэлтэй холбогдсон харилцааг энэ хуулийн 74.1.5-д заасан журмаар зохицуулна.” Санал гаргасан Ажлын хэсэг. Сайнзориг тогтоол гаргана гэж ярьдаг юм уу тогтоол батална гэж ярих уу? Найруулга дээрээ тогтоол батална гэсэн юугаар явахгүй бол тогтоол гаргана гэж яваад байна. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн оролцож 50 гишүүн дэмжиж 75,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. 2 минут дутуу байна.

66.Төслийн 89 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 37 дугаар зүйл болгон Наймдугаар бүлэгт шилжүүлэх:

“37 дугаар зүйл.Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт

37.1.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг энэ хуулийн 36.3-т заасны дагуу бүртгэснээс хойш 60 хоногийн дотор шүүгчид нэр дэвшигчийн шалгалт авна. Шүүгчид нэр дэвшигчийн шалгалт нь хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтаас бүрдэнэ.

37.2.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтыг эрх зүйн тохиолдол шийдвэрлэх, сорилын асуултад хариулах, эрх зүйн баримт бичиг боловсруулах, хууль тайлбарлан хэрэглэх, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зэрэг аргаас сонгон хэрэглэж, 70 хүртэлх оноогоор үнэлнэ. Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн шалгалт ялгаатай байна.

37.3.Хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт нь нэр дэвшигчийг урьдчилан мэдэх боломжгүй, хөндлөнгийн байдлаар үнэлэх нөхцөлийг хангасан байх бөгөөд шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг Ерөнхий зөвлөл хариуцна.

37.4.Энэ хуулийн 37.2-т заасан шалгалтад 50, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг хууль зүйн мэдлэг, чадварын шалгалтад тэнцсэнд тооцож, тогтоол гарган мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад оруулна.

37.5.Энэ хуулийн 37.4-т заасан тогтоол гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор хувь хүний нууцад хамаарахаас бусад нэр дэвшигчийн мэргэжлийн үйл ажиллагааны танилцуулга болон холбогдох баримт бичгийг Ерөнхий зөвлөлийн

цахим хуудаст байршуулна. Ийнхүү байршуулснаас хойш 14 хоногийн дотор сонирхогч этгээд нэр дэвшигчийн талаарх саналаа Ерөнхий зөвлөлд хүргүүлж болох бөгөөд нэр, хаяггүй саналыг хүлээн авахгүй.

37.6.Энэ хуулийн 37.4-т заасан нэр дэвшигчийг тохиолдлын журмаар Ерөнхий зөвлөлийн гишүүн /цаашид “илтгэгч гишүүн” гэх/-д тэнцвэртэй хуваарилна. Илтгэгч гишүүн өөрт хуваарилагдсан нэр дэвшигчийн баримт бичиг, шүүн таслах болон бусад ажлын туршлага, шүүгчээр ажиллаж байсан нэр дэвшигчийн хувьд хянан шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийн чанар, олон нийтээс хүлээн авсан санал, нэр дэвшигчийн талаар бусад этгээдтэй болон нэр дэвшигчтэй хийсэн ярилцлагын дүн зэргийг судалсны үндсэн дээр тухайн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг үнэлсэн үндэслэл бүхий тайлан бичиж, Ерөнхий зөвлөлийн бусад гишүүдэд хүргүүлж, хуралдаанд танилцуулна.

37.7.Ерөнхий зөвлөл нэр дэвшигчтэй ярилцлага хийсний дараа дараах зүйлийг үндэслэн нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүй, зан төлөвийг 30 хүртэл оноогоор үнэлэх бөгөөд 20, түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг уг шалгалтад тэнцсэнд тооцно:

- 37.7.1.нэр дэвшигчтэй хийсэн ярилцлага;
- 37.7.2.нэр дэвшигчийн баримт бичиг;
- 37.7.3.нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх хөндлөнгийн дүгнэлт;
- 37.7.4.олон нийтээс хүлээн авсан санал;
- 37.7.5.илтгэгч гишүүний тайлан;
- 37.7.6.бусад.

37.8.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, чадвар болон мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт тус бүрд өгсөн оноо, тэдгээрийн нийлбэр онооны дарааллаар эрэмбэлэн өөрийн цахим хуудаст байршуулж, нийтэд мэдээлнэ.

37.9.Энэ хуулийн 37.8-д заасан үнэлгээ хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

37.10.Шүүгчийн сонгон шалгаруулалт олон нийтэд ил тод байх бөгөөд шалгалттай холбогдуулан гаргасан Ерөнхий зөвлөлийн шийдвэр үндэслэл бүхий, оролцогч болон сонирхогч этгээдэд ойлгомжтой, нээлттэй байна.

37.11.Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчээс шалгалт авахдаа зохих журмын дагуу хөндлөнгийн хараат бус шинжээчийг оролцуулж болно.

37.12.Шалгалт авах арга, хэлбэр, үнэлэх аргачлал, нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх хөндлөнгийн дүгнэлт гаргах, олон нийтээс санал хүлээн авах болон холбогдох бусад харилцааг энэ хуулийн 74.1.5-д заасан журмаар зохицуулна.” Санал гаргасан Ажлын хэсэг. Төрийн албаны зөвлөлийн тэр тест сорил авах журмыг нэг хармаар л юм байна. Санал хураалт. Азийн улсуудад бол Күнзийн ёс зүйн номыг цээжээр мэддэг байх шаардлагатай. Санал хураалтад 66 гишүүн оролцож 48 гишүүн дэмжиж 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

67.Төслийн 91 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 91.1.9 дэх заалт нэмэх:

“91.1.9.иргэн, хуулийн этгээдээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, хариу өгөх;” Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтад 66 гишүүн

оролцож 50 гишүүн дэмжиж 75,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Ингээд гарсан горимын саналын дагуу 7 цаг хүртэл хуралдахаар өнөөдөр төлөвлөсөн. 19 цаг болсон учраас өнөөдрийн чуулган үүгээр завсарласныг мэдэгдье. Маргааш 10 цагаас 68 дахь санал хураалтаас эхлэн санал хураалтыг үргэлжлүүлнэ. Яг талдаа ороод л зогслоо.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

